



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ДАРГА САНДАГИЙН БЯМБАЦОГТ  
ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2026.04.30 № 3Г-1/36  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
тухай

“Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай” ЮНЕСКО-ийн конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэгт заасны дагуу зөвшилцөх, хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Н.УЧРАЛ

000264001576



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026.04.13 № НЭГ/1183  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
хугацааг товлох тухай

“Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай” ЮНЕСКО-ийн конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд хүргүүлэхээр шийдвэрлэснийг холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлохыг хүсье.

Хавсралт <sup>181</sup> хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Б.ЭНХБАЯР


000265005111

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 7 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“11.ХЭЛЭЛЦСЭН нь: “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай” ЮНЕСКО-ийн конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай” ЮНЕСКО-ийн конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэгт заасны дагуу зөвшилцөх, хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд хүргүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН  
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД**

Энхтайваны өргөн чөлөө 7а,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210  
Утас: 26 21 35, Факс: (976-11) 32 21 27,  
Цахим шуудан: info@mfa.gov.mn  
Цахим хуудас: www.mfa.gov.mn

2026.03.13 № 01/1158  
танай 2026.03.03 -ны № 01/609 -т

**СОЁЛ, СПОРТ,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,  
ЗАЛУУЧУУДЫН САЙД  
Ч.УНДРАМ ТАНАА**

“Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай”  
ЮНЕСКО-гийн конвенцыг соёрхон батлах тухай  
хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх  
зөвшөөрлийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 40  
дүгээр зүйлийн 40.1.8 дэх хэсэгт заасны дагуу үүгээр  
олгов.



**Б.БАТЦЭЦЭГ**

**115051502**



6. Өмнөх

118260109

МОНГОЛ УИХ-ЫН ХУРИЛ / ӨМНӨХ АЖААЛ ГАРГАХ ХЯАМ /-ЫН  
 ӨМНӨХ АЖААЛ ГАРГАХ ХЯАМ / 00 ӨМНӨХ АЖААЛ ГАРГАХ ХЯАМ / 00. 0. 4 ӨМНӨХ  
 АЖААЛ ГАРГАХ ХЯАМ / ӨМНӨХ АЖААЛ ГАРГАХ ХЯАМ / ӨМНӨХ АЖААЛ ГАРГАХ ХЯАМ /  
 ӨМНӨХ АЖААЛ ГАРГАХ ХЯАМ / ӨМНӨХ АЖААЛ ГАРГАХ ХЯАМ / ӨМНӨХ АЖААЛ ГАРГАХ ХЯАМ /  
 «ӨМНӨХ АЖААЛ ГАРГАХ ХЯАМ / ӨМНӨХ АЖААЛ ГАРГАХ ХЯАМ / ӨМНӨХ АЖААЛ ГАРГАХ ХЯАМ /»

6. Өмнөх

Өмнөх

Өмнөх

\_\_\_\_\_

Өмнөх \_\_\_\_\_ Өмнөх

Өмнөх \_\_\_\_\_ Өмнөх

Өмнөх \_\_\_\_\_ Өмнөх

Өмнөх \_\_\_\_\_ Өмнөх

Өмнөх \_\_\_\_\_ Өмнөх

Өмнөх \_\_\_\_\_ Өмнөх

Өмнөх \_\_\_\_\_ Өмнөх



**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД**

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,  
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,  
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,  
Цахим хуудас: http://www.mof.gov.mn


2026.03.11 № 01/1642

танай 2026.03.03 ны № 01/609-т

**СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН  
САЙД Ч.УНДРАМ ТАНАА**

Танаас ирүүлсэн “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай” ЮНЕСКО-ийн конвенцыг соёрхон батлах тухай” хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгож байна.

Хүндэтгэсэн,



**Б.ЖАВХЛАН**

**9761000268**



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас/Факс: (976-51) 26 75 33,  
Цахим шуудан: info@mojha.gov.mn,  
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2026.03.11 № 1/1232  
танай 2026.03.03 -ны № 01/609 -т

**СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,  
ЗАЛУУЧУУДЫН САЙД Ч.УНДРАМ  
ТАНАА**

Танаас ирүүлсэн “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай” ЮНЕСКО-ийн конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгов.

  
Б.ЭНХБАЯР

ХЗДХЯ-ны А5

152640473



## “УСАН ДООРХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ” ЮНЕСКО-ИЙН КОНВЕНЦЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

### Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

**1.1.Хууль эрх зүйн үндэслэл:** Монгол Улсын Үндсэн хуулийн Долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэж, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 1.1.6-д “Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж, хөгжүүлэх нь Монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа мөн” гэж, мөн 2011 оны 10 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал”-ын 25.4-д “Боловсрол, соёл, урлаг, спорт, олон нийт мэдээллийн олон улсын байгууллагатай идэвхтэй харилцах, шаардлагатай гэрээнд нэгдэн орох, ижил төрлийн байгууллагуудын хооронд шууд харилцаа, солилцоо хөгжүүлэх, соёл, урлаг, спортын олон улсын арга хэмжээнд оролцох, ийм төрлийн арга хэмжээг эх орондоо зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх” гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 1.1.9-д “Монгол Улсад түүх, соёлын өвийг сүйтгэгчидтэй хийх тэмцлийг орон даяар өрнүүлж, хууль сахиулах болон тусгай чиг үүрэгтэй байгууллагуудын хариуцлагыг нэмэгдүүлнэ” гэж тус тус заажээ.

Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 1.13.117-д “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцыг соёрхон батлах”-аар заасан.

**1.2.Практик шаардлага:** Монгол Улсын нутаг дэвсгэр дээрх эртний тахилгатай томоохон нуур, гол мөрний ёроолд уламжлалт зан үйлийн дагуу өргөсөн алт, мөнгөн аяга, тагш, мөнгөн ембүү, мөнгөн аягыг төлөөлүүлж өргөсөн бүслүүр, амсар, ёроол зэрэг зүйлс хадгалагдан үлдсэн байдаг. Тухайлбал, Орхон голд “Түшээ гүн” цол олгож, жил бүр 25 лангийн мөнгөн ембүү өргөн тахидаг уламжлал байсан бол, Отгонтэнгэр хайрханы Бадархундага нуурт мөнгөн аягаар өргөл өргөдөг уламжлал өнөө ч хадгалагдсаар байна. Эдгээр нь түүхэн тодорхой цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж, түүх, соёл, шинжлэх ухаан, танин мэдэхүйн үнэ цэнэ, ач холбогдолтой байдаг нь зарим талаар соёлын өвийн хэв шинжийг агуулдаг бөгөөд цаг улирах тусам үнэ цэнэ нь улам бүр өсөн нэмэгдэж, угсаатны бүлэг, хамт олны зан үйлийн уламжлалыг биетээр гэрчлэн үлддэг байна.

Түүнчлэн, томоохон нуур, гол мөрний усан дор эвдрэл гэмтлийн зэрэг шалтгааны улмаас живсэн усан завь, гатлага онгоц, сал, элдэв төрлийн техник хэрэгсэл, бусад эд зүйлс цөөнгүй хадгалагдаж байна. Эдгээр нь тодорхой цаг хугацааны ой санамжийг тээн үлдэж, жил ирэх тусам үнэ цэнтэй эд зүйлд тооцогддог.

Монгол Улс усан доор хадгалагдан үлдсэн дээрх үнэт зүйлсийг эрх зүйн хүрээнд томъёолж, хадгалж хамгаалах харилцааг нарийвчлан зохицуулж байсан туршлага байхгүй, бүртгэл судалгаагүй, усан доор ажиллах хүний нөөц бэлтгэгдээгүй дэд бүтэц, техник технологийн орчин, нөхцөл дутмаг зэрэг олон шалтгааны улмаас усан доорх соёлын өв, үнэт зүйл эрсдэлд орох тохиолдол гарсаар байна. Энэ нөхцөл байдал Монголчуудын бүтээн туурвисан соёлын биет болон биет бус өвийн харилцан шүтэлцээтэй үнэт зүйлийн илэрхийллийг цогцоор нь хамгаалах боломж хомс байгааг илтгэдэг.

2018 онд Завхан аймгийн Отгон сумын нутаг, Отгонтэнгэр хайрхны бэлд орших Бадархундага нуурт хэсэг этгээд шумбалт хийж, иргэдийн өргөсөн том жижиг мөнгөн аяга, мөнгөн аяганы бүрдэл хэсэг болох бүслүүр, ёроол зэрэг нийт 366 ширхэг эд зүйлийг хулгайлсныг цагдаагийн байгууллага илрүүлэн, эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан. Уг хэргийг шүүхийн шатанд шийдвэрлэхдээ 366 ширхэг эд зүйлийг Завхан аймгийн Улиастай сумын Засаг даргын Тамгын газарт шилжүүлжээ. Тус сумын Тамгын газар аяганы мөнгийг тагшнаас салган авч, нийт 6,825 гр болгоод нэг ланг 35,000 төгрөгөөр тооцон худалдаж 6,370,000.0 төгрөг болсныг автомашины сэлбэг зэрэг зүйлд зарцуулсан байна. Хэргийн үйл явцад эрх зүйн зохицуулалт байхгүйн улмаас соёлын өвийн мэргэжилтнийг аль ч шатанд оролцуулаагүй ажээ.

Монгол орны томоохон нуур, гол мөрний усан доор өмнө дурдсан уламжлалын дагуу өргөсөн мөнгөн аяга, живсэн усан завь зэрэг үнэт зүйлс цөөнгүй хадгалагдаж байдаг. Эдгээр нь бүгд эзгүй зэлүүд газар, эсхүл хүний хараа хяналтаас хол далд газарт, гүехэн усанд оршин байдаг нь хялбар аргаар ашиг хонжоо хайгчдад далим болж, шунахайн сэдлээр тонон дээрэмдэх нөхцөлийг бүрдүүлж байна. Энэ нь Монголын ард түмний оюун санааны болон эдийн соёлын үнэт зүйлийн өвөрмөц өвийн нэг болох нуур, усаа эрхэмлэн шүтэх уламжлалт зан үйл оршин тогтнох чадвараа алдаж мартагдах, цаашлаад устаж болзошгүй байна.

Дээрх жишээ баримт нь усан доорх соёлын өвийг хамгаалах эрх зүйн тогтолцоог нэн даруй бүрдүүлж, олон улсын жишгийн дагуу үнэт зүйлсийг бүртгэн баримтжуулах, судлан шинжлэх, хадгалж хамгаалах, сурталчлан таниулах, зохистой хэлбэрээр ашиглах асуудлыг хуулийн хүрээнд журамлах шаардлагатай байгааг харуулж байна.

Нэгдсэн Үндэстний Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагаас хүн төрөлхтний түүх, соёл, шинжлэх ухаанд чухал ач холбогдолтой, доод тал нь 100 жилийн туршид хэсэгчлэн эсхүл бүхэлдээ, тодорхой хугацааны туршид эсхүл байнга усан доор байсан соёл, түүх эсхүл археологийн шинж чанартай, хүний оролцоотой бий болсон бүхий л ул мөрийг “усан доорх соёлын өв” хэмээн үзэж, эдгээр өвийг хамгаалах, оролцогч талуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, усан доорх соёлын өвийг судлах, малтах, хамгаалахад шинжлэх ухааны тусгай арга зүй, техник технологийг ашиглах, хөгжүүлэх зорилгоор “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай” конвенцыг Бүгд Найрамдах Франц Улсын Парис хотноо 2001 оны 10 дугаар

сарын 15-ны өдрөөс 11 дүгээр сарын 3-ны өдрүүдэд хуралдсан 31 дүгээр Ерөнхий бага хурлаар батласан.

Конвенцын механизмыг ашиглан оролцогч талуудтай хамтран усан доорх соёлын өвийг хамгаалах үндэсний тогтолцоог бүрдүүлэн, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хууль бус аливаа үйл ажиллагаатай тэмцэх замаар Монгол Улсын соёлын өвийн сан хөмрөгийн аюулгүй байдлыг хангах боломжийг бүрдүүлэхээр зорьж байна.

Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтад “Монгол Улсын хуульд зааснаас өөр журам тогтоож байгаа, эсхүл тухайн гэрээг байгуулснаар, нэгдсэнээр, эсхүл хэрэгжүүлснээр Монгол Улсын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл хууль шинээр батлах шаардлагатай олон улсын гэрээг заавал соёрхон батална” гэж заасны дагуу тус конвенцыг Монгол Улсын Их Хурлаар соёрхон батлуулах шаардлагатай байна.

### **Хоёр.Хуулийн төслийн ерөнхий зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төсөл нь 1 зүйлтэй байх бөгөөд тус зүйлд “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай” ЮНЕСКО-ийн 2001 оны конвенцыг Монгол Улсын Засгийн газар өргөн мэдүүлснээр соёрхон батлах тухай заана.

### **Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

“Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай” ЮНЕСКО-ийн конвенцыг соёрхон баталснаар Монгол Улсын хэмжээнд байгаа усан доорх соёлын өвийг хамгаалах эрх зүйн үндэс тавигдаж, усан доорх соёлын өвийг бүртгэн баримтжуулах, судлан шинжлэх, хадгалан хамгаалах, сурталчлан таниулах, зохистой хэлбэрээр ашиглах зэрэг үйл ажиллагааг олон улсын жишгийн дагуу үр нөлөөтэй зохицуулах боломж бүрдэнэ.

“Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай” ЮНЕСКО-ийн конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг баталснаар нийгэм, эдийн засаг, хууль эрх зүйн хүрээнд сөрөг үр дагавар гарахгүй болно.

**Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар**

Хуулийн төслийг Олон улсын гэрээний тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хууль болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн боловсруулна. Хууль батлагдсанаар шинээр өөр хууль боловсруулах, бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, эсхүл хүчингүй болгох шаардлагагүй болно.

## “УСАН ДООРХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ” ЮНЕСКО-ИЙН КОНВЕНЦЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**1.Хуулийн төслийн ерөнхий агуулга, зохицуулах харилцаа:** Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай ЮНЕСКО-ийн конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл нь 1 зүйлтэй, соёрхон батлахаар заасан. Конвенц нь усан доор байгаа соёлын өвийг бүртгэх, судлах, хадгалах, сэргээх, ашиглахтай холбоотой харилцааг үндэсний хэмжээнд зохицуулах боломжийг бүрдүүлэх юм.

**2.Тухайн харилцааг хууль, эрх зүйн бусад актаар зохицуулж ирсэн байдал:** Монгол Улс усан доорх соёлын өвийг хамгаалахтай холбоотой харилцааг өмнө нь хууль, эрх зүйн хүрээнд зохицуулж ирсэн туршлагагүй юм. Харин, 2014 онд шинэчлэн баталсан Соёлын өвийг хамгаалах тухай хуульд “ус”-ыг төрийн тахилгатай болгох асуудлыг анх удаа тусгасан байдаг.

**3.Хууль санаачлагчаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:** Соёлын яам /хуучин нэрээр/ Усан доорх соёлын өвийг хамгаалах конвенцыг үндэсний хэмжээнд танин мэдүүлэх, ач холбогдлыг сурталчлах чиглэлээр 2019, 2021 онд 2 удаагийн сургалтыг Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага, ЮНЕСКО-ийн Бээжин дэх төлөөлөгчийн газар, Конвенцын нарийн бичгийн дарга нарын газартай хамтран салбарын албан хаагчид, эрдэмтэн, судлаачид болон хууль сахиулах байгууллагын төлөөллийг оролцуулж зохион байгуулсан.

Мөн 2023 оноос үндэсний мэргэжилтнүүдийг Япон Улсын Такашима арлын орчимд хэрэгжүүлж байгаа усан доорх хөлөг онгоцыг судлах, сурталчлах үйл ажиллагаатай танилцуулж, туршлага судлах ажлыг зохион байгуулсан.

Дээрх арга хэмжээнд хамрагдсан үндэсний мэргэжилтнүүд конвенцын ач холбогдлыг үнэлэх, үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх стратегийг тодорхойлох, хуулийн төслийг боловсруулах үйл явцад голлох үүргийг гүйцэтгэжээ.

Усан доорх соёлын өвийг хамгаалах конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсруулах, үзэл баримтлалыг батлуулах, конвенцын орчуулгыг баталгаажуулах, олон нийтийн дунд танилцуулах, зөвлөлдөх уулзалт зохион байгуулах зэрэг үе шаттай ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүрдүүлж ажиллалаа.

**4.Хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн дүн:** Усан доорх соёлын өвийг хамгаалах конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны цахим хуудаст 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр <https://mocstv.gov.mn/news/hC5kqmjWA6p6Jq1EY46NUuFblOOtQP6u> холбоосоор байршуулж олон нийтэд танилцуулсан. Хуулийн төсөлтэй 930 орчим хүн танилцсан, төсөлд тухайлан санал ирүүлсэн тохиолдол байхгүй байна.

**5.Гадаад орны туршлага, бусад судалгаа, шинжилгээний ажлын тайлангийн дүгнэлт:** Монгол Улсад урьд өмнө усан доорх соёлын өвийг хамгаалахтай холбоотой судалгаа, шинжилгээний ажил хийгдэж байгаагүй, хуулийн төсөл боловсруулах явцад ашиглах тайлан, эх сурвалж байхгүй тул эрдэмтдийн багийн гүйцэтгэсэн “Хуулийн

хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны ажлын тайлан"-д дурдсан зөвлөмжийг үндэслэн төслийг боловсруулсан.

Өнөөдрийн байдлаар конвенцыг соёрхон баталж, нэгдэн орсон 81 улс, түүнчлэн далай тэнгист гарцтай улс орнууд усан доорх соёлын өвийг хамгаалах чиглэлээр тус тусын стратегийг тодорхойлж, судалгаа шинжилгээний ажлыг зохион байгуулдаг.

Конвенцын нарийн бичгийн дарга нарын газраас улс, орнуудад зориулан гаргасан гарын авлага, удирдамжийг цахим хуудсаар дамжуулан хүлээн авч, танилцан холбогдох мэдээллийг өмнө зохион байгуулсан сургалтын үеэр тухайн төслийг удирдсан, эсхүл төсөлд оролцсон эрдэмтэн судлаачид тусгайлан танилцуулга бэлтгэж, оролцогчдод танилцуулсан байна.

Монгол Улсын хувьд 2023 оноос Япон Улсын Такашима арал орчимд хэрэгжүүлж байгаа Хубилай хааны цэргийн флотын усан онгоцны судалгааны үйл явцтай танилцах, туршлага судлах, хамтран ажиллах чиглэлээр үндэсний мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлж байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

## “УСАН ДООРХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ” ЮНЕСКО-ИЙН КОНВЕНЦЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Нэгдсэн Үндэсний Байгууллагаас 1982 онд баталсан “Далайн эрх зүйн тухай конвенц”-ын 149 дүгээр зүйлд археологийн болон түүхийн объектын талаар “...Район (Далайн эрх зүйн тухай конвенцод тодорхойлсноор “...үндэсний эрх хэмжээний гадна орших далайн ёроол болон түүний хэвлийг” ойлгоно)-оос олдсон археологийн болон түүхийн чанартай бүх объектыг нийт хүн төрөлхтний тусын тулд хадгалж, ашиглана. Гэхдээ тэдний гарлын улс болон орон, тэдгээрийн соёлын гарлын улс, эсхүл тэдгээрийн түүх, археологийн гарлын улсын давуу эрхийг онцлон анхаарна” гэж заасан.

Гэвч үүгээр усан доорх соёлын өвийг хамгаалах үйл ажиллагааг бүрэн гүйцэт зохицуулах боломжгүй байв. Ялангуяа эрт цагт осолдсон усан онгоцны эд зүйлсийг хулгайлах, усан дор орсон хот суурины үлдэгдлийг тонон дээрэмдэх зэрэг гэмт хэргийг таслан зогсоох, буруутай этгээдэд хариуцлага тооцох, эд зүйлсийн өмчлөх эрхийг хангах зэрэг үндсэн усан доорх соёлын өвийг хамгаалах асуудлыг нийт хүн төрөлхтний эрх ашгийн үүднээс шийдвэрлэхэд “Далайн эрх зүйн тухай конвенц” учир дутагдалтай байсан.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО)-ын Ерөнхий бага хурлын 2001 оны 31 дүгээр чуулганаар усан доорх соёлын өвийг хамгаалах, тогтвортой хадгалах зорилгоор 2001 онд баталсан “Усан доорх соёлын өвийг хамгаалах конвенц” нь 35 зүйл, дүрмээс бүрддэг.

Конвенцын 1 дүгээр зүйлд нэр томъёог тодорхойлсон бөгөөд “...доод тал нь 100 жилийн туршид хэсэгчлэн, эсхүл бүхэлдээ, тодорхой хугацааны туршид, эсхүл байнга усан доор байсан соёл, түүх, эсхүл археологийн шинж чанартай, хүний оролцоотой бүхий л ул мөрийг “усан доорх соёлын өв” гэж тодорхойлон, түүнд “...археологи болон байгалийн орчинтой хамт байгаа дурсгалт газар, байгууламж, барилга, олдвор болон хүний биеийн үлдэгдэл”, “...археологи болон байгалийн орчинтой байгаа хөлөг онгоц, агаарын хөлөг, бусад төрлийн тээврийн хэрэгсэл эсхүл тэдгээрийн аливаа хэсэг, ачаа эсхүл бусад эд зүйлс”, “...эртний түүхэнд хамаарах эд зүйлс”-ийг хамруулахаар заажээ. Харин “...далайн ёроолд байрлуулсан дамжуулах хоолой болон кабелийн утас, тоног төхөөрөмж”-ийг усан доорх соёлын өвд хамруулахгүй гэж тодорхойлсон байна.

Монгол Улс далай, тэнгист гарцгүй боловч нутаг дэвсгэр дээр орших том, жижиг нуур, голын усыг эртнээс тахин шүтэж ирсэн уламжлалтай бөгөөд түүнд холбогдох зан үйлийн дотор ембүү, алт, мөнгөн сав эд зүйлс өргөх явдал цөөнгүй байсан нь конвенцын 1 дүгээр зүйлд заасан “усан доорх эд зүйлс”-д хамаарахаар байна. Мөн Хөвсгөл зэрэг нууранд хуучны усан завь зэрэг зүйлс хадгалагдан үлдсэн байдаг бөгөөд эдгээр нь цаг хугацаа өнгөрөх тусам үнэ цэнтэй болж, соёлын өвийн шинжийг хадгалдаг тул конвенцын тодорхойлолтод заасан дотоодын усан доорх соёлын өвд хамаарна.

Манай улс усан доорх соёлын өвийг хамгаалах эрх зүйн зохицуулалтын туршлагагүй, цаашид энэ төрлийн дурсгалт зүйлсийг конвенцын зорилгын үүднээс илрүүлж бүртгэх, хадгалж хамгаалах, өмчилж эзэмших, зохистойгоор ашиглах үйл ажиллагааны зохион байгуулалтыг боловсронгуй болгон түүнтэй холбогдох харилцааг эрх зүйн хүрээнд зохицуулах асуудал тулгамдаж байна. Түүнчлэн, усан доорх соёлын

өвийг хамгаалах чиглэлээр үндэсний мэргэжилтнүүдийг бэлтгэж, чадавхыг үе шаттай бэхжүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

Дотоодын усан дахь соёлын өвөөс гадна Монголын Эзэнт гүрний үед далайн замыг ашиглан худалдаа хийх, улс орнуудыг байлдан дагуулах үйл явцад осолдож, гадаад далай, тэнгисийн ёроолд үлдсэн олон зуун хөлөг онгоц бий. Өдгөө мэдэгдсэн Япон Улсын Нагасаки мужийн Мацуура хотын Такашима арлын усан доор Хубилай хааны Япон Улс руу 1274, 1281 онд хийсэн хоёр довтолгооны үеэр далайн хар шуурганд өртөж сүйрсэн 900 орчим хөлөг онгоц хадгалагдаж байна. Далайн ёроолд байгаа эдгээр олдвор, эд өлгийн зүйлсийг судлах ажил 1980-аад оноос тус улсад идэвхжиж, “Дөрвөлжин” бичиг бүхий Юань гүрний цэргийн жанжны зэс тамга, төмөр дуулга, шаазан ваар, тоосго, шавар вааран тэсрэх бөмбөгний хэлтэрхий зэрэг олон олдвор, эд өлгийн зүйлс илрүүлэн тусгай музей байгуулан, идэвхтэй судалгаа явуулж байгаа бөгөөд 2012 онд Япон Улс Такашима арлын Козаки орчмын 384,000 м<sup>2</sup> талбай бүхий газар нутгийг “Далайн ёроолын түүхэн дурсгалт газар” хэмээн тодорхойлсон байдаг.

Монголын түүхэнд хамаарах тус дурсгалт газарт далайн археологийн чиглэлээр хамтарсан судалгаа зохион байгуулах ажлыг Монгол Улс Япон Улстай хамтран эхлүүлээд байна. Энэ төрлийн судалгааг хамтран зохион байгуулах нь конвенцын хэрэгжилтийг олон улсын түвшинд эрчимжүүлэх, гишүүн орны оролцоог хангахад чухал үүрэгтэйгээс гадна, Монгол Улсын түүх бичлэгийг хөдлөшгүй баримтаар баяжуулахад үнэтэй хувь нэмэр оруулах юм.

Дээрх үндэслэл, хэрэгцээ шаардлагыг харгалзан усан доорх соёлын өвийг хамгаалах олон улсын гэрээ, хэлэлцээрт нэгдэн өөрийн орны усан доорх соёлын өвийг хамгаалах эрх зүйн үндсийг бүрдүүлэх зорилгоор хуулийн үзэл баримтлал болон хуулийн төслийг боловсрууллаа.

“Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай” ЮНЕСКО-ийн конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг хуулийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайланд үндэслэн, салбарын мэргэжилтнүүд, холбогдох байгууллагатай зөвшилцөн холбогдох хуульд заасан шаардлагын дагуу боловсруулж, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Гадаад харилцааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд хамтран баталсан болно.

“Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай” ЮНЕСКО-ийн конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл нь 1 заалттай, хуулийг дагаж шинээр хууль тогтоомж санаачлах, эсхүл хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага байхгүй юм.

Хуулийн төслийн томъёоллыг конвенц соёрхон баталсан жишиг хуулийн бичвэртэй нэгэн адилаар хэвшиж заншсан хэл, найруулгатай боловсрууллаа.

Монгол Улсад өмнө нь усан доорх соёлын өвийг хамгаалах тухай харилцааг хууль, эрх зүйн хүрээнд зохицуулж байгаагүй тул конвенцыг соёрхон баталсны дараа усан доорх соёлын өвийг хамгаалах асуудлыг конвенцын баталгаажсан орчуулгад заасан агуулгын хүрээнд зохицуулна. Тухайлбал, конвенцод “усан доорх соёлын өв” гэж томъёолсон ойлголтыг дэлхий дахинд нэг хэлбэр, агуулгаар хэрэглэж заншсан тул үндэсний хэмжээнд тэр хэвээр хэрэглэнэ.

Конвенц нь усан доорх соёлын өвийн хамгаалалтыг хангаж, бэхжүүлэх зорилгыг дэвшүүлсэн бөгөөд түүнд хүрэх арга замыг оролцогч талуудын идэвхтэй хамтын ажиллагааны механизм гэж тодорхойлсон. Энэ хүрээнд усан доорх соёлын өвийг эрэн хайх, илрүүлж тодорхойлох, бүртгэж баримтжуулах, судлан шинжлэх, хадгалж хамгаалах үйл ажиллагааг зохих зөвшөөрлийн хүрээнд мэргэжлийн түвшинд гүйцэтгэх харилцааг зохицуулсан байдаг. Конвенцод тодорхойлсон зорилго, үйл ажиллагааны хэв шинжийг мөн энэ хэвээр нь ашиглах юм.

Конвенц нь ЮНЕСКО-ийн 1970 оны “Соёлын эд зүйлийг хууль бусаар импортлох, экспортлох, өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай конвенц”, 1972 оны “Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах тухай конвенц”, 1982 оны “Далайн эрх зүйн тухай конвенц” хоорондын харилцан уялдааг сайжруулах, бие биенээ нөхөх үүрэгтэй юм. Монгол Улс эдгээр конвенцуудад өмнө нэгдэн орсон тул эрх зүйн хувьд зөрчил, хийдэл үүсэхгүй юм.

Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцод өнөөдрийн байдлаар 81 улс орон нэгдэн орсон бөгөөд тэдгээрийн 72 нь конвенцыг соёрхон баталсан, 8 улс хүлээн зөвшөөрсөн, 1 улс зөвшөөрсөн байна.

Эдгээр улсын ихэнх нь конвенцод заасан нийтлэг хэм хэмжээнд нийцүүлэн дотоодын хууль тогтоомждоо усан доорх соёлын өвийг хамгаалах талаар нарийвчилсан зохицуулалт оруулж, хамгаалах үйл ажиллагааг явуулж байна.

Монгол Улс эдгээр конвенцуудад өмнө нэгдэн орсон тул эрх зүйн хувьд зөрчил, хийдэл үүсэхгүй юм.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Төрийн ордон,  
Улаанбаатар хот

### КОНВЕНЦ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО)-ын Ерөнхий бага хурлын 2001 оны 31 дүгээр чуулганаар баталсан “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенц”-ыг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

ГАРЫН ҮСЭГ



**CONVENTION ON THE  
PROTECTION OF THE UNDERWATER CULTURAL HERITAGE**

UNESCO  
Paris, 2 November 2001

## **CONVENTION ON THE PROTECTION OF THE UNDERWATER CULTURAL HERITAGE**

The General Conference of the United Nations Educational, Scientific and Cultural Organization, meeting in Paris from 15 October to 3 November 2001, at its 31st session,

Acknowledging the importance of underwater cultural heritage as an integral part of the cultural heritage of humanity and a particularly important element in the history of peoples, nations, and their relations with each other concerning their common heritage,

Realizing the importance of protecting and preserving the underwater cultural heritage and that responsibility therefor rests with all States,

Noting growing public interest in and public appreciation of underwater cultural heritage,

Convinced of the importance of research, information and education to the protection and preservation of underwater cultural heritage,

Convinced of the public's right to enjoy the educational and recreational benefits of responsible non-intrusive access to *in situ* underwater cultural heritage, and of the value of public education to contribute to awareness, appreciation and protection of that heritage,

Aware of the fact that underwater cultural heritage is threatened by unauthorized activities directed at it, and of the need for stronger measures to prevent such activities,

Conscious of the need to respond appropriately to the possible negative impact on underwater cultural heritage of legitimate activities that may incidentally affect it,

Deeply concerned by the increasing commercial exploitation of underwater cultural heritage, and in particular by certain activities aimed at the sale, acquisition or barter of underwater cultural heritage,

Aware of the availability of advanced technology that enhances discovery of and access to underwater cultural heritage,

Believing that cooperation among States, international organizations, scientific institutions, professional organizations, archaeologists, divers, other interested parties and the public at large is essential for the protection of underwater cultural heritage,

Considering that survey, excavation and protection of underwater cultural heritage necessitate the availability and application of special scientific methods and the use of suitable techniques and equipment as well as a high degree of professional specialization, all of which indicate a need for uniform governing criteria,

Realizing the need to codify and progressively develop rules relating to the protection and preservation of underwater cultural heritage in conformity with international law and practice, including the UNESCO Convention on the Means of Prohibiting and Preventing the Illicit Import, Export and Transfer of Ownership of Cultural Property of 14 November 1970, the UNESCO Convention for the Protection of the World Cultural and Natural Heritage of 16 November 1972 and the United Nations Convention on the Law of the Sea of 10 December 1982,

Committed to improving the effectiveness of measures at international, regional and national levels for the preservation *in situ* or, if necessary for scientific or protective purposes, the careful recovery of underwater cultural heritage,

Having decided at its twenty-ninth session that this question should be made the subject of an international convention,

Adopts this second day of November 2001 this Convention.

### **Article 1 – Definitions**

For the purposes of this Convention:

1. (a) “Underwater cultural heritage” means all traces of human existence having a cultural, historical or archaeological character which have been partially or totally under water, periodically or continuously, for at least 100 years such as:
  - (i) sites, structures, buildings, artefacts and human remains, together with their archaeological and natural context;
  - (ii) vessels, aircraft, other vehicles or any part thereof, their cargo or other contents, together with their archaeological and natural context; and
  - (iii) objects of prehistoric character.
- (b) Pipelines and cables placed on the seabed shall not be considered as underwater cultural heritage.
- (c) Installations other than pipelines and cables, placed on the seabed and still in use, shall not be considered as underwater cultural heritage.
2. (a) “States Parties” means States which have consented to be bound by this Convention and for which this Convention is in force.
- (b) This Convention applies *mutatis mutandis* to those territories referred to in Article 26, paragraph 2(b), which become Parties to this Convention in accordance with the conditions set out in that paragraph, and to that extent “States Parties” refers to those territories.

3. “UNESCO” means the United Nations Educational, Scientific and Cultural Organization.
4. “Director-General” means the Director-General of UNESCO.
5. “Area” means the seabed and ocean floor and subsoil thereof, beyond the limits of national jurisdiction.
6. “Activities directed at underwater cultural heritage” means activities having underwater cultural heritage as their primary object and which may, directly or indirectly, physically disturb or otherwise damage underwater cultural heritage.
7. “Activities incidentally affecting underwater cultural heritage” means activities which, despite not having underwater cultural heritage as their primary object or one of their objects, may physically disturb or otherwise damage underwater cultural heritage.
8. “State vessels and aircraft” means warships, and other vessels or aircraft that were owned or operated by a State and used, at the time of sinking, only for government non-commercial purposes, that are identified as such and that meet the definition of underwater cultural heritage.
9. “Rules” means the Rules concerning activities directed at underwater cultural heritage, as referred to in Article 33 of this Convention.

#### **Article 2 – Objectives and general principles**

1. This Convention aims to ensure and strengthen the protection of underwater cultural heritage.
2. States Parties shall cooperate in the protection of underwater cultural heritage.
3. States Parties shall preserve underwater cultural heritage for the benefit of humanity in conformity with the provisions of this Convention.
4. States Parties shall, individually or jointly as appropriate, take all appropriate measures in conformity with this Convention and with international law that are necessary to protect underwater cultural heritage, using for this purpose the best practicable means at their disposal and in accordance with their capabilities.
5. The preservation *in situ* of underwater cultural heritage shall be considered as the first option before allowing or engaging in any activities directed at this heritage.
6. Recovered underwater cultural heritage shall be deposited, conserved and managed in a manner that ensures its long-term preservation.
7. Underwater cultural heritage shall not be commercially exploited.

8. Consistent with State practice and international law, including the United Nations Convention on the Law of the Sea, nothing in this Convention shall be interpreted as modifying the rules of international law and State practice pertaining to sovereign immunities, nor any State's rights with respect to its State vessels and aircraft.

9. States Parties shall ensure that proper respect is given to all human remains located in maritime waters.

10. Responsible non-intrusive access to observe or document *in situ* underwater cultural heritage shall be encouraged to create public awareness, appreciation, and protection of the heritage except where such access is incompatible with its protection and management.

11. No act or activity undertaken on the basis of this Convention shall constitute grounds for claiming, contending or disputing any claim to national sovereignty or jurisdiction.

### **Article 3 – Relationship between this Convention and the United Nations Convention on the Law of the Sea**

Nothing in this Convention shall prejudice the rights, jurisdiction and duties of States under international law, including the United Nations Convention on the Law of the Sea. This Convention shall be interpreted and applied in the context of and in a manner consistent with international law, including the United Nations Convention on the Law of the Sea.

### **Article 4 – Relationship to law of salvage and law of finds**

Any activity relating to underwater cultural heritage to which this Convention applies shall not be subject to the law of salvage or law of finds, unless it:

- (a) is authorized by the competent authorities, and
- (b) is in full conformity with this Convention, and
- (c) ensures that any recovery of the underwater cultural heritage achieves its maximum protection.

### **Article 5 – Activities incidentally affecting underwater cultural heritage**

Each State Party shall use the best practicable means at its disposal to prevent or mitigate any adverse effects that might arise from activities under its jurisdiction incidentally affecting underwater cultural heritage.

**Article 6 – Bilateral, regional or other multilateral agreements**

1. States Parties are encouraged to enter into bilateral, regional or other multilateral agreements or develop existing agreements, for the preservation of underwater cultural heritage. All such agreements shall be in full conformity with the provisions of this Convention and shall not dilute its universal character. States may, in such agreements, adopt rules and regulations which would ensure better protection of underwater cultural heritage than those adopted in this Convention.
2. The Parties to such bilateral, regional or other multilateral agreements may invite States with a verifiable link, especially a cultural, historical or archaeological link, to the underwater cultural heritage concerned to join such agreements.
3. This Convention shall not alter the rights and obligations of States Parties regarding the protection of sunken vessels, arising from other bilateral, regional or other multilateral agreements concluded before its adoption, and, in particular, those that are in conformity with the purposes of this Convention.

**Article 7 – Underwater cultural heritage  
in internal waters, archipelagic waters and territorial sea**

1. States Parties, in the exercise of their sovereignty, have the exclusive right to regulate and authorize activities directed at underwater cultural heritage in their internal waters, archipelagic waters and territorial sea.
2. Without prejudice to other international agreements and rules of international law regarding the protection of underwater cultural heritage, States Parties shall require that the Rules be applied to activities directed at underwater cultural heritage in their internal waters, archipelagic waters and territorial sea.
3. Within their archipelagic waters and territorial sea, in the exercise of their sovereignty and in recognition of general practice among States, States Parties, with a view to cooperating on the best methods of protecting State vessels and aircraft, should inform the flag State Party to this Convention and, if applicable, other States with a verifiable link, especially a cultural, historical or archaeological link, with respect to the discovery of such identifiable State vessels and aircraft.

**Article 8 – Underwater cultural heritage in the contiguous zone**

Without prejudice to and in addition to Articles 9 and 10, and in accordance with Article 303, paragraph 2, of the United Nations Convention on the Law of the Sea, States Parties may regulate and authorize activities directed at underwater cultural heritage within their contiguous zone. In so doing, they shall require that the Rules be applied.

**Article 9 – Reporting and notification  
in the exclusive economic zone and on the continental shelf**

1. All States Parties have a responsibility to protect underwater cultural heritage in the exclusive economic zone and on the continental shelf in conformity with this Convention.

Accordingly:

- (a) a State Party shall require that when its national, or a vessel flying its flag, discovers or intends to engage in activities directed at underwater cultural heritage located in its exclusive economic zone or on its continental shelf, the national or the master of the vessel shall report such discovery or activity to it;
  - (b) in the exclusive economic zone or on the continental shelf of another State Party:
    - (i) States Parties shall require the national or the master of the vessel to report such discovery or activity to them and to that other State Party;
    - (ii) alternatively, a State Party shall require the national or master of the vessel to report such discovery or activity to it and shall ensure the rapid and effective transmission of such reports to all other States Parties.
2. On depositing its instrument of ratification, acceptance, approval or accession, a State Party shall declare the manner in which reports will be transmitted under paragraph 1(b) of this Article.
3. A State Party shall notify the Director-General of discoveries or activities reported to it under paragraph 1 of this Article.
4. The Director-General shall promptly make available to all States Parties any information notified to him under paragraph 3 of this Article.
5. Any State Party may declare to the State Party in whose exclusive economic zone or on whose continental shelf the underwater cultural heritage is located its interest in being consulted on how to ensure the effective protection of that underwater cultural heritage. Such declaration shall be based on a verifiable link, especially a cultural, historical or archaeological link, to the underwater cultural heritage concerned.

**Article 10 – Protection of underwater cultural heritage  
in the exclusive economic zone and on the continental shelf**

1. No authorization shall be granted for an activity directed at underwater cultural heritage located in the exclusive economic zone or on the continental shelf except in conformity with the provisions of this Article.
2. A State Party in whose exclusive economic zone or on whose continental shelf underwater cultural heritage is located has the right to prohibit or authorize any activity directed at such heritage to prevent interference with its sovereign rights or jurisdiction as provided for by international law including the United Nations Convention on the Law of the Sea.
3. Where there is a discovery of underwater cultural heritage or it is intended that activity shall be directed at underwater cultural heritage in a State Party's exclusive economic zone or on its continental shelf, that State Party shall:
  - (a) consult all other States Parties which have declared an interest under Article 9, paragraph 5, on how best to protect the underwater cultural heritage;
  - (b) coordinate such consultations as "Coordinating State", unless it expressly declares that it does not wish to do so, in which case the States Parties which have declared an interest under Article 9, paragraph 5, shall appoint a Coordinating State.
4. Without prejudice to the duty of all States Parties to protect underwater cultural heritage by way of all practicable measures taken in accordance with international law to prevent immediate danger to the underwater cultural heritage, including looting, the Coordinating State may take all practicable measures, and/or issue any necessary authorizations in conformity with this Convention and, if necessary prior to consultations, to prevent any immediate danger to the underwater cultural heritage, whether arising from human activities or any other cause, including looting. In taking such measures assistance may be requested from other States Parties.
5. The Coordinating State:
  - (a) shall implement measures of protection which have been agreed by the consulting States, which include the Coordinating State, unless the consulting States, which include the Coordinating State, agree that another State Party shall implement those measures;
  - (b) shall issue all necessary authorizations for such agreed measures in conformity with the Rules, unless the consulting States, which include the Coordinating State, agree that another State Party shall issue those authorizations;

- (c) may conduct any necessary preliminary research on the underwater cultural heritage and shall issue all necessary authorizations therefor, and shall promptly inform the Director-General of the results, who in turn will make such information promptly available to other States Parties.
6. In coordinating consultations, taking measures, conducting preliminary research and/or issuing authorizations pursuant to this Article, the Coordinating State shall act on behalf of the States Parties as a whole and not in its own interest. Any such action shall not in itself constitute a basis for the assertion of any preferential or jurisdictional rights not provided for in international law, including the United Nations Convention on the Law of the Sea.
7. Subject to the provisions of paragraphs 2 and 4 of this Article, no activity directed at State vessels and aircraft shall be conducted without the agreement of the flag State and the collaboration of the Coordinating State.

#### **Article 11 – Reporting and notification in the Area**

1. States Parties have a responsibility to protect underwater cultural heritage in the Area in conformity with this Convention and Article 149 of the United Nations Convention on the Law of the Sea. Accordingly when a national, or a vessel flying the flag of a State Party, discovers or intends to engage in activities directed at underwater cultural heritage located in the Area, that State Party shall require its national, or the master of the vessel, to report such discovery or activity to it.
2. States Parties shall notify the Director-General and the Secretary-General of the International Seabed Authority of such discoveries or activities reported to them.
3. The Director-General shall promptly make available to all States Parties any such information supplied by States Parties.
4. Any State Party may declare to the Director-General its interest in being consulted on how to ensure the effective protection of that underwater cultural heritage. Such declaration shall be based on a verifiable link to the underwater cultural heritage concerned, particular regard being paid to the preferential rights of States of cultural, historical or archaeological origin.

#### **Article 12 – Protection of underwater cultural heritage in the Area**

1. No authorization shall be granted for any activity directed at underwater cultural heritage located in the Area except in conformity with the provisions of this Article.
2. The Director-General shall invite all States Parties which have declared an interest under Article 11, paragraph 4, to consult on how best to protect the underwater cultural heritage, and to appoint a State Party to coordinate such consultations as the “Coordinating State”. The Director-General shall also invite the International Seabed Authority to participate in such consultations.

3. All States Parties may take all practicable measures in conformity with this Convention, if necessary prior to consultations, to prevent any immediate danger to the underwater cultural heritage, whether arising from human activity or any other cause including looting.
4. The Coordinating State shall:
  - (a) implement measures of protection which have been agreed by the consulting States, which include the Coordinating State, unless the consulting States, which include the Coordinating State, agree that another State Party shall implement those measures; and
  - (b) issue all necessary authorizations for such agreed measures, in conformity with this Convention, unless the consulting States, which include the Coordinating State, agree that another State Party shall issue those authorizations.
5. The Coordinating State may conduct any necessary preliminary research on the underwater cultural heritage and shall issue all necessary authorizations therefor, and shall promptly inform the Director-General of the results, who in turn shall make such information available to other States Parties.
6. In coordinating consultations, taking measures, conducting preliminary research, and/or issuing authorizations pursuant to this Article, the Coordinating State shall act for the benefit of humanity as a whole, on behalf of all States Parties. Particular regard shall be paid to the preferential rights of States of cultural, historical or archaeological origin in respect of the underwater cultural heritage concerned.
7. No State Party shall undertake or authorize activities directed at State vessels and aircraft in the Area without the consent of the flag State.

#### **Article 13 – Sovereign immunity**

Warships and other government ships or military aircraft with sovereign immunity, operated for non-commercial purposes, undertaking their normal mode of operations, and not engaged in activities directed at underwater cultural heritage, shall not be obliged to report discoveries of underwater cultural heritage under Articles 9, 10, 11 and 12 of this Convention. However States Parties shall ensure, by the adoption of appropriate measures not impairing the operations or operational capabilities of their warships or other government ships or military aircraft with sovereign immunity operated for non-commercial purposes, that they comply, as far as is reasonable and practicable, with Articles 9, 10, 11 and 12 of this Convention.

#### **Article 14 – Control of entry into the territory, dealing and possession**

States Parties shall take measures to prevent the entry into their territory, the dealing in, or the possession of, underwater cultural heritage illicitly exported and/or recovered, where recovery was contrary to this Convention.

### **Article 15 – Non-use of areas under the jurisdiction of States Parties**

States Parties shall take measures to prohibit the use of their territory, including their maritime ports, as well as artificial islands, installations and structures under their exclusive jurisdiction or control, in support of any activity directed at underwater cultural heritage which is not in conformity with this Convention.

### **Article 16 – Measures relating to nationals and vessels**

6. Энэ зүйлд заасны дагуу зөвлөгөөн зохион байгуулах, арга хэмжээ авч хэрэгжүүлэх, урьдчилсан судалгаа хийх болон/ эсхүл зөвшөөрөл олгохдоо тухайн Зохицуулагч улс өөрийн ашиг сонирхлын үүднээс бус, бүх Оролцогч Улсын өмнөөс үйл ажиллагаа явуулна. Ингэхдээ тухайн усан доорх соёлын өвтэй холбоотой соёл, түүх, археологийн үүсэл гаралд харьяалагдах улсын давуу эрхийг түлхүү анхаарч үзнэ.

7. Аль ч Оролцогч Улс харьяалалгүй орон зайд орших өөр улсын өмчийн хөлөг онгоц болон агаарын хөлөг рүү чиглэсэн ажиллагааг тухайн далбааны эзэн улсын зөвшөөрөлгүйгээр авч хэрэгжүүлэхийг хориглоно.

### 13 дугаар зүйл. Халдашгүй дархан эрх

Арилжааны бус зорилгоор өөрийн хэвийн горимоор ажиллаж, усан доорх соёлын өв рүү чиглэсэн ажиллагаанд оролцоогүй, халдашгүй дархан эрхтэй байлдааны хөлөг онгоц, төрийн өмчийн бусад хөлөг онгоц, байлдааны нисэх онгоц нь энэхүү Конвенцын 9, 10, 11, 12 дугаар зүйлийн дагуу усан доорх соёлын өвийг илрүүлсэн тухай мэдээлэх үүрэг хүлээхгүй. Гэхдээ арилжааны бус зорилгоор үйл ажиллагаа явуулж байгаа халдашгүй дархан эрхтэй байлдааны хөлөг онгоц, төрийн өмчийн бусад хөлөг онгоц болон байлдааны нисэх онгоцныхоо ашиглалт эсхүл ашиглах нөөц боломжийг алдагдуулахгүйгээр тухайн Оролцогч Улс нь эдгээр хөлөг онгоц болон нисэх онгоц энэхүү Конвенцын 9, 10, 11, 12 дугаар зүйлийн заалтыг дагаж мөрдүүлэх талаар боломжтой арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

### 14 дүгээр зүйл. Хилээр нэвтрэх, худалдах болон эзэмшихтэй холбоотой

#### хяналт

Оролцогч Улс бүр хууль бусаар экспортолсон болон /эсхүл энэхүү Конвенцод харшлах хэлбэрээр илрүүлсэн усан доорх соёлын өвийг өөрийн нутаг дэвсгэрт нэвтрүүлэх, худалдаалах, эзэмшихийг хориглох талаар арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

Монгол Улсын Гадаад харилцааны яам  
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН

Борисогийг Бүрэлдэглэл  
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia  
OFFICIAL TRANSLATION

### **15 дугаар зүйл. Оролцогч Улсуудын харьяалал дахь газрыг ашиглахгүй байх**

Оролцогч Улсууд өөрийн газар нутаг түүнд хамаарах далайн боомт, хиймэл арал, барилга, байгууламж зэрэг тусгай харьяалал, хяналттай газруудад усан доорх соёлын өвд чиглэсэн энэхүү Конвенцод үл нийцэх аливаа үйл ажиллагааг дэмжих, ашиглахыг хориглох арга хэмжээ авна.

### **16 дугаар зүйл. Иргэн болон хөлөг онгоцонд хамаарах арга хэмжээ**

Оролцогч Улс харьяат иргэн болон өөрийн далбаа бүхий хөлөг онгоц энэхүү Конвенцод харшлах хэлбэрээр усан доорх соёлын өвд чиглэсэн аливаа ажиллагаа явуулахгүй байх талаар боломжтой бүх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

### **17 дугаар зүйл. Хориг арга хэмжээ**

1. Энэхүү Конвенцын дагуу авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ зөрчигдсөн тохиолдолд Оролцогч Улс хориг арга хэмжээ авна.

2. Энэхүү Конвенцын хэрэгжилтийг үр дүнтэй болгох, аль ч газар зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, мөн зөрчил гаргасан этгээд хууль бус ажиллагаанаасаа ашиг олох боломжийг хаах үүднээс зөрчилд авах хориг арга хэмжээ хүнд, хөнгөнийг зохих түвшинд байлгахаар тогтооно.

3. Оролцогч Улсууд энэ зүйлийн дагуу авсан хориг арга хэмжээг хэрэгжүүлэхийн төлөө хамтран ажиллана.

### **18 дугаар зүйл. Усан доорх соёлын өвийг хураан авах, хадгалах**

1. Оролцогч Улс бүр өөрийн нутаг дэвсгэрийн хүрээнд энэхүү Конвенцод харшлах аливаа аргаар усан доороос гарган авсан соёлын өвийг хураан авах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2. Оролцогч Улс бүр энэхүү Конвенцын дагуу хураан авсан усан доорх соёлын өвийг бүртгэх, хамгаалах болон түүний тогтвортой байдлыг хадгалах талаар бүх талын зохих арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3. Оролцогч Улс бүр Конвенцын дагуу усан доорх соёлын өвийг хураан авсан талаар Ерөнхий захирал болон тухайн усан доорх соёлын өвтэй соёл, түүх эсхүл археологийн холбоо хамааралтай нь нотлогдсон бусад улсад мэдэгдэнэ.

4. Усан доорх соёлын өвийг хураан авсан Оролцогч Улс тухайн өвийн хадгалалт, хамгаалалт, судалгааны хэрэгцээ, тарж салсан цуглуулгын нэгдмэл цогц байдлыг хангах хэрэгцээ, үзэсгэлэн, боловсролын зориулалтаар олон нийтийн хүртээл болгох хэрэгцээг харгалзан үзэж, тухайн өвтэй соёл, түүх эсхүл археологийн холбоо хамааралтай нь нотлогдсон улсын сонирхлыг хүндэтгэж, олон нийтийн ашиг сонирхолд нийцүүлэн усан доорх соёлын өвийг нийтийн ашиг тусын төлөө хадгалж, ашиглана.



## 19 дүгээр зүйл. Хамтын ажиллагаа болон мэдээлэл солилцох

1. Оролцогч Улс энэхүү Конвенцын дагуу усан доорх соёлын өвийн хамгаалалт, удирдлагын хүрээнд ялангуяа хайгуул, малтлага, баримтжуулалт, хадгалалт, судалгаа болон өвийг танилцуулах зэрэг чиглэлээр хамтран ажиллаж, харилцан дэмжлэг үзүүлнэ.

2. Оролцогч Улс бүр энэхүү Конвенцын зорилгод нийцэх хүрээнд усан доорх соёлын өвийг илрүүлсэн тухай, өвийн байршил, Конвенцод үл нийцэх эсхүл Олон улсын хууль тогтоомжийг зөрчиж өвийг малтсан эсхүл усан доороос гарган авсан, холбогдох шинжлэх ухааны арга зүй, технологи, болон тухайн өвтэй холбоотой хууль эрхзүйн зохицуулалтын өөрчлөлтийн талаарх мэдээллийг Оролцогч Улсуудтай хуваалцах үүргийг хүлээнэ.

3. Усан доорх соёлын өвийг илрүүлсэн эсхүл түүний байршлыг тогтоосон талаар Оролцогч Улс хооронд, эсхүл ЮНЕСКО болон Оролцогч Улс хооронд солилцсон мэдээллийг ил болгох нь усан доорх тухайн соёлын өвийг хадгалж үлдээхэд аюул заналхийлэл учруулах эсхүл өөр хэлбэрээр эрсдэл үүсгэж байгаа бол тухайн мэдээллийг холбогдох Оролцогч Улсуудын дотоодын хууль тогтоомжид нийцүүлэх хүрээнд нууцалж, зөвхөн Оролцогч Улсын эрх бүхий байгууллагуудад танилцуулна.

4. Оролцогч Улс бүр энэхүү Конвенц эсхүл олон улсын эрх зүйн бусад хэмжээг зөрчин малтлага хийж эсхүл сэргээн авсан усан доорх соёлын өвийн талаарх мэдээллийг тараах, үүний дотор боломжтой бол олон улсын холбогдох мэдээллийн санг ашиглан түгээх талаар хэрэгжүүлж болох бүх талын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

## 20 дугаар зүйл. Олон нийтийн мэдлэг ойлголт

Оролцогч Улс бүр усан доорх соёлын өвийн үнэ цэн, ач холбогдол болон тус Конвенцын дагуу усан доорх соёлын өвийг хамгаалах ач холбогдлын талаар олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх боломжит арга хэмжээг авна.

## 21 дүгээр зүйл. Усан доорх археологийн сургалт

Оролцогч Улсууд усан доорх археологийн сургалтыг хүртээмжтэй байлгах, усан доорх соёлын өвийг хадгалж, хамгаалах арга техник болон тохиролцсон нөхцөлд усан доорх соёлын өвтэй холбоотой технологийг дамжуулах чиглэлээр хамтран ажиллана.

## 22 дугаар зүйл. Эрх бүхий байгууллага

1. Энэхүү Конвенцыг зохих түвшинд хэрэгжүүлэх үүднээс Оролцогч Улсууд усан доорх соёлын өвийн бүртгэл бий болгох, түүнийг хөтлөх болон шинэчлэх, усан доорх соёлын өвийг үр дүнтэйгээр хамгаалах, хадгалж үлдээх, нийтэд танилцуулах, харж хандах, мөн эрдэм шинжилгээний болон боловсролын зорилгоор эрх бүхий

Гарын үсэг /Signature/ .....

20...оны...сарын...өдөр  
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia  
OFFICIAL TRANSLATION

байгууллагыг үүсгэн байгуулж, эсхүл шаардлагатай тохиолдолд одоо байгаа байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлнэ.

2. Оролцогч Улсууд усан доорх соёлын өвтэй холбоотой эрх бүхий байгууллагын нэр, хаягийг Ерөнхий захиралд мэдэгдэнэ.

### **23 дугаар зүйл. Оролцогч Улсуудын хурал**

1. Ерөнхий захирал энэхүү Конвенц хүчин төгөлдөр болсноос хойш нэг жилийн дотор, цаашид хоёр жил тутамд нэгээс доошгүй удаа Оролцогч Улсуудын хурлыг зарлан хуралдуулна. Оролцогч Улсуудын олонхын хүсэлтээр Ерөнхий захирал Оролцогч Улсуудын Ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна.

2. Оролцогч Улсуудын хурлаар хурлын чиг үүрэг, хариуцлагын талаар шийдвэр гаргана.

3. Оролцогч Улсуудын хурал өөрийн үйл ажиллагааны Дүрмийг батална.

4. Оролцогч Улсуудын хурлаар Оролцогч Улсуудаас нэр дэвшүүлсэн шинжээчдээс бүрдсэн Шинжлэх ухаан, техникийн зөвлөх багийг газарзүйн тэгш хуваарилах зарчим болон жендэрийн тэнцвэрт байдалд нийцүүлэн байгуулж болно.

5. Шинжлэх ухаан, техникийн зөвлөх баг нь Конвенцын дүрмийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор гарах шинжлэх ухаан, техникийн чанартай асуудлаар Оролцогч Улсын хуралд зохих ёсны туслалцаа үзүүлнэ.

### **24 дүгээр зүйл. Конвенцын Нарийн бичгийн дарга нарын газар**

1. Ерөнхий захирал энэхүү Конвенцын Нарийн бичгийн дарга нарын газрын чиг үүргийг хариуцна.

2. Нарийн бичгийн дарга нарын газрын чиг үүрэг нь:

(a) 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан Оролцогч Улсуудын хурлыг зохион байгуулах;

(b) Оролцогч Улсуудын хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхэд Оролцогч Улсуудад дэмжлэг үзүүлэх.

### **25 дугаар зүйл. Маргааныг эв зүйгээр шийдвэрлэх**

1. Энэхүү Конвенцыг тайлбарлах, хэрэглэхтэй холбоотойгоор хоёр буюу түүнээс дээш Оролцогч Улсын хооронд гарсан аливаа маргааныг сайн санааны үндсэн дээр хэлэлцээр хийж эсхүл өөрсдийн сонгосон эв зүйгээр зохицуулах өөр аргаар шийдвэрлэнэ.

2. Эдгээр хэлэлцээ нь маргааныг зохих хугацаанд шийдвэрлээгүй тохиолдолд Оролцогч Улсуудын зөвшилцсөнөөр эвлэрүүлэн зуучлахыг хүсэж ЮНЕСКО-д хандаж болно.



3. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа зохион байгуулагдаагүй эсхүл эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр дүнд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд энэ Конвенцыг тайлбарлах, хэрэглэхтэй холбоотойгоор энэ Конвенцод Оролцогч Улсуудын хооронд үүссэн аливаа маргаанд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Далайн эрхзүйн байдлын тухай Конвенцод Оролцогч эсэхээс үл хамааран Нэгдсэн Үндэстний Байгууллагын Далайн эрх зүйн байдлын тухай Конвенцын XV хэсэгт заасан маргааныг шийдвэрлэх заалтыг ашиглан шаардлагатай зохицуулалтыг хийнэ.

4. Энэхүү Конвенцын болон Далайн эрх зүйн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенцын Оролцогч Улс Далайн эрх зүйн тухай НҮБ-ын Конвенцын 287 дугаар зүйлийн дагуу сонгосон журмыг энэ зүйлд дурдсан маргааныг шийдвэрлэх ажиллагаанд ашиглана. Тухайн Оролцогч Улс Далайн эрх зүйн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенцын 287 дугаар зүйлд заасны дагуу энэхүү Конвенцтой холбоотой үүсэх маргааныг шийдвэрлэх ажиллагаанд өөр журмыг энэхүү Конвенцыг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах эсхүл түүнд нэгдэн ороход эсхүл дараа нь сонгосон бол үүнд хамаарахгүй.

5. Далайн эрх зүйн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенцын оролцогч тал болоогүй энэхүү Конвенцын Оролцогч Улс нь энэхүү Конвенцыг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, эсхүл түүнд нэгдэн орохдоо эсхүл дараа нь Далайн эрх зүйн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенцын 287 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан аргуудаас аль нэгийг эсхүл хэд хэдийг энэ зүйлд заасан маргааныг шийдвэрлэх зорилгоор бичгээр мэдэгдэл гаргах замаар сонгох эрхтэй. 287 дугаар зүйл нь ийнхүү гаргасан мэдэгдлийн хувьд, түүнчлэн түүнд дурдагдаагүй боловч мэдэгдэл гаргасан тухайн Оролцогч Улс нэг тал нь болж байгаа бусад маргааны хувьд үйлчилнэ. Далайн эрх зүйн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенцын V болон VII хавсралтад заасан эвлэрүүлэх журам болон арбитрын шүүхийн зорилгын хүрээнд тухайн Оролцогч Улс нь энэхүү Конвенцтой холбоотой үүсэх маргааныг шийдвэрлэх эвлэрүүлэгч, арбитрын шүүгчийг V хавсралтын 2 дугаар зүйл болон VII хавсралтын 2 дугаар зүйлд дурдсан жагсаалтад оруулахаар нэрийг нь дэвшүүлэх эрхтэй.

## **26 дугаар зүйл. Соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах эсхүл нэгдэн орох**

1. ЮНЕСКО-ийн гишүүн улсууд энэхүү Конвенцыг соёрхон баталж, хүлээн зөвшөөрч, эсхүл батална.

2. Дараах этгээд энэхүү Конвенцод нэгдэж орно. Үүнд:

(a) ЮНЕСКО-ийн гишүүн биш боловч Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллага эсхүл Олон улсын атомын энергийн агентлагийн гишүүн улс, түүнчлэн Олон улсын шүүхийн дүрмийн Оролцогч Улс болон ЮНЕСКО-ийн Ерөнхий бага хурлаас энэхүү Конвенцод нэгдэн орохыг урьсан бусад улс;

b) Нэгдсэн Үндэстний Байгууллагаас хүлээн зөвшөөрснөөр дотоодоо өөрийгөө удирдах бүрэн эрхтэй боловч Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий ассамблейн 1514 (XV) тогтоолын дагуу тусгаар тогтнолоо бүрэн аваагүй байгаа ба...



энэхүү Конвенцоор зохицуулагдах аливаа асуудлаар шийдвэр гаргах, үүний дотор эдгээр асуудлаар олон улсын гэрээ байгуулах эрх мэдэлтэй нутаг дэвсгэр зэрэг хамаарна.

3. Конвенцыг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан болон түүнд нэгдэн орсон тухай баримт бичгийг Ерөнхий захиралд хадгалуулна.

### **27 дугаар зүйл. Хүчин төгөлдөр болох**

Энэхүү Конвенц нь 26 дугаар зүйлд дурдсан хорь дахь баримт бичгийг 20 дахь улс хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно, ингэхдээ баримт бичгээ хадгалуулсан хорин улс эсхүл нутаг дэвсгэрийн хүрээнд хүчин төгөлдөр болно. Харин бусад улсын хувьд тухайн улс баримт бичгийг хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно.

### **28 дугаар зүйл. Дотоодын усны тухай мэдэгдэл**

Энэхүү Конвенцыг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах эсхүл нэгдэн орох үед түүний дараа аль ч улс эсхүл нутаг дэвсгэр Дүрмийг далайн шинж чанартай биш дотоодын усанд мөрдөх тухай мэдэгдэж болно.

### **29 дүгээр зүйл. Газарзүйн хамрах хүрээний хязгаарлалт**

Конвенцыг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, нэгдэн орох үед тухайн улс эсхүл нутаг дэвсгэр, нутаг дэвсгэрийн тодорхой хэсэг, дотоодын ус, олтиргийн ус эсхүл харьяа тэнгист энэхүү Конвенц үйлчлэхгүй болохыг хадгалуулах баримт бичигт мэдэгдэх бөгөөд мөн энэ мэдэгдлийн шалтгааныг тодорхойлно. Мэдэгдэл гаргагч улс нь мэдэгдэлд заасан газар нутагт Конвенцын ашиглах хүрээ, нөхцөлийг аль болох хурдан, боломжтой хэмжээнд тодорхой болгох бөгөөд биелүүлсэн даруйд мэдэгдлийг бүхэлд нь эсхүл буюу хэсэгчлэн эгүүлэн татна.

### **30 дугаар зүйл. Тайлбар хийх**

29 дүгээр зүйлд зааснаас бусад тохиолдолд энэхүү Конвенцод тайлбар хийж үл болно.

### **31 дүгээр зүйл. Нэмэлт өөрчлөлт**

1. Оролцогч Улс Ерөнхий захиралд бичгээр мэдэгдэл хүргүүлэн энэхүү Конвенцод нэмэлт өөрчлөлт оруулах саналаа гаргаж болно. Ерөнхий захирал ийм мэдэгдлийг оролцогч бүх улсад хүргүүлнэ. Хэрэв ийм мэдэгдлийг хүргүүлсэн өдрөөс хойш зургаан сарын дотор Оролцогч Улсын тэн хагасаас доошгүй хувь нь дэмжсэн хариу өгсөн бол Ерөнхий захирал нэмэлт өөрчлөлт оруулах саналыг хэлэлцүүлж, батлуулахаар Оролцогч Улсын ээлжит хуралд тухайн саналыг танилцуулна.

2. Нэмэлт өөрчлөлтийг санал хураалтад оролцсон нийт Оролцогч Улсын гуравны хоёрын саналаар батална.



3. Энэхүү Конвенцод оруулах нэмэлт өөрчлөлтийг баталсны дараа Оролцогч Улсууд түүнийг соёрхон баталж, хүлээн зөвшөөрч, баталж эсхүл түүнд нэгдэн орно.

4. Нэмэлт өөрчлөлт нь энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан баримт бичгийг Оролцогч Улсын гуравны хоёр нь хадгалуулахаар өгснөөс хойш гурван сарын дараа түүнийг соёрхон баталж, хүлээн зөвшөөрч, баталж эсхүл түүнд нэгдэн орсон Оролцогч Улсын хувьд хүчин төгөлдөр үйлчилнэ. Үүнээс хойш нэмэлт өөрчлөлт нь түүнийг соёрхон баталж, хүлээн зөвшөөрч, баталж эсхүл түүнд нэгдэн орсон улс эсхүл нутаг дэвсгэр холбогдох баримт бичгээ хадгалуулахаар өгснөөс хойш гурван сарын дараа тухайн улс эсхүл нутаг дэвсгэрийн хувьд хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ.

5. Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр болсны дараа энэхүү Конвенцын оролцогч тал болсон аливаа улс эсхүл нутаг дэвсгэр өөрөөр хүсэл зорилго илэрхийлээгүй бол тухайн улс эсхүл нутаг дэвсгэрийг:

(a) Нэмэлт өөрчлөлт оруулсан Конвенцын Оролцогч тал; болон

(b) нэмэлт өөрчлөлтийг зөвшөөрөөгүй аливаа Оролцогч Улсын хувьд нэмэлт өөрчлөлт ороогүй конвенцын оролцогч тал болно гэж тус тус авч үзнэ.

### 32 дугаар зүйл. Цуцлах

1. Оролцогч Улс энэхүү Конвенцыг цуцалсан тухайгаа бичгээр үйлдэж Ерөнхий захиралд хадгалуулна.

2. Цуцлах өдрийг мэдэгдэлд өөрөөр заагаагүй тохиолдолд цуцалсан тухай мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш арван хоёр сарын дараа цуцлалт хүчин төгөлдөр болно.

3. Конвенцыг цуцлах нь аливаа Оролцогч Улсад уг Конвенцод тусгагдсан олон улсын эрх зүйн хүрээнд хамаарах аливаа үүргээ биелүүлэхэд нөлөөлөхгүй.

### 33 дугаар зүйл. Дүрэм

Энэхүү Конвенцын хавсралтад орсон Конвенцын дүрэм нь түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг болох бөгөөд өөрөөр шууд заагаагүй тохиолдолд энэхүү Конвенцыг иш татсан бол конвенцын дүрмийг мөн иш татсан гэж үзнэ.

### 34 дүгээр зүйл. Нэгдсэн Үндэстний Байгууллагад бүртгүүлэх

Нэгдсэн үндэстний байгууллагын дүрмийн 102 дугаар зүйлийн дагуу энэхүү Конвенцыг ЮНЕСКО-ийн Ерөнхий захирлын хүсэлтээр Нэгдсэн үндэстний байгууллагын Нарийн бичгийн дарга нарын газарт бүртгүүлнэ.

### 35 дугаар зүйл. Эх бичвэрүүд адил хүчинтэй байх

Энэхүү Конвенцыг Араб, Хятад, Англи, Франц, Орос болон Испани хэл дээр үйлдсэн бөгөөд эдгээр зургаан эх бичвэр нь адил хүчинтэй байна.



## УСАН ДООРХ СОЁЛЫН ӨВД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ

### I. Ерөнхий зарчим

Дүрэм 1. Усан доорх соёлын өвийг оршин буй газарт нь хадгалж, хамгаалахыг хадгалалт, хамгаалалтын эхний сонголт гэж үзнэ. Энэ дагуу усан доорх соёлын өвд чиглэсэн үйл ажиллагааг тухайн өвийг хамгаалахтай нийцүүлэн зөвшөөрөх бөгөөд усан доорх соёлын өвийг хамгаалах, эсхүл мэдлэг ойлголт, эсхүл нөхцөл байдлыг сайжруулахад үнэмлэхүй хувь нэмэр оруулах зорилго бүхий үйл ажиллагаанд зөвшөөрөл олгож болно.

Дүрэм 2. Усан доорх соёлын өвийг худалдах эсхүл ашиг хонжоо олох зорилгоор эсхүл эргэн нөхөгдөшгүйгээр тараан задруулах нь тухайн өвийг хамгаалах, зохистой удирдах зарчимтай нийцэхгүй. Усан доорх соёлын өвийг арилжааны бараа болгон худалдах, зарах, худалдаж авах, солилцохыг хориглоно.

Энэ дүрмийг дараах зүйлийг хориглох зорилгоор тайлбарлахгүй:

(a) Зорилго, чиглэл нь энэхүү Конвенцод бүрэн нийцсэн, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэй археологийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх эсхүл үүнтэй холбоотой шаардлагатай үйл ажиллагаа явуулах арга хэмжээ авах;

(b) Конвенцын дагуу зохион байгуулагдсан судалгааны явцад гарган авсан усан доорх соёлын өвийн үлдцийг Дүрмийн 33 болон 34 дэх хэсэгт заасны дагуу эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр түүний шинжлэх ухаан эсхүл соёлын ач холбогдол, гарган авсан материалын бүрэн бүтэн байдал эсхүл эргэн нөхөгдөшгүй байдалд нөлөөлөхгүй байхаар хадгална.

Дүрэм 3. Усан доорх соёлын өвд чиглэсэн ажиллагаа нь төслийн зорилгод шаардагдах хэмжээнээс илүүтэйгээр тухайн усан доорх соёлын өвд сөрөг нөлөөлөл үзүүлэхийг хориглоно.

Дүрэм 4. Усан доорх соёлын өвд чиглэсэн ажиллагаанд олдворыг гарган авснаас илүү түүнд гэмтэл учруулахгүй байх техник хэрэгсэл болон судалгааны арга зүйг түлхүү ашиглана. Усан доорх соёлын өвийн талаар шинжлэх ухааны судалгаа хийх эсхүл түүнийг цаашдаа хамгаалах зорилгоор малтлага хийж гаргах эсхүл уснаас гарган авах шаардлагатай байгаа бол ашиглагдах арга зүй, техник хэрэгсэл нь тухайн олдворт аль болох гэмтэл учруулахгүй ба түүнийг хадгалж үлдээхэд хувь нэмэр үзүүлэхээр байна.

Дүрэм 5. Усан доорх соёлын өвд чиглэсэн үйл ажиллагаа нь хүний биеийн үлдэгдэл эсхүл сүсэг бишрэл бүхий дурсгалт газруудад эвдрэл учруулахаас зайлсхийнэ.

Дүрэм 6. Усан доорх соёлын өвд чиглэсэн үйл ажиллагааг соёл, түүхийн болон археологийн мэдээллийг зохих ёсоор баримтжуулах зорилгоор хатуу журамлана.



Дүрэм 7. Хамгаалалт, менежменттэй нийцэхгүйгээс бусад тохиолдолд анх байрлаж буй усан доорх соёлын өвийн дурсгалт газрыг олон нийтийн хүртээл болгохыг дэмжинэ.

Дүрэм 8. Археологичид болон бусад холбогдох мэргэжилтнүүдийн үр дүнтэй солилцоо, усан доорх соёлын өвд чиглэсэн үйл ажиллагаанд татан оролцуулах зорилгоор усан доорх соёлын өвд чиглэсэн олон улсын хамтын ажиллагааг дэмжинэ.

## II. Төслийн баримт бичиг

Дүрэм 9. Усан доорх соёлын өвд чиглэсэн аливаа үйл ажиллагааг явуулахаас өмнө тухайн үйл ажиллагааны төслийн баримт бичгийг боловсруулж, эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авч болон зохих хөндлөнгийн хяналт үнэлгээг хийлгэнэ.

Дүрэм 10. Төслийн загвар дараах бүрдэлтэй байна:

- (a) Өмнөх эсхүл урьдчилсан судалгааны үнэлгээ;
- (b) Төслийн агуулга болон зорилго;
- (c) Ашиглах арга зүй болон техник;
- (d) Санхүүжүүлэх эх үүсвэр;
- (e) Төслийн дуусгавар болгох хугацаа;
- (f) Багийн бүрэлдэхүүн, багийн гишүүн бүрийн мэргэшил, үүрэг хариуцлага болон туршлага;
- (g) Хээрийн судалгааны ажлын дараах судалгаа шинжилгээ болон бусад үйл ажиллагааны төлөвлөгөө;
- (h) Эрх бүхий байгууллагатай нягт хамтарч, эд өлгийн зүйл болон дурсгалт газрыг хадгалж, хамгаалах хөтөлбөр;
- (i) Төслийг хэрэгжүүлэх хугацаан дахь дурсгалт газрын менежмент болон арчилгааны бодлого;
- (j) Баримтжуулалтын хөтөлбөр;
- (k) Аюулгүй байдлын бодлого;
- (l) Байгаль орчны бодлого;
- (m) Музей болон бусад байгууллагууд, ялангуяа шинжлэх ухааны байгууллагатай хамтран ажиллах зохицуулалт;
- (n) Тайлан боловсруулах;
- (o) Архив, үүний дотор уснаас гарган авсан соёлын өвийг хадгалуулахаар хүлээлгэн өгөх ажиллагаа; болон
- (p) Хэвлэн нийтлэх хөтөлбөр зэрэг орно.

Дүрэм 11. Эрх бүхий байгууллагаас баталсан төслийн баримт бичгийн дагуу усан доорх соёлын өвд чиглэсэн ажиллагааг хийж гүйцэтгэнэ.

Дүрэм 12. Гэнэтийн нээлт хийх эсхүл нөхцөл байдал өөрчлөгдөх тохиолдолд эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр төслийн баримт бичгийг дахин нягталж, нэмэлт өөрчлөлт оруулна.

Дүрэм 13. Усан доорх соёлын өвд чиглэсэн үйл ажиллагаа, яаралтай эсхүл санамсаргүй байдлаар илэрсэн нээлтийн үед түүнийг богино хугацаанд хадгалах...



арга хэмжээ авах, эсхүл үйл ажиллагаа явуулах, ялангуяа дурсгалт газрыг тогтворжуулах, усан доорх соёлын өвийг хамгаалах зорилгоор төслийн баримт бичигт байхгүй үйл ажиллагаанд зөвшөөрөл өгч болно.

### III. Бэлтгэл ажил

Дүрэм 14. Дүрэм 10 (а) -д дурдсан урьдчилсан ажлын үнэлгээнд усан доорх соёлын өвийн ач холбогдол болон эмзэг байдал, төсөл хэрэгжсэнээр байгаль орчинд үзүүлэх эвдрэл гэмтэл, төслийн зорилгод нийцсэн мэдээлэл олж авах боломж зэргийг багтаана.

Дүрэм 15. Мөн үнэлгээнд түүх, археологийн баримтад холбогдох судалгаа, дурсгалт газрын археологи болон хүрээлэн буй орчны шинж чанар, аливаа үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн усан доорх соёлын өвийн урт хугацааны тогтвортой байдалд учирч болзошгүй үр дагаврыг оруулна.

### IV. Төслийн зорилго, арга зүй болон техник

Дүрэм 16. Арга зүй нь төслийн зорилгод нийцсэн байх ёстой бөгөөд ашигласан техник нь аль болох нөлөөлөл үзүүлэхгүй байх ёстой.

### V. Санхүүжилт

Дүрэм 17. Усан доорх соёлын өвийг хамгаалах яаралтай тохиолдлоос бусад тохиолдолд гарган авсан аливаа олдворыг хадгалж, хамгаалах, баримтжуулах, сан хөмрөгт авах, тайлан боловсруулах болон түгээн дэлгэрүүлэх зэрэг төслийн бүх үе шатыг дуусгахад хангалттай санхүүгийн үүсвэрийг аливаа үйл ажиллагааны өмнө баталгаажуулсан байна.

Дүрэм 18. Төслийн баримт бичиг нь төсөл хэрэгжиж дуусах хүртэл түүнийг санхүүжүүлэх, тухайлбал, бонд гаргах боломжийг нотлон харуулсан байна.

Дүрэм 19. Төслийн загварт хүлээгдэж буй санхүүжилт тасалдсан тохиолдолд дэмжих баримт бичиг болон усан доорх соёлын өвийг хадгалж, хамгаалах болзошгүй арга хэмжээний төлөвлөгөө багтсан байна.

### VI. Төслийн үргэлжлэх хугацаа – Цагийн хуваарь

Дүрэм 20. Усан доороос гарган авсан олдворыг хадгалах, баримтжуулах, эмхлэх, тайлан бэлтгэх, түгээн дэлгэрүүлэх зэрэг төслийн баримт бичигт тусгагдсан усан доорх соёлын өвд чиглэсэн бүхий л үе шатыг дуусгавар болгохыг баталгаажуулж, цаг хугацааг хангалттай төлөвлөх ёстой.

Дүрэм 21. Төслийн баримт бичиг нь төслийг зогсоох эсхүл цуцлах үед усан доорх соёлын өв болон түүнтэй холбоотой баримт бичгийг хадгалж үлдээх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний нөөц төлөвлөгөөг багтаасан байна.



## VII. Ур чадвар, мэргэшил

Дүрэм 22. Усан доорх соёлын өвд чиглэсэн үйл ажиллагааг зөвхөн төсөлд тохирсон шинжлэх ухааны ур чадвартай, усан доорх археологиор мэргэшсэн хүний байнгын удирдлага, хяналт дор зохион байгуулна.

Дүрэм 23. Төслийн багийн бүх гишүүд төсөлд гүйцэтгэх үүрэгтээ тохирсон мэргэжлийн ур чадвартай байх бөгөөд түүнийгээ нотлон харуулсан байна.

## VIII. Хадгалалт болон дурсгалт газрын менежмент

Дүрэм 24. Хадгалалтын хөтөлбөр нь усан доорх соёлын өвд чиглэсэн үйл ажиллагааны үеэр болон тээвэрлэлтийн явцад, мөн урт хугацааны туршид археологийн олдворын хадгалалт, хамгаалалтын арга зүйг хангана. Хадгалалт, хамгаалалтыг хүчин төгөлдөр үйлчилж байгаа мэргэжлийн стандартын дагуу гүйцэтгэнэ.

Дүрэм 25. Дурсгалт газрын менежментийн хөтөлбөр нь судалгааны ажил хийх явцад болон дууссаны дараа анх олдсон газраа буй усан доорх соёлын өвийг хамгаалах, удирдах ажлыг хангах ёстой. Хөтөлбөрт олон нийтэд зориулсан мэдээлэл, дурсгалт газрыг тогтворжуулах, хяналт тавих болон хөндлөнгийн оролцооноос хамгаалах талаар зохих заалтыг тусгасан байна.

## IX. Баримтжуулалт

Дүрэм 26. Баримтжуулалтын хөтөлбөр нь археологийн баримтжуулалтын одоо үйлчилж байгаа мэргэжлийн стандартын дагуу усан доорх соёлын өвд чиглэсэн үйл ажиллагааны явцын тайлан зэрэг баримтжуулалтыг бүрдүүлнэ.

Дүрэм 27. Баримтжуулахдаа усан доорх соёлын өв рүү чиглэсэн ажиллагааны явцад нүүлгэн шилжүүлсэн эсхүл уснаас гарган авсан усан доорх соёлын өвийн гарал үүслийн талаарх мэдээлэл, хээрийн тэмдэглэл, төлөвлөгөө, схем зураг, зүсэлтийн зураг болон бусад эх үүсвэрт агуулагдах гэрэл зураг эсхүл бичлэг зэрэг эргэн тойрны газрын талаарх иж бүрэн баримтыг заавал бүрдүүлсэн байна.

## X. Аюулгүйн ажиллагаа

Дүрэм 28. Аюулгүйн ажиллагааны дүрмийг төслийн баг болон гуравдагч этгээдийн аюулгүй байдал болон эрүүл мэндийг зохих ёсоор хамгаалсан, мөн хүчин төгөлдөр байгаа хууль тогтоомж болон мэргэжлийн байгууллагын шаардлагад нийцсэн байхаар боловсруулна.

## XI. Байгаль орчин

Дүрэм 29. Далайн ёроол, далайн амьдралыг зүй бусаар хөндөхгүй байхад чиглэсэн байгаль орчны зохих бодлогыг боловсруулна.



## XII. Тайлагнах

Дүрэм 30. Төслийн ажлын хуваарьт заасны дагуу завсрын болон эцсийн тайланг боловсруулж, холбогдох нийтийн архивын албанд хадгалуулна.

Дүрэм 31. Тайланд дараах мэдээллийг багтаана. Үүнд:

- (a) Зорилгын тайлан;
- (b) Ашигласан арга зүй, техникийн тайлан;
- (c) Хүрсэн үр дүнгийн тайлан;
- (d) Үйл ажиллагааны бүх үе шатыг харуулсан анхан шатны бүдүүвч болон гэрэл зургийн баримтжуулалт;
- (e) Дурсгалт газрын болон нүүлгэн шилжүүлсэн усан доорх соёлын өвийн хадгалалт, бүртгэлийн талаарх зөвлөмж; болон
- (f) Ирээдүйн үйл ажиллагааны зөвлөмж.

## XIII. Төслийн архивыг хадгалах

Дүрэм 32. Төслийн архивын хадгалалт, зохион байгуулалтыг аливаа үйл ажиллагаа эхлэхээс өмнө зөвшилцөж, төслийн төлөвлөгөөнд тусгасан байна.

Дүрэм 33. Уснаас гарган авсан аливаа усан доорх соёлын өв орсон төслийн архив болон түүнтэй холбоотой бүх баримт бичгийн хуулбарыг цуглуулаг хэлбэрээр аль болох хамт цуг, иж бүрэн байхаар, мөн мэргэжилтнүүд болон олон нийт танилцах боломжтой байхаар архивын бүрэн байдлыг хангаж хадгална. Энэ ажлыг усан доорх соёлын өвийг хадгалж үлдээх зорилгод зохих ёсоор нийцүүлэн ямар ч тохиолдолд төсөл хэрэгжүүлж дууссанаас хойш 10 жилийн дотор аль болох хурдан хугацаанд хийж гүйцэтгэнэ.

Дүрэм 34. Төслийн архивыг олон улсын мэргэжлийн стандартын дагуу удирдан зохицуулах бөгөөд зөвшөөрлийг эрх бүхий байгууллага олгоно.

## XIV. Түгээн дэлгэрүүлэлт

Дүрэм 35. Төсөл нь олон нийтийн боловсролыг нэмэгдүүлэх, төслийн үр дүнг нийтийн хүртээл болгох зорилгыг агуулсан байна.


Дүрэм 36. Төслийн эцсийн бүрдлийг:

(a) төслийн нарийвчлал, нууцлал эсхүл мэдээлэл эмзэг байх шинжийг харгалзан үзсэний үндсэн дээр аль болох богино хугацааны дотор хэвлэн нийтэлж; мөн

(b) холбогдох олон нийтийн архивын газарт хадгалуулахаар өгнө.

Дээрх нь Парис хотноо хуралдаж, 2001 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр өндөрлөсөн Нэгдсэн Үндэстний Боловсрол, соёл шинжлэх ухаан болон соёлын байгууллагын Ерөнхий бага хурлын 31 дүгээр чуулганаар батлагдсан Конвенцын жинхэнэ эх бичвэр болно.

Дээрхийг гэрчилж 2001 оны 11 дүгээр сарын 6-ны өдөр гарын үсэг зурав.



**УСАН ДООРХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ  
ЮНЕСКО-ИЙН 2001 ОНЫ КОНВЕНЦЫГ СОЁРХОН  
БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЦЭЭ,  
ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН  
ТАНДАН СУДЛАХ СУДАЛГАА**

**2022**

**СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

Бүртгэлийн дугаар .....

Нууцын зэрэглэл ...

Гэрээний дугаар *СоЯ-21/425*

**“УСАН ДООРХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ЮНЕСКО-ИЙН  
2001 ОНЫ КОНВЕНЦЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН  
ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН  
ТАНДАН СУДЛАХ СУДАЛГАА”  
*захиалгат ажлын тайлан***

Төслийн гүйцэтгэгч:

МУИС-ийн ХЗС-ийн доктрант, Ч.Доржсүрэн

Хууль зүйн ухааны доктор (Ph.D), Х.Эрдэм-Ундрах

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн  
Эрдэм шинжилгээний ажилтан, Х.Буянбат

Тайланг хянаж,  
баталгаажуулсан:

Захиалагч байгууллага:

Соёлын яам, Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг  
зохицуулах газар

Тайлан өмчлөгч:

Монгол Улсын Соёлын Яам

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 7-р хороо,  
Денверийн гудамж

Утас: 51265622/51265626

Цахим шуудан: [info@moc.gov.mn](mailto:info@moc.gov.mn)

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

НҮБ

Нэгдсэн Үндэсний Байгууллага

УИХ

Улсын Их Хурал

ЮНЕСКО

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, Шинжлэх  
Ухаан, Соёлын Байгууллага.

БНСУ

Бүгд Найрамдах Солонгос Улс

## ӨРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Үндсэн Хуулийн оршил хэсэгт “төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг илдэндигнан өвлөж” гэж, Долдугаар зүйлийн нэгт “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна.” хэмээн тус тус заажээ. Үндсэн Хэм хэмжээ, хийгээд Үндсэн хуульдаа ийнхүү заасны учир манай улс түүх, соёл, түүнд Хамаарах бүхий л өвийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг буй болгон ирээдүй хойчдоо Өвлүүлэн үлдээх үүрэгтэй.

Монгол Улсын Их Хурлын 2012 оны 52 дугаар тогтоолоор “Төрөөс соёлын талаар Баримтлах бодлого”-ыг баталсан бөгөөд тус бодлогын зорилгыг “соёлын үнэт зүйлийг иргэд Бүтээн бий болгох, хүртэх, эзэмших, уламжлах болон соёлын өвийг найдвартай хадгалах, хамгаалах орчин нөхцөлийг бүрдүүлэх, уламжлалт соёлоо дэлхий нийтэд сурталчлан таниулах, үндэсний хөгжилд соёлын эзлэх байр суурь, оруулах хувь нэмэр, үр ашгийг дээшлүүлэх...” хэмээн тодорхойлсон байдаг. Соёлын өвийг хамгаалах тухай эрх зүйн зохицуулалтын хувьд өдгөө хүчин төгөлдөр үйлчилж буй 2014 онд батлагдсан Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн шинэчлэн найруулгаар соёлын өвийг сурвалжлан олох, бүртгэх, ангилал тогтоох, археологи, палеоантропологи, палентологийн хайгуул, малтлага, судлах хийх, сурталчлах, хадгалж хамгаалах, сэргээн засварлах, өмчлөх, эзэмших, ашиглах, хилээр нэвтрүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж байна.

Гэвч тус хуулиар усан доорх соёлын өвийн тухай, түүнтэй холбогдсон аливаа харилцааг зохицуулаагүй байна. Нийтийн тооллын өмнөх үед хамаарах Хүннү улсаас Монголын Эзэнт Гүрэн хүртэлх манай улсын түүхийн ул мөр болсон соёлын өв нь дэлхийд өргөн тархсан бөгөөд энэ нь дан ганц газар дээрх болон газар доорх орон зайгаар үл хязгаарлагдах билээ. Ийм учир усан доорх соёлын өвийг хадгалан хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, хууль бус худалдаа, малтлагаас сэргийлэх нөхцөлийг бий болгох нь зүйтэй.

ЮНЕСКО-ийн 2001 оны Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенц нь усан доорх соёлын өвийг хамгаалах үндсэн зарчмуудыг тодорхойлж, улс орнуудын хамтын ажиллагааны нарийвчилсан тогтолцоог бий болгох, усан доорх соёлын өвийг сэргээх, судлахад хүлээн зөвшөөрөгдсөн жишиг буй болгох зорилготой олон улсын гэрээ юм.

Дээрхтэй холбоотойгоор 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 12 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 1.13 дахь хэсэгт заасны дагуу “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцыг соёрхон батлах тухай” хуулийн төслийг боловсруулж, 2023 онд Улсын Их Хуралд өргөн барихаар төлөвлөсөн. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.3.6-д “Соёлын өвийг хамгаалах олон улсын гэрээ хэлэлцээрт нэгдэн орох асуудлыг судалж шийдвэрлүүлнэ” гэж, 2.6.3.7-д “соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх зорилгоор хууль, эрх зүйн орчныг сайжруулна” хэмээн тус тус заасан байна.

Мөн түүнчлэн тус конвенц нь Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу заавал соёрхон батлах зохицуулалт бүхий олон талт олон улсын гэрээ мөн учир Монгол Улсын Их Хурлаар соёрхон батлуулах шаардлагатай.

Иймд “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийг соёрхон батлах тухай” хуулийн хэрэгцээ, шаардлага бий эсэхийг судлах шаардлагатай хэмээн үзэж тус судалгааг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар

Батлагдсан хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын дагуу гүйцэтгэлээ.

### **Судалгааны аргачлал**

Тус судалгааг гүйцэтгэхдээ Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор батлагдсан аргачлалын дагуу дараах үе шаттайгаар гүйцэтгэв.

1. Асуудалд дүн шинжилгээ хийх
2. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг томъёолох
3. Тухайн асуудлуудыг зохицуулах хувилбаруудыг тогтоож тэдгээрийн эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах
4. Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судлах
5. Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулж дүгнэлт хийх
6. Зохицуулалтын талаарх олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгааг хийх
7. Зөвлөмж боловсруулах

### **УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын<sup>1</sup> 2.1-т заасан үе шатны дагуу хийж гүйцэтгэлээ.

#### **НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ**

ЮНЕСКО-гийн Бээжин дэх төлөөлөгчийн газар, ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комисс 2003 онд хамтран зохион байгуулсан “Соёлын үнэт зүйлсийг хууль бусаар хилээр гаргах, оруулах, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх тухай бүсийн сургалт семинар”-ийн төлөөлөгчдөөс ЮНИДРУА-гийн 1995 оны Конвенц болон ЮНЕСКО-гийн 2001 оны “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай” Конвенцод Монгол улсыг боломжийн богино хугацаанд нэгдэн орох асуудлыг тавьж шийдвэрлүүлэх<sup>2</sup> талаар анх Монгол Улсын Засгийн газарт зөвлөмж болгосон. Мөн “Соёлын эд зүйлсийн хууль бус худалдаатай тэмцэх чадавх дээшлүүлэх” ЮНЕСКО-гийн төслийн хүрээнд Монакогийн Итгэлцлийн сангийн санхүүжилтээр зохион байгуулсан сургалт хэлэлцүүлгээс Монгол Улсын Засгийн газарт хандан гарсан 2011 оны Үндэсний Зөвлөмжид ЮНИДРУА-гийн 1995 оны Конвенц болон ЮНЕСКО-гийн 2001 оны Усан доорхи соёлын өвийг хамгаалах тухай Конвенцод Монгол улсыг хугацаа алдалгүй нэгдэн орох асуудлыг шийдвэрлүүлэх<sup>3</sup> тухай тусгажээ.

2021 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 12 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 1.13 дахь хэсэгт заасны дагуу “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцыг соёрхон батлах тухай” хуулийн төслийг боловсруулж, 2023 онд Улсын Их Хуралд өргөн барихаар төлөвлөсөн байна. Ийнхүү

<sup>1</sup> Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоол. Нэгдүгээр хавсралт.

<sup>2</sup> “Соёлын үнэт зүйлсийг хууль бусаар хилээр гаргах, оруулах, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх тухай бүсийн сургалт семинар” эмхтгэл, УБ хот. 2003 он. 7 дахь тал.

<sup>3</sup> “ЮНЕСКО-Монакогийн хамтын ажиллагаа” Соёлын эд зүйлсийн хууль бус худалдаатай тэмцэх чадавх дээшлүүлэх төсөл. Үр дүнгийн Тайлан 2009-2011 (I үе шат). УБ хот 2013 он. 22 дахь тал.

Төлөвлөхдөө хууль санаачлагч нь Засгийн Газар, хариуцан боловсруулах байгууллага нь Соёлын яам байхаар тодорхойлжээ. Тус хуулийн төслийг боловсруулах үндэслэл, зохицуулах харилцааны тухайд товч байдлаар “Усан доорх соёлын өвийг хадгалан хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, хууль бус худалдаа, малтлагаас сэргийлэх нөхцөлийг бий болгох.” хэмээсэн байна<sup>4</sup>. “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийг 2015 оны 5 дугаар сарын 29-ний өдөр батлагдсан “Хууль тогтоомжийн тухай хууль/Шинэчилсэн найруулга/”-ийн 7 дугаар зүйлийн 7.1-д үндэслэсэн байна. Тус хэсэг буюу 7.1-д “Үндсэн чиглэлийн төслийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал хэлэлцэн батална” гэж заасан байх ба мөн 7.1, 7.2, 7.3-т Засгийн газар тухайн бүрэн эрхийнхээ хугацаанд санаачлах хууль тогтоомжийн талаар урьдчилан төлөвлөж, хууль тогтоомжийг боловсронгуй болгох Үндсэн чиглэлд тусгах, Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох байгууллагын саналыг авч, нэгтгэн судалсны үндсэн дээр Үндсэн чиглэлийн төслийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн боловсруулах, Үндсэн чиглэлийн төсөлд санал өгөх байгууллага нь нийгмийн тухайн харилцааг зохицуулж байгаа хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр уг асуудлаар шинээр хууль гаргах, эсхүл хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлагыг тодорхойлох харилцаануудыг зохицуулжээ.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.3.6-д “Соёлын өвийг хамгаалах олон улсын гэрээ хэлэлцээрт нэгдэн орох асуудлыг судалж шийдвэрлүүлнэ” гэж<sup>5</sup>, 2.6.3.7-д “соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх зорилгоор хууль, эрх зүйн орчныг сайжруулна” хэмээн тус тус заасан байна.

Соёлын өвийг хамгаалах тухай эрх зүйн зохицуулалтын хувьд анх 1970 онд “БНМАУ-ын Соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль” батлагдаж хожим нь 1994 онд “Монгол Улсын түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах хууль” батлагдсаныг 2001 онд “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” нэртэйгээр шинэчлэн баталж, түүх, соёлын дурсгалт зүйл гэдэг ухагдахууныг шинжлэх ухаан, урлаг, эрх зүйн үүднээс нарийвчлан тодорхойлж, түүх, соёлын дурсгалыг сурвалжлан олох, бүртгэх, зэрэглэл тогтоох, археологи, палентологийн хайгуул, малтлага хийх, судлах, сурталчлах, хадгалж хамгаалах, сэргээн засварлах, өмчлөх, эзэмших, ашиглах, хилээр нэвтрүүлэхтэй холбогдсон бүхий л харилцааг нэг хуулиар зохицуулдаг болсон. Тус хуулийг 2014 онд шинэчлэн найруулсан бөгөөд соёлын өвийг сурвалжлан олох, бүртгэх, ангилал тогтоох, археологи, палеоантропологи, палентологийн хайгуул, малтлага, судлах хийх, сурталчлах, хадгалж хамгаалах, сэргээн засварлах, өмчлөх, эзэмших, ашиглах, хилээр нэвтрүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах, нэр томъёог хуульд нэг мөр хэрэглэх зорилгоор хуульд “Соёлын өв”, “Соёлын биет өв”, “Хөдлөх дурсгал”, “Үл хөдлөх дурсгал”, “Дэлхийн өв”, “Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч” гэсэн нэр томъёог анх удаа тайлбарласан зэрэг онцлог бөгөөд шинэлэг зохицуулалтыг тусгасан байдаг.

Түүнчлэн, Соёлын тухай хуулийн зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хуулийн агуулга, үзэл баримтлалд нийцүүлж үндэсний аюулгүй байдлын баталгааг хангах, аль нэг соёлын дарангуйлалд өртөхгүй байх, өөрийн уламжлалт зан заншил, соёлын давтагдашгүй байдал, онцлогийг хадгалан үлдэх, иргэдийн соёлын талаарх мэдээлэл, мэдлэгийг дээшлүүлэх, үндэсний соёлыг орчин үеийн дэлхий нийтийн соёлын ололттой хослуулан хөгжүүлэх, соёл, урлагийг хүний хөгжлийг хангах үндсэн хүчин зүйл болгоход чиглүүлэх

<sup>4</sup> Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралт: “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл” Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/annex/details/11551?lawid=16009>

<sup>5</sup> Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт: “Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” Эх сурвалж: <https://legalinfo.mn/nw/detail/15804>

Замгаар нийгмийн шинэчлэлд соёл, урлагийн нөлөөллийг хангахуйц удирдлагын үр ашигтай тогтолцоог бүрдүүлэх, чанар, хүртээмж сайтай соёлын үйлчилгээний тогтвортой хөгжлийг хангах зэрэг шаардлага бий болсны<sup>6</sup> үндсэн дээр, төрөөс соёлын талаар баримтлах бодлого, зарчмыг тодорхойлж, соёлын үйл ажиллагаа эрхлэх, түүний удирдлага, зохион байгуулалт, оролцогчдын эрх, үүрэг, эдийн засгийн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулах зорилготой Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ 2021 оны 07 сарын 02 өдөр баталсан нь энэ оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлсэн хүчин төгөлдөр үйлчилж эхлээд байна.

Гэвч дээр дурдсан хуулиуд нь соёлын өвийг хамгаалах тухай ерөнхий харилцааг зохицуулжээ. Тухайлбал, хадгалалт хамгаалалтаас эхлээд тусгай зохицуулалтыг зайлшгүй шаардах усан доорх соёлын өв, устай холбоотой соёлын биет бус өвтэй холбогдох харилцааг тус хуулиудад нарийвчлан тодорхойлж зохицуулаагүй буюу тухайн нэр томъёог дурдаагүй байна. Манай улсын түүхтэй холбогдох соёлын өв нь дэлхийд өргөн тархсан байдаг учир усан доорх соёлын өвийг хадгалан хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, хууль бус худалдаа, малтлагаас сэргийлэх нөхцөлийг бий болгох нь зүй ёсны шаардлага мөн.

ЮНЕСКО-ийн 2001 оны Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенц нь усан доорх соёлын өвийг хамгаалах үндсэн зарчмуудыг тодорхойлж, улс орнуудын хамтын ажиллагааны нарийвчилсан тогтолцоог бий болгох, усан доорх соёлын өвийг сэргээх, судлахад хүлээн зөвшөөрөгдсөн жишиг буй болгох зорилготой олон улсын гэрээ юм. Энэхүү конвенцод нэгдсэнээр усан доорх соёлын өвийг хамгаалахад шаардлагатай арга хэмжээг бие даан эсвэл оролцогч улсуудтай зохих түвшинд хамтран хэрэгжүүлэх боломж нээгдэж усан доорх соёлын өвийн хамгаалалтыг хангах, бэхжүүлэх нөхцөл бүрдэх бөгөөд дотоодын эрх зүйн үйлчлэлийн гадна буй өөрийн орны түүхэнд холбогдох усан доорх соёлын өвийг хамгаалж амжилттай хамгаалж чадна.

Мөн энэхүү конвенцын 26 дугаар зүйлийн 1-т “Энэ Конвенцыг ЮНЕСКО-ийн гишүүн орнууд соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, нэгдэн орох ёстой.”<sup>7</sup> хэмээн заасан тул Манай улс ЮНЕСКО-ийн гишүүн орны хувьд уг конвенцыг заавал соёрхон батлах шаардлагатай байна.

Дээрхээс Монгол Улсад Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай ЮНЕСКО-ийн 2001 оны конвенцыг соёрхон батлах тухай хуулийг батлах хэрэгцээ, шаардлага буй болох нь харагдаж байна.

Иймд аргачлалын 3-т заасны дагуу асуудалд дүн шинжилгээ хийхдээ асуудлыг тодорхойлж түүний мөн чанар, цар хүрээ, шалтгаан, нөхцлийг тогтоож эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэдийн эрхэд тухайн асуудал хэрхэн нөлөөлж буй талаар судалгааны энэ хэсэгт авч үзсэн болно.

### **1.1. Асуудлыг тодорхойлж шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоох**

Дээр дурдсан нөхцөл байдлыг дүгнэж үзвэл дараах асуудлуудыг шийдвэрлэх асуудал хэмээн үзэж байна. Үүнд:

<sup>6</sup> “Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах тухай” хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлан, Эх сурвалж:

<http://forum.parliament.mn/projects/10650?fbclid=IwAR21ZgMIVqaVq2TP52W XoNBC XAGakWeOY I6SG78bcHAsJ WaogbcCd1Q17ftU>

<sup>7</sup> The UNESCO Convention on the Protection of the Underwater Cultural Heritage, adopted in November 2001

Нэгдүгээрт, “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцыг соёрхон батлах тухай” хуулийг батлах шаардлага нь юун түрүүнд Монгол Улсын олон улсын гэрээтэй холбоотой байна.

Хоёрдугаарт, “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцыг соёрхон батлах тухай” хуулийг батлах хэрэгцээ, шаардлага нь Монгол Улсад усан доорх соёлын өвийг хамгаалах эрх зүйн тодорхой, нарийвчилсан зохицуулалтыг бий болгох, энэ чиглэлээр бусад улсуудтай хамтын ажиллагаа хөгжүүлэх замаар өөрийн улсын түүх, археологийн холбогдол бүхий соёлын өвийг үндэсний эрх зүйн үйлчлэлээс өргөн хүрээнд хамгаалах боломжтой болох зэрэг бодит нөхцөл байдлуудаас үүсэж байна.

Иймд тус асуудлуудын хүрээнд “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцыг соёрхон батлах тухай” хуулийн хэрэгцээ шаардлагыг тандан судлах судалгааны цар хүрээг тогтоож судлах нь тохиромжтой хэмээн үзлээ.

## **1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэдийг тодорхойлох<sup>8</sup>**

Дээр тодорхойлсон цар хүрээтэй холбоотойгоор дараах нийгмийн бүлэг, бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж байна гэж үзлээ.

| Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг  | Нөлөөлж буй хэлбэр  |
|------------------------------|---|
| 1. Хүн ам                    | Монгол Улсын Үндсэн Хуулийн оршил хэсэгт “төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж” гэж, долдугаар зүйлийн нэгт “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна.” хэмээн тус тус заасан байдгийн учир Усан доорх соёлын өвийг хамгаалах нь юун түрүүнд Монгол Улсын нийт хүн амын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөх нь тодорхой. Учир нь Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцод соёл, түүх, археологийн шинж чанартай хүний оролцоотой бүхий л улс мөрийг байгалийн болон археологийн хосолмол агуулгаар нь “Усан доорх соёлын өв” хэмээн өргөн хүрээнд авч үздэг бөгөөд энэ утгаараа манай улсын түүх, археологийн холбогдол бүхий соёлын өв нь нийт ард түмэн буюу хүн амын эрх ашигтай зүй ёсоор хамаарч байна. |
| 2. Соёлын салбарт ажиллагсад | Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцын зорилгод “Усан доороос гарган авсан соёлын өвийг урт хугацаанд хадгалахын тулд түүнийг хадгалж, хамгаалж, хариуцах ёстой” <sup>9</sup> хэмээн конвенцын зорилго, ерөнхий зарчмын тухай  |

<sup>8</sup> Аргачлалын 3.1.2-т зааснаар “эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээд”-ийг тодорхойлохоор байгаа. Манай судалгааны хүрээнд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарах оролцогчид болон хүн ам зэргээр эрх ашиг нь хөндөгдөх бүлгийг тодорхойлсон тул дээрх бүгд хамаарна.

<sup>9</sup> The UNESCO Convention on the Protection of the Underwater Cultural Heritage, adopted in November 2001

|    |   |  |
|----|---|--|
|    |   | <p>хэсэгт заасан байдаг. Мөн конвенцын 20 дугаар зүйлд заасны дагуу оролцогч улс нь усан доорх соёлын өвийн үнэ цэн, ач холбогдол, түүнийг хамгаалхын учир холбогдлын талаар олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх боломжит арга хэмжээг авах үүрэгтэй бөгөөд усан доорх соёлын өвийн хадгалалт, хамгаалалт, танилцуулга, менежмент, судалгаа болон болосвролын асуудлыг үр дүнтэй байлгах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг эрх бүхий байгууллагыг зохистой байдлаар бэхжүүлэх ёстой<sup>10</sup>. Иймд соёлын үнэт зүйлийг бүтээх, эзэмших, ашиглах, хадгалж хамгаалах, судлах, түгээн дэлгэрүүлэхэд оролцож байгаа иргэд, хуулийн этгээд, төрийн байгууллага, албан хаагчийн эрх ашиг хөндөгдөнө.</p>  |
| 3. | <p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчид</p> | <p>Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцын зорилгод Усан доорх соёлын өвийг арилжааны зорилгоор ашиглахыг хориглоно<sup>11</sup> хэмээн заагаад 14 дүгээр зүйлд Оролцогч улсууд нь хууль бусаар экспортлогдсон болон энэ конвенцод харшлах байдлаар олж авсан усан доорх соёлын өвийг нутаг дэвсгэрт нь нэвтрэх, худалдаа хийх, эзэмших, ашиглахыг хориглох арга хэмжээ авах үүрэгтэй болохыг тусгажээ. Манай улс соёлын өвийн эсрэг чиглэсэн дээрх хууль бус үйл ажиллагааг Эрүүгийн хуулиар буюу тус хуулийн 25 дугаар бүлэгт Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг хэмээн тодорхойлж тусгайлан зохицуулсан байдаг. Иймд соёлын өвийн эсрэг гэмт хэргийн хэргийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарах хохирогч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан болон бусад оролцогчид бүгд хамаарахаар байна.</p> |

### 1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл

Судалгааны энэ хэсэгт “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийг соёрхон батлах тухай” хуулийг батлах шаардлагыг үүсгэж буй асуудлын шалтгаан нөхцлийг авч үзье.

#### **А. Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай ЮНЕСКО-ийн 2001 оны конвенц нь Монгол Улсын заавал соёрхон батлах олон улсын гэрээ болох нь**

“Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийг соёрхон батлах тухай” хуулийг батлах шаардлага нь юун түрүүнд Монгол Улсын олон улсын гэрээтэй холбоотой байгааг өмнөх дэд хэсэгт дурдсан билээ. Иймд судалгааны энэхүү дэд хэсэгт уг холбоо хамаарлын тухай авч үзнэ.

<sup>10</sup> The UNESCO Convention on the Protection of the Underwater Cultural Heritage, adopted in November 2001

<sup>11</sup> Мөн тэнд.

ЮНЕСКО (United Nations Educational, Scientific and Cultural Organization) буюу Нэгдсэн Үндэстний Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллагыг 1945 оны арван нэгдүгээр сарын 16-нд үүсгэн байгуулж, ЮНЕСКО-ийн Дүрмийг баталж 37 орон гарын үсэг зурсан бөгөөд 1946 оны арван нэгдүгээр сарын 4-ний өдөр уг ЮНЕСКО-ийн Дүрэм хүчин төгөлдөр болж, ЮНЕСКО нь албан ёсоор НҮБ-ын төрөлжсөн байгууллагаар хүлээн зөвшөөрөгдсөн түүхтэй. ЮНЕСКО-ийн Дүрэмд зааснаар НҮБ-ын гишүүн улс орнууд ЮНЕСКО-д элсэн орох эрхтэй байдаг тул Монгол Улс 1961 онд НҮБ-ын бүрэн эрхт гишүүн болж, дараа жил нь буюу 1962 оны арваннэгдүгээр сарын 01-нд ЮНЕСКО-ийн 108 дахь гишүүнээр элссэн юм.<sup>12</sup> Монгол улс, ЮНЕСКО-ийн гишүүн болсон цагаасаа эхлэн түүний Дүрмийн заалтад нийцүүлэн, хүн төрөлхтний хөгжил дэвшлийн төлөө ЮНЕСКО-оос дэвшүүлж ирсэн үзэл санаа, санал санаачилгыг дэмжин төрийн бодлого чиглэлдээ тусган боломжийнхоо хэрээр хэрэгжүүлэн өөрийн улсын нийгмийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулсаар байгааг дурдах нь зүйтэй.

2001 оны 10 дугаар сарын 15-наас 11 дүгээр сарын 03-ны өдрүүдэд Францын Парис хотноо ЮНЕСКО-ийн Ерөнхий бага хурлын 31 дэх удаагийн чуулган хуралдаж 11 дүгээр сарын 02-ны өдөр Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийг баталсан. Энэхүү конвенц нь усан доорх соёлын өвийг хадгалан хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, хууль бус худалдаа, малтлагаас сэргийлэх нөхцөлийг бий болгох, тухайн чиглэлд улс орнуудын хамтын ажиллагааг дэмжих зэрэг зорилготой бөгөөд одоогоор 71 улс тус конвенцод нэгдэн ороод байна.<sup>13</sup>

Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийг батлах хэрэгцээ, шаардлагыг; соёлын өвийг үр дүнтэй хамгаалахын тулд юун түрүүнд хууль эрх зүйн хамгаалалт бий болгох шаардлагатай байдаг бөгөөд аль нэг улсын үндэсний хууль тогтоомж болон өмнө нь мөрдөгдөж байсан олон улсын хэм хэмжээ нь усан доорх соёлын өвийг цогц байдлаар хамгаалж чаддаггүйтэй байсантай холбоотой<sup>14</sup> хэмээн үздэг. Учир нь тус конвенцоос өмнө олон улсын хэм хэмжээгээр усан доорх соёлын өвийг хараахан хамгаалаагүй байснаас гадна соёлын өвийг хамгаалахаас илүү арилжааны ашиг сонирхлыг илүүд үзсэн хандлагатай байсан бол үндэсний хууль тогтоомж нь ерөнхийдөө тухайн улсын нутаг дэвсгэрээс гадуур үйлчилдэггүй сул талтай.

Олон улсын эрх зүйн хүрээнд усан доорх соёлын өвийг хамгаалах тогтолцоо, зохицуулалт буй болгосноор үндэсний эрх зүйн үйлчлэлээс гадуур соёлын өвийг хамгаалах боломжийг бий болгосон бөгөөд улс орнууд олон улсын болон хамтын гэрээ байгуулах, нийтлэг ашиг сонирхол бүхий асуудлыг шийдвэрлэх, харилцан хамтын ажиллагааны тогтолцоог бий болгох боломжтой юм. Иймд усан доорх соёлын өвийн талаар зохицуулсан олон улсын зохицуулалтын талаар авч үзье.

Усан доорх соёлын өвийн талаар зохицуулсан олон улсын гэрээнүүд нь дараах болно. Үүнд:

- Далайн эрх зүйн тухай НҮБ-ын конвенц (Монтего Бэй, 1982) –Усан доорх соёлын өвийг бага зэрэг хөнддөг
- Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай ЮНЕСКО-гийн 2001 оны конвенц (Парис, 2001) – усан доорх соёлын өвийг тусгайлан авч үздэг дэлхийн гэрээ

<sup>12</sup> Холбоос: <https://unesco.mn/mn/mongolia-and-unesco/about-unesco>

<sup>13</sup> States Parties to the 2001 Convention on the Protection of the Underwater Cultural Heritage 2001. Paris, 2 November 2001, Холбоос:

<https://en.unesco.org/underwater-heritage-2001#:~:text=UNESCO%202001%20Convention,ensuring%20the%20preservation%20and%20sustainability>

<sup>14</sup> UNESCO, The Legal Protection of Underwater Cultural Heritage-ЮНЕСКО-ийн албан ёсны танилцуулга

- Хоёр талын гэрээ (жишээлбэл, RMS Титаник хөлөг онгоцны сүйрсэн хөлөг онгоцны тухай гэрээ (Лондон, 2003)) болон бүс нутгийн гэрээ (жишээ нь, Археологийн өвийг хамгаалах тухай Европын конвенц (Валетта, 1992) гэх мэт болно.

1982 онд НҮБ-ын 3 дугаар бага хурлаар Далайн Эрх Зүйн Тухай Конвенцийг хэлэлцэн баталсан бөгөөд 1994 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Энэхүү конвенц нь нутаг дэвсгэрийн далай эх газрын хормой залгаа бүс нээлттэй далай зэрэгтэй холбогдох эрх зүйн хэм хэмжээг бататган үндэсний эрх мэдлээс гадагш орших далайн ёроолтой холбогдох харилцаа, тэндээс олох ашиг орлогыг тэнцүү хуваарилах зэргийг зохицуулсан.<sup>15</sup> Гэвч тус конвенцод усан доорх соёлын өвийн тухай зохицуулсан ердөө хоёрхон л заалт байдаг. (149, 303-р зүйл)

149 дүгээр зүйл. Археологи, түүхийн эд зүйлс

“Тухайн нутаг дэвсгэрээс олдсон археологи, түүхийн шинж чанартай бүх зүйлийг хүн төрөлхтний тусын тулд бүхэлд нь хадгалж, захиран зарцуулж, тухайн улс, гарал үүслийн улс, түүх, археологийн гарлын улс эсвэл соёлын гарал үүслийн улсын давуу эрхийг харгалзан үзнэ.”

303-р зүйл. Далайгаас олдсон археологи, түүхийн эд зүйлс

1. Улс орнууд далайгаас олдсон археологи, түүхийн шинж чанартай объектуудыг хамгаалах үүрэгтэй бөгөөд энэ зорилгоор хамтран ажиллана.

2. Ийм объектын хөдөлгөөнийг хянахын тулд эрэг орчмын улс 33-р зүйлийг [зэргэлдээх бүсийн тухай] хэрэглэхдээ түүнийг зөвшөөрөлгүйгээр тухайн зүйлд дурдсан бүсийн далайн ёроолоос хөдөлгөхийг зөрчил хэмээн үзэж болно.

3. Энэ зүйл нь тодорхой өмчлөгчийн эрх, аврах хууль эсвэл адмиралтатын бусад дүрэм, соёлын солилцооны хууль, практикийг хөндөөгүй болно.

4. Энэ зүйл нь археологи, түүхийн шинж чанартай объектыг хамгаалах тухай олон улсын бусад гэрээ хэлэлцээр, олон улсын эрх зүйн хэм хэмжээг хөндөөгүй болно.<sup>16</sup>

Конвенцийн эдгээр заалтууд нь хэт ерөнхий зохицуулалттай бөгөөд арилжааны зорилгоор соёлын өвийг малтахыг хязгаарлаагүй болох нь харагдаж байна. Далайтай холбогдох харилцааг хамгийн өргөн, тухайлчлан зохицуулсан тус конвенцод усан доорх соёлын өвийг хамгаалах тухай ийм явцуу хүрээнд зохицуулсан байгаагаас үзвэл усан доорх соёлын өвийг хамгаалах бие даасан олон улсын эрх зүйн хэм хэмжээг бий болгох зайлшгүй шаардлага байжээ.

Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцын 26 дугаар зүйлд соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах эсвэл нэгдэн орох асуудлыг зохицуулсан байдаг. Тус зүйлийн 1-т “Энэ Конвенцыг ЮНЕСКО-ийн гишүүн орнууд соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, нэгдэн орох ёстой.”<sup>17</sup> хэмээн заажээ. Дээр дурдсанчлан Монгол Улс нь ЮНЕСКО-ийн гишүүн орон мөн учир энэ конвенцод соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах замаар нэгдэн орох үүрэгтэй байна.

Монгол Улсын Олон Улсын Гэрээний тухай хуулийн Заавал соёрхон батлах олон улсын гэрээний тухай зохицуулсан 8 дугаар зүйлийн 8.2-дахь хэсэгт “Заавал соёрхон батлах зохицуулалт бүхий олон талт олон улсын гэрээ болон заавал соёрхон батлуулахаар тохиролцсон хоёр талт олон улсын гэрээг соёрхон батална.” гэж заасан байна. Энэд олон улсын гэрээг байгуулахдаа талууд соёрхон батлуулахаар тохиролцсон гэрээг соёрхон

<sup>15</sup> М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр, Олон улсын эрх зүй, уб, 1999 он, 372 дахь тал

<sup>16</sup> United Nations Convention on the Law of the Sea, Холбоос:

[https://www.un.org/depts/los/convention\\_agreements/convention\\_overview\\_convention.htm](https://www.un.org/depts/los/convention_agreements/convention_overview_convention.htm)

<sup>17</sup> The UNESCO Convention on the Protection of the Underwater Cultural Heritage, adopted in November 2001

Батална гэж заажээ. Эл утгаар авч үзвэл гэрээний объектээс хамаарахгүйгээр талуудын Тохиролцсон хоёр болон олон талт гэрээг энд хамруулж болох юм. Нэгэнт тухайн гэрээнд Түүнийг соёрхон батлах заалт тусгагдсан эсхүл уг гэрээний салшгүй хэсэг болох аливаа Баримт бичигт энэ тухай дурдсан байгаа бол тэрхүү гэрээг соёрхон батлах нь зайлшгүй болно.<sup>18</sup>

Олон улсын эрх зүйн хэм хэмжээг үндэсний хэмжээнд дараах аргуудаар хэрэгжүүлдэг.

Үүнд:

- Олон улсын гэрээний биелэлтийг хангах үүднээс шинэ хууль тогтоомж гаргах, эсхүл үйлчилж буй хуульд нэмэлт, өөрчлөлт хийх
- Дээрх зорилгоор олон улсын гэрээг хэрэглэх журам тогтоосон эрх зүйн акт гаргах
- Нэгдэн орсон олон улсын гэрээнд ишлэл хийх буюу зохих байгууллагад олон улсын гэрээг хэрэглэхэд баримжаа болох ишлэлийг хийх<sup>19</sup>

**Иймд дээрхээс дүгнэвэл, Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай ЮНЕСКО-ийн 2001 оны конвенц нь Монгол Улсын заавал соёрхон батлах олон улсын гэрээ мөн учир соёрхон батлах зайлшгүй шаардлагатай байна.**

**Б. “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийг соёрхон батлах тухай” хуулийг батлах нь өөрийн улсын түүх, археологийн холбогдол бүхий соёлын өвийг үндэсний эрх зүйн үйлчлэлээс өргөн хүрээнд хамгаалах боломж болох нь**

Монголчууд дэлхийн хэмжээний эзэнт гүрнийг байгуулахын тулд Евро-Азийн тал хээрийн улс орнуудыг асар ихээр сүйтгэсэн боловч тухайн нутаг дэвсгэр дээр орших олон нийгэм, ард түмний хоорондын харилцааг хөхиүлэн дэмжиж Евро-Азийн улс орнуудыг урьд өмнөхөөс ч илүү нэгдмэл Евро-Азийн интеграцийг бий болгосон<sup>20</sup> гэдэгт судлаачид санал нэгддэг.

Чингис хааны байлдан дагууллаар эхэлсэн Монголын эзэнт гүрэн Монголын тал нутгийг Европ, Ойрх Дорнод, Орос, Зүүн Азийг холбосон худалдаа, засаг захиргааны нэгдсэн тогтолцооны төв болгож чадсан билээ. Ингэснээр хоорондоо эрс ялгаатай нийгэм, соёлын бүс нутгуудын хоорондох харилцаа идэвхжиж Италаас Хятад хүртэлх Евро-Азийн өргөн уудам нутагт худалдаачид, жуулчид, дипломатчид, шашин түгээгчид зорчин явдаг болсон байна. Улс төрийн тогтвортой байдал, эдийн засгийн тэлэлт, хүн амын өсөлтийн үр дүнд далайн худалдаа ч өргөжин тэлсэн юм. Мод, төмөр зэрэг түүхий эдээр зогсохгүй нарийн тансаг бараа таваар Хятад, Солонгос, Японоос Өмнөд Хятадын эрэг дамжин Зүүн Өмнөд Ази, тэндээс Энэтхэгийн далайгаар дамжин Араб, Дорнод Африк хүртэл өмнө байгаагүй их хэмжээгээр тээвэрлэгдэх болжээ.<sup>21</sup>

Өмнөд Сүн улсыг өөртөө нэгтгэсний үр дүнд Их Монгол Улс нь эцэстээ далай руу гарах бүрэн боломжтой болсон юм. Ингэснээр Хубилайн 2 талт байлдааны ажиллагаа нь хуурай газар, далай тэнгисийг нэгэн зэрэг хардаг болж өөрчлөгдсөн байна. Өмнөд Сүн улсыг ийнхүү эзэлснээр Монголчуудын гарт дан ганц флот төдийгүй түүнийг дагалдсан хөлөг онгоц хийх хүч, технологи, далайд аялах технологи болон далайн соёлын талаарх мэдлэг,

<sup>18</sup> Ж.Амарсанаа, Б.Чимид, Б.Гүнбилэг, Б.Алтангэрэл, М.Мөнхбат, Ц.Амарсайхан, А.Төмөр, Олон улсын гэрээний тухай Монгол Улсын хуулийн дэлгэрэнгүй тайлбар, 2011 он, 18 дахь тал

<sup>19</sup> М.Мөнхбат, Олон улсын гэрээний эрх зүй, 2017 он, 137 дахь тал

<sup>20</sup> МУИС-ийн Түүхийн тэнхимийн багш нар, Монгол Улсын түүх, 2017 он, 186 дахь тал

<sup>21</sup> МУИС-ийн Түүхийн тэнхимийн багш нар, Монгол Улсын түүх, 2017 он, 198 дахь тал

Мэдээлэл зэргийг цөмийг нь залгамжилсан<sup>22</sup> юм. Хятадаас Энэтхэг хүртэлх далайн бүс нутаг нь энэ үед асар хурднаар Их Юань улсын флотын тэнгис болж хувирсан бол харин Энэтхэгээс, баруун зүгт Ил хаант улсын Иран-арабын дау хөлөг онгоцнууд зорчих болжээ.<sup>23</sup>

Евроазийн ертөнц нь зүүн зүгт Японы бүлэг арлаас баруун зүгт Британийн арал хүртэл өргөн уудам гинжин цагираган дотор холбогдсон нь Монголоор төвлөрөн тогтворжсон олон улсын орчинд дорно өрнийн худалдаа харилцаа идэвхжиж Евроазийн худалдааны бүс гэж нэрлэж болохоор дэлхийн хэмжээний нэгдэл анхны дүр төрхөө олсон юм. Энэ нь зүүн зүгт Цюанжоу, Гуанчжоу тэргүүтэн, баруун зүгт Персийн булангийн Хормуз, тэдний хооронд өмнөд зүгт Суматра арлын Паленбан хийгээд Борнео арлын Бруней, Энэтхэгийн өмнө захын ойролцоох Малабар, Маабар зэрэг тэнгисийн эргийн олон боомт, түүнчлэн умар зүгт Хар тэнгисийн эргийн Судак, Азовын тэнгисийн эргийн Тана зэрэг боомт хотууд цэцэглэн хөгжиж байлаа. Мөн түүнчлэн Газар дундын тэнгисийн Венеци, Генуяа зэрэг боомт хот улсууд түүнээс ч илүүтэйгээр хөгжсөн<sup>24</sup> түүхтэй.

Уламжлалт Азийн худалдааны систем болон түрүү үеийн дэлхийн арилжааны систем нь “Монголын эзэнт гүрэн” хийгээд “Хубилай хааны хаанчлал” хэмээх хоёр хүчин зүйлийн түүхэн нөхцөл бүрэлдсэний үндсэн дээр бий болсныг<sup>25</sup> дээр дурдсан түүхэн баримт, судлаачдын судалгааны үр дүнгээр нотолж байдаг.

**Далайд ийнхүү идэвхтэй үйл ажиллагаа явуулж байсны ул мөр газар нутгийн хувьд өргөн, орон зай, хэлбэрийн хувьд олон янз, тооны хувьд арвин их бөгөөд үүний нэгэн тод жишээ нь Хубилай хааны Япон руу хийсэн довтолгооны сүйрсэн флоттой холбогдох Японы Такашима арлын орчим дахь Такашима Коозакигийн түүхийн дурсгалт газар юм.**

Юань улс 1274 онд 30000 орчим цэрэг, 300 том, 400-500 жижиг онгоц бүхий хөлөглөн анхны дайралтыг Япон руу хийсэн<sup>26</sup> ч далайн хар шуурганы улмаас флот тэр чигтээ сүйрсэн бол дараа нь 1281 оны 5 дугаар сарын 3-нд 900 онгоц, 40000 цэрэгтэйгээр Цүшима арал руу довтолсон<sup>27</sup> ч мөн адил далайн хар шуурганы улмаас сүйрсэн юм. Монголын түүхчид флотын хэмжээг дээрх байдлаар бичдэг бол Японы эрдэмтэд флотын хэмжээг илүү их байсан гэж үздэг. Японы түүхч Сүгияма Масааки өөрийн “Монголын эзэнт гүрний мандал буурал” номдоо; ЧжиЮаны 11-р он буюу 1274 онд Японы эсрэг анхны аян дайн эхэлсэн. Энэхүү аян дайнд чхөнрөжү буюу 1000 сөг куб буюу 1 сөг нь ойролцоогоор 180 литртэй тэнцдэг байсан мөн баатар буюу кйөнжилжү хэмээх хурдан онгоц болон усаар хангах зориулалттай 300 жижиг хөлөг онгоц, нийт 900 хөлөг онгоцноос бүрдэж байсан бол бүрэлдэхүүний хувьд сэлүүрчдийг оролцуулан 27000 мянган хүн байжээ.<sup>28</sup> Харин удаах аян дайн Чжи Юаны 18-р он буюу 1281 онд Ханчжоу-гийн далайн хаалга хэмээх Цинюань боомтоос 10 түм хүнийг суулгасан 3500 орчим хөлөг онгоц бүхий аварга флот Дорнод Хятадын тэнгисийг чиглэн хөдөлсөн<sup>29</sup> хэмээн бичжээ. Түүхэн баримтуудад тоон мэдээлэл хэдийгээр зөрүүтэй байгаа ч уг сүйрсэн 2 флот нь асар олон цэрэг болоод усан онгоцноос бүрдэж байжээ.

2011 оны 10-р сард Такашима Козакигийн талбайн нэг буланд Монголчуудын довтолгоотой холбоотой, түүхэн нөхцөл байдлыг тодруулах зорилгоор усан доорх малтлагыг

<sup>22</sup> Сүгияма Масааки, Монголын эзэнт гүрний мандал буурал, 2015 он, 254 дэх тал

<sup>23</sup> Мөн тэнд, 289 дэх тал

<sup>24</sup> Мөн тэнд, 289 дэх тал

<sup>25</sup> Мөн тэнд, 292 дэх тал

<sup>26</sup> МУИС-ийн Түүхийн тэнхимийн багш нар, Монгол Улсын түүх, 2017 он, 181 дэх тал

<sup>27</sup> МУИС-ийн Түүхийн тэнхимийн багш нар, Монгол Улсын түүх, 2017 он, Мөн тэнд

<sup>28</sup> Сүгияма Масааки, Монголын эзэнт гүрний мандал буурал, 2015 он, 274 дэх тал

<sup>29</sup> Мөн тэнд, 278 дахь тал

Өргөн хүрээнд хийж эхэлжээ. Энэхүү усан доорх археологийн судалгаа, малтлагын ажил нь Их Такашимагийн арлын орчимд 1980 онд эхэлсэн бөгөөд дараа жилээс нь арлын өмнөд Рэг дагуу 7.5 км, далайн гүнд 200 м үргэлжилсэн газрыг далайд живсэн соёлын өв хэмээн Үлээн зөвшөөрүүлэх кампанит ажил эхэлсэн юм.

Өнөөдрийг хүртэл хийсэн малтлагаар далайд живсэн Монголчуудын довтолгоотой холбоотой маш олон олдворууд олдсон бөгөөд үүний дотор завины зангуу, модон эд ангиудаас гадна ваар болон бусад сав, сэлэм, хуяг зэрэг олон төрлийн олдворууд багтдаг. 2012 онд Япон улс Такашима арлын Козакимэн орчмын 384,000 м<sup>2</sup> талбай бүхий газар нутгийг "Түүхэн дурсгалт газар" хэмээн тодорхойлсон ажээ.<sup>30</sup>

Такашима Козакигийн түүхэн дурсгалт газартай холбоотойгоор манай улсын тал ойрын жилүүдэд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. 2016 онд Япон улсын Мацүүра хотын соёлын өвийн төвийн лабораторитой танилцах судалгааг Нара их сургуулийн хадгалалт хамгаалалтын тэнхимийн доктор, Соёлын өвийн үндэсний төвийн мэргэжилтэн М.Оюунтулга биечлэн танилцаж далайн археологийн судалгааны аргазүй чиглэлээр туршлага солилцох асуудал хөндөж байв. 2017 оны 8 дугаар сард Япон улсын Нара их сургуулийн соёлын өвийн хадгалалт хамгаалалтын тэнхимийн багш судлаач доктор Имазү Сэцүо одоогийн соёлын яамны соёлын өвийн газрын дарга Б.Даваацэрэнтэй уулзаж далайн археологийн судалгааны аргазүйг Такашима арлын дурсгал дээр суурилж туршлага солилцох хамтын ажиллагааг эхлүүлэх талаар ярилцан шийдвэрт хүрсэн бөгөөд Хархорум музейд Такашима арлын далайн хэсэгт хийгдэж буй усны археологийн малтлагын аргазүй, малтлагаас илэрсэн олдворын судалгаа, хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалтын технологийн чиглэлээр 4 байгууллагын мэргэжилтнүүдэд сургалт семинар зохион байгуулсан. Түүнчлэн, 2021 оны 5 дугаар сард цахим хэлбэрээр Такашима арлын далайн археологийн судалгаа болон олдворын хадгалалт хамгаалалт сэдэвт сургалтын Соёлын өвийн үндэсний төв, ШУА-Археологийн хүрээлэн, Үндэсний түүхийн музей гэх мэт мэргэжлийн байгуулагд илтгэл хэлэлцүүлж туршлага солилцсон юм.

Өдгөө манай улс далайн археологийн малтлага судалгааны чиглэлээр Япон улсын эрдэмтэн судлаач Рюүкюү их сургуулийн багш судлаач Доктор Икэда Ёшифүми, Япон улсын Нара их сургуулийн соёлын өвийн хадгалалт хамгаалалтын тэнхимийн багш судлаач доктор Имазү Сэцүо нартай Такашима арлын археологийн судалгааг түшиглэн хамтарсан судалгаа хийх талаар хэлэлцэж байна.

Өөрийн улсын түүх, археологийн үнэт дурсгалыг малтах, археологийн судалгаанд гар бие оролцох нь манай улсын хувьд эрхэм чухал үйл даруй мөн. Тиймдээ ч энэхүү далай доорх малтлагын ажилд японы талтай хамтран ажиллахаар олон жилийн турш зорьсоор байгаа билээ. Үүний тулд юун түрүүнд манай улс далай доорх малтлага хийх мэргэшсэн боловсон хүчинтэй байх ёстой. Далайд гарцгүй орны хувьд манай улсын археологийн салбарт усан доорх малтлага судалгааны чиглэл хөгжөөгүй өдийг хүрсэн. Иймийн учир тус чиглэлээр бусад орны болон олон улсын байгууллагын дэмжлэг зайлшгүй шаардлагатайг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.

Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцод нэгдсэнээр бидэнд усан доор археологийн малтлага хийх, тус чиглэлийн боловсон хүчнийг бэлтгэхэд олон талын боломжийг олгох давуу талтай. Конвенцийн 21 дүгээр зүйлд Усан доорх археологийн сургалтын тухай ийнхүү заажээ: "Оролцогч улсууд усан доорх археологийн сургалтыг

<sup>30</sup> International Exchange Committee of the Japanese Archaeological Association (Tokyo, Japan), Холбоос: [http://archaeology.jp/sites/2012\\_takashima.htm?fbclid=IwAR3UDvoGbLFon-HPspswCtzwzBr1\\_goZ3clo88bh72jav7KJ7A1FdKxSdLJA](http://archaeology.jp/sites/2012_takashima.htm?fbclid=IwAR3UDvoGbLFon-HPspswCtzwzBr1_goZ3clo88bh72jav7KJ7A1FdKxSdLJA)

Хүртээмжтэй байлгах, усан доорх соёлын өвийг хадгалж, хамгаалах арга техник болон гохиролцсон нөхцөлд усан доорх соёлын өвтэй холбоотой технологийг дамжуулах чиглэлээр хамтран ажиллана". Мөн түүнчлэн конвенцийн салшгүй хэсэг болсон Усан доорх соёлын өвд чиглэсэн үйл ажиллагааны дүрмийн Чадавх бэхжүүлэх тухай 52 дугаар зүйлд "Оролцогч улсууд усан доорх археологийн чиглэлээр сургалт зохион байгуулах, усан доорх соёлын өвийг хадгалж, хамгаалах арга техник, усан доорх соёлын өвтэй хамааралтай технологийг гохиролцсон нөхцөлд дамжуулах чиглэлээр хамтран ажиллана." хэмээн зааж хамтын ажиллагааны дараах төрлүүдийг тодорхойлсон байна. Үүнд:

- а.) бүс нутгийн болон олон улсын сургатын хөтөлбөрийг зохион байгуулах, оролцох;
- б.) Усан доорх соёлын өвийг судлах болон хамгаалах чиглэлээр ажиллах мэргэжилтнийг сургах; болон
- с.) Усан доорх археологийн сургалт, усан доорх соёлын өвийн судалгаа болон материалын хадгалалт, хамгаалалтын чиглэлээр мэргэшсэн үндэсний эсвэл олон улсын байгууллагыг байгуулах.

Дээрхээс харвал Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцод нэгдсэнээр манай улсын археологийн салбар усан доор малтлага, судалгаа хийх чиглэлээр хөгжих боломж бүрдээд зогсохгүй үүгээр дамжуулан бидний нэгэн гол зорилго болсон өөрийн улсын түүхэн холбогдол бүхий гадаад улс дахь дурсгалт газруудад тухайн улстай хамтран ажиллах боломж ч бий болох өндөр ач холбогдолтой байна.

## **В. Усан доорх археологийн малтлага, судалгаа явуулах боломж буюу конвенцийн үйлчлэл дотоодын усанд хамаарах тухай**

Монгол Улс нь далайд гарцгүй орон билээ. Тиймдээ ч уг Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцыг соёрхон батлах хэрэгцээ, шаардлага бий эсэх талаар зарим нэг эргэлзээ үүсэж болохыг үгүйсгэхгүй. Иймд конвенцын үйлчлэл манай улсын дотоодын усанд үйлчлэх боломжтой эсэх буюу усан доорх археологийн малтлага судалгаа явуулах боломж бий эсэх тухай энэ хэсэгт авч үзье.

Монгол Улс нь далайн эрх зүйн чиглэлээр доорх олон талт олон улсын гэрээнүүдэд нэгдэн орсон байна. Үүнд:

*Хүснэгт 2. Монгол Улсын нэгдэн орсон далайн эрх зүйн олон талт олон улсын гэрээ*

| № | Гэрээний нэр   | Байгуулагдсан огноо | Хүчин төгөлдөр болсон огноо | Монгол Улсын нэгдэн орсон огноо |
|---|--|---------------------|-----------------------------|---------------------------------|
| 1 | Их далайн тухай Женевийн конвенц   | 1958.04.29          | 1962.09.30                  | 1976.10.10                      |
| 2 | 1982 оны Далайн эрх зүйн НҮБ-ын конвенцийн 11 дүгээр хэсгийн заалтыг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр | 1994.07.28          | 1996.07.28                  | 1996.08.13                      |
| 3 | Олон улсын далайн байгууллагын тухай конвенц, түүний нэмэлтүүд                                   | 1948                |                             | 1996.12.11                      |
| 4 | Далайн тээврийн тухай конвенц  | 1958                |                             | 1996                            |
| 5 | Далайн эрх зүйн тухай конвенц  | 1982.11.10          | 1994.11.16                  | 1996.08.13                      |

|    |   |            |            |            |
|----|---|------------|------------|------------|
| 6  | Дипломтай далайчдыг бэлтгэх болон ээлжийн ажиллагааны тухай конвенц   | 1978.07.17 | 1984.04.28 | 2001       |
| 7  | Далайд хөлөг онгоц мөргөлдөхөөс урьдчилан сэргийлэх олон улсын дүрмийн тухай конвенц  | 1972.10.20 | 1977.07.15 | 2001       |
| 8  | Далайд хүний аюулгүй байдлыг хангах тухай конвенц   | 1974.11.01 | 1980.05.25 | 2001       |
| 9  | Хөлөг онгоцны багтаамжийн хэмжлийн тухай конвенц  | 1969.06.23 | 1982.07.18 | 2001       |
| 10 | Далайг усан онгоцноос бохирдуулахаас сэргийлэх тухай конвенц  | 1973       |            | 2001       |
| 11 | Далайд газрын тос тээвэрлэгч хөлөг онгоцноос далайд учруулсан хохирлын талаар хүлээх иргэний хариуцлагын тухай 1969 оны олон улсын конвенцид нэмэлт өөрчлөлт оруулах тухай протокол | 1992.11.27 |            | 2006.06.09 |
| 12 | Далайг хөлөг онгоцноос бохирдуулахаас сэргийлэх тухай Конвенцид (1978 оны протоколоор оруулсан өөрчлөлтийг оруулсанаар) нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протокол                     | 1997.09.26 |            | 2007.05.04 |
| 13 | Далайн олон улсын байгууллагын тухай конвенцид оруулах нэмэлт, өөрчлөлт   | 1991.11.07 |            | 2007.05.04 |
| 14 | Далайд хүний аюулгүй байдлыг хангах тухай 1974 оны олон улсын конвенцийн 1988 оны протокол  | 1988.11.11 |            | 2007.05.04 |

1982 онд НҮБ-ын 3 дугаар бага хурлаар батлагдаж, 1994 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Далайн Эрх Зүйн тухай Конвенцийг батлахад манай улсын төлөөлөгчид боловсруулах явцад далайд гарцгүй орны ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн санал, санаачлагуудыг идэвхтэй гаргаж ажилласан байдаг.<sup>31</sup> Тиймдээ ч тус конвенцыг хүчин төгөлдөр хэрэгжиж эхлэхэд нь нэг их удалгүй нэгдэн орсон. Манай улс нь хэдийгээр далайд гарцгүй орон боловч далайн эрх зүйн чиглэлээр байгуулагдсан олон улсын олон талт гэрээнүүдэд идэвхтэй нэгдэн орж, тус эрх зүйн хөгжилтэй зэрэгцэн хөгжиж байгааг онцлох хэрэгтэй. Дээр дурдсан гэрээнүүд нь далайн эрх зүйд хамаарна хэмээгдэж

<sup>31</sup>М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр, Олон улсын эрх зүй, Уб, 1999 он, 371 дэх тал.

Байгаа ч тус эрх зүйгээр дотоодын усны харилцааг ч зохицуулсан байх нь бий. Үүний нэг жишээ нь Далайн Эрх Зүйн тухай Конвенц юм.

Далайн Эрх Зүйн тухай Конвенцод далайн боомт тохой, нутаг дэвсгэрийн далайн шугамаас дотогш орших нуур, гол, мөрөн, сувгийг дотоод далайн ус буюу дотоодын ус болохыг тодорхойлсон байдаг.<sup>32</sup> Дотоод далайн ус нь эргийн улсын нутаг дэвсгэрийн бүрэлдэхүүн хэсэг. Эргийн улс энд өөрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэн, эрх зүйн дэглэмийг, тухайлбал гадаадын далайн хөлөг онгоц нэвтрэн орох журмыг тогтооно. Дотоод далайн усанд оршиж байгаа гадаадын хөлөг онгоц нь гааль, эрүүл ахуй, цагаачлалын хяналт, хөлөг онгоц зорчих аюулгүй байдал, орчин ахуйг хамгаалахтай холбогдсон эргийн улсын хууль, дүрмийг дагаж биелүүлэх ёстой. Загас агнах, үйлдвэрлэл эрхлэх явдлыг гагцхүү эргийн улсын завшөөрөлтэйгээр гүйцэтгэнэ. Дотоод далайн усанд оршиж байгаа гадаадын худалдааны хөлөг онгоцны хувьд захиран шийдвэрлэх эрхийг зарчмын хувьд эргийн улс эдэлдэг. Гэвч практик дээр гэмт хэргийн хор уршиг нь эргийн улсын нутаг дэвсгэртэй холбоогүй, түүний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг эвдээгүй, иргэнийнх эрх ашгийг хөндөөгүй бол эргийн улс оролцдоггүй<sup>33</sup> байна.

Монгол Улс нь зөвхөн ОХУ, БНХАУ гэсэн хоёр оронтой л хиллэдэгийн хувьд хилийн устай холбоотой тус хоёр улстай идэвхтэй хамтран ажилладаг. Хилийн усыг хамгаалах болон ашиглах тухай Монгол Улсын засгийн газар, БНХАУ-ын засгийн газрын хоорондын хэлэлцээрийг 1994 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр Улаанбаатар хотноо байгуулсан. Уг хэлэлцээр нь 10 жил, 5 жилээр аяндаа сунгагдах нөхцөлтэй.<sup>34</sup> Харин 1995 оны 2 дугаар сарын 11-ний өдөр Улаанбаатар хотноо "Хилийн усыг хамгаалах, ашиглах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг баталсан бөгөөд Засгийн газраас өргөн мэдүүлсний дагуу 1995 оны 5 дугаар сарын 29-ний өдөр УИХ-иар соёрхон баталсан<sup>35</sup> байдаг. Энэхүү хэлэлцээрт дуусах хугацааг заагаагүй байна. Мөн түүнчлэн, Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч В.В.Путин нар хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ойг тэмдэглэх хүрээнд Москва хотноо 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдөр хийсэн хэлэлцээний үеэр "Монгол Улс болон Оросын Холбооны Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ойн хамтарсан тунхаглал"-ыг гаргасан. Энэхүү тунхаглалд "Талууд байгаль орчныг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх хамтын ажиллагаанд өндөр ач холбогдол өгч, бие биенийхээ ашиг сонирхлыг харгалзан үзэж, харилцан хүндэтгэх үндсэн дээр хил дамнасан усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалахад нягт хамтарч ажиллахыг эрмэлзэнэ"<sup>36</sup> хэмээн заажээ.

Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцын 7 дугаар зүйлд дотоодын ус, арал хоорондын ус болон харья тэнгис дэх усан доорх соёлын өвийн тухай зохицуулсан байдаг. Тус зүйлийн 1-дэх хэсэгт зааснаар оролцогч улс нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ дотоодын ус, арал хоорондын ус болон харьяа тэнгис дэх усан доорх соёлын өвд чиглэсэн үйл ажиллагаа буюу усан доорх соёлын өвийг үндсэн объект болгон ашигладаг, усан доорх соёлын өвийг шууд болон шууд бусаар сүйтгэх, эсвэл гэмтээж болзошгүй үйл ажиллагааг зохицуулах, зөвшөөрөх онцгой эрхтэй. Үүний тулд тус конвенцын 28 дугаар зүйлд заасанчлан Дотоодын усны тухай мэдэгдлийг гаргах шаардлагатай юм. Энэ нь тус конвенцыг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, нэгдэн орох үед эсвэл түүний дараа аль ч улс эсвэл нутаг

<sup>32</sup> Мөн тэнд, 372 дахь тал

<sup>33</sup> М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр, Олон улсын эрх зүй, УБ, 1999 он, 372 дахь тал

<sup>34</sup> ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ, Холбоос: <https://legalinfo.mn/mn/detail/10051>

<sup>35</sup> ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ, Холбоос: <https://legalinfo.mn/mn/detail/10054>

<sup>36</sup> Монгол Улсын Гадаад харилцааны яамны албан ёсны цахим хаяг, холбоос: <https://mfa.gov.mn/65949>

Дэвсгэр Дүрмийг далайн шинж чанартай биш дотоодын усанд ашиглахыг мэдэгдсэний үндсэн дээр конвенцын салшгүй хэсэг болох уг Дүрмийг дагаж мөрдөх ёстой байдаг.

Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенц нь ийнхүү дотоодын усан доорх соёлын өвийг хамгаалах боломжтой байгаа учир Монгол Улсын дотоодын усны тухай авч үзэх хэрэгтэй болж байна.

Монгол орны гадаргын усны нийт нөөц нь дэлхийн усны нөөцийн (1386 сая км<sup>3</sup>, И.А.Шикломанов, 1998) 0.00004 хувийг, гол мөрний усны нөөц нь дэлхийн гол мөрний усны нийт нөөцийн (42700 км<sup>3</sup>, И.А.Шикломанов, 1998) 0.08 хувийг тус тус эзэлдэг.<sup>37</sup> Манай орны нийт гадаргын усны нөөц нь 599 км<sup>3</sup>, үүний ихэнхийг буюу 500 км<sup>3</sup> нь нуур, 62.9 км<sup>3</sup>-нь мөстлөг, мөсөн гол, 34.6 км<sup>3</sup> (5.8 хувь) нь гол мөрний ус байдаг бөгөөд (Б.Мягмаржав, Г.Даваа нар, 1999) гадаргын усны үндсэн бүрэлдэхүүн болох гол мөрөн, нуурууд нь нийт нутаг дэвсгэрийн 0.67 хувь буюу 10,560 км<sup>2</sup> талбайг эзэлдэг ажээ.<sup>38</sup> Мөн гадаргын усны эх үүсвэрийн тоо 4,087 бөгөөд гол мөрний усны эзлэхүүний хэлбэлзэл 1 жилд 34.6 км<sup>3</sup> байдаг байна.

Доорх хүснэгтэд Монгол орны усны нийт нөөцийг төрлөөр ангилан, хэмжээний хамтаар харууллаа.

Хүснэгт 3. Монгол орны усны нийт нөөц

| № | Ус                 | Хэмжээ  | Судалсан судлаач, оны хамт |
|---|--------------------|---|----------------------------|
| 1 | Нуурын ус          | 500 км <sup>3</sup>   | Ж. Цэрэнсодном, 1970, 2000 |
| 2 | Хур цас, мөсөн гол | 19.4 км <sup>3</sup>  | Г. Даваа нар, 2012         |
| 3 | Гол мөрөн          | 34.6 км <sup>3</sup>  | Б.Мягмаржав, 1975, 1996    |
| 4 | Газар доорх ус     | 10.8 км <sup>3</sup>  | Н.Жадамбаа, 2003           |
| 5 | Хөвсгөл нуур       | 380.7 км <sup>3</sup><br>(Энэ нь нуурын усны 76.1 %, гадаргын нийт усны 68.7%.) |                            |

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны тодорхойлсноор гадаргын хэмжээ нь 50 км<sup>2</sup>-аас дээш нууруудаас “томоохонд тооцогдох” гэж хүснэгт дэх 6 нуурыг нэрлэсэн байх ба 2021-06-04 өдрийн байдлаарх тухайн нууруудын гадаргын талбай, гүний хэмжээг Үндэсний статистикийн хорооны албан ёсны цахим хаягт доор дурдсанаар гаргасан байна.<sup>39</sup>

Хүснэгт 4. Монгол орны томоохон нуур

| № | Нуур    | Гадаргын талбай       | Дундаж гүн | Хамгийн гүн |
|---|---------|-----------------------|------------|-------------|
| 1 | Увс     | 3,453 км <sup>2</sup> | 11.9 м     | 20 м        |
| 2 | Хөвсгөл | 2,782 км <sup>2</sup> | 137.9 м    | 262 м       |

<sup>37</sup> Г.Даваа, Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн, "Монгол орны гадаргын усны нөөцийн судалгааны үр дүнгээс" танилцуулга, 2018 он.

<sup>38</sup> Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн тоон мэдээлэл, холбоос: <https://niwf-mn.org/%D0%BC%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BB-%D0%BE%D1%80%D0%BD%D1%8B-%D0%B3%D0%B0%D0%B4%D0%B0%D1%80%D0%B3%D1%8B%D0%BD-%D1%83%D1%81%D0%BD%D1%8B-%D0%BD%D3%A9%D3%A9%D1%86%D0%B8%D0%B9%D0%BD-%D1%81%D1%83%D0%B4/>

<sup>39</sup> Монгол улсын томоохон нууруудын талаарх Статистикийн үндэсний хорооны тоон мэдээ, холбоос: [https://www.1212.mn/tables.aspx?tbl\\_id=DT\\_NS0\\_0100\\_004V1&CL\\_LAKE\\_select\\_all=0&CL\\_LAKE\\_SingleSelect=2020&viewtype=table](https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NS0_0100_004V1&CL_LAKE_select_all=0&CL_LAKE_SingleSelect=2020&viewtype=table)

|   |        |                       |        |        |
|---|--------|-----------------------|--------|--------|
| 3 | Хар ус | 1,196 км <sup>2</sup> | 2.2 м  | 4.5 м  |
| 4 | Хяргас | 1,388 км <sup>2</sup> | 46.9 м | 80 м   |
| 5 | Буйр   | 621 км <sup>2</sup>   | 6.5 м  | 10.2 м |
| 6 | Хар    | 585 км <sup>2</sup>   | 4.2 м  | 7 м    |

Мөн түүнчлэн манай орны хүний гараар бүтсэн хамгийн залуу нуур бол Говь-Алтай аймгийн Тайшир суманд орших Гэгээн нуур юм. Улаан Боомын хавцалд 2008 онд “Тайшир гуулин” УЦС-ыг байгуулахын тулд 50 метр өндөр, 190 метр урт далан байгуулан Завхан голын усыг хуралдуулсанаар 17,2 гаруй километр урт, 3,7 орчим километр өргөнтэй уг нуур бий болжээ. Тус нууранд Завхан голд байдаг Монгол хадран, Алтайн сугас гэсэн хоёр төрлийн загас үржиж, усны шувууд суурьшин, мал ундаалах болжээ.<sup>40</sup> Гэгээн нуурыг энэ 2018 онд “Google” хайлтын системд албан ёсоор бүртгэгдсэн байна.

Дээрхээс дүгнэвэл манай улс далайн эрх зүйн чиглэлд олон улсад санаачилгатай, идэвхтэй үйл ажиллагаа явуулсаар өдийг хүрсэн нь нээлттэй далайд ч, дотоодын усанд ч хамааралтай олон улсын гэрээ, конвенцуудад нэгдэн орсон байдал, хил орчмын усны тухайд хөрш орнуудтайгаа олон талаар идэвхтэй хамтран ажиллаж байгаа зэргээс харагдаж байна. Энэ нь манай улс усан доорх соёлын өвийг хамгаалах чиглэлд ч идэвхтэй үйл ажиллагаа явуулах үүргийг албан бусаар хүлээлгэж байна.

Мөн түүнчлэн, Монгол Улсын гадаргын усны нөхцөл байдал, цаашид ирээдүйд эрчим хүчний чиглэлээрх төрийн бодлого усан цахилгаан станц байгуулахад чиглэж байгаагаас манай улсад усан доорх археологийн малтлага, судалгаа явуулах бүрэн боломжтой болох нь батлагдаад зогсохгүй Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцын үйлчлэл дотоодын усанд ч үйлчлэх боломжтой учир үүгээр дамжуулан тус чиглэлийг хөгжүүлэх ч боломж нээлттэй байгааг дурдах нь зүйтэй.

#### **Г. Усан доорх малтлага, судалгааны ажлыг хөгжүүлэх нь хүрээлэн буй орчныг хамгаалахад чухал болох нь**

Хөвсгөл нуурын эко системийг хамгаалах, нуурын ёроолын аюултай хог хаягдлыг цэвэрлэх, бохирдлыг багасгах асуудал манай улсын хүрээлэн буй орчныг хамгаалах үйл ажиллагааны тэргүүний зорилт болоод байгаа билээ. Хөвсгөл нуурын гүнд живсэн хичнээн тээврийн хэрэгсэл бий талаар өдгөө ч нэгдсэн тоо байхгүй зарим судлаачид 60 гаруй тээврийн хэрэгсэл живсэн гэж үздэг. Хамгийн анх 1969 онд Хөвсгөл нуурт “ДТ-75” трактор живжээ. Дараа нь, “ЗИС-164” цистерн дөрвөн тонн орчим шатахуунтай явахдаа живсэн бол сүүлд 2011 онд НИК-ийн шатахуун тээвэрлэгч машинууд живсэн ажээ.

Өдийг хүртэлх хугацаанд Хөвсгөл нуурыг цэвэрлэх ажил, санаачлагууд гарсаар байв. Тэдгээрийн нэг Зүүний хүчний холбооныхны санаачлага, УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалангийн дэмжсэн Хөх сувд-Хөвсгөл зэрэг юм. Юуны өмнө нуурын ёроолд живсэн машин техник, хөлөг онгоцны байршлыг тогтоох шаардлагатай болох нь ойлгомжтой. Энэ талаар Монголын Зүүний хүчний холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Баатар: “Сантын аманд живсэн техник төхөөрөмжийг гаргахад 10 тонн даацтай техник хэрэгтэй байгаа. Сүхбаатар хөлөг онгоц энэ далайд живээд олон жил болж байна. Энэ хөлөг онгоцны өөрийнх нь жин нь 300 тонн учраас хэрхэн татаж гаргах вэ гэдэг хамгийн том асуудал болоод байна” гэж ярьж байжээ. Японы мэргэжилтэн Күмагай сан “Хоёр машины байршлыг баттай тогтоолоо. Татаж гаргах технологи, техникийн асуудал хэцүү биш. Миний санаа зовж байгаа ганц зүйл бол мөнгө. Яагаад гэхээр Японы нуураас машин татаж гаргах гээгүй. Хөвсгөл нуураас тээврийн

<sup>40</sup> Говь Алтай аймгийн байгаль орчны газар, холбоос: <http://govi-Altai.nature.gov.mn/>

Хэрэгсэл татаж гаргахад хэдэн төгрөг шаардагдахыг Японы жишгээр тооцож яагаад ч болохгүй. Тээвэр, даатгал, татвар гээд олон асуудлыг шийдэх хэрэгтэй болно. Ер нь нэг машин гаргахад хэчнээн төгрөг хэрэгтэй вэ гэдэг төсвийг тооцоолон бодоход хүндрэлтэй санагдаж байна” гэсэн байр суурийг Хөвсгөл нуурын ёроолд байгаа хоёр машины байршлыг тооцоогоод ирснийхээ дараа илэрхийлж байжээ. 2013 онд БНСУ-аас ирсэн дөрвөн шумбагч Хөвсгөл нуурын ёроолд байгаа зарим техник хэрэгслийн бичлэгийг хийж олон нийтэд түгээсэн бөгөөд тус шумбалтаар тэд нуурын ёроолд байгаа хамгийн том техник Сүхбаатар хөлөг онгоцыг онцолсон байдаг<sup>41</sup>.

Нууранд живсэн тээврийн хэрэгслүүдийг татаж гаргах ажиллагаанууд хэд хэдэн удаа амжилттай хийсэн байдаг. 2011 оны хоёрдугаар сард “НИК” ХХК-ийн Хөвсгөл аймаг дахь салбарын “Урал-375-ЯМБ-36” загварын шатахуун тээвэрлэгч хоёр машин Мөрөн сумаас Цагааннуур суманд шатахуун хүргэхээр явсан бөгөөд 92-01 ХӨА дугаартай машинд 6740 литр, 75-79 ХӨА дугаартай машинд 6510 литр, нийт 13250 литр А-80 автобензин тус тус тээвэрлэсэн байсан ба эдгээр машин Рэнчинлхүмбэ сумын 4 дүгээр багийн Хатгал тосгоноос зүүн хойд зүгт 80 км, Ханх сумаас 50 км, нуурын эргээс 220 метр зайтай “Адуутын-Ам” гэдэг газар Хөвсгөл нуурт живсэн юм. Эхний машины шатахууныг соруулж, улмаар машиныг хавчуулагдсан мөснөөс чирч гаргасан. Аврах тусгай ангийн аврагч дээд түрүүч Г.Баяртогтох, тэргүүн түрүүч Б.Дэлгэрсайхан нар усны гүний шумбалт үйлдэж 50 метрийн гүнд живсэн 75-79 ХӨА дугаартай шатахуун тээвэрлэгч автомашинд 100 метр урт ган татлагыг холбож, татаж гаргасан байдаг. Харин хамгийн сүүлд буюу 2021 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр нууранд живсэн хамгийн том тээврийн хэрэгсэл болох “Бор-500” загварын “Сүхбаатар” хөлөг онгоцыг татан гаргах ажиллагааг амжилттай зохион байгуулаад байна.

“Сүхбаатар” хөлөг онгоцны урт нь 43.3 м, өргөн нь 8.4 м, өндөр нь 5.7 м, жин нь 309 тонн юм. Нуурын эргээс 110-120 метр, 12-16 метрийн гүнд живсэн, хөлөг онгоцны тэнхлэгээр тооцвол хойд хэсгээрээ усны түвшнээс 9 м, урд хэсгээрээ 3,2 м гүнд зүүн хойноос баруун урд чигт байрласан, нуурын ёроолд 1,4-1,9 метр шигдсэн байсныг нуурын гүнд, мандалд, эрэгт алба хаагчид татан гаргасан байна.<sup>42</sup> Онгоцон доторх усны жин 1176.51 тн, 195.5 тн шавар хуримтлагдсан байжээ.

Тус хөлөг онгоцыг хөвсгөл усан замын газрын техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор 1956 онд ЗХУ-тай байгуулсан Худалдааны хэлэлцээрийн дагуу “Красный Сормов” үйлдвэрийн зураг төслөөр хийсэн бөгөөд тухайн үеийн ЗХУ-аас шатахуун болон бусад бараа, бүтээгдэхүүнийг тээвэрлэн Хөвсгөл, Завхан, Увс, Говь-Алтай зэрэг баруун аймгуудыг хангахад голлох үүргийг гүйцэтгэж байжээ.<sup>43</sup> Онгоцноос 400 литр техникийн тос алдагдах аюултай байсан бөгөөд 100 литр шатахуун алдахад 1.1 км<sup>3</sup> ус бохирдоно гэсэн тооцоолол гарсан учир тус татан гаргах ажиллагааг хийх зайлшгүй шаардлагатай гэж үзсэн байна.

Тус ажиллагаанд ОБЕГ-ын Тэргүүн дэд дарга, хурандаа Ж.Чүлтэмсүрэнгээр ахлуулсан Батлан хамгаалах яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Онцгой байдлын ерөнхий газар, дээрх байгууллагуудын харьяа ангиуд, Зам, тээврийн хөгжлийн яамны Далайн захиргааны газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, ШУТИС, Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн газар, Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгоны Захирагчийн ажлын алба, “Хөвсгөл усан зам” ХК-ийн нийт 120 гаруй хүн, 50 нэгж техник хэрэгсэл оролцсон бөгөөд онцгой байдлын байгууллагын 20

<sup>41</sup> <https://gogo.mn/r/126552?i=>

<sup>42</sup> <https://montsame.mn/mn/read/280314>

<sup>43</sup> <https://www.montsame.mn/mn/read/279997>

Гаруй усчин аврагч хөлөг онгоцыг холбох, хөшүүрэг хийх, гүн хэмжих, битүүмжлэх зэргийг сар гаруй хугацаанд 100 удаагийн шумбалтаар гүйцэтгэсэн байна.<sup>44</sup>

Монгол Улсын Засгийн газар Хөвсгөл нуурын эко системийг хамгаалах, нуурын ёроолын аюултай хог хаягдлыг цэвэрлэх, бохирдлыг бууруулах зорилгоор 2019, 2020 онд Тогтоол гарган, шаардагдах санхүүжилтийг нь шийдвэрлэсэн бөгөөд 2024 он гэхэд нуурын ёроолд байгаа 60 орчим машин, техникийг татаж гаргахаар төлөвлөсөн ажээ.

Гэвч дээр өгүүлсэнчлэн татан гаргах ажиллагаанд нэн тэргүүнд живсэн объектын талаарх дэлгэрэнгүй судалгаа зайлшгүй шаардлагатай бөгөөд энэ чиглэлийн усанд доор малтлага, судалгааны ажил хийх боловсон хүчний нөөц байхгүйгээс бусад улстай хамтран ажиллах шаардлагатай болж байгаа нь үйл ажиллагаа хэрэгжихэд хугацааны хувьд удаашрах, түүнээс үүдэж хүрээлэн буй орчинд живсэн объектын учруулах хор, хөнөөлийг хязгаарлах боломжгүй болох зэрэг эрсдлүүдийг дагуулж байна.

#### **Д. Усан доорх соёлын өвийг хамгаалах эрх зүйн орчны дутмаг байдал**

Монголын ард түмэн соёлын биет болон биет бус өвийн арвин баялаг санг бүтээн өвлөн уламжилж ирсэн билээ. Түүний дотор “Уул ус тахих монгол ёс заншил, зан үйл” онцгой үнэ цэнтэй. Уул овоо тахих зан үйл эрт үедээ бөөгийн ёсоор тахиж ирсэн бөгөөд 16 дугаар зууны үеэс буддын шашны зан үйл болон хөгжүүлж ирсэн түүхтэй. Ариун нандин, тахилга бүхий уул усаа шүтэх монголчуудын уламжлалт зан заншил нь байгаль, хүрээлэн буй орчинтой нягт уялдан зохицсон нүүдэлчин амьдралын соёлын үнэт өв юм. Эртний бөө мөргөлийн дагуу тэнгэр, газар, уул усанд байгалийн үл үзэгдэгч сахиус бий гэдэгт итгэдэг. Орон нутгийн ахмад настнууд залуучуудад энэхүү ёслолыг хэрхэн хийх, үйл ажиллагаанд яаж оролцохыг зааж сургадаг байжээ. Харин социалист тогтолцооны үед уул усаа тахиан шүтэхийг хориглосон нь зан үйл бүдгэрэх, ёс заншил алдагдахад нөлөөлсөн юм. Хэдийгээр 1990-ээд оноос уламжлалыг идэвхтэй сэргээсэн боловч өдгөө устаж үгүй болох соёлын биет бус өвд тооцогдож, яаралтай хамгаалах шаардлагатай хэмээн үзсэн нь хэд хэдэн шалтгаантай. Эдгээрт хотжилт хурдацтай явагдаж байгаа, уул овоо тахин шүтэх зан үйл ёс заншлаа мэддэг малчид хот руу нүүдэллэж ирэх болсон нь ёс заншлаа мэдэхгүйгээр буруу үйлдэх үндэс болжээ. Ийнхүү өнгөрсөн хорьдугаар зуунд энэхүү үнэ цэнтэй өв уламжлалыг шашны хэмээн үзэж, өдгөө “хуучны”, “хоцрогдсон” гэж үзэж үгүйсгэж, зарим үед хориглосноос мартагдах эрсдэл бодитой бий болсон юм.

Иймээс тэрхүү үнэт өв уламжлалыг шинэ нөхцөл байдалд сэргээн тэтгэж хөгжүүлэх шаардлага бий болсон. Дээрх учир шалтгаанаас үүдэн Монгол Улс “Уул ус тахих монгол ёс заншил, зан үйл”-ийг “Соёлын биет бус өвийг хамгаалан дэмжих тухай” ЮНЕСКО-ийн 2003 оны Конвенцийн “Яаралтай хамгаалах шаардлагатай Соёлын Биет Бус Өвийн Дэлхийн Жагсаалт”-д бүртгүүлэхээр 2015 онд нэрийг дэвшүүлж баримтыг бүрдүүлж энэ Конвенцийн Засгийн газар хоорондын Хороонд хүргүүлсэн билээ. ЮНЕСКО-ийн энэ Хороо Монгол улсын хүсэлт, материалыг 2017 онд БНСУ-ын Чэжу аралд болсон хурлаараа хэлэлцэн “Яаралтай хамгаалах шаардлагатай Соёлын Биет Бус Өвийн Дэлхийн Жагсаалт”-д бүртгэн авч, уг өвийг сэргээн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхээр болсон байдаг.

Уул ус тахих монгол ёс заншил, зан үйлийн нэгэн тод жишээ нь Төрийн Тахилгат Отгонтэнгэр уулын энгэрт байрлах Бадархундага нуурт мөнгөн эдлэл өргөх зан үйл юм. Бадархундага нууртай Энэтхэгийн Ганга мөрөн газар доогуураа хүйн холбоотой гэж эртний

<sup>44</sup> Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх: Хөвсгөл нуурт живсэн бүх машин, техникийг 2024 он гэхэд татаж гаргана <https://president.mn/21692>

Ном сударт тэмдэглэгдсэн гэдэгт итгэж нуурыг зорин ирсэн сүсэгтэн олон Бадархундага нуурын усыг рашаан хэмээн хүртэж нууранд алт, мөнгөөр урласан эдлэл, цалин цагаан мөнгөн эмбүү, мөнгөн аяга хадагт ороон өргөдөг эртний уламжлалтай ажээ. Домогт өгүүлснээр хэрэв нуур өргөлийг хүлээн авбал тухайн хүний хүсэл биелж, өргөснөөсөө хэд дахин ихийг эргүүлэн авдаг, харин нүгэл хилэнц ихтэй хүний өргөл эмбүү живдэггүй гэх ба энэ нь Очирваань бурхан таалахгүй байгааг илтгэдэг хэмээн хүмүүс итгэдэг байна. Өдгөө ч тус нууранд мөнгөн эдлэл өргөх зан үйлийг иргэд идэвхтэй үйлдсээр байгаа бөгөөд үүнтэй холбоотой нэгэн тохиолдлыг судалгааны энэ хэсэгт усан доорх соёлын өвийг хамгаалах эрх зүй орчны дутмаг байдалтай холбоотойгоор авч үзлээ.

### **Хэргийн агуулга**

Иргэн Ц.Д нь бусад хоёр хүний хамт 2018 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр 10 цагийн орчимд Завхан аймгийн Отгон сумын нутаг дэвсгэрт байх Отгонтэнгэр уулын энгэрт байрлах Бадархундага нуурын усанд шумбалт хийн иргэдийн өргөсөн аягыг түүн гаргаж байтал уг нуур орчимд хүмүүс ирэх үед уул өгсөн зугтан нуугдаж тэдний хүрээд ир гэсэн шаардлагыг үл биелүүлэн улмаар өөрийн авч явсан ТО3-8 маркийн буугаар буудаж сум нь хохирогч Ч.О-ын хүзүүний баруун хэсгээр орж хэлний уг хэсгийг дайрч зүүн хацрын дунд хэсгээр нэвт гарч хүндэвтэр гэмтэл учруулан, мөн хохирогч Б.Б-ийн араас буудаж сум нь түүний баруун бугалаганы гадна хэсэгт хайрагдсан шарх үүсгэн хөнгөн гэмтэл учруулсан байна. Ц.Д нь дээрх үйлдлийн дараа хохирогч Б.Б-ээс түүний Nokia маркийн гар утсыг өгөхийг шаардан авч ажиллагаагүй болгосон, хохирогч Ч.О-ын эзэмшлийн Samsung Note-3 маркийн гар утсыг авсан мөн Sony маркийн гэрэл зургийн аппаратыг нь түүний хүү О.А-оос өгөхийг шаардан авч зургийн аппаратыг хад руу шидсэн бөгөөд улмаар хохирогч Ч.О-ын жолоодож явсан Toyota Landcruiser-200 маркийн \*\*-\* УНР улсын дугаартай авто машиныг хэн нэгнийх нь зөвшөөрөлгүйгээр жолоодож зугтан усанд суулган орхисон байна.

### **Шүүхийн шийдвэрлэсэн байдал**

Завхан аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 02 сарын 20-ны өдрийн 21 дугаартай шийтгэл тогтоолд дурдсанаар; Завхан аймгийн Прокурорын газрын хяналтын прокурорын яллах дүгнэлтэд шүүгдэгч Ц.Д-ын үйлдлээс хохирогч Б.Ба-ийн Nokia-N106 маркийн гар утас, хохирогч Ч.О-ын Samsung Note-3 маркийн гар утас, гэрэл зургийн Sony маркийн аппаратыг ТО3-8 маркийн галт зэвсэг хэрэглэж хууль бусаар авсан гэх үйлдлийг Эрүүгийн хуулийн 17.2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.2-д зааснаар зүйлчилж ирүүлснийг хөнгөрүүлэн өөрчилж, Эрүүгийн хуулийн 17.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар зүйлчилсэн байна.

Харин Ганган овогт Ц-ийн Д-ыг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг журамлан тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.6-д заасан буюу Ч.О-, Б.Б- нарыг буудаж алахыг завдсан гэмт хэрэг, Эрүүгийн хуулийн 17.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан буюу хохирогч Ч.О-ын жолоодож явсан Toyota Landcruiser-200 маркийн \*\*-\* УНР улсын дугаартай авто машиныг өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр авч явсан гэмт хэрэг, Эрүүгийн хуулийн 17.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан буюу хохирогч Б.Б-ийн Nokia-N106 маркийн гар утас, хохирогч Ч.О-ын Samsung Note-3 маркийн гар утас, гэрэл зургийн Sony маркийн аппаратыг хууль бусаар гэмтээсний улмаас бага хэмжээнээс дээш хохирол учруулсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцож шийдвэрлэсэн.

Мөн шүүхээс Цагаан өнгийн металлаар бүрсэн нийт 279 ширхэг аяга/амсрын голч нь 7.0-7.5 мм хэмжээтэй аяга 91 ширхэг, амсрын голч нь 8.0-8.5 мм хэмжээтэй аяга 19 ширхэг, амсрын голч нь 85-90 мм хэмжээтэй аяга 19 ширхэг, амсрын голч нь 100-105 мм хэмжээтэй

Аяга 29 ширхэг, амсрын голч нь 115-120 мм хэмжээтэй аяга 78 ширхэг, амсрын голч нь 130-135 мм хэмжээтэй аяга 28 ширхэг, амсрын голч нь 145-150 мм хэмжээтэй аяга 11 ширхэг, амсрын голч нь 155 мм хэмжээтэй аяга 3 ширхэг, амсрын голч нь 170 мм хэмжээтэй аяга 1 ширхэг, аяганы бүрсэн металлаас салж унасан хэсэг болох том, жижиг бүслүүр 33 ширхэг, 10м, жижиг ёроол 54 ширхэг/-ыг улсын орлого болгохоор шийдвэрлэжээ.

Энэхүү хэрэгт шүүх гэмт этгээдүүдийн аль үйлдлийг гэмт хэрэг хэмээн үзсэн бэ гэдэгт анхаарах ёстой юм. Шүүх гэмт этгээдийг 17.8 дугаар зүйлд заасан эд хөрөнгө устгах, гэмтээх гэмт хэрэг, 17.7 дугаар зүйлд заасан автотээврийн хэрэгслийг зөвшөөрөлгүйгээр авч явах гэмт хэрэг үйлдсэн хэмээн, 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.6-д заасанчлан хүнийг алах гэмт хэргийг “хоёр, түүнээс олон хүнийг алах” гэх хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр үйлдэхийг завдсан хэмээн тус тус шийдвэрлэсэн. Харин Бадархундага нуурын усанд шумбалт хийн иргэдийн өргөсөн аягыг түүж авсан үйлдлийг шүүх дараах байдлаар тайлбарлажээ: “Хэрэгт эд мөрийн баримтаар хураагдсан цагаан өнгийн металлаар бүрсэн 279 ширхэг аягыг шүүгдэгч Ц.Д нь Отгонтэнгэр уулын Бадархундага нуурааас гаргаж авсан болох нь тогтоогдсон бөгөөд иргэдийн нууранд өргөсөн аяга гэх тул Монгол Улсын Иргэний хуулийн 96 дугаар зүйлийн 96.1-д зааснаар тухайн иргэд аягаа нууранд өргөснөөр өмчлөх, эзэмших эрх нь дуусгавар болсон бөгөөд өөр бусад хэн нэг иргэд, байгууллагын өмчлөл, эзэмшилд хамаарахгүй байна. Мөн уг аягануудыг шүүгдэгч Ц.Д нь шударгаар олж авсан гэж үзэх боломжгүй учир 279 аягыг бүрсэн металлын салсан хэсгүүдийн хамт улсын орлого болгож шийдвэрлэх нь зүйтэй.” Шүүх ийнхүү үзсэнийг шууд буруутгах үндэслэлгүй. Учир нь Эрүүгийн хуулийн 2.1-т заасанчлан аливаа үйлдлийг гэмт хэрэг хэмээн үзэхийн тулд зайлшгүй тухайн үйлдлийг Эрүүгийн хуульд гэмт хэрэг хэмээн заасан байх ёстой.

Гэвч иргэд тэрхүү мөнгөн аягыг хэн нэгэн олж авна, ашиглана хэмээн мэдэж, хүсэж нууранд хийгээгүй. Тэд тус газар нутаг, нуурыг “аргадах” гэж, өөрсдийнх нь энэхүү зан үйлийг үйлдсэний төлөө нуур хүслийг нь биелүүлнэ, тухайн газар нутгийн цаг агаарын нөхцөл байдал таатай болно хэмээн итгэж энэхүү “өргөх” хэмээх зан үйлийг үйлдсэн юм. Гэтэл өөрт ашиг олох зорилготойгоор тус өргөлийн эд зүйл болох мөнгөн аягануудыг гаргаж авсан нь иргэдийн энэхүү сүсэг бишрэл, итгэл үнэмшлийн эсрэг чиглэсэн үйлдэл мөн. Энэхүү үйлдэл нь Монгол Улсын Үндсэн Хуулийн оршил хэсэгт “төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж...эрхэм зорилго болгоно,” хэмээн тунхаглаж, 16 дугаар зүйлийн 15-т “шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй”, 16-д “итгэл үнэмшилтэй байх” үндсэн эрхүүдийг Монгол Улсын иргэн бүр баталгаатай эдэлнэ хэмээн заасанд үл нийцэх үйлдэл мөн. Харамсалтай нь энэ эрхүүдийг зөрчсөн дээрх үйлдлийг өдгөө хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуульд гэмт хэрэг хэмээн заагаагүй. Үүний улмаас тус хуулийн Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилго хангагдахгүйд хүрч байна.

Мөн түүнчлэн шүүхээс улсын орлого болгохоор шийдвэрлэсэн мөнгөн аягуудыг хайлуулж Эрдэнэсийн санд шилжүүлсэн гэх мэдээлэл бий. Засгийн газрын 2017 оны 195 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлогоболгох, устгах журмын 3.4 дүгээр зүйлд хөрөнгө, эд зүйл, хэрэгслийг шилжүүлэх тухай зохицуулсан бөгөөд тус зүйлийн 3.4.3 дахь хэсэгт үндэсний мөнгөн тэмдэгт, гадаад валют, алт, мөнгө, үнэт эдлэлийг Монголбанкинд шилжүүлэх ёстой байна. Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлд заасанчлан Монголбанк нь Эрдэнэсийн сангийн талаар Эрдэнэсийн санг эрхлэх, Эрдэнэсийн сангийн эрдэнэс, хөрөнгийн хөдөлгөөний бүртгэл хийж, төлбөр тооцоог гүйцэтгэх бүрэн эрхтэй ба мөн тус хуулийн 4.1-т зааснаао Эрдэнэсийн сан төрийн өмчид байна. Түүнчлэн Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-т зааснаар

Эрдэнэсийн сангийн орлого нь иргэн, хуулийн этгээдээс төрд худалдсан, бэлэглэсэн, хандивласан болон хууль тогтоомжийн дагуу шилжүүлсэн эрдэнэсээс бүрддэг. Иймд шүүх нуураас гаргаж авсан мөнгөн аягануудыг Монгол банкинд шилжүүлсэн нь хуульд нийцсэн байна.

Харин хүлээн авсан Монгол банк тэрхүү мөнгөн аягануудыг Эрдэнэсийн сангийн Орлогот шилжүүлэхдээ хайлуулсан нь асуудалтай байж болох юм.

Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 3.1 дүгээр зүйлийн 3.1.1 дэх хэсэгт "эрдэнэс" гэж түүхий эд, хайлш, химийн нэгдэл, бүтээгдэхүүн зэрэг ямар ч байдалд байгаа үнэт металл, эрдэнийн чулуу, түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйл, байгалийн төрцийг, 3.1.2 дахь хэсэгт "үнэт металл" гэж алт, мөнгө, платина болон түүний бүлэгт багтдаг палладий, иридий, родий, рутений, осмийг ойлгохоор тус тус заасан байна. Харин "Эрдэнэсийн сан" гэж мөн зүйлийн 3.1.4 дэх хэсэгт зааснаар төрийн нэрийн өмнөөс Монголбанк эрхэлж, бүрдүүлж, хамгаалж, эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулж байгаа эрдэнэс, түүний дагалдах зүйл, хөрөнгийн хуримтлал гэж тодорхойлжээ.

Эрдэнэсийн сан нь хуульд заасны дагуу үндсэн болон гүйлгээ санд хуваагдах бөгөөд үндсэн сан байнгын болон байнгын бус хэсгээс бүрдэнэ. Үндсэн сангийн байнгын хэсэгт Монгол Улсын хуваагдашгүй өмч болох эрдэнэс байх бөгөөд тэдгээрийг худалдах, шилжүүлэх, захиран зарцуулахыг хориглодог. Харин үндсэн сангийн байнгын бус хэсэгт олон улсын жишгээр цэвэршүүлсэн үнэт металл, засаж өнгөлсөн эрдэнийн чулуу, түүх, соёлын үнэт дурсгалт зүйл, үнэт болон бусад металлаар хийж нөөцөд авсан зоос байдаг байна.

Хуулийн дээрх заалтын дагуу мөнгөн аяга, аяганы бүрсэн металлаас салж унасан хэсэг болох том, жижиг бүслүүр, том, жижиг ёроол нь үнэт метал мөн хэдий ч түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйл ч байх боломжтой юм. Иймийн учир тухан зүйлийг нэн түрүүнд үнэлэх шаардлагатай. Үнэлгээ хийх тухай Засгийн газрын 2017 оны 195 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журамд доорх байдлаар зохицуулсан байна.

**Хоёр. Хураагдсан хөрөнгө, эд зүйл, хэрэгсэлд үнэлгээ хийх, худалдан борлуулах, хохирол, нөхөн төлбөр гаргуулах**

2.1. Эрх бүхий байгууллага, албан тушаалтан албадлагын арга хэмжээ авсантай холбогдуулан хураан авсан хөрөнгөнөөс хохирол нөхөн төлүүлэх, хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслийг улсын орлого болгох, устгах, бусад байгууллагад шилжүүлэх асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлтийг харьяа нутаг дэвсгэрийнхээ Засаг даргын дэргэдэх Зөвлөлд хүргүүлж шийдвэрлүүлнэ.

2.2. Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллага, Засгийн газрын агентлагийн эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хураасан хөрөнгөөс хохирол нөхөн төлүүлэх, хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслийг улсын орлого болгох, устгах, шилжүүлэх асуудлыг зөрчил үйлдэгдсэн нутаг дэвсгэрийн харьяалах Зөвлөл шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд эрх бүхий албан тушаалтны саналыг үндэслэн Зөвлөлийн харьяаллыг прокурор тогтооно. (Энэ дэд заалтад Засгийн газрын 2019 оны 157 дугаар тогтоолоор нэмэлт орсон)

2.3. Зөвлөл нь худалдан борлуулах, улсын орлого болгох, устгах шийдвэр гаргахын өмнө тухайн хөрөнгө, эд зүйл, хэрэгсэлд үнэлгээ хийлгэнэ.

2.4. Эрх бүхий албан тушаалтан энэхүү журмын 2.3-т заасан үнэлгээний талаарх саналаа Зөвлөлд хүргүүлж болно.

2.5. Энэхүү журмын 2.3-т заасан үнэлгээг зөрчил гаргасан этгээдэд танилцуулна. Тухайн этгээд уг үнэлгээг хүлээн зөвшөөрөхгүй талаар гомдол гаргасан тохиолдолд хөндлөнгийн шинжээчээр үнэлгээг дахин нэг удаа хийлгэнэ. Энэ тохиолдолд үнэлгээний зардлыг гомдол гаргасан этгээд хариуцна.

2.6. Хөрөнгө, эд зүйл, хэрэгслийн үнэлгээг тухайн үеийн зах зээлийн үнэ, ханшийн жишгийг харгалзан Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд заасан журмын дагуу тогтооно. Үнэлгээ хийх явцад тухайн хөрөнгө, эд зүйл, хэрэгслийг худалдан борлуулах боломжгүй гэж үзсэн тохиолдолд дахин үнэлгээ тогтоож, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдэнэ.

2.7. Зөвлөлөөс тухайн хөрөнгө, эд зүйл, хэрэгсэлд үнэлгээ тогтоох боломжгүй гэж үзсэн тохиолдолд хөндлөнгийн шинжээчээр үнэлгээ хийлгэнэ.

Дээрх журмын зохицуулалтаас харвал үнэлгээ хийх хөрөнгө, эд зүйл, хэрэгсэл нь соёлын өв байх магадлалтай тохиолдолд хөндлөнгийн шинжээчээр үнэлгээ хийлгэх боломжтой байна. Гэвч усан доороос олдсон эд зүйлийг соёлын өв мөн эсэх, тухайн эд зүйлийн усан доор байсан хугацааг тогтоох шинжилгээ, судалгааны материаллаг бааз болоод боловсон хүчин манай улсад байхгүй. Бадархундага нуурыг хэдий үеэс эхлэн тахиж эхэлсэн нь тодорхойгүй ч нийтлэг байдлаар тахилгын зан үйл дэлгэрсэн цагаас тооцвол 500 орчим жилийн өмнөөс тахисан байх боломжтой юм. Гэтэл тус нуураас гаргаж авсан мөнгөн аягануудыг хайлуулж Эрдэнэсийн санд шилжүүлсэн нь Усан доорх соёлын өвийг хамгаалах эрх зүйн зохицуулалт огт байхгүйг харуулж байна.

Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийн зургаа дугаар зүйлд “Усан доороос гарган авсан соёлын өвийг урт хугацаанд хадгалахын тулд түүнийг хадгалж, хамгаалж, хариуцах ёстой.” гэж, 21 дүгээр зүйлд оролцогч улсууд усан доорх археологийн сургалтыг хүртээмжтэй байлгах, усан доорх соёлын өвийг хадгалж, хамгаалах арга техник болон тохиролцсон нөхцөлд усан доорх соёлын өвтэй холбоотой технологийг дамжуулах чиглэлээр хамтран ажиллах үүргийг хүлээлгэсэн байгаагаас үзвэл тус конвенцод нэгдсэнээр энэ чиглэлээр манай улс бусад оролцогч улсуудтай хамтран ажиллахын сацуу тодорхой хэмжээнд дэмжлэг авч, усан доорх соёлын өвийг хамгаалах салбарыг хөгжүүлэх боломжтой юм.

Эдгээр асуудлын шалтгаан нөхцөл нь дээрх асуудлуудад үндэслэсэн 2021 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 12 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д заасан Усан доорх соёлын өвийг хамгаалах конвенцыг соёрхон батлах тухай хуулийг батлах шалтгаан, нөхцөл болж байна.

## **ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ**

Судалгааны энэ үе шатанд тухайн асуудлыг шийдвэрлэх зорилгыг тодорхойлж, томъёолох ажлыг гүйцэтгэсэн болно. Ингэснээр өмнөх үе шатад хөндөж, гаргаж ирсэн асуудлуудыг шийдвэрлэснээр хүрэх үр дүн, хийж гүйцэтгэх үйл ажиллагааг тодорхойлсон.

Шийдвэрлэх зорилгын тухайд өмнөх шатанд хийсэн дүгнэлтэд үндэслэн “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай ЮНЕСКО-ийн 2001 оны конвенцод нэгдэн орох” хэмээн шийдвэрлэх зорилгыг дэвшүүлж байна.

## **ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЭРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ**

Судалгааны энэхүү гуравдугаар үе шатыг дараах 3 шатлалтайгаар гүйцэтгэсэн болно:

1. Асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоох;
2. Зохицуулалтуудын хувилбаруудын эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах;
3. Харьцуулалтанд үндэслэн хамгийн үр дүнтэй хувилбарыг сонгох.

### 1. Асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоох

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай ЮНЕСКО-ийн 2001 оны конвенцод нэгдэн орох” зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан дараах дүгнэлтийг гаргалаа.

Хүснэгт 5. Асуудлыг зохицуулж болох хувилбаруудын эерэг болон сөрөг тал

| Хувилбар   | Зорилгод хүрэх байдал  | Зардал, үр өгөөжийн харьцаа   | Үр дүн                    |
|--|--|---|---------------------------|
| 1. Тэг хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах                  | Одоогийн тулгамдаж буй асуудлууд хэвээр үргэлжлэх ба зорилгод хүрэх боломжгүй байна.   | Нэмэлт зардал гарахгүй бөгөөд тулгамдсан асуудлууд хэвээр үргэлжлэх тул ямар нэгэн үр өгөөжгүй байна.   | Тодорхой үр дүнд хүрэхгүй |
| 2. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх                 | Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх нь гагцхүү олон нийтэд усан доорх соёлын өвийг хамгаалах үйл ажиллагааг таниулах ач холбогдолтой ч соёлын өвийг хамгаалахад тодорхой зохицуулалт шаардагдах учир зорилгыг биелүүлэхэд шийдвэрлэх нөлөө үзүүлэхгүй байна. | Зардал тодорхой хэмжээгээр шаардагдах хэдий ч тулгамдаж буй асуудлуудыг шийдэх боломжгүй байдалд хүрнэ. | Тодорхой үр дүнд хүрэхгүй |
| 3. Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх | Усан доорх соёлын өвийг хамгаалах нэг чухал шаардлага нь энэхүү соёлын өвийг арилжааны зорилгоор ашиглах нь түгэмээл байдагт оршдог. Иймд зах зээлийн эдийн засгийн хэрэгслийг ашиглах нь зорилгод үл нийцэх эрсдэл бий болгож болох юм.   | Төрөөс их хэмжээний зардал гарах хэдий ч үр өгөөжийн хувьд тодорхойгүй.                                 | Тодорхой үр дүнд хүрэхгүй |
| 4. Төрөөс санхүүгийн интервенц хийх  | Төр санхүүгийн дэмжлэг, нөлөөлөл үзүүлснээр тодорхой   | Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.  |                           |

|    |   |   |  |                            |
|----|---|---|--|----------------------------|
|    |   | хэмжээнд зорилго биелэгдэхэд нөлөөлөхийг үгүйсгэхгүй ч хангалттай биш бөгөөд төрийн энэхүү оролцоо нь эрх зүйн актыг батлан гаргах замаар л хэрэгжих боломжтой тул энэхүү арга нь бие даан асуудлыг зохицуулж зорилгод хүрэх боломжгүй байна.   |  | Тодорхой үр дүнд хүрэхгүй. |
| 5. | Төрийн бус байгууллага, хувийн хэвслээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх | Тодорхой үйл ажиллагаанд тэдний оролцоо, хамтын ажиллагаа ач холбогдолтой боловч зохицуулалт дутагдах учир зорилго хангагдахгүй.  | Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.   | Тодорхой үр дүнд хүрэхгүй. |
| 6. | Захиргааны шийдвэр гаргах   | Усан доорх соёлын өвийг хамгаалах үйл ажиллагаа нь зөвхөн Монгол Улсын нутаг дэвсгэр дэх үйл ажиллагаагаар үл хязгаарлагдах учир олон улсын хамтын ажиллагаа, дэмжлэг зайлшгүй хэрэгтэй. Иймд Захиргааны шийдвэр гаргах буюу захиргааны хэм хэмжээний акт болох журам, дүрмээр тус асуудлыг бүрэн бөгөөд үр дүнтэй зохицуулах боломжгүй юм. | Үүсээд байгаа шалтгаан нь хуулиар зохицуулагдах нь илүү ач холбогдолтой бөгөөд зардлын хувьд журмаар зохицуулах нь илүү зардал бага гарах ч үр өгөөжийн хувьд муу байна. | Үр дүн муутай.             |
| 7. | Хууль тогтоомжийн төсөл боловсруулах                                      | Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай ЮНЕСКО-ийн 2001 оны конвенцыг соёрхон батлах тухай хуулийг баталснаар зорилгод хүрэх бүрэн боломжтой юм.  | Төрөөс хууль батлахтай холбоотой зардал тодорхой хэмжээгээр гарах хэдий ч тус хувилбар нь зорилгод хүрэхэд илүү тохиромжтой, үр өгөөжтэй байна.                          | Үр дүнтэй.                 |

Тэг хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх, зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан

Төрөөс зохицуулалт хийх, төрөөс санхүүгийн интервенц хийснээр тухайн асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэж, дэвшүүлсэн зорилгод хүрэх боломжгүй байна.

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт болох Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын 5 дугаар зүйлийн 5.4-т хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг шууд сонгох дөрвөн тохиолдлыг заасан байх бөгөөд тус зүйлийн 5.4.2 дахь хэсэгт “тухайн асуудлыг гагцхүү хуулиар зохицуулах шаардлагатай болохыг Үндсэн хуульд онцлон заасан бол” хэмээн заажээ. Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.”,<sup>45</sup> 20 дугаар зүйлд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их хурал хадгална.”<sup>46</sup> хэмээгээд Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт: Монгол Улсын хуульд зааснаас өөр журам тогтоож байгаа олон улсын гэрээг заавал соёрхон батална, 16 дугаар зүйлийн 16.3-т: Улсын Их Хурал ...өргөн мэдүүлсэн олон улсын гэрээ соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн дэмжсэн бол тухайн олон улсын гэрээг соёрхон батлах тухай хууль... гаргана<sup>47</sup> гэжээ.

Энэд дурдсанчлан олон улсын гэрээнд нэгдэн орохын тулд зайлшгүй соёрхон батлах тухай хуулийг батлах замаар л нэгдэн орох боломжтой хэмээн Үндсэн хуульд заасан байгаа нь аргачлалын 5.4.2 дахь хэсэгт тохирч байна. Энэхүү судалгааг тус аргачлалын дагуу гүйцэтгэж буй тул хууль тогтоомжийн төсөл боловсруулах зохицуулалтын хувилбарыг шууд сонгох ёстой юм.

Иймд Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай ЮНЕСКО-ийн 2001 оны конвенцод нэгдэн орох зорилгын дагуу хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг сонгосон тул зохицуулалтын хувилбарыг “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай ЮНЕСКО-ийн 2001 оны конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл боловсруулж батлах” хэмээн тодорхойллоо.

Ийнхүү дээр дэвшүүлсэн асуудлыг шийдвэрлэх боломжит 7 хувилбарыг ерөнхий байдлаар нягтлан шалгахад 1-ээс 6 дугаар хувилбар зорилгодоо хүрэхэд төдийлөн үр дүнтэй арга биш бөгөөд шалгах боломжгүй болох нь батлагдсан тул тэдгээрийн үр нөлөөг тооцох шаардлагагүй гэж үзлээ. Харин 7 дугаар хувилбар нь энэхүү судалгаанд дэвшүүлээд буй зорилгод хүрэхэд илүү үр дүнтэй байх боломжтой байгаа тул томъёоллыг хийж үр нөлөөг тооцох ажиллагааг үргэлжлүүлэх нь зүйтэй гэж үзэв.

## **2. Зохицуулалтуудын хувилбаруудын эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах**

Энэ хэсэгт асуудлыг шийдвэрлэх хувилбаруудын эерэг болон сөрөг талыг:

2.1.Зорилгод хүрэх байдал;

2.2.Зардал, үр өгөөжийн харьцаа гэсэн шалгуур үзүүлэлтийг харгалзан харьцуулан судлана.

### **2.1. Зорилгод хүрэх байдал**

<sup>45</sup> Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл, 1992 он, №1 /7/

<sup>46</sup> Мөн тэнд

<sup>47</sup> Олон улсын гэрээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017, №2

Энэхүү шалгуурын хүрээнд зохицуулалтын хувилбар нь анх тавьсан зорилгод хүрч чадах эсэхийг тогтооно.

Тухайн зохицуулалтын хувилбарыг өөр салбарт хэрэглэсэн адилтгах туршлага байна уу, тухайн асуудлаар эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдүүд болон салбарын мэргэжилтнүүд хэр хүлээж авахаар байна гэдгийг ярилцлага, санал асуулга явуулах, өмнө хийгдсэн судалгааны материал ашиглах зэргээр тандан судалсны үндсэн дээр зорилгод хүрэх байдлыг тогтоох юм.

Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр зорилгодоо хүрч чадах эсэхийг тогтооход (1) адилтгах туршлага буюу тодорхой нэг конвенцод нэгдсэнээр соёлын өвийг амжилттай хамгаалсан сайн туршлага (2) эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд болон салбарын мэргэжилтнүүдийн санал болон өмнө хийсэн судалгааны материал зэргийг харгалзах, ашиглах шаардлагатай.

(1) Адилтгах туршлага буюу тодорхой нэг конвенцод нэгдсэнээр соёлын өвийг амжилттай хамгаалж буй сайн туршлага бол “Соёлын биет бус өвийг хамгаалан дэмжих тухай” ЮНЕСКО-ийн 2003 оны Конвенцод нэгдэн орсон жишээ юм.

Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенцыг 2003 онд ЮНЕСКО-ийн Ерөнхий бага хурлын 32 дугаар чуулганаар баталж, Монгол улс 2005 оны 6 дугаар сарын 29-нд нэгдэн орсон байдаг. 2020 оны 7 дугаар сарын байдлаар тус конвенцод 179 орон нэгдэж орсон байна. Энэхүү конвенцыг 2003 онд баталсан нь даяарчлалын орчин үеийн үйл явцаас үүдэн соёлын биет бус өвд тулгараад буй аюул эрсдэлийг даван туулах, нэгдэн шийдвэрлэх алхам болсон юм. Энэ тухай уг конвенцод дараах байдлаар заасан байдаг.

## 2 дугаар зүйл

1. Соёлын биет бус өв гэж хамт олон, бүлэг хүмүүс, зарим тохиолдолд хувь хүмүүс соёлын өвийнхөө бүрэлдэхүүн хэсэг гэж хүлээн зөвшөөрсөн заншил, дүрслэх болон илэрхийлэх хэлбэр, мэдлэг болон дадал, эдгээртэй холбоо бүхий багаж зэмсэг, эд зүйл, урлагийн бүтээл, соёлын орон зайг хэлнэ. Үеэс үед уламжлагдах соёлын биет бус өвийг хамт олон, бүлэг хүмүүс нь тэдгээрийг хүрээлэн буй орчин, байгаль, түүхийн харилцан шүтэлцээнээс шалтгаалан байнга шинэчилдэг бөгөөд тухайн өв нь тэдгээрт оршин тогтнох болон залгамж чанарын мэдрэмж төрүүлж, соёлын төрөл зүйл, хүний туурвилыг хүндэтгэхэд дэмжлэг үзүүлдэг. Энэхүү конвенцын зорилгод олон улсын хүний эрхийн зөвхөн одоо мөрдөж буй баримт бичиг болон хамт олон, бүлэг, хувь хүмүүсийн хоорондын харилцан хүндэтгэл, мөн тогтвортой хөгжлийн шаардлагуудад нийцсэн соёлын биет бус өвийг авч үзнэ.

Үндэснийхээ соёлын биет бус өв (СББӨ)-ийг ЮНЕСКО-д бүртгүүлж баталгаажуулна гэдэг нь тухайн улс үндэстний нэр төрийн хэрэг бөгөөд дэлхийн хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн хүндтэй үүрэг хариуцлага юм. Тухайн өвийг орон нутаг, улс үндэстэн, олон улсын түвшинд танин мэдүүлж, хадгалж хамгаалах, сэргээн амилуулах, түгээн дэлгэрүүлэх явдал хамгийн чухал. Иймд соёлын өвөө бүртгүүлсэн улс орон илүү их идэвх санаачилгатай ажиллах хэрэгтэй болдог.

Соёлын биет бус өвийн нэг өвөрмөц онцлог бол түүний байнга хувьсан өөрчлөгдөж, үргэлжилж байдаг чанар юм. Тухайн өв нь газарзүйн өргөн уудам нутагт оршин байж болох бөгөөд тухайн бүлэг хүмүүст тохиолдож болох олон янзын нөхцөл байдалд дасан зохицож амьдрах чадвартай байдаг аж. Энэ утгаар конвенцийн дагуу бий болгосон Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалт; Хүн төрөлхтний соёлын биет бус

Өвийн Төлөөллийн жагсаалт; Хадгалалт хамгаалалтын шилдэг туршлагын бүртгэл; гэсэн Гурван жагсаалтад хамтран нэр дэвшүүлэхийг оролцогч улсуудад ЮНЕСКО уриалан дэмжиж Байгаа билээ.

2020 оны байдлаар ЮНЕСКО-ийн Соёлын биет бус өвийг хамгаалах тухай 2003 оны Конвенцын Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалт болон Хүн Төрөлхтний соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалтад нийт 549 өвийг бүртгээд байна.

Манай улс 2008 оноос хойш Соёлын биет бус өвийн конвенцийн Яаралтай хамгаалах шаардлагатай болон Төлөөллийн жагсаалтад:

1. *Морин хуур хөгжмийн уламжлалт урлаг (2008)*
2. *Монгол ардын уртын дуу (2008)*
3. *Монгол бий биелгээ, уламжлалт бүжгийн урлаг (2009)*
4. *Монгол тууль (2009)*
5. *Монгол цуур хөгжмийн уламжлалт урлаг (2009)*
6. *Монголын уламжлалт Хөөмэйн урлаг (2010)*
7. *Шувуучлахуй буюу Бүргэдээр ан хийх зан үйл (Ази, Европ, Арабын 18 улстай хамтран) (2010)*
8. *Монгол баяр наадам (2010)*
9. *Монгол лимбэчдийн уртын дуу тоглох уламжлалт арга барил – битүү амьсгаа (2011)*
10. *Монгол уран бичлэг (2013)*
11. *Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл (2013)*
12. *Монгол шагайн харваа (2014)*
13. *Ботго авахуулах зан үйл (2015)*
14. *Уул овоо тахих Монгол зан үйл (2017)*
15. *Хөхүүрийн айраг исгэх уламжлал, холбогдох зан үйл (2019)*

гэх нийт 15 өвийг бүртгүүлсэн юм.<sup>48</sup>

Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенцыг Монгол улсад хэрэгжүүлэх үүднээс ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын зохион байгуулсан арга хэмжээнүүдийн нэг бол Соёл, спорт, аялал жуулчлалын яам, Соёлын өвийн төв, Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнтэй хамтран 2013 онд Улаанбаатар хотноо зохион байгуулсан “Төв Азийн тууль II” олон улсын симпозиум, их наадам юм. Тус симпозиум, их наадамд Монгол, ОХУ-ын Буриад, Тува, Халимаг, Якут /Саха/, БНХАУ-ын Шинжаан-Уйгарын өөртөө засах орон болон Өвөр Монголын өөртөө засах орон, АНУ, БНСУ, Казакстан, Киргизстан, Тажикстан, Конго зэрэг 15 орны 100 гаруй эрдэмтэн судлаачид, авьяастнууд оролцжээ.

Монгол улс 1999 онд “Төв Азийн баатарлаг туульс” гэсэн симпозиум-их наадмыг зохион байгуулж, 10 гаруй орны 120 гаруй авьяастан, эрдэмтэн, судлаач нар оролцсон. Энэ үеэр “Монголын утга соёлын өвийн төв” албан ёсоор байгуулагдаж, “Монголын аман өвийг дүрс болон дугаар баримтжуулах нь” төслийг ЮНЕСКО-ийн тусламжаар хэрэгжүүлж эхэлсэн байдаг. Энэ төслийн хүрээнд 2-3 жилийн хугацаанд нийт 60 гаруй мянган километр зам туулж, 16 аймаг, нийслэл хотын 480 ардын авьяастны урын санг багтаасан 220 цагийн дүрс, 87 цагийн дууны бичлэг хийж бүртгэл мэдээллийн санд авсан юм. Түүнчлэн ардын уламжлалт ёс заншил, аман өвийн холбогдолтой баримтат кино хийснээс гадна ЮНЕСКО-ийн төслөөр 2013-2016 онд хэрэгжсэн “Монгол туулийг хадгалан хамгаалах” төслийн хүрээнд “Монгол тууль” 12 боть ном нийтлэгдсэн болно.

<sup>48</sup> [https://unesco.mn/?page\\_id=150](https://unesco.mn/?page_id=150)

Дээр дурдсан үйл ажиллагаануудаас гадна ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс нь 2012-2020 оны хооронд Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенцыг Монгол улсад хэрэгжүүлэх үүднээс “Япон улсын Итгэлцлийн сан”, БНСУ дахь ЮНЕСКО-ийн 2 дугаар зэрэглэлийн Соёлын биет бус өвийн мэдээлэл солилцооны Ази-Номхон Далайн төв (ICNSAP), БНХАУ дахь ЮНЕСКО-ийн 2 дугаар зэрэглэлийн Ази, Номхон далайн бүсийн Соёлын биет бус өвийн олон улсын сургалтын төв, ЮНЕСКО-ийн Бээжин дэх төлөөлөгчийн газар зэрэг олон улсын байгууллагууд, Монгол улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Соёлын өвийн төв зэрэг үндэсний байгууллагуудтай хамтран “Конвенцын хэрэгжүүлэлт болон хамт олонд түшиглэсэн соёлын биет бус өвийн бүртгэл” сургалт, “СББӨ-ийг хамгаалах тухай ЮНЕСКО-ийн конвенцыг хэрэгжүүлэхэд Монгол улсын чадавхыг бэхжүүлэх нь” сургалт, “СББӨ-ийн хадгалалт, хамгаалалтын төлөвлөгөө” сургалт, “Зүүн хойд Азид Соёлын биет бус өвийн хадгалалт, хамгаалалтын талаар мэдээлэл солилцох, мэдээллийн сүлжээг өргөжүүлэх нь” сэдвээр ээлжит уулзалт семинар, “Соёлын биет бус өв боловсрол: Албан ба албан бус боловсролоор дамжуулан соёлын биет бус өвийг хөхиүлэн дэмжих хамтын ажиллагаа” сэдэвт соёлын биет бус өвийг хадгалан хамгаалах Зүүн хойд Азийн бүс нутгийн хурал зэрэг арга хэмжээнүүдийг тус тус зохион байгуулсан.

Эдгээр сургалт семинарыг олон улсын экспертүүд удирдан явуулж, үндэсний соёл, урлагийн байгууллагуудын мэргэжилтнүүд, төрийн бус байгууллага, өвлөн уламжлагч, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн ажилтнуудад Соёлын биет бус өвийг хамгаалах конвенцтой холбоотой олон улсын эрх зүйн баримт бичиг, олон төрлийн бүтцийг танилцуулан, тэдгээрийг хэрхэн ашигтайгаар хэрэглэх, онолын болон практик хичээлүүдийг зааж, соёлын биет бус өвийг хэрхэн үр дүнтэй хадгалж, хамгаалах тухай ойлголт, мэдээллийг өгсөн юм.

2014 оны 6 дугаар сарын 4-ний өдөр Парис хотноо хуралдсан Соёлын биет бус өвийн конвенцын гишүүн орнуудын Ерөнхий ассамблейн үеэр болсон Засгийн газар хоорондын хорооны сонгуульд Монгол улс нэрээ дэвшүүлэн өрсөлдөж, сонгогдсон билээ. Засгийн газар хоорондын хороо нь нийт 24 гишүүнээс бүрдэх бөгөөд манай улс 2018 оныг хүртэл ажиллав. Хороо нь гишүүн орнуудаас нэр дэвшүүлсэн өвийг бүртгэх, биет бус өвийг хамгаалах, хадгалах зорилгоор улс орнуудад олон улсын санхүүгийн тусламж үзүүлэх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, соёлын биет бус өвийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах ТББ-уудыг томилж эрх олгох зэрэг Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенцийн зорилго, үзэл санааг хэрэгжүүлэхэд хамгийн чухал үүрэг гүйцэтгэдэг.

ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс нь ЮНЕСКО-ийн гишүүн орнууд төдийгүй дэлхий дахинд монголынхоо соёлын өвийг танилцуулах, сурталчлах боломж, бололцоо бүрийг алдалгүй ашиглахыг чармайдаг билээ. Тухайлбал, 2011 онд ЮНЕСКО-ийн Ерөнхий бага хурлын 36 дугаар чуулганы нээлтийн арга хэмжээний хүрээнд ЮНЕСКО-ийн Төв байранд морин хуур, уртын дуу, бий биелгээ, хөөмэй зэрэг монгол үндэстний язгуур соёлын хэв төрх, өвөрмөц онцлогийг илэрхийлсэн “Хөх тэнгэрийн эгшиглэн” нэртэй урлагийн тоглолтыг зохион байгуулж нийт 1300 гаруй үзэгчдийн сонорыг мялаасан. Урлагийн тоглолтыг нээж ЮНЕСКО-ийн Ерөнхий захирал Ирина Бокова, БСШУ-ын сайд Ё.Отгонбаяр нар үг хэлж, монголын язгуур урлагийн арвин их өвийг онцолсон билээ.

Мөн 2012 онд ЮНЕСКО-ийн Төв байранд болсон ЮНЕСКО-ийн Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенцын гишүүн орнуудын Ерөнхий ассамблейн ээлжит 4 дүгээр чуулганы нээлтийн үеэр Монгол улс ЮНЕСКО-д элссэний 50 жилийн ойг тохиолдуулан “Монгол хувцасны нууц товчоон” хэмээх монгол дээлний загварын тоглолтыг Монгол Костюмс ХХК, Парис дахь Монгол улсын ЭСЯ-тай хамтран ЮНЕСКО-ийн МҮК зохион байгуулсан юм. Эдгээр үйл ажиллагаа нь монголын соёлыг дэлхийд сурталчлахаас гадна

ЮНЕСКО-ийн Соёлын биет бус өвийн жагсаалтад шинээр соёлын биет бус өвөө бүртгүүлэхэд чухал нөлөө үзүүлэв.

(2) Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд болон салбарын мэргэжилтнүүдийн санал. 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаар “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийсэн. Уг хуралдаанаар УИХ-ын гишүүн Б.Баярсайхан доорх саналыг гаргасан байдаг.

"Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөлд санал оруулах хүсэлтэй байна. Соёлын яамнаас оруулж ирсэн "Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай" хуулийн төслийг энэ жагсаалтад оруулж өгнө үү?

Бид олон сайхан нууртай. Тэднийгээ хангалттай сайн хамгаалж чадахгүй байна. Жишээ нь Завхан аймагт Отгонтэнгэр хайрханы дэргэд орших Бадархундага нуур, Хөвсгөл аймагт ч бас олон сайхан нуурууд бий.

Монгол Улс Усан доорхи соёлын өвийг хамгаалах тухай ЮНЕСКО-ийн 2001 оны конвенцид нэгдэн орохоор Соёлын яамнаас ажиллаж байгаа. Үүний тулд манай улс Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай хуулийг батлахгүйгээр нэгдэн орох боломжгүй юм. Тиймээс уг хуулийг 2024 он хүртэл хууль, тогтоомжийг боловсронгуй болгох жагсаалтад оруулж өгнө үү.

Японы Такашима арал орчимд далайн гүнд байгаа Юань гүрний усан флотын үлдэгдлийг судлах эрдэмтдийн ажлын хэсэгт манай эрдэмтэд орох хүсэлтэй байдаг ч Монгол улс дээрх конвенцид нэгдээгүй байгаа учир оролцож чаддаггүй."<sup>49</sup>

Ийнхүү гишүүдийн дэмжлэг авснаар 2021 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 12 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 1.13 дахь хэсэгт “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийг соёрхон батлах тухай” хуулийн төслийг боловсруулж, 2023 онд Улсын Их Хуралд өргөн барихаар төлөвлөсөн байна. Төлөвлөгөөнд тусгахдаа хууль санаачлагч нь Засгийн Газар, хариуцан боловсруулах байгууллага нь Соёлын яам байхаар тодорхойлжээ. Тус хуулийн төслийг боловсруулах үндэслэл, зохицуулах харилцааны тухайд товч байдлаар “Усан доорх соёлын өвийг хадгалан хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, хууль бус худалдаа, малтлагаас сэргийлэх нөхцөлийг бий болгох.” хэмээсэн байна<sup>50</sup>.

2021 оны сарын 29, 30-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Соёлын үнэт зүйлийг хууль бусаар хилээр гаргах, оруулах, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай ЮНЕСКО-ийн 1970 оны конвенц батлагдсаны 50 жилийн ойд зориулсан Ази, Номхон далайн бүс нутгийн цахим бага хуралд Соёлын сайд Ч.Номин үг хэлэхдээ “Улс орнууд соёлын эд зүйлсийг хууль бусаар худалдаалах үйл ажиллагаатай хамтран тэмцэж, нийт хүн төрөлхтний хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хил дамнасан олон улсын хамтын ажиллагааны механизмыг улам бүр боловсронгуй болгож бэхжүүлэхийг чухалчлан Монгол Улсын Засгийн газар 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөндөө ЮНЕСКО-ийн 2001 оны Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцод нэгдэн орж, “Хууль сахиулах байгууллагад соёлын өвийн

<sup>49</sup> Б.Баярсайхан: Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай хуулийг боловсронгуй болгох хуулийн жагсаалтад оруулж өгнө үү <https://vip76.mn/content/72473>

<sup>50</sup> Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралт: “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл” Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/annex/details/11551?lawid=16009>

Эсрэг гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх нэгж байгуулан, чадавхыг бэхжүүлэх зорилтыг тусган  
Эжиллаж байгаа” хэмээн Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийг онцолжээ.<sup>51</sup>

Монгол Улс соёлын өвийг хамгаалах хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоход  
Анхаарч, 2023 онд ЮНЕСКО-ийн Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцод нэгдэн  
Орохоор зорьж, бэлтгэл ажлаа хангах хүрээнд усан доорх соёлын өвийг таньж тодорхойлох,  
Хадгалан хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, хууль бус худалдаа, малтлагаас  
Сэргийлэх чиглэлээр Соёлын яам, ЮНЕСКО-ийн Бээжин дэх төлөөлөгчийн газар хамтран  
“Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай 2001 оны конвенц”-ын хүрээнд мэдлэг ойлголтыг  
Нэмэгдүүлэх, чадавх бэхжүүлэх цахим сургалтыг 2021 оны 09 дүгээр сарын 22-ноос 23-ны  
Өдрүүдэд зохион байгуулсан байна.

Сургалтад, ЮНЕСКО-ийн 2001 оны конвенцын нарийн бичгийн дарга нарын газрын  
Хөтөлбөрийн мэргэжилтэн Чихиро Нишикава, Эдинбургийн их сургуулийн судлаач Артуро  
Рей да Силва Итали Улсын Соёлын яамны Усан доорх соёлын өвийн үндэсний удирдах  
Газрын дарга, Барбара Дэвидде тэргүүтэй олон улсын мэргэжилтнүүд оролцжээ.

Монгол Улсаас Соёлын яам, Гадаад харилцааны яам, Хууль зүй, дотоод хэргийн яам,  
Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар,  
ШУА-ийн Археологийн хүрээлэн, Түүх, угсаатны зүйн хүрээлэн, Соёлын өвийн үндэсний төв,  
Чингис хаан музей, Байгалийн түүхийн музей, МУИС, МУБИС, ШУТИС, Улаанбаатарын их  
сургууль, “Монголын археологичдын холбоо” ТББ-ын 65 оролцогч хамрагджээ.<sup>52</sup>

Энэхүү сургалтын нээлтийн арга хэмжээнд Соёлын Дэд сайд М.Батбаяр “Монгол  
Улсын боловсон хүчний усан доорх соёлын өвийн хадгалалт, хамгаалалтын талаарх онол  
болон практикийн мэдлэгийг дээшлүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт эргэлзэхгүй  
байна. Монгол Улс цаашид энэ салбарын шинжээч, мэргэжилтнүүдийг бэлтгэх, техник  
технологийг нэвтрүүлэх, судалгаа шинжилгээний ажлыг эрчимжүүлэх чиглэлд анхаарлаа  
хандуулж ажиллах болно.” хэмээсэн нь соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв  
байгууллагын зүгээс тус конвенцод нэгдэн орох гол давуу талыг зөвөөр үнэлж байгаа нь  
харагдаж байна.

## 2.2. Зардал, үр өгөөжийн харьцаа

Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлэхэд Олон улсын гэрээний тухай хуульд заасан  
олон улсын гэрээ байгуулах асуудлаар хэлэлцээ хийх, томилолтоор ажиллах, төлөөлөгчид  
хүлээн авах, хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулах, олон улсын гэрээ байгуулах, олон  
улсын гэрээнд нэгдэн орохтой холбоотой судалгаа хийх, олон улсын гэрээг орчуулах,  
орчуулгыг хянан баталгаажуулах, олон улсын гэрээний тусгай хэвлэмэл хуудас, хавтас,  
үдээс, лац захиалах<sup>53</sup> зардал улсын төсвөөс гарах бөгөөд аж ахуйн нэгж, байгууллага,  
иргэдэд захиргааны ачаалал, нэмэлт зардал үүсгэхгүй юм.

Нийгэмд үзүүлэх үр өгөөж нь конвенцыг ашиглан усан доорх соёлын өвийг хамгаалах  
эрх зүйн зохицуулалт сайжирч, усан доорх археологийн салбар тус чиглэлээр хөгжиж,

<sup>51</sup> Ч.Номин: Монгол Улс бусад улс орнуудтай хамтран соёлын эд зүйлсийг хууль бусаар  
худалдаалахтай тэмцэнэ, <http://livetv.mn/p/275064>

<sup>52</sup> Усан доорх соёлын өвийг хамгаалах олон улсын сургалт болж байна,  
<https://moc.gov.mn/news/R9RBvYvkXxPuOXxxTkZvYxvukMmZiOcFcv>

<sup>53</sup> Олон улсын гэрээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэг.  
Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017, №2

Цаашид өөрийн улсын түүх, археологийн холбогдол бүхий соёлын өвийг бусад улстай хамтран судлах, малтах боломжтой болох явдал бөгөөд гарах зардлаас ямагт өндөр байна.

#### ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу өмнөх үе шатанд сонгон авсан хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлт гаргалаа.

##### 4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Хүснэгт 6. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөөг тандан судалсан байдал

| Үзүүлэх үр нөлөө                                    | Холбогдох асуулт  | Хариулт |      | Тайлбар   |
|---|---|---------|------|---|
| 1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх | 1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх   |         |      |   |
|   | 1.1.1. Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх   | Тийм    | -    | Усан доорх соёлын өвийг хамгаалах конвенцийн оршил хэсэгт “Усан доорх соёлын өв нь хүн төрөлхтний соёлын өвийн салшгүй хэсэг, ялангуяа ард түмэн, улс үндэстний түүх болон тэдгээрийн нийтлэг өвийн талаарх хоорондын харилцааны чухал элемент болохыг хүлээн зөвшөөрч” хэмээн тунхаглан заасан нь аливаа улс, үндэстэн, тэдгээрийн овог, аймаг, уугуул иргэд хийгээд нийгмийн аливаа бүлгийн соёлын өвийг ялгалгүй хамгаалах эрхэм зорилготойг харуулж байна. Мөн тус конвенцийн зохицуулалт нь Хүний эрхийн түгээмэл тунхаглал /2, 7, 8, 17, 22, 27, 28, 29/, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт /2, 15/, Монгол Улсын Үндсэн хууль /14, 16.3, 16.8, 16.14/-ийн холбогдох зүйл, заалттай бүрэн нийцэж буйг онцлох хэрэгтэй. |
|   | 1.1.2. Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх   | -       | Үгүй |   |
|   | 1.1.3. Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх | Тийм    | -    |   |
|   | 1.2. Оролцоог хангах  |         |      |   |
|   | 1.2.1. Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох  | Тийм    | -    | Дээрх зохицуулалтын хувилбарыг сонгохдоо практикт тулгарч буй бэрхшээл, тулгамдаж буй асуудлыг тодорхойлохын  |

|  |             |   |  |
|--|-------------|---|--|
| боломжийг бүрдүүлсэн эсэх  |             |   | тулд салбарын алба хаагчдын ярилцлага, илтгэл, мэргэжлийн болон олон улсын байгууллагын судалгаанд үндэслэсэн оролцоог хангасан.   |
| 1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх | <b>Тийм</b> | - | Судалгааны нэгдүгээр бүлгийн 1.2-т зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэдийг тодорхойлсон болно.   |
| <b>1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага</b>   |             |   |  |
| 1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх                            | <b>Тийм</b> | - | Усан доорх соёлын өвийг хамгаалах конвенцийн гол зорилго нь усан доорх соёлын өвийн хамгаалалтыг хангах, бэхжүүлэх бөгөөд үүний тулд оролцогч улсуудыг энэ чиглэлээр хамтран ажиллахаар үүрэгжүүлж, усан доорх соёлын өвийг хүн төрөлхтний ашиг тусын тулд хадгалах, усан доорх соёлын өвийг хамгаалахад шаардлагатай бүхий л арга хэмжээг бие даан эсвэл зохих түвшинд хамтран хэрэгжүүлэх зорилгоор өөрсдийн боломж, чадварт нийцүүлэн хамгийн боломжит арга хэрэгслийг ашиглах үүргийг хүлээлгэдэг. Мөн хамгийн чухал нь усан доорх соёлын өвийг арилжааны зорилгоор ашиглахыг хориглодог. Ийнхүү зохицуулснаар соёлын өвийн хууль бус худалдааг хязгаарлаж, соёлын эрхийг хангах, хамгаалахад чухал нөлөө үзүүлнэ. |
| 1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн                             | <b>Тийм</b> | - | Усан доорх соёлын өвийг хамгаалах конвенцийн зорилго болоод үндсэн зохицуулалт нь усан доорх соёлын өвийг арилжааны  |

|   |   |             |   |  |
|---|---|-------------|---|--|
|   | талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх   |             |   | зорилгоор ашиглахыг хориглоход чиглэж соёлын өвийн хууль бус худалдааг хязгаарлаж, соёлын эрхийг хангах, хамгаалах юм. Иймд хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, НҮБ-ын зөвлөмжтэй нийцнэ.   |
|   | 1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх                                     | <b>Тийм</b> | - | Усан доорх соёлын өвийг хамгаалах конвенцийн 14 дүгээр зүйлд заасанчлан конвенцийн Оролцогч Улсууд хууль бусаар экспортлосон болон эсвэл/ энэ Конвенцод харшлах байдлаар олж авсан усан доорх соёлын өвийг нутаг дэвсгэрт нь нэвтрэх, худалдаа хийх, эзэмших, ашиглахыг хориглох арга хэмжээ авна. Түүнчлэн тус конвенцийн 18 дугаар зүйлийн 1-т зааснаар конвенцод үл нийцэх байдлаар усан доороос гарган авсан соёлын өвийг хураан авах арга хэмжээг Оролцогч улс бүр өөрийн нутаг дэвсгэрт авахаар зохицуулсан. |
| 2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх | 2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх | <b>Тийм</b> | - | Усан доорх соёлын өвийг хамгаалах конвенцийн 14, 18 дугаар зүйлд Конвенцод харшлах байдлаар олж авсан соёлын өвийг хураах тухай зохицуулсан нь эрхийн хязгаарлалт мөн боловч тус конвенцийн гол зорилго болох усан доорх соёлын өвийн хамгаалалтыг хангах, бэхжүүлэх, арилжааны зорилгоор ашиглахыг хориглоход уг хязгаарлалт зайлшгүй шаардлагатай болно.   |
|   | 2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх  | <b>Тийм</b> | - |  |
| 3.Эрх агуулагч  | 3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх   | <b>Тийм</b> | - | Усан доорх соёлын өвийг хамгаалах конвенцийн Оролцогч улсууд, эрх бүхий  |

|  |                    |          |   |
|--|--------------------|----------|---|
| <p>агуулагчдыг тодорхойлсон эсэх</p>   |                    |          | <p>байгууллага, соёл, түүх эсвэл археологийн холбоо хамааралтай улс, Зохицуулагч улс, Зөвлөлдөж буй улсууд, Оролцогч улсын харьяаллын иргэн, Конвенцын Нарийн бичгийн дарга нарын газар, ЮНЕСКО-ийн Ерөнхий Захирал</p>   |
| <p>3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх</p>   | <p><b>Тийм</b></p> | <p>-</p> | <p>Усан доорх соёлын өв бүхий Оролцогч Улс нь эмзэг байдал бүхий эрх агуулагч юм.</p>   |
| <p>3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх</p>   | <p><b>Тийм</b></p> | <p>-</p> | <p>Усан доорх соёлын өвийг хамгаалах конвенцийн удиртгал хэсэгт усан доорх соёлын өвийг арилжааны зориулалтаар ашиглах, ялангуяа усан доорх соёлын өвийг худалдах, олж авах эсвэл солилцох зорилготой тодорхой үйл ажиллагаанд гүнээ зовниж буй учир тус конвенцийг баталсан тухай өгүүлсэн байх бөгөөд эндээс усан доорх соёлын өв бүхий бүхий л улсууд өнөөгийн нөхцөл байдалд эмзэг эрх агуулагч болохыг илэрхийлж байна. Харин конвенцийн Оролцогч Улс болсноор Усан доорх соёлын өвийг өнөөгийн байдлаар нь хадгалах, эсвэл, шаардлагатай тохиолдолд шинжлэх ухааны болон хамгаалалтын зорилгоор хянамгай малтаж гаргахад авч хэрэгжүүлэх арга хэмжээний үр дүнг олон улсын, бүс нутгийн болон үндэсний түвшинд нэмэгдүүлэх үүргийг хүлээж, мөн тус үүргийг хүлээсэн улсуудтай хамтран ажиллаж, усан доорх соёлын өвийг хадгалах, хамгаалах, судлахад шаардлагатай бүхий л тусламж, дэмжлэгийг</p> |
| <p>3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)</p> | <p><b>Тийм</b></p> | <p>-</p> | <p>Усан доорх соёлын өвийг хамгаалах конвенцийн удиртгал хэсэгт усан доорх соёлын өвийг арилжааны зориулалтаар ашиглах, ялангуяа усан доорх соёлын өвийг худалдах, олж авах эсвэл солилцох зорилготой тодорхой үйл ажиллагаанд гүнээ зовниж буй учир тус конвенцийг баталсан тухай өгүүлсэн байх бөгөөд эндээс усан доорх соёлын өв бүхий бүхий л улсууд өнөөгийн нөхцөл байдалд эмзэг эрх агуулагч болохыг илэрхийлж байна. Харин конвенцийн Оролцогч Улс болсноор Усан доорх соёлын өвийг өнөөгийн байдлаар нь хадгалах, эсвэл, шаардлагатай тохиолдолд шинжлэх ухааны болон хамгаалалтын зорилгоор хянамгай малтаж гаргахад авч хэрэгжүүлэх арга хэмжээний үр дүнг олон улсын, бүс нутгийн болон үндэсний түвшинд нэмэгдүүлэх үүргийг хүлээж, мөн тус үүргийг хүлээсэн улсуудтай хамтран ажиллаж, усан доорх соёлын өвийг хадгалах, хамгаалах, судлахад шаардлагатай бүхий л тусламж, дэмжлэгийг</p> |

|  |   |             |   |   |
|--|---|-------------|---|---|
|  |   |             |   | Оролцогч Улсуудын болон, олон улсын байгууллагын зүгээс хүлээн авах боломжтой болох юм. Энэ нь бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон, эмзэг байдлыг харгалзсан зохицуулалт юм. |
| 4.Үүрэг хүлээгч  | 4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх   | <b>Тийм</b> | - | Эрх агуулагчид Конвенцийн дагуу тодорхой үүрэг хүлээнэ.   |
| 5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх | 5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх  | <b>Тийм</b> | - | Жендэрийн хувьд ялгавартай байх үзэл хандлага агуулагдаагүй.  |
|  | 5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх | <b>Тийм</b> | - | Хүйсийн тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгаанд шууд сөргөөр нөлөөлөхгүй.  |

#### 4.2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Хүснэгт 7. Эдийн засагт үзүүлэх үр нөлөөг тандан судалсан байдал

| Үзүүлэх үр нөлөө   | Холбогдох асуулт   | Хариулт     |             | Тайлбар   |
|--|--|-------------|-------------|---|
| 1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар                        | 1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх        | -           | <b>Үгүй</b> | Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, өрсөлдөөн, эдийн засаг, гадаадын хөрөнгө оруулалтад ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.  |
|  | 1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан) | -           | <b>Үгүй</b> |   |
|  | 1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх                 | <b>Тийм</b> | -           | Усан доорх соёлын өвийг арилжааны зорилгоор ашиглахыг хориглосноор хууль бус худалдаа, далд зах зээлийн учруулах аливаа сөрөг нөлөөллийг бууруулж хязгаарлах боломж бүрдэнэ._ |
| 2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал | 2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх  | -           | <b>Үгүй</b> | Зах зээлийн өрсөлдөөн, үнийн хөөрөгдөл, монопол байдал бий болгохгүй.   |
|  | 2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх  | -           | <b>Үгүй</b> |   |
|  | 2.3.Зах зээлд шинээр орж ирж   | -           | <b>Үгүй</b> |   |

|  |  |      |      |   |
|--|--|------|------|---|
|  | байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх   |      |      |   |
|  | 2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх  | -    | Үгүй |   |
| 3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал         | 3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх                                 | -    | Үгүй | Аж ахуйн нэгжүүдэд ямар нэгэн зардал, үйл ажиллагааны хязгаарлалт, хориг саад учруулахгүй.  |
|  | 3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх  | -    | Үгүй |   |
|  | 3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх   | -    | Үгүй |   |
|  | 3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх                                   | -    | Үгүй |   |
|  | 3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх  | -    | Үгүй |   |
| 4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал | 4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх | Тийм | -    | Төрийн захиргааны байгууллагаас мэдээлэхтэй холбоотой тодорхой /бага/ зардал гарч болно.  |
| 5.Өмчлөх эрх   | 5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх        | Тийм | -    | Усан доорх соёлын өвийг хамгаалах конвенцийн 14, 18 дугаар зүйлд Конвенцод харшлах байдлаар олж авсан соёлын өвийг хураах тухай зохицуулсан нь эрхийн хязгаарлалт мөн боловч тус конвенцийн гол зорилго болох усан доорх соёлын өвийн хамгаалалтыг хангах, бэхжүүлэх, арилжааны зорилгоор ашиглахыг хориглоход уг хязгаарлалт зайлшгүй шаардлагатай болно |
|  | 5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх                                   | Тийм | -    |   |
|  | 5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх           | -    | Үгүй | Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг  |

|                                     |   |   |      |   |
|-------------------------------------|---|---|------|---|
|                                     |   |   |      | хөндсөн зохицуулалт байхгүй бөгөөд ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.   |
| 6.Инноваци болон судалгаа шинжилгээ | 6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх                                 | - | Үгүй | Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийн удиртгал хэсэгт усан доорх соёлын өвийн судалгаа, малтлага, хамгаалалтад шинжлэх ухааны тусгай арга зүйн ашиглалт, хүртээмжийн хэрэгцээ болон зохих техник, тоног төхөөрөмж, мөн мэргэжлийн өндөр ур чадварыг ашиглах зэрэг асуудлуудад удирдлагын нэгдсэн шалгуур шаардлагатайг харгалзан үзсэний учир тус конвенцийг баталсан хэмээсэн байх бөгөөд конвенцийн 19, 21, 22 дугаар зүйлүүд дээрх үзэл баримтлалыг дэмжсэн тусгай зохицуулалтууд байна. Тус конвенцод нэгдэн орсноор усан доорх археологийн малтлага, судалгаа шинжилгээ, тус салбар дахь шинжлэх ухааны нээлт хийхэд томоохон дэмжлэг авах боломж бүрдэж байна. |
|                                     | 6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх | - | Үгүй | Үйлдвэрлэлийн шинэ технологи нэвтрүүлэх, дэлгэрүүлэх асуудалд нөлөөлөхгүй.  |
| 7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв  | 7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх  | - | Үгүй | Хэрэглэгчийн эрх ашиг, санхүүгийн байдалд ямар нэг  |
|                                     | 7.2.Хэрэглэгчдийн хувьд   | - | Үгүй |   |

|                                 |  |      |      |   |
|---------------------------------|--|------|------|---|
|                                 | дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх   |      |      | сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй.  |
|                                 | 7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх  | -    | Үгүй |   |
|                                 | 7.4.Хувь хүний / гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх               | -    | Үгүй |   |
| 8.Тодорхой бүс нутаг, салбарууд | 8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх                            | -    | Үгүй | Бүс нутаг, байгууллага, салбар, нэгжид ажлын байр нэмэх, хасах, нөлөөлөх зүйлгүй. |
|                                 | 8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх               | -    | Үгүй |   |
|                                 | 8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх  | -    | Үгүй |   |
| 9.Төрийн захиргааны байгууллага | 9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх  | Тийм | -    | Бага хэмжээний урсгал зардал гарна.   |
|                                 | 9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх | -    | Үгүй | Төрийн байгууллагын бүтэц, чиг үүрэгт ямар нэг өөрчлөлт оруулах шаардлагагүй.     |
|                                 | 9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх  | -    | Үгүй |   |
| 10.Макро эдийн засгийн хүрээнд  | 10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх  | -    | Үгүй | Эдийн засаг, ажил эрхлэлт, хөрөнгө оруулалт, инфляцид нөлөөлөхгүй.                |
|                                 | 10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх                        | -    | Үгүй |   |
|                                 | 10.3.Инфляци нэмэгдэх эсэх   | -    | Үгүй |   |
| 11.Олон улсын харилцаа          | 11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх   | Тийм | -    | Венийн болон бусад олон улсын гэрээнүүдтэй нийцнэ.                                |

#### 4.3.Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Хүснэгт 8. Нийгэмд үзүүлэх үр нөлөөг тандан судалсан байдал

| Үзүүлэх үр нөлөө                               | Холбогдох асуулт                     | Хариулт |   | Тайлбар   |
|--|--------------------------------------|---------|---|---|
| 1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл | 1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх | Тийм    | - | Усан доорх соёлын өвийг хамгаалах конвенцод нэгдэн орсноор тодорхой хэмжээнд шинээр |

|  |  |   |             |   |
|--|--|---|-------------|---|
|  |  |   |             | <p>ажлын байр бий болно гэж үзэж байна. Конвенцийн удиртгал хэсэгт Усан доорх соёлын өвийг хамгаалахад улс орнууд, олон улсын байгууллагууд, шинжлэх ухааны хүрээлэнгүүд, мэргэжлийн байгууллагууд, археологичид, шумбагчид, бусад сонирхогч талууд болон олон нийтийг хамарсан хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай гэдэгт итгэсний учир энэхүү конвенцийг баталсан хэмээжээ. Конвенцийн 19, 21, 22 дугаар зүйлүүд дээрх үзэл баримтлалыг дэмжсэн тусгай зохицуулалтууд байна. Тус конвенцод нэгдэн орсноор манай улсын дээр дурдсан салбарт мэргэжлийн боловсон хүчин, мэргэжилтнүүд бэлтгэгдэж улмаар усан доорх археологийн салбар үүсэж, хөгжих юм. Ингэснээр шинээр ажлын байр бий болно.</p> |
|  | 1.2. Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх                         | - | <b>Үгүй</b> | Усан доорх соёлын өвийг хамгаалах конвенцод нэгдэн орсноор ажлын байрны ямар нэг цомхотгол явагдахгүй бөгөөд тодорхой ажил,   |
|  | 1.3. Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх | - | <b>Үгүй</b> |   |
|  | 1.4. Тодорхой насны хүмүүсийн  | - | <b>Үгүй</b> |   |

|  |   |      |      |  |
|--|---|------|------|--|
|  | ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх   |      |      | хөдөлмөр эрхлэгч болон ажил эрхлэлтэд ямар нэг сөрөг нөлөөгүй.   |
| 2. Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх             | 2.1. Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх  | -    | Үгүй | Салбар, байгууллагын ажлын чанар, стандарт, ажилчдын эрх, үүрэг, эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхгүй.  |
|  | 2.2. Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх                           | -    | Үгүй |  |
|  | 2.3. Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх                                | -    | Үгүй |  |
|  | 2.4. Шинээр ажлын стандарт гаргах эсэх  | -    | Үгүй |  |
|  | 2.5. Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх | Тийм | -    | Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийн удиртгал хэсэгт усан доорх соёлын өвийн судалгаа, малтлага, хамгаалалтад шинжлэх ухааны тусгай арга зүйн ашиглалт, хүртээмжийн хэрэгцээ болон зохих техник, тоног төхөөрөмж, мөн мэргэжлийн өндөр ур чадварыг ашиглах зэрэг асуудлуудад удирдлагын нэгдсэн шалгуур шаардлагатайг харгалзан үзсэний учир тус конвенцийг баталсан хэмээсэн байх бөгөөд конвенцийн 19, 21, 22 дугаар зүйлүүд дээрх үзэл баримтлалыг дэмжсэн тусгай зохицуулалтууд байна. |
| 3. Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал | 3.1. Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх                                       | -    | Үгүй | Тэгш бус байдал үүсгэж, нийгмийн эмзэг бүлэгт сөрөг нөлөө үзүүлэхгүй.  |
|  | 3.2. Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг,           | -    | Үгүй |  |

|  |   |             |             |   |
|--|---|-------------|-------------|---|
|  | хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт   |             |             |   |
|  | 3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх  | <b>Тийм</b> | -           | Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийн 14 дүгээр зүйлд Оролцогч Улсууд хууль бусаар экспортлосон болон эсвэл/ энэ Конвенцод харшлах байдлаар олж авсан усан доорх соёлын өвийг нутаг дэвсгэрт нь нэвтрэх, худалдаа хийх, эзэмших, ашиглахыг хориглох арга хэмжээ авах тухай заасан байна. Иймд гадаадын иргэнд нөлөөлөл үзүүлэхээр байна. |
| 4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун | 4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх   | -           | <b>Үгүй</b> | Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.  |
|  | 4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх   | <b>Тийм</b> | -           | Холбогдох яам, агентлаг, байгууллага, албан тушаалтны үүрэг, үйл ажиллагаа, гадаад харилцаанд эерэг нөлөө үзүүлнэ.  |
|  | 4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх   | <b>Тийм</b> | -           |   |
|  | 4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх  | <b>Тийм</b> | -           | Энэхүү эрхийг дэмжиж баталгаажуулна.  |
|  | 4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх   | -           | <b>Үгүй</b> | Ямар нэг сөрөг нөлөөгүй.  |
| 5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал   | 5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх  | -           | <b>Үгүй</b> | Нийтийн эрүүл мэнд, хүмүүсийн амьдралын хэв маягт ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.  |
|  | 5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх | -           | <b>Үгүй</b> |   |
|  | 5.3.Хүмүүсийн амьдралын хэв   | -           | <b>Үгүй</b> |   |

|  |   |      |      |  |
|--|---|------|------|--|
|  | маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх  |      |      |  |
| 6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем | 6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх   | -    | Үгүй | Нийгмийн төрөл бүрийн ажил, үйлчилгээний чанар, хүртээмж, боловсролын тогтолцоо, сургалтын байгууллагын үйл ажиллагаанд ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй. Харин ч холбогдох салбарын хөгжлийг дэмжинэ.  |
|  | 6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх  | -    | Үгүй |  |
|  | 6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх | -    | Үгүй |  |
|  | 6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх  | -    | Үгүй |  |
|  | 6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх  | -    | Үгүй |  |
| 7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал                | 7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх  | Тийм | -    | Соёлын өвийн эсрэг гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлнө. Учир нь Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийн 14 дүгээр зүйлд Оролцогч Улсууд хууль бусаар экспортлосон болон эсвэл/ энэ Конвенцод харшлах байдлаар олж авсан усан доорх соёлын өвийг нутаг дэвсгэрт нь нэвтрэх, худалдаа хийх, эзэмших, ашиглахыг хориглох арга хэмжээ авах үүргийг хүлээсэн байна. |
|  | 7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх   | Тийм | -    | Хуулийн хэрэгжилтийг хангахад эерэгээр нөлөөлнө.   |
|  | 7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх   | Тийм | -    | Конвенцийн дагуу Оролцогч улсууд нь соёлын өвийн эсрэг   |

|        |   |             |             |  |
|--------|---|-------------|-------------|--|
|        |   |             |             | гэмт хэргийн эсрэг хамтран ажиллах үүргийг хүлээсэн байх тул уг гэмт хэргийн илрүүлэлтэд эерэгээр нөлөөлнө.  |
|        | 7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх | -           | <b>Үгүй</b> | Ямар нэг сөрөг нөлөөгүй, харин ч хохирогчийн эрх ашгийг хамгаалахад чиглэнэ.   |
| 8.Соёл | 8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх                     | <b>Тийм</b> | -           | Соёлын өвийг хамгаалахад чухал нөлөөтэй.<br>Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийн удиртгал хэсэгт усан доорх соёлын өв нь хүн төрөлхтний соёлын өвийн салшгүй хэсэг, ялангуяа ард түмэн, улс үндэстний түүх болон тэдгээрийн нийтлэг өвийн талаарх хоорондын харилцааны чухал элемент болохыг хүлээн зөвшөөрсний учир тус конвенцийг батлах болсныг дурдаад тус конвенцийн гол зорилгыг 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Энэ Конвенц нь усан доорх соёлын өвийн хамгаалалтыг хангах, бэхжүүлэх зорилготой” хэмээн заасан байх бөгөөд ийм учир тус конвенцийн зүйл, заалт бүхэн усан доорх соёлын өвийг хамгаалахад чиглэж байгаа болно. |
|        | 8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг           | -           | <b>Үгүй</b> | Хэл, соёлын ялгаатай байдалд   |

|  | ялгаатай байдалд нөлөөлөх эсэх                                     |                    |          | сөрөг нөлөөгүй.  |
|--|--|--------------------|----------|--|
|  | <p>8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх</p> | <p><b>Тийм</b></p> | <p>-</p> | <p>Иргэдийн итгэл, үнэмшил, идэвх, оролцоог нэмнэ. Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийн удиртгал хэсэгт “Усан доорх соёлын өвийн өнөөгийн байдалд нөлөөлөл учруулахгүйгээр боловсролын болон чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх олон нийтийн эрх болон уг өвийн хамгаалалт, үнэлэмж, ойлголтыг нэмэгдүүлэхэд олон нийтийн боловсрол үнэ цэнтэй” хэмээн тунхаглаад тус конвенцийн 20 дугаар зүйлд Оролцогч улс бүр усан доорх соёлын өвийн үнэ цэн, ач холбогдол болон тус Конвенцын дагуу усан доорх соёлын өвийг хамгаалах ач холбогдлын талаар олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх боломжит арга хэмжээг авах үүрэгтэй болохыг тусгайлан зохицуулжээ. Түүнчлэн конвенцийн 2 дугаар зүйлийн 10 дахь хэсэгт усан доорх соёлын өвийн хамгаалалт болон менежментэд нийцэхгүй</p> |

|  |   |                    |   |   |
|--|---|--------------------|---|---|
|  |   |                    |   | <p>тохиолдлоос бусад тохиолдолд дурсгалын хамгаалалт, олон нийтийн ойлголт, хүртээмжийг бий болгох зорилгоор усан доорх соёлын өвийн дурсгалт газарт нөлөөлөл үүсгэхгүйгээр тухайн байгаа байдлыг нь ажиглах эсвэл баримтжуулахыг дэмжих тухай заасан байна.</p>  |
|  | <p>8.4.Хууль бусаар гадаад улсад гаргасан соёлын эд зүйлийг эгүүлэх, буцаах механизмыг бүрдүүлэх эсэх</p> | <p><b>Тийм</b></p> | - | <p>Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийн удиртгал хэсэгт ЮНЕСКО-ийн Соёлын эд зүйлийг хууль бусаар импортлох, экспортлох, өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай 1970 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн Конвенцод нийцүүлэн усан доорх соёлын өвийн хамгаалах, хадгалахтай холбоотой дүрмийг төрөлжүүлэх, үе шаттайгаар хөгжүүлэх шаардлагатай байгааг ухамсарласны учир энэхүү конвенцийг баталсан хэмээжээ. Тус конвенцийн 18 дугаар зүйлд энэ тухай дэлгэрэнгүй</p> |

#### 4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Хүснэгт 9. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг тандан судалсан байдал

| Үзүүлэх үр нөлөө                 | Холбогдох асуулт   | Хариулт |      | Тайлбар   |
|----------------------------------|--|---------|------|---|
| 1. Агаар                         | 1.1. Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх     | -       | Үгүй | Агаарын бохирдлыг нэмэгдүүлэхгүй.   |
| 2. Зам тээвэр, түлш, эрчим хүч   | 2.1. Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх        | -       | Үгүй | Зам тээвэр, түлш, эрчим хүчний хэрэглээ, үйлдвэрлэлд ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй. |
|                                  | 2.2. Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх                                 | -       | Үгүй |   |
|                                  | 2.3. Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх                             | -       | Үгүй |   |
|                                  | 2.4. Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх                  | -       | Үгүй |   |
| 3. Ан амьтан, ургамлыг хамгаалах | 3.1. Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх                                    | -       | Үгүй | Ан, амьтан, ургамал, экологийн тэнцвэрт байдалд сөрөг нөлөө үзүүлэхгүй.               |
|                                  | 3.2. Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх        | -       | Үгүй |   |
|                                  | 3.3. Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх                      | -       | Үгүй |   |
|                                  | 3.4. Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх                 | -       | Үгүй | Хосолмол өв бүхий газар нутгийн хамгаалалтад эерэг нөлөөлнө.                          |
| 4. Усны нөөц                     | 4.1. Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх | -       | Үгүй | Усны чанар, нөөцөд нөлөөлөхгүй.   |
|                                  | 4.2. Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх   | -       | Үгүй |   |
|                                  | 4.3. Ундны усны чанарт нөлөөлөх эсэх   | -       | Үгүй |   |
| 5. Хөрсний бохирдол              | 5.1. Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх                                  | -       | Үгүй | Хөрсний бохирдол, эвдрэл үүсгэхгүй.   |
|                                  | 5.2. Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх             | -       | Үгүй |   |
| 6. Газрын ашиглалт               | 6.1. Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх                                | -       | Үгүй | Газрын ашиглалт, зориулалтыг өөрчлөхгүй.  |
|                                  | 6.2. Газрын зориулалтыг өөрчлөх эсэх   | -       | Үгүй |   |
|                                  | 6.3. Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын                             | -       | Үгүй |   |

|  |  |   |      |   |
|--|--|---|------|---|
|  | зориулалтыг өөрчлөх эсэх   |   |      |   |
| 7.Нөхөн сэргээгдэх /Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг | 7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх | - | Үгүй | Байгалийн баялагийн ашиглалтад ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй. |
|  | 7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх  | - | Үгүй |   |

#### 4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Зохицуулалтын хувилбарын үр нөлөөг шалгах энэ үе шатанд “хуульд нийцэж байгаа байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжийн үзэл санаа, зарчим, утга агуулгад нийцэж байгаа эсэхийг судлан үзнэ. Ингэхдээ зохицуулалтын хувилбар нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинтой холбогдох зохицуулалт, зарчимтай нийцэж буйг тулган үзэж, нарийвчлан шалгадаг.

Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенц нь Удиртгал хэсэг, 35 зүйлтэй бөгөөд конвенцийн зүйл нэг бүрийг Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох бусад хууль, эрх зүйн актын зохицуулалттай харьцуулж шалгах боломжгүй. Учир нь тус конвенцийн ихэнх зохицуулалт далайн усан дахь соёлын өвийн асуудлыг шууд зохицуулсан байна. Далайд гарцгүй манай улсын хувьд тус конвенцийн дотоодын усан дахь зохицуулалт болон нийтлэг зохицуулалт чухал. Түүнчлэн конвенцийн тодорхойлолт хэсэг тэргүүтэй зарим хэсэгт тус шалгалтын ажлыг хийх боломжгүй байна. Иймд тус конвенцийн дотоодын усан дахь зохицуулалт болон нийтлэг зохицуулалт бүхий зүйл, заалтыг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэхийг шалгасан болно.

#### Удиртгал хэсэг

Усан доорх соёлын өв нь хүн төрөлхтний соёлын өвийн салшгүй хэсэг, ялангуяа ард түмэн, улс үндэстний түүх болон тэдгээрийн нийтлэг өвийн талаарх хоорондын харилцааны чухал элемент болохыг **хүлээн зөвшөөрч**,

Усан доорх соёлын өвийг хамгаалахын ач холбогдол болон үүрэг хариуцлагыг бүх оролцогч улсууд **ухамсарлаж**,

Усан доорх соёлын өвийн талаарх олон нийтийн сонирхол, ойлголт өсөн нэмэгдэж буйг **тэмдэглэж**,

Усан доорх соёлын өвийн хадгалалт, хамгаалалтад үзүүлэх судалгаа, мэдээлэл болон боловсролын ач холбогдолд **итгэж**,

Усан доорх соёлын өвийн өнөөгийн байдалд нөлөөлөл учруулахгүйгээр боловсролын болон чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх олон нийтийн эрх болон уг өвийн хамгаалалт, үнэлэмж, ойлголтыг нэмэгдүүлэхэд олон нийтийн боловсрол үнэ цэнтэй гэдэгт **итгэж**,

Усан доорх соёлын өв, түүнд чиглэсэн зөвшөөрөлгүй үйл ажиллагаанаас болж аюулд өртөж буй нөхцөл болон ийм үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэхийн тулд илүү хүчтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байгааг **ойлгож**,

Хууль ёсны үйл ажиллагаанаас үүдэн усан доорх соёлын өвд санамсаргүй байдлаар нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөлд зохих ёсоор хариу өгөх хэрэгцээг мэдэрч,

Усан доорх соёлын өвийг арилжааны зориулалтаар ашиглах, ялангуяа усан доорх соёлын өвийг худалдах, олж авах эсвэл солилцох зорилготой тодорхой үйл ажиллагаанд гүнээ **ЗОВНИЖ**,

Усан доорх соёлын өвийг олж илрүүлэх, түүнд нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх дэвшилтэт технологи буй эсэхийг анхаарч, Усан доорх соёлын өвийг хамгаалахад улс орнууд, олон улсын байгууллагууд, шинжлэх ухааны хүрээлэнгүүд, мэргэжлийн байгууллагууд, археологичид, шумбагчид, бусад сонирхогч талууд болон олон нийтийг хамарсан хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай гэдэгт **ИТГЭЖ**,

Усан доорх соёлын өвийн судалгаа, малтлага, хамгаалалтад шинжлэх ухааны тусгай арга зүйн ашиглалт, хүртээмжийн хэрэгцээ болон зохих техник, тоног төхөөрөмж, мөн мэргэжлийн өндөр ур чадварыг ашиглах зэрэг асуудлуудад удирдлагын нэгдсэн шалгуур шаардлагатай харгалзан **ҮЗЭЖ**,

ЮНЕСКО-ийн Соёлын эд зүйлийг хууль бусаар импортлох, экспортлох, өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай 1970 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн Конвенц, Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах тухай 1972 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн Конвенц, Далайн эрхзүйн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын 1982 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Конвенц зэрэг олон улсын хууль тогтоомж, практикт нийцүүлэн усан доорх соёлын өвийн хамгаалах, хадгалахтай холбоотой дүрмийг төрөлжүүлэх, үе шаттайгаар хөгжүүлэх шаардлагатай байгааг **УХАМСАРЛАЖ**,

Усан доорх соёлын өвийг өнөөгийн байдлаар нь хадгалах, эсвэл, шаардлагатай тохиолдолд шинжлэх ухааны болон хамгаалалтын зорилгоор хянамгай малтаж гаргахад авч хэрэгжүүлэх арга хэмжээний үр дүнг олон улсын, бүс нутгийн болон үндэсний түвшинд нэмэгдүүлэх үүргийг хүлээж, Энэ асуултыг олон улсын Конвенцын сэдэв байх ёстой гэж үзэн хорин ес дэх хурлаараа **ШИЙДВЭРЛЭЖ**, 2001 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр энэ Конвенцыг батлав.

Удиртгалд дурдсан Конвенцын үндсэн зарчим, зорилго нь Монгол Улсын дараах эрх зүйн баримт бичгүүдэд нийцэж байна. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн Хуулийн оршил хэсэгт “Монголын ард түмэн бид...төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж...зорилго болгоно. Үүний учир Монгол Улсын Үндсэн хуулийг даяар олноо зарлан тунхаглаж байна.” хэмээн тунхаглаад Долдугаар зүйлийн 1-т “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна.” хэмээн заасан.
- 2021 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 12 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 1.13 дахь хэсэгт заасны дагуу “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийг соёрхон батлах тухай” хуулийн төслийг боловсруулж, 2023 онд Улсын Их Хуралд өргөн барихаар төлөвлөсөн байна. Ийнхүү төлөвлөхдөө хууль санаачлагч нь Засгийн Газар, хариуцан боловсруулах байгууллага нь Соёлын яам байхаар тодорхойлжээ. Тус хуулийн төслийг боловсруулах үндэслэл, зохицуулах харилцааны тухайд товч байдлаар “Усан доорх соёлын өвийг хадгалан хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, хууль бус худалдаа, малтлагаас сэргийлэх нөхцөлийг бий болгох.” хэмээсэн байна<sup>54</sup>.
- “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийг 2015 оны 5 дугаар сарын 29-ний өдөр батлагдсан “Хууль тогтоомжийн

<sup>54</sup> Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралт: “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл” Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/annex/details/11551?lawid=16009>

тухай хууль/Шинэчилсэн найруулга/-ийн 7 дугаар зүйлийн 7.1-д үндэслэсэн байна. Тус хэсэг буюу 7.1-д “Үндсэн чиглэлийн төслийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал хэлэлцэн батална” гэж заасан байх ба мөн 7.1, 7.2, 7.3-т Засгийн газар тухайн бүрэн эрхийнхээ хугацаанд санаачлах хууль тогтоомжийн талаар урьдчилан төлөвлөж, хууль тогтоомжийг боловсронгуй болгох Үндсэн чиглэлд тусгах, Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох байгууллагын саналыг авч, нэгтгэн судалсны үндсэн дээр Үндсэн чиглэлийн төслийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн боловсруулах, Үндсэн чиглэлийн төсөлд санал өгөх байгууллага нь нийгмийн тухайн харилцааг зохицуулж байгаа хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр уг асуудлаар шинээр хууль гаргах, эсхүл хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлагыг тодорхойлох харилцаануудыг зохицуулжээ.

- Мөн Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.3.6-д “Соёлын өвийг хамгаалах олон улсын гэрээ хэлэлцээрт нэгдэн орох асуудлыг судалж шийдвэрлүүлнэ” гэж<sup>55</sup>, 2.6.3.7-д “соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх зорилгоор хууль, эрх зүйн орчныг сайжруулна” хэмээн тус тус заасан байна.

#### Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийн зүйл, заалт

##### 1. 1 дүгээр зүйл – Тодорхойлолт

Конвенцын зорилго:

1.(a) “Усан доорх соёлын өв” гэж хамгийн багадаа 100 жилийн туршид хэсэгчлэн эсвэл бүхэлдээ тодорхой хугацааны туршид эсвэл байнга усан доор байсан соёл, түүх эсвэл археологийн шинж чанартай, хүний оролцоотой бүхий л ул мөрийг:

(i) Дурсгалт газар, байгууламж, барилга, олдвор болон хүний үлдэц энэ бүгд нь археологийн болон байгалийн хосолмол агуулгаараа;

(ii) Археологийн болон байгалийн хосолмол агуулгаараа буй олдвор, хөлөг онгоц, тээврийн хэрэгсэл болон түүний хэсгүүд, нисэх онгоц, болон бусад бүрэлдэхүүн; болон

(iii) нэн эрт үед хамаарах эд зүйлс.

(b) Далайн ёроолд байрлуулсан дамжуулах хоолой болон кабелийн утсыг усан доорх соёлын өв гэж үзэхгүй.

(c) Шугам хоолой, кабелиас бусад далайн ёроолд байрлуулсан, ашиглагдаж байгаа төхөөрөмжийг усан доорх соёлын өв гэж үзэхгүй.

2.(a) “Оролцогч улсууд” гэдэг нь энэ Конвенцыг дагаж мөрдөхийг хүлээн зөвшөөрсөн болон энэ Конвенц хүчин төгөлдөр мөрдөгдөж буй улсуудыг хэлнэ.

(b) Энэ Конвенцын 26 дугаар зүйлийн 2 (b) хэсэгт заасан Конвенцын нөхцөлийн дагуу талууд болсон нутаг дэвсгэрийг “Оролцогч улсууд” гэж ойлгон шаардлагад нийцүүлсэн өөрчлөлтүүдийг хийнэ.

3.“ЮНЕСКО” гэж Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын Байгууллага.

4.“Ерөнхий Захирал” гэдэг нь ЮНЕСКО-ийн Ерөнхий Захирал.

5.“Харьяалалгүй орон зай” гэж улсын нутаг дэвсгэрийн харьяаллын гадна орших далайн ёроол, далай тэнгисийн ёроол дахь газрын хэвлийг хэлнэ.

6.“Усан доорх соёлын өвд чиглэсэн үйл ажиллагаа” гэж усан доорх соёлын өвийг үндсэн объект болгон ашигладаг, усан доорх соёлын өвийг шууд болон шууд бус байдлаар сүйтгэх, эсвэл гэмтээж болзошгүй үйл ажиллагааг хэлнэ.

7.“Усан доорх соёлын өвд санамсаргүй нөлөөлж буй үйл ажиллагаа” гэж усан

<sup>55</sup> Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт: “Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” Эх сурвалж: <https://legalinfo.mn/inn/detail/15804>

доорх соёлын өвийг үндсэн объект эсвэл тэдний аль нэг объект болохыг үл харгалзан, усан доорх соёлын өвийг бодитойгоор сүйтгэх, гэмтээж болзошгүй үйл ажиллагааг хэлнэ.

8.“Улсын хөлөг онгоц, агаарын хөлөг” гэж живэх хүртэл нь худалдааны бус зориулалтаар зөвхөн засгийн газар ашиглаж, тухайн улсын эзэмшилд байж, үйл ажиллагаа явуулж байсан усан доорх соёлын өвийн тодорхойлолтыг хангасан байлдааны хөлөг онгоц, бусад хөлөг онгоц болон нисэх онгоцыг хэлнэ.

9.“Дүрэм” гэж энэ Конвенцын 33 дугаар зүйлд заасан, усан доорх соёлын өвд чиглэгдсэн үйл ажиллагааны дүрмийг хэлнэ.

#### Нийцэж буй эрх зүйн актын холбогдох хэсэг

### 2. Соёлын тухай хууль

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."соёлын үнэт зүйл" гэж түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах, эсхүл хүний оюун санаа, үйлдэхүйн үр дүнд бий болсон соёлын агуулга бүхий биет болон биет бус илэрхийллийг;

### 3. Соёлын өвийг хамгаалах тухай хууль

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."соёлын өв" гэж түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах байгаль, нийгэм, түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдол бүхий өвийг;

3.1.2."соёлын биет өв" гэж түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлөх биетээр оршин байгаа дурсгалыг;

3.1.3."түүх, соёлын үл хөдлөх дурсгал" гэж унаган газартаа хүрээлэн байгаа орчны хамт үнэ цэнэ, ач холбогдол нь илэрхийлэгдэх дангаар болон цогцолбор байдлаар орших дурсгалыг;

3.1.4."түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл" гэж тодорхой орон зайд шилжүүлэн байрлуулах боломжтой дурсгалыг;

3.1.6."соёлын өвийн дурсгалт газар" гэж соёлын биет болон биет бус өв нь байгаль орчин, уламжлалт ахуйтайгаа харилцан шүтэлцсэн соёлын орон зай, газар нутгийг;

#### 4 дүгээр зүйл.Соёлын өвийн ангилал

4.1.Соёлын өвийг биет ба биет бус гэж ангилна.

4.2.Соёлын биет өвийг түүх, соёлын үл хөдлөх дурсгал болон хөдлөх дурсгалт зүйл гэж ангилна.

#### 5 дугаар зүйл.Түүх, соёлын үл хөдлөх дурсгал

5.1.Дараах соёлын биет өвийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр түүх, соёлын үл хөдлөх дурсгалд хамааруулна:

5.1.1.эртний ургамал, амьтны олдворт газар;

5.1.2.эртний хүний оршин сууж байсан ул мөрийг хадгалсан соёлт давхарга;

5.1.3.чулуун зэвсгийн олдворт газар;

5.1.4.хадны зураг, бичээс;

5.1.5.булш, хиргисүүр, оршуулга, тахил, тайлгын байгууламж;

5.1.6.эртний хот суурин, сүм хийдийн үлдэгдэл, түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгал;

5.1.7.хөшөө дурсгал;

5.1.8.эрт цагт ашигт малтмал олборлож, боловсруулж үйлдвэрлэл, газар тариалан эрхэлж байсан газар, түүнд холбогдох чулуун дурсгал;

5.1.9.тахилгат газар;

5.1.10.түүхэн үйл явдал болсон дурсгалт газар;

5.1.11.бусад түүх, соёлын үл хөдлөх дурсгал.

**6 дугаар зүйл.Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл**

6.1.Дараах соёлын биет өвийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлд хамааруулна:

6.1.1.ховор эрдэс;

6.1.2.эрдэнийн чулууны ховор олдвор;

6.1.3.солир;

6.1.4.ховор болон ховордсон ургамлын хатаамал цуглуулга, амьтны чихмэл;

6.1.5.эртний ургамал, амьтны олдвор;

6.1.6.археологийн олдвор;

6.1.7.угсаатны хувцас, чимэглэл;

6.1.8.уламжлалт аж ахуйн тоног хэрэгсэл, хөдөлмөрийн багаж зэвсэг;

6.1.9.угсаатан, ястны уламжлалт хөгжмийн зэмсэг, эд өлгийн зүйл;

6.1.10.уламжлалт тоглоом, наадгай;

6.1.11.уламжлалт шашин, шүтлэгийн холбогдолтой эд өлгийн зүйл;

6.1.12.бичгийн дурсгалт зүйл;

6.1.13.дүрс, дуу авианы баримт;

6.1.14.дүрслэх урлагийн бүх төрлийн бүтээл, холбогдох эд өлгийн зүйл;

6.1.15.уламжлалт монгол эмнэлгийн оношилгоо, эмчилгээний хэрэглэгдэхүүн, тэдгээрт холбогдох эд өлгийн зүйл;

6.1.16.гэр, сууц, тэдгээрт холбогдох эд өлгийн зүйл;

6.1.17.бусад түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл.

**38 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалахтай холбоотой хориглох үйл ажиллагаа**

38.1.Соёлын өвд хохирол учруулж болзошгүй дараах үйл ажиллагааг хориглоно:

38.1.1.түүх, соёлын дурсгалт газар түүний орчны бүсэд дэд бүтцийн барилга байгууламж барих, уул уурхай, газар тариалан эрхлэх, үйлдвэрлэл явуулах;

38.1.2.палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэхгүйгээр хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, тариалангийн талбай олгох, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулж газар олгох;

38.1.3.хуульд зааснаас бусад тохиолдолд нийтийн өмчийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр өөр байгууллага, орчинд шилжүүлэн хадгалах, зөөж тээвэрлэх, хөдөлгөх;

38.1.4.улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалд зар сурталчилгааны самбар, бичиг хадах, анхны хэлбэр төрх, хийц, бүтээцийг өөрчлөх.

38.2.Палеонтологи, археологи, угсаатны урьдчилсан хайгуул, судалгааны ажлын дүгнэлтээр соёлын өвд эрсдэл учирч болзошгүй байгаа нь тогтоогдсон бол аж ахуйн үйл ажиллагааг зогсоох үндэслэл болно.

38.3.Газрын хэвлийг эзэмших, ашиглах явцад соёлын биет өв илэрвэл газрын хэвлийг ашиглагч ажлаа зогсоож, энэ тухай сум, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг хариуцсан байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

Соёлын тухай хууль дахь соёлын үнэт зүйлийн тодорхойлолт, Соёлын өвийг хамгаалах тухай хууль дахь соёлын өвийн тодорхойлолт нь тухайн ойлголтуудыг хэт ерөнхий тодорхойлсон байх бөгөөд конвенцод нэгдэн ороход тус тодорхойлолтыг өөрчлөх шаардлага тулгарах нь зайлшгүй. Учир нь тус конвенцод “Усан доорх соёлын өв” гэж хамгийн багадаа 100 жилийн туршид хэсэгчлэн эсвэл бүхэлдээ тодорхой хугацааны туршид эсвэл байнга усан доор байсан соёл, түүх эсвэл археологийн шинж чанартай, хүний оролцоотой бүхий л үл мөрийг ойлгохоор тодорхойлсон байгаа нь Соёлын өвийг хамгаалах тухай хуульд заасан соёлын биет өвд хамаарахаар байгаа ч илүү нарийн шалгуур тогтоосон учир тусгайлан тодорхойлохоос өөр аргагүйд хүргэж байна. Түүнчлэн конвенцод нэгдэн орсон тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан түүх, соёлын хөдлөх дурсгалт

Зүйлийн жагсаалтад “живсэн хөлөг онгоц, агаарын хөлөг” гэж нэмэх, “Усан доорх соёлын өвд чиглэсэн үйл ажиллагаа”, “Усан доорх соёлын өвд санамсаргүй нөлөөлж буй үйл ажиллагаа” гэх ойлголтуудыг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хуульчлах шаардлагатай.

| Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийн зүйл, заалт |  |
|--|--|
| 1.   | <p><b>2 дугаар зүйл – Зорилго, ерөнхий зарчим</b></p> <p>1.Энэ Конвенц нь усан доорх соёлын өвийн хамгаалалтыг хангах, бэхжүүлэх зорилготой.</p> <p>2.Оролцогч улсууд усан доорх соёлын өвийг хамгаалах чиглэлээр хамтран ажиллана.</p> <p>3.Оролцогч улсууд энэхүү Конвенцын заалтад нийцүүлэн усан доорх соёлын өвийг хүн төрөлхтний ашиг тусын тулд хадгална.</p> <p>4.Оролцогч улсууд нь энэ Конвенц болон олон улсын хууль тогтоомжид нийцүүлэн усан доорх соёлын өвийг хамгаалахад шаардлагатай бүхий л арга хэмжээг бие даан эсвэл зохих түвшинд хамтран хэрэгжүүлэх зорилгоор өөрсдийн боломж, чадварт нийцүүлэн хамгийн боломжит арга хэрэгслийг ашиглана.</p> <p>5.Усан доорх соёлын өвд чиглэсэн аливаа үйл ажиллагааг зөвшөөрөх эсвэл хийхээс өмнө усан доорх соёлын өвийг оршин байгаа газарт одоогийн байдлаар нь хадгалах нь хамгаалалтын эхний сонголт гэж үзэх ёстой.</p> <p>6.Усан доороос гарган авсан соёлын өвийг урт хугацаанд хадгалахын тулд түүнийг хадгалж, хамгаалж, хариуцах ёстой.</p> <p>7.Усан доорх соёлын өвийг арилжааны зорилгоор ашиглахыг хориглоно.</p> <p>8.Үндэсний туршлага болон Олон улсын хууль тогтоомж, түүний дотор НҮБ-ын Далайн эрх зүйн тухай Конвенцтой уялдуулан энэ Конвенцын зүйл, заалт нь олон улсын эрх зүйн дүрэм болон тухайн улсын бүрэн эрхт байдал, улсын усан онгоц, нисэх онгоцтой холбогдох аливааэрхийг өөрчилнө гэж тайлбарлагдахгүй болно.</p> <p>9.Оролцогч улсууд далай, тэнгисийн усан дахь хүний бүх төрлийн үлдэгдэлд зохих ёсоор хүндэтгэлтэй хандана.</p> <p>10.Усан доорх соёлын өвийн хамгаалалт болон менежментэд нийцэхгүй тохиолдлоос бусад тохиолдолд дурсгалын хамгаалалт, олон нийтийн ойлголт, хүртээмжийг бий болгох зорилгоор усан доорх соёлын өвийн дурсгалт газарт нөлөөлөл үүсгэхгүйгээр тухайн байгаа байдлыг нь ажиглах эсвэл баримтжуулахыг дэмжиж болно.</p> |
| Нийцэж буй эрх зүйн актын холбогдох хэсэг                      |  |
| 2.   | <p><b>Монгол Улсын Үндсэн Хууль</b></p> <p>Долдугаар зүйл.</p> <p>1.Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна.</p> <p>Аравдугаар зүйл.</p> <p>2.Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.</p> <p>3.Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.</p>   |
| 3.   | <p><b>Соёлын тухай хууль</b></p> <p><b>4 дүгээр зүйл.Төрөөс соёлын талаар баримтлах бодлого</b></p> <p>4.1.Төрөөс соёлын талаар дараах бодлого хэрэгжүүлнэ:</p> <p>4.1.1.соёлын өвийг төрийн онцгой анхаарал, ивээлд байлгах;</p> <p><b>21 дүгээр зүйл.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх</b></p> <p>21.1.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага соёлын үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>21.1.7.соёлын гадаад харилцаа, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, соёлын үнэт зүйлийг сурталчлах ажлыг зохион байгуулах;</p> <p><b>27 дугаар зүйл.Олон улсын хамтын ажиллагаа</b></p> <p>27.1.Олон улсын хамтын ажиллагааг дараах чиглэлээр дэмжиж, хөгжүүлнэ:</p> <p>27.1.1.монголын түүх, соёлд холбогдох соёлын өвийг сурвалжлан олох, судалж шинжлэх, хадгалж хамгаалах талаар уг өв байгаа улстай хамтран ажиллах;</p> <p>27.1.2.монголын түүх, соёлд холбогдох соёлын үнэт зүйлийн хуулбарыг авчрах;</p> <p>27.1.3.хууль бусаар алдагдсан соёлын өвийг эргүүлэн авчрах;</p>   |

27.1.4.монголын түүх, соёлыг гадаадад сурталчлах;  
27.1.5.соёлын биет өвийг сэргээн засварлах;  
27.1.6.уран бүтээл хамтран бүтээх, солилцох;  
27.1.7.соёлын ажилтныг сургах, мэргэшүүлэх;  
27.1.8.соёлын үйл ажиллагаанд шинэ техник технологи, инновац, тоног төхөөрөмж нэвтрүүлэх;  
27.1.9.соёлын боловсрол олгох сургалтын арга зүй, сургалтын хөтөлбөрийг харилцан солилцох.  
27.2.Төрийн холбогдох байгууллага бүрэн эрхийнхээ хүрээнд энэ хуулийн 27.1-д заасан чиглэлийн дагуу үйл ажиллагаа эрхэлнэ.

**4. Соёлын өвийг хамгаалах тухай хууль**

**13 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх**

13.1.Засгийн газар соёлын өвийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:  
13.1.4.язгуур гарал үүсэл нэг, илэрхийлэгдэх шинжээрээ нийтлэг, монгол угсаатны түүхэнд ач холбогдол бүхий соёлын өвийг хамгаалах талаар уг өв хадгалагдаж буй гадаад улстай хэлэлцээр хийх, хамтын ажиллагааг хөгжүүлэх;  
13.1.5.улсын хилээр гарч алдагдсан соёлын биет өвийг эргүүлэн авчрах ажлыг зохион байгуулах, холбогдох байгууллагад чиглэл өгөх, хэрэгжилтэд хяналт тавих;

**30 дугаар зүйл.Олдвор**

30.1.Түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдол бүхий үнэт зүйл оршин байгаа нутаг дэвсгэр, газрын хэвлий нь төрийн хамгаалалтад байх бөгөөд аливаа олдвор нь төрийн өмч мөн.

30.2.Олдворыг хадгалах, хамгаалах, судлахдаа түүний эх төрх, бүрэн бүтэн байдал, хэлбэр, шинж чанарыг алдагдуулж гэмтээхийг хориглоно.

**35 дугаар зүйл.Соёлын биет өвийг худалдах, худалдан авах**

35.4.Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд худалдахыг хориглоно.

35.5.Палеонтологи, археологийн олдворыг худалдахыг хориглоно.

**36 дугаар зүйл.Соёлын биет өвийг ашиглах**

36.1.Соёлын биет өвийг сурталчлах, судалгаа, шинжилгээ, сургалт явуулах зориулалтаар ашиглана.

36.2.Соёлын биет өвийг сурталчлах, судалгаа, шинжилгээ хийх, сургалт явуулах зориулалтаар ашиглахдаа гэмтээх, үрэгдүүлэхийг хориглоно.

**37 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тогтолцоо**

37.1.Соёлын өвийг хамгаалах асуудлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага болон бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, энэ хуулиар үүрэг хүлээсэн байгууллага, эрх бүхий этгээд хариуцна.

37.2.Соёлын өвийн хамгаалалтад соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, бүх шатны Засаг дарга, соёлын өвийн хяналтын улсын байцаагч, гэрээт харуул, хуулиар эрх олгосон байгууллага, албан тушаалтан хяналт тавина.

37.3.Соёлын өвийн анхны төрх, нэгдмэл цогц байдлыг алдагдуулахгүйгээр тухайн орон нутагт нь хадгалах зарчим баримтална. Хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулах зорилгоор соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний зөвшөөрлөөр төрийн болон, орон нутгийн музейд шилжүүлэн хадгалж болно.

Тус конвенцийн зорилго, ерөнхий зарчим нь Монгол Улсын Үндсэн Хууль, төрөөс соёлын талаар баримтлах бодлого, зарчмыг тодорхойлж, соёлын үйл ажиллагаа эрхлэх, түүний удирдлага, зохион байгуулалт, оролцогчдын эрх, үүрэг, эдийн засгийн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулах зорилготой Соёлын тухай хууль, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалах, хамгаалах, сэргээн засварлах, сэргээн уламжлуулах, өвлүүлэх, өмчлөх, эзэмших, ашиглах, сурталчлахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилготой Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн холбогдох зүйл, заалтуудад бүрнээ нийцэж байгааг дээрх хүснэгтээс харагдаж байна.

| Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийн зүйл, заалт |  |
|--|--|
| 1.   | 3 дугаар зүйл – Энэ конвенц болон Далайн эрхзүйн тухай НҮБ-ын Конвенц хоорондын хамаарал<br>Энэ Конвенцын зүйл, заалт нь НҮБ -ын Далайн эрх зүйн тухай Конвенц зэрэг олон улсын хууль, эрх зүйд заасан улс орнуудын эрх, харьяалал, үүргийг зөрчихгүй. Энэ Конвенцыг олон улсын хууль, эрх зүй түүний дотор НҮБ-ын Далайн эрх зүйн тухайн Конвенцын хүрээнд нийцүүлэн тайлбарлаж, хэрэглэнэ. |
| Нийцэж буй эрх зүйн актын холбогдох хэсэг                      |  |
| 2.   | <b>Монгол Улсын Үндсэн Хууль</b><br>Аравдугаар зүйл.<br>2. Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.<br>3. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.   |
| 3.   | <b>Конвенц соёрхон батлах тухай</b><br>1996 оны 5 дугаар сарын 28-ны өдөр<br>1 дүгээр зүйл. Монтего-Бей хотноо 1982 оны 12 дугаар сарын 10-ны өдөр байгуулагдсан "Далайн эрх зүйн тухай НҮБ-ын Конвенц"-ийг Засгийн газраас өргөн мэдүүлсний дагуу соёрхон баталсугай.   |

Тус конвенцийн дээрх зүйлд НҮБ -ын Далайн эрх зүйн тухай Конвенц зэрэг олон улсын хууль, эрх зүйд заасан улс орнуудын эрх, харьяалал, үүргийг зөрчихгүй бөгөөд энэ Конвенцыг олон улсын хууль, эрх зүй түүний дотор НҮБ-ын Далайн эрх зүйн тухайн Конвенцын хүрээнд нийцүүлэн тайлбарлаж, хэрэглэхээр заажээ. Монгол Улс нь 1996 оны 5 дугаар сарын 28-ны өдөр Монтего-Бей хотноо 1982 оны 12 дугаар сарын 10-ны өдөр байгуулагдсан "Далайн эрх зүйн тухай НҮБ-ын Конвенц"-ийг Засгийн газраас өргөн мэдүүлсний дагуу соёрхон баталсан байдаг. Иймд Монгол Улсын Үндсэн Хууль болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд нийцсэн буюу харшлахааргүй байна.

| Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийн зүйл, заалт |   |
|--|---|
| 1.   | <b>6 дугаар зүйл – Хоёр талт, бүс нутгийн эсвэл бусад олон талт хэлэлцээрүүд</b><br>1. Оролцогч улсууд нь усан доорх соёлын өвийг хадгалах зорилгоор хоёр талт, бүс нутгийн болон бусад олон талт хэлэлцээр байгуулах, эсвэл одоо байгаа гэрээг сайжруулж ажиллахад дэмжлэг үзүүлнэ. Ийм бүх хэлэлцээр нь энэ Конвенцын зүйл заалттай бүрэн нийцэж байх ёстой бөгөөд түүний нийтлэг шинж чанарыг алдагдуулахгүй байна. Улс орнууд ийм хэлэлцээр хийснээр усан доорх соёлын өвийг энэ Конвенцод тусгаснаас илүү сайн хамгаалж чадахуйц дүрэм, журам баталж болно.<br>2. Хоёр талт, бүс нутгийн болон бусад олон талт хэлэлцээрт оролцогч талууд нотлогдохуйц хамаарал бүхий, ялангуяа соёл, түүх эсвэл археологийн холбоо хамааралтай улс орнуудыг усан доорх соёлын өвийн талаарх хэлэлцээрт нэгдэхийг урьж болно.<br>3. Конвенц батлахаас өмнө Оролцогч улсуудын байгуулсан живсэн хөлөг онгоцыг хамгаалах хоёр талт, бүс нутгийн болон бусад олон талт гэрээ, хэлэлцээр болон ялангуяа энэ Конвенцын зорилго, зорилттой нийцэж эрх үүргүүдэд өөрчлөлт оруулахгүй. |
| Нийцэж буй эрх зүйн актын холбогдох хэсэг                      |   |
| 2.   | <b>Монгол Улсын Үндсэн Хууль</b><br>Долдугаар зүйл.<br>1. Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна.<br>Аравдугаар зүйл.<br>2. Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.<br>3. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.  |
| 3.   | <b>Соёлын тухай хууль</b><br>21 дүгээр зүйл. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх<br>21.1. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага соёлын үйл   |

ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

21.1.7.соёлын гадаад харилцаа, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, соёлын үнэт зүйлийг сурталчлах ажлыг зохион байгуулах;

27 дугаар зүйл.Олон улсын хамтын ажиллагаа

27.1.Олон улсын хамтын ажиллагааг дараах чиглэлээр дэмжиж, хөгжүүлнэ:

27.1.1.монголын түүх, соёлд холбогдох соёлын өвийг сурвалжлан олох, судалж шинжлэх, хадгалж хамгаалах талаар уг өв байгаа улстай хамтран ажиллах;

27.1.2.монголын түүх, соёлд холбогдох соёлын үнэт зүйлийн хуулбарыг авчрах;

27.1.3.хууль бусаар алдагдсан соёлын өвийг эргүүлэн авчрах;

27.1.4.монголын түүх, соёлыг гадаадад сурталчлах;

27.1.5.соёлын биет өвийг сэргээн засварлах;

27.1.6.уран бүтээл хамтран бүтээх, солилцох;

27.1.7.соёлын ажилтныг сургах, мэргэшүүлэх;

27.1.8.соёлын үйл ажиллагаанд шинэ техник технологи, инновац, тоног төхөөрөмж нэвтрүүлэх;

27.1.9.соёлын боловсрол олгох сургалтын арга зүй, сургалтын хөтөлбөрийг харилцан солилцох.

27.2.Төрийн холбогдох байгууллага бүрэн эрхийнхээ хүрээнд энэ хуулийн 27.1-д заасан чиглэлийн дагуу үйл ажиллагаа эрхэлнэ.

4. **Соёлын өвийг хамгаалах тухай хууль**

13 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх

13.1.Засгийн газар соёлын өвийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

13.1.4.язгуур гарал үүсэл нэг, илэрхийлэгдэх шинжээрээ нийтлэг, монгол угсаатны түүхэнд ач холбогдол бүхий соёлын өвийг хамгаалах талаар уг өв хадгалагдаж буй гадаад улстай хэлэлцээр хийх, хамтын ажиллагааг хөгжүүлэх;

13.1.5.улсын хилээр гарч алдагдсан соёлын биет өвийг эргүүлэн авчрах ажлыг зохион байгуулах, холбогдох байгууллагад чиглэл өгөх, хэрэгжилтэд хяналт тавих;

Конвенцод Оролцогч улсууд нь усан доорх соёлын өвийг хадгалах зорилгоор хоёр талт, бүс нутгийн болон бусад олон талт хэлэлцээр байгуулах, эсвэл одоо байгаа гэрээг сайжруулж ажиллахад дэмжлэг үзүүлэх ба ийм бүх хэлэлцээр нь энэ Конвенцын зүйл заалттай бүрэн нийцэж байх ёстой бөгөөд түүний нийтлэг шинж чанарыг алдагдуулахгүй байх ёстой. Улс орнууд ийм хэлэлцээр хийснээр усан доорх соёлын өвийг энэ Конвенцод тусгаснаас илүү сайн хамгаалж чадахуйц дүрэм, журам баталж болно. Түүнчлэн хоёр талт, бүс нутгийн болон бусад олон талт хэлэлцээрт оролцогч талууд нотлогдохуйц хамаарал бүхий, ялангуяа соёл, түүх эсвэл археологийн холбоо хамааралтай улс орнуудыг усан доорх соёлын өвийн талаарх хэлэлцээрт нэгдэхийг урьж болно.

Энэхүү зохицуулалт нь манай улсын хувьд онцгой ач холбогдолтой. Өөрийн улстай соёл, түүх эсвэл археологийн холбоо хамааралтай улс орнуудтай усан доорх соёлын өвийг хамгаалах тухайд хамтын ажиллагаа хэрэгжүүлэхэд тус конвенц дэмжлэг болно. Иймийн учир энэхүү конвенцод нэгдэн орох бол холбогдох хуулиудад усан доорх соёлын өвийг хадгалах зорилгоор хоёр талт, бүс нутгийн болон бусад олон талт хэлэлцээр байгуулах, олон улсын хамтын ажиллагааны тухай дэлгэрэнгүй зохицуулалтыг нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хуульчлах нь чухал.

**Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийн зүйл, заалт**

- |    |  |
|----|--|
| 1. | 7 дугаар зүйл – Дотоодын ус, арал хоорондын ус болон харьяа тэнгис дэх усан доорх соёлын өв  |
|    | 1. Оролцогч улсууд бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ дотоодын ус, арал хоорондын ус болон харьяа тэнгис дэх усан доорх соёлын өвд чиглэсэн үйл ажиллагааг зохицуулах, зөвшөөрөх онцгой эрхтэй.  |
|    | 2. Усан доорх соёлын өвийг хамгаалахтай холбоотой бусад олон улсын хэлэлцээр, олон улсын эрх зүйн хэм хэмжээг зөрчихгүйгээр Оролцогч улсууд дотоодын ус, арал хоорондын ус, харьяа тэнгис дэх усан доорх соёлын өвд чиглэсэн үйл ажиллагаанд |

энэхүү Дүрмийг хэрэглэнэ.

3. Арал хоорондын ус болон харьяа далай тэнгистээ бүрэн эрхээ хэрэгжүүлж, улс орнууд болон оролцогч улсын нийтлэг туршлагыг танин мэдэж, улсын өмчит хөлөг онгоц болон нисэх онгоцыг хамгаалах хамгийн сайн арга зүйгээр хамтран ажиллахын тулд энэ Конвенцод нэгдсэн Оролцогч улсын далбаа, хэрэгцээтэй тохиолдолд танигдахуйц улсын өмчит хөлөг онгоц, агаарын хөлгийг илрүүлсэнтэй холбогдуулан бусад улсуудтай хамаарах нотлогдохуйц холбоо хамаарал, ялангуяа соёл, түүхийн эсвэл археологийн холбоо хамаарлыг тус тус мэдэгдэнэ.

**Нийцэж буй эрх зүйн актын холбогдох хэсэг**

**2. Монгол Улсын Үндсэн Хууль**

Долдугаар зүйл.

1. Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна.

Аравдугаар зүйл.

2. Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.

3. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.

**3. Соёлын тухай хууль**

2 дугаар зүйл. Соёлын хууль тогтоомж

2.1. Соёлын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

**4. Соёлын өвийг хамгаалах тухай хууль**

2 дугаар зүйл. Соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж

2.1. Соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Соёлын тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

Манай улсад тус конвенцийн Оролцогч улсын дотоодын ус, арал хоорондын ус болон харьяа тэнгис дэх усан доорх соёлын өвд чиглэсэн үйл ажиллагааг бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ зохицуулах, зөвшөөрөх онцгой эрхтэй болохыг хязгаарласан ямар нэг хууль тогтоомж байхгүй байна.

**Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийн зүйл, заалт**

1. 14 дүгээр зүйл – Нутаг дэвсгэрт нэвтрэх, худалдаалах болон эзэмшихэд хяналт тавих Оролцогч Улсууд хууль бусаар экспортлосон болон эсвэл/ энэ Конвенцод харшлах байдлаар олж авсан усан доорх соёлын өвийг нутаг дэвсгэрт нь нэвтрэх, худалдаа хийх, эзэмших, ашиглахыг хориглох арга хэмжээ авна.

**Нийцэж буй эрх зүйн актын холбогдох хэсэг**

**2. Монгол Улсын Үндсэн Хууль**

Долдугаар зүйл.

1. Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна.

Аравдугаар зүйл.

2. Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.

3. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.

**3. Соёлын тухай хууль**

9 дүгээр зүйл. Соёлын үйл ажиллагааны чиглэл

9.2. Соёлын өвийг хамгаалахтай холбогдсон харилцааг Соёлын өвийг хамгаалах тухай хуулиар нарийвчлан зохицуулна.

**4. Соёлын өвийг хамгаалах тухай хууль**

10 дугаар зүйл. Соёлын биет өвийн даатгал

10.1.Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг үзэсгэлэнд оролцуулах, сэргээн засварлах, судалгаа шинжилгээ хийлгэх зорилгоор Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд заавал даатгуулна.

**14 дүгээр зүйл.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**

14.1.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага соёлын өвийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

14.1.11.түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлэх, палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийх зөвшөөрөл олгох;

**24 дүгээр зүйл.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн мэдээллийг ашиглах**

24.3.Соёлын биет өв алдагдсан тохиолдолд соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг хариуцсан байгууллага холбогдох мэдээллийг хил, гааль, цагдаа, хяналтын байгууллагад нэн даруй хүргүүлэх арга хэмжээ авна.

**32 дугаар зүйл.Төрийн өмчийн соёлын биет өвийг эзэмшигчийн эрх, үүрэг**

32.2.Соёлын биет өвийг эзэмшигч дараах үүрэг хүлээнэ:

32.2.4.түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хилээр гаргахад зохих журмын дагуу зөвшөөрөл авах;

**33 дугаар зүйл.Соёлын биет өвийг өмчлөгчийн эрх, үүрэг**

33.2.Соёлын биет өвийг өмчлөгч иргэн, хуулийн этгээд дараах үүрэг хүлээнэ:

33.2.1.соёлын өвийн гарал үүслийн байдлыг тодорхойлох;

33.2.2.харьяалах аймаг, нийслэлийн Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлэх;

33.2.3.худалдах, бэлэглэх, өвлүүлэх зэргээр өмчлөх эрхээ бусдад шилжүүлсэн тохиолдолд тухайн шатны Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд мэдэгдэх;

33.2.4.түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хилээр гаргахад зохих журмын дагуу зөвшөөрөл авах;

33.2.5.алдагдаж, үрэгдсэн тохиолдолд нэн даруй тухайн шатны Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан, Засаг дарга, цагдаагийн байгууллагад мэдэгдэх;

33.2.6.түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг худалдах анхны саналыг төрд тавих;

33.2.7.түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд бэлэглэх, өвлүүлэх зэргээр түүний өмчлөлд шилжүүлэхгүй байх.

**35 дугаар зүйл.Соёлын биет өвийг худалдах, худалдан авах**

35.1.Соёлын биет өвийг түрээслэх, худалдах, худалдан авах, түр солилцох журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

35.2.Соёлын биет өвийг худалдан авах ажлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, улс, орон нутгийн музей, номын сан олон нийтэд нээлттэй, ил тод хэлбэрээр зохион байгуулна.

35.3.Соёлын биет өвийг худалдан авсан байгууллага жил бүр үзэсгэлэн зохион байгуулж, нийтэд сурталчилна.

35.4.Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд худалдахыг хориглоно.

35.5.Палеонтологи, археологийн олдворыг худалдахыг хориглоно.

**36 дугаар зүйл.Соёлын биет өвийг ашиглах**

36.1.Соёлын биет өвийг сурталчлах, судалгаа, шинжилгээ, сургалт явуулах зориулалтаар ашиглана.

36.2.Соёлын биет өвийг сурталчлах, судалгаа, шинжилгээ хийх, сургалт явуулах зориулалтаар ашиглахдаа гэмтээх, үрэгдүүлэхийг хориглоно.

**Эрүүгийн хууль**

**18.5 дугаар зүйл.Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх**

1.Хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу хориглосон бараа, эрдэнэс, эрдсийг Монгол Улсын хилээр, гаалийн хилээр хууль бусаар нэвтрүүлсэн бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийг түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, музейн үзмэр, эртний амьтны, ургамлын өвөрмөц ховор үнэт олдвор, археологийн, палеонтологийн олдвор, эд өлгийн зүйлийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлж үйлдсэн бол арван мянган

нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

**25.5 дугаар зүйл. Соёлын биет өвийн хууль бус худалдааг зохион байгуулах, зуучлах**

1. Соёлын биет өвийн худалдааг хууль бусаар явуулсан, зуучилсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

**25.6 дугаар зүйл. Түүх, соёлын дурсгалт зүйлийг тогтоосон хугацаанд хилээр оруулж ирэхгүй байх**

1. Түүх, соёлын дурсгалт зүйлийг хуулиар тогтоосон журмын дагуу тогтоосон хугацаанд улсын хилээр оруулж ирээгүй бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлийг хуулиар тогтоосон журмын дагуу тогтоосон хугацаанд улсын хилээр оруулж ирээгүй, эсхүл түүх, соёлын дурсгалт зүйлийг завшсан бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

**Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх журам.**

Дөрөв. Лиценз олгох

4.1. Засгийн газраас хосгүй үнэт дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Засгийн газрын 2002 оны 219 дүгээр тогтоолоор баталсан "Улсын хилээр төрийн хяналтын дор нэвтрүүлэх бараанд экспорт, импортын лиценз олгох журам"-д заасны дагуу зөвшөөрөл хүсэгчид улсын хилээр нэвтрүүлэх лиценз (цаашид "лиценз" гэх) олгоно.

4.2. Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага Засгийн газрын 2002 оны 219 дүгээр тогтоолоор батлагдсан "Улсын хилээр төрийн хяналтын дор нэвтрүүлэх бараанд экспорт, импортын лиценз олгох журам"-д заасны дагуу лицензийн эх хувь, хуулбар хувь /MNS 5022:2001 стандартын "D" хавсралт/-ийг тус бүр нэг хувь монгол хэлээр үйлдэнэ. Лицензийн өргөдөл, эх хувь, хуулбар хувьд Төрийн захиргааны төв байгууллагын соёлын асуудал хариуцсан нэгжийн дарга гарын үзэг зурж, яамны тэмдэг дарж баталгаажуулна.

**Улсын хилээр төрийн хяналтын дор нэвтрүүлэх бараанд экспорт, импортын лиценз олгох журам.**

Хоёр. Лиценз авах өргөдөл гаргах, хянан шийдвэрлэх журам.

2.6 Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол лицензийг энэхүү журмын 2 дугаар хавсралтад заасан "MNS 5022:2001" стандартын "D" маягтаар олгоно.

**Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам.**

Арван гурав. Бусад

13.3. Гаалийн хилээр нэвтрүүлэхийг хязгаарласан бараа, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, барилгын материал, бүх төрлийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, түүхий эд, боловсруулаагүй эсхүл дахин боловсруулах бараа, химийн болон цацраг идэвхит бодис, ашигт малтмал, уул уурхайн бүтээгдэхүүн, түүх, соёлын дурсгалт зүйлс, палеонтологийн болон археологийн олдвор, шинжлэх ухаан, техникийн ололт, газар нутгийн дүрс, зураг зүйн бусад материал, судалгаа шинжилгээний материал, хүнсний бүтээгдэхүүн зэрэг бараанд "Барааны гаалийн бүрдүүлэлтийн хуудас" /Маягт №2/-аар гаалийн бүрдүүлэлт хийхгүй.

Тус конвенцийн 14 дүгээр зүйлд нутаг дэвсгэрт нэвтрэх, худалдаалах болон эзэмшихэд хяналт тавих асуудлыг зохицуулсан байх бөгөөд Оролцогч Улсууд хууль бусаар экспортлосон болон эсвэл/ энэ Конвенцод харшлах байдлаар олж авсан усан доорх соёлын өвийг нутаг дэвсгэрт нь нэвтрэх, худалдаа хийх, эзэмших, ашиглахыг хориглох арга хэмжээ

Авах үүргийг хүлээнэ. Манай улсын хувьд хууль бусаар соёлын өвийг өөрийн нутаг дэвсгэрт оруулах, гаргах, хууль бус худалдаа хийх, эзэмших, ашиглахаас урьдчилсан сэргийлэхэд чиглэсэн эрх зүйн тогтолцоо салбарын хуулиудаас эхлэн Эрүүгийн хууль, нарийвчлан зохицуулсан журмууд бүхий тун нарийн болохыг дээрх хүснэгтээс харж болохоор байна.

| <b>Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийн зүйл, заалт</b> |   |
|---|---|
| <b>1.</b>   | 15 дугаар зүйл – Оролцогч улсуудын харьяалал дахь газрыг ашиглахгүй байх<br>Оролцогч улсууд өөрийн газар нутаг түүнд хамаарах далайн боомт, хиймэл арал, барилга, байгууламж зэрэг тусгай харьяалал, хяналттай газруудад усан доорх соёлын өвд чиглэсэн энэ Конвенцод үл нийцэх аливаа үйл ажиллагааг дэмжих, ашиглахыг хориглох арга хэмжээ авна.  |
| <b>Нийцэж буй эрх зүйн актын холбогдох хэсэг</b>                      |   |
| <b>2.</b>   | <b>Монгол Улсын Үндсэн Хууль</b><br>Долдугаар зүйл.<br>1. Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна.<br>Аравдугаар зүйл.<br>2. Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.<br>3. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.  |
| <b>3.</b>   | <b>Соёлын тухай хууль</b><br>4 дүгээр зүйл. Төрөөс соёлын талаар баримтлах бодлого<br>4.1. Төрөөс соёлын талаар дараах бодлого хэрэгжүүлнэ:<br>4.1.1. соёлын өвийг төрийн онцгой анхаарал, ивээлд байлгах;  |
| <b>4.</b>   | <b>Соёлын өвийг хамгаалах тухай хууль</b><br>38 дугаар зүйл. Соёлын өвийг хамгаалахтай холбоотой хориглох үйл ажиллагаа<br>38.1. Соёлын өвд хохирол учруулж болзошгүй дараах үйл ажиллагааг хориглоно:<br>38.1.1. түүх, соёлын дурсгалт газар түүний орчны бүсэд дэд бүтцийн барилга байгууламж барих, уул уурхай, газар тариалан эрхлэх, үйлдвэрлэл явуулах;<br>38.1.2. палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэхгүйгээр хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, тариалангийн талбай олгох, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулж газар олгох;<br>38.1.3. хуульд зааснаас бусад тохиолдолд нийтийн өмчийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр өөр байгууллага, орчинд шилжүүлэн хадгалах, зөөж тээвэрлэх, хөдөлгөх;<br>38.1.4. улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалд зар сурталчилгааны самбар, бичиг хадах, анхны хэлбэр төрх, хийц, бүтээцийг өөрчлөх.<br>38.2. Палеонтологи, археологи, угсаатны урьдчилсан хайгуул, судалгааны ажлын дүгнэлтээр соёлын өвд эрсдэл учирч болзошгүй байгаа нь тогтоогдсон бол аж ахуйн үйл ажиллагааг зогсоох үндэслэл болно.<br>38.3. Газрын хэвлийг эзэмших, ашиглах явцад соёлын биет өв илэрвэл газрын хэвлийг ашиглагч ажлаа зогсоож, энэ тухай сум, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг хариуцсан байгууллагад нэн даруй мэдэгдэнэ. |

Тус конвенцийн 15 дугаар зүйлд Оролцогч улсуудын харьяалал дахь газрыг ашиглахгүй байхтай холбогдсон хязгаарлалтын арга хэмжээ авах тухай заасан байна. Оролцогч улсууд өөрийн газар нутаг түүнд хамаарах далайн боомт, хиймэл арал, барилга, байгууламж зэрэг тусгай харьяалал, хяналттай газруудад усан доорх соёлын өвд чиглэсэн энэ Конвенцод үл нийцэх аливаа үйл ажиллагааг дэмжих, ашиглахыг хориглох арга хэмжээ авах үүргийг хүлээдэг байна. Энэхүү зохицуулалт нь Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн холбогдох зүйлтэй нийцэж байна. Харин тус хуулийн 38 дугаар зүйлд тодорхойлсон соёлын өвийг хамгаалахтай холбоотой хориглох үйл ажиллагаанууд нь газар, газрын доорх соёлын өвд шууд хамаарах агуулгатай байгааг анхаарах хэрэгтэй ба Усан доорх соёлын өвийг

Хамгаалах тухай конвенцод нэгдэн орсон тохиолдолд конвенцийн зохицуулалтад нийцүүлэх үүднээс тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага үүсэхээр байна.

| Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийн зүйл, заалт |   |
|--|---|
| 1.   | 16 дугаар зүйл – Иргэн болон хөлөг онгоцтой холбоотой арга хэмжээ<br>Оролцогч улсууд нь харьяаллын иргэн болон далбаа бүхий усан онгоц нь усан доорх соёлын өвд чиглэсэн энэ Конвенцод үл нийцэх аливаа үйл ажиллагаа явуулахгүй байх боломжит бүх арга хэмжээг авна.   |
| Нийцэж буй эрх зүйн актын холбогдох хэсэг                      |   |
| 2.   | <b>Монгол Улсын Үндсэн Хууль</b><br>Долдугаар зүйл.<br>1. Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна.<br>Аравдугаар зүйл.<br>2. Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.<br>3. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.  |
| 3.   | <b>Далай ашиглах тухай хууль</b><br>3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ<br>3.1. Энэ хууль нь Монгол Улсын төрийн далбаа мандуулсан хөлөг онгоцоор тээвэр хийх, далай ашиглах үйл ажиллагаа явуулах иргэн, хуулийн этгээдэд улсын харьяалал, өмчийн төрөл, хэлбэрээс үл хамааран үйлчилнэ.<br>3.2. Монгол Улсын төрийн далбаа мандуулсан хөлөг онгоц дээр зөвхөн Монгол Улсын хууль үйлчилнэ.<br>4.1.2. "Монгол Улсын төрийн далбаа мандуулсан хөлөг онгоц" гэж энэ хуулийн 22 дугаар зүйлийн дагуу Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэгдсэн хөлөг онгоцыг;  |
| 4.   | <b>Соёлын тухай хууль</b><br>6 дугаар зүйл. Соёлын үйл ажиллагаа<br>6.1. Соёлын үйл ажиллагаа соёлын үнэт зүйлийг бүтээн туурвих, судлан шинжлэх, хадгалж хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, хөгжүүлэхтэй холбоотой бүхий л үйл ажиллагаанаас бүрдэнэ.<br>6.2. Соёлын үйл ажиллагаа бүх нийтийн оролцоонд тулгуурлана.<br>14 дүгээр зүйл. Соёлын талаарх иргэний эрх, үүрэг<br>14.2. Монгол Улсын иргэн соёлын талаар дараах үүрэг хүлээнэ:<br>14.2.1. эх хэл, бичиг үсэг, үндэсний түүх, соёл, өв уламжлал, зан заншил, үнэт зүйлийг хамгаалах, хойч үедээ өвлүүлэх;<br>14.2.2. соёлын илэрхийллийн олон төрлийг хүндэтгэх, соёлын үнэт зүйлийг хамгаалах;<br>14.2.4. соёлын үнэт зүйлийг хууль бус халдлагаас хамгаалах.<br>14.3. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн энэ хуулийн 14.2.2, 14.2.4-т заасан үүрэг хүлээнэ.<br>16 дугаар зүйл. Соёлын үйл ажиллагааг дэмжих талаарх аж ахуйн нэгж, байгууллагын оролцоо<br>16.1. Соёлын үйл ажиллагааг дэмжих талаар аж ахуйн нэгж, байгууллага дараах хэлбэрээр оролцоотой байна:<br>16.1.1. соёлын илэрхийллийн олон төрлийг хүндэтгэх, соёлын үнэт зүйлийг хадгалж хамгаалах;<br>17 дугаар зүйл. Соёлын үйл ажиллагааг дэмжих талаарх төрийн бус байгууллагын оролцоо<br>17.1. Соёлын үйл ажиллагааг дэмжих талаар мэргэжлийн төрийн бус байгууллага дараах үйл ажиллагааг явуулж болно:<br>17.1.1. соёлын хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;<br>17.1.2. соёлын илэрхийллийн олон төрөл, үндэсний соёлын үнэт зүйлийг хадгалж хамгаалах, түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг зохион байгуулах;<br>17.2. Соёлын үнэт зүйлийг ашиглах, хамгаалах онцгой эрхийг хэрэгжүүлэх зорилго |

бүхий ашгийн төлөө бус хамтын удирдлагын байгууллагын саналыг салбарын хууль тогтоомж боловсруулахад харгалзан үзэж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж болно. 22 дугаар зүйл. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

22.1. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага соёлын үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

22.1.1. соёлын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;

22.1.4. соёлын үнэт зүйлийг хадгалах, хамгаалах ажлыг зохицуулах, үндэсний соёл, дизайны уламжлалыг дэмжин хөгжүүлэх;

32 дугаар зүйл. Соёлын үйл ажиллагааны санхүүжилт

32.6. Соёлын үйл ажиллагааг дэмжих, соёлын өвийг хамгаалах зорилгоор иргэн, хуулийн этгээдээс оруулсан хандив, хөрөнгө оруулалтад албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх журмыг холбогдох хуулиар тогтооно.

**5. Соёлын өвийг хамгаалах тухай хууль**

14 дүгээр зүйл. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

14.1. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага соёлын өвийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

14.1.1. соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой дүрэм, журам, зааврыг баталж, хэрэгжилтийг хангах;

Далай ашиглах тухай хууль нь Монгол Улсын төрийн далбаа мандуулсан хөлөг онгоцоор тээвэр хийх, далайн баялаг хайх, ашиглах, олборлох, загас агнах, далайн шинжлэх ухааны судалгаа хийх зэрэг далай ашиглах үйл ажиллагаа явуулах, далай дахь аюулгүй байдлыг хангах, далайн орчныг хамгаалах, хөлөг онгоц бүртгэх, далбааны эзэн улсын эрх, үүргийг хэрэгжүүлэх, хөлөг онгоц дээрх хөдөлмөрийн харилцаа, далайчны чадамжийн гэрчилгээг баталгаажуулахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилготой хууль бөгөөд уг хуулийн үйлчлэлийн хувьд Монгол Улсын төрийн далбаа мандуулсан хөлөг онгоцоор тээвэр хийх, далай ашиглах үйл ажиллагаа явуулах иргэн, хуулийн этгээдэд улсын харьяалал, өмчийн төрөл, хэлбэрээс үл хамааран үйлчлэх ба Монгол Улсын төрийн далбаа мандуулсан хөлөг онгоц дээр зөвхөн Монгол Улсын хууль үйлчилнэ.

Гэвч уг хуульд Монгол Улсын төрийн далбаа мандуулсан хөлөг онгоц усан доорх соёлын өвтэй холбоотой ямар нэг харилцаанд орох бол хэрхэх тухай ямар ч зохицуулалт байхгүй байна. Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийн 16 дугаар зүйлд Оролцогч улсууд нь харьяаллын иргэн болон далбаа бүхий усан онгоц нь усан доорх соёлын өвд чиглэсэн энэ Конвенцод үл нийцэх аливаа үйл ажиллагаа явуулахгүй байх боломжит бүх арга хэмжээг авах тухай заасан байх тул тус конвенцод нэгдэн орох бол Далай ашиглах тухай хуульд конвенцийн зохицуулалтад нийцүүлэх үүднээс нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай байна.

**Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийн зүйл, заалт**

- |    |  |
|----|--|
| 1. | 17 дугаар зүйл – Хориг арга хэмжээ<br>1. Оролцогч улс бүр энэхүү Конвенцыг хэрэгжүүлэх арга хэмжээг зөрчсөн тохиолдолд хориг арга хэмжээ авна.<br>2. Зөрчилд ногдуулсан хориг арга хэмжээ нь энэ Конвенцыг хэрэгжүүлэхэд үр дүнтэй байх, зөрчил гарсан тохиолдолд зөрчлийг таслан зогсоох болон гэмт хэрэгтнүүдийн хууль бус үйл ажиллагаанаас ашиг хүртдэг байдлыг үгүй болгоход хангалттай хэмжээнд чиглэгдсэн байх ёстой.<br>3. Оролцогч улсууд нь энэ зүйлийн хүрээнд тавьсан хориг арга хэмжээг мөрдүүлэхэд хамтран ажиллана. |
|----|--|

**Нийцэж буй эрх зүйн актын холбогдох хэсэг**

- |    |   |
|----|---|
| 2. | <b>Монгол Улсын Үндсэн Хууль</b><br>Долдугаар зүйл. |
|----|---|

1. Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна. Аравдугаар зүйл.
2. Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.
3. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.

Энэхүү Конвенцыг хэрэгжүүлэх арга хэмжээг зөрчсөн тохиолдолд Оролцогч улс бүр хориг арга хэмжээ авах эрхтэй ба зөрчилд ногдуулсан хориг арга хэмжээ нь энэ Конвенцыг хэрэгжүүлэхэд үр дүнтэй байх, зөрчил гарсан тохиолдолд зөрчлийг таслан зогсоох болон гэмт хэрэгтнүүдийн хууль бус үйл ажиллагаанаас ашиг хүртдэг байдлыг үгүй болгоход хангалттай хэмжээнд чиглэгдсэн байх ёстой. Үүгээр зогсохгүй Оролцогч улсууд нь энэ зүйлийн хүрээнд тавьсан хориг арга хэмжээг мөрдүүлэхэд хамтран ажиллах үүргийг хүлээлгэсэн байна. Хэдийгээр уг зүйл нь сөрөг үр дагавар бүхий зохицуулалт хэдий ч гагцхүү конвенцийг зөрчсөн тохиолдолд л үйлчлэхээр байна.

#### Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийн зүйл, заалт

##### 1. 18 дугаар зүйл – Усан доорх соёлын өвийг хураан авах, хадгалах

1. Конвенцод үл нийцэх байдлаар усан доороос гарган авсан соёлын өвийг хураан авах арга хэмжээг Оролцогч улс бүр өөрийн нутаг дэвсгэрт авна.
2. Оролцогч улс бүр энэ Конвенцын дагуу хураан авсан усан доорх соёлын өвийг бүртгэн баримтжуулах, хамгаалах, зохих бүх арга хэмжээг авах болно.
3. Оролцогч улс бүр Конвенцын дагуу усан доорх соёлын өвийг хураан авсан талаар Ерөнхий Захирал болон тухайн усан доорх соёлын өвтэй соёл, түүх эсвэл археологийн холбоо хамааралтай нь нотлогдсон бусад улсад мэдэгдэнэ.
4. Усан доорх соёлын өвийг хураан авсан Оролцогч улс тухайн өвийн хадгалалт, хамгаалалт, судалгааны хэрэгцээ, тарж салсан цуглуулгын нэгдмэл цогц байдлыг хангах хэрэгцээ, үзэсгэлэн, боловсролын зориулалтаар олон нийтийн хүртээл болгох хэрэгцээг харгалзан үзэж, тухайн өвтэй соёл, түүх эсвэл археологийн холбоо хамааралтай нь нотлогдсон улсын сонирхлыг хүндэтгэж, олон нийтийн ашиг сонирхолд нийцүүлэн усан доорх соёлын өвийг нийтийн ашиг тусын төлөө хадгалж, ашиглана.

#### Нийцэж буй эрх зүйн актын холбогдох хэсэг

##### 2. Монгол Улсын Үндсэн Хууль

Долдугаар зүйл.

1. Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна. Аравдугаар зүйл.
2. Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.
3. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.

##### 3. Эрүүгийн хууль

7.5 дугаар зүйл. Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ

1. Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг, эсхүл бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор гэмт хэргийн улмаас учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хувьд ногдох хөрөнгө, орлогоос албадан гаргуулна.
2. "Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого" гэж Монгол Улсад бол энэ хуулийн тусгай ангид заасан, гадаад улсад бол тухайн улсын хуулиар нэг жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдэж шууд, шууд бусаар олсон эдийн, эдийн бус хөрөнгө, түүний үнэ, түүнээс олсон ашиг, орлого, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, ашиглахаар завдсан техник, хэрэгслийг ойлгоно.
3. Хураан авсан хөрөнгө, орлогыг бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх, хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны зардалд зарцуулна. Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогын хэмжээ нь хохирлоос илүү гарсан тохиолдолд улсын төсөвт шилжүүлнэ.
6. Шүүх хөрөнгө, орлого хураан авахдаа хураан авах хөрөнгө, орлогыг шийдвэртээ нэг

бүрчлэн заана.

**4. Зөрчлийн тухай хууль**

4.1 дүгээр зүйл. Хөрөнгө, орлогыг хураах, шилжүүлэх

1. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулж, зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлогыг эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хураана.

2. Хураасан хөрөнгө, орлогыг хохирол нөхөн төлөхөд зарцуулах, эсхүл устгах, шилжүүлэх эсэхийг холбогдох хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

3. Хуульд өөрөөр заагаагүй бол энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хөрөнгө, орлогоос хохирол нөхөн төлөхөд зарцуулж, үлдсэн хэсгийг улсын төсөвт төвлөрүүлнэ.

Тайлбар: "Зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлого" гэж зөрчил үйлдэн олж авсан мөнгө, эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, тэдгээрийг арилжаалж бий болгосон бусад эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, тэдгээрийг түрээслэх, ашиглах замаар олсон бүх төрлийн орлогыг ойлгоно.

**5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль**

21.2 дугаар зүйл. Эд хөрөнгө битүүмжлэх

1. Хохирлыг нөхөн төлүүлэх, хор уршгийг арилгуулах болон хөрөнгө, орлого хураах албадлагын арга хэмжээг хангах зорилгоор яллагдагч, шүүгдэгчийн эд хөрөнгийг шүүх, прокурорын шийдвэрээр битүүмжилнэ.

2. Шүүх, прокурорын шийдвэрээр хураан авсан эд мөрийн баримт овор хэмжээ ихтэй, эсхүл бусад шалтгаанаар хадгалах боломжгүй бол мөрдөгч байгаа газарт нь битүүмжилнэ.

3. Эд хөрөнгийг битүүмжлэхдээ эд хөрөнгөө бусдад шилжүүлэх, устгах, өөрчлөх, захиран зарцуулах, хөдөлгөхийг хориглож, өөрт нь, эсхүл бусад боломжтой хүнд хадгалах, хамгаалах үүрэг хүлээлгэнэ.

Хууль бус аргаар олж авсан соёлын өвийг хэрхэн хураах авах, хадгалах талаар тусгайлан зохицуулсан зохицуулалт үгүй бөгөөд практикт дээрх хүснэгтэд буй Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Зөрчлийн хууль дахь эд хөрөнгө хураах тухай зохицуулалтуудаар зохицуулагдсаар байгаа юм. Гэтэл соёлын өв гэдэг хадгалахад тусгай орчин, нөхцөл шаарддаг эд зүйл билээ. Усан доороос илрүүлсэн соёлын өв нь газар дээрх болон газрын доороос гаргасан соёлын өвтэй харьцуулахад илүү ихээр тусгай нөхцөл шаарддаг. Тийм ч учраас тус конвенцод энэ асуудлыг тусгайлан зохицуулахыг Оролцогч улсуудад үүрэг болгосон байна. Цаашид манай улс соёлын өвийг хураан авах, хадгалах тухайд холбогдох хуулиудад зааж зохицуулах нь зүйтэй.

**Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийн зүйл, заалт**

1. 19 дүгээр зүйл –Хамтын ажиллагаа болон мэдээлэл солилцох
1. Оролцогч улсууд энэ Конвенцын дагуу усан доорх соёлын өвийн хамгаалалт, удирдлага ялангуяа хайгуул, малтлага, баримтжуулалт, хадгалалт, судалгаа болон өвийг танилцуулах зэрэг чиглэлээр хамтран ажиллаж, харилцан дэмжлэг үзүүлнэ.
2. Усан доорх соёлын өвийг илрүүлсэн тухай, өвийн байршил, Конвенцод үл нийцэх эсвэл Олон улсын хууль тогтоомжийг зөрчиж өвийг малтсан эсвэл усан доороос гарган авсан, холбогдох шинжлэх ухааны арга зүй, технологи, болон тухайн өвтэй холбоотой хууль эрхзүйн хөгжлийн талаарх мэдээллийг энэ Конвенцын зорилгод нийцүүлэн бусад Оролцогч улсуудтай хуваалцах үүргийг Оролцогч улс бүр хүлээнэ.
3. Усан доорх соёлын өвийг илрүүлсэн тухай эсвэл түүний байршлын тухай мэдээлэл нь усан доорх соёлын өвийн хадгалалтад аюул эсвэл эрсдэл учруулж болзошгүй байдаг тул Оролцогч улсуудын хооронд, эсвэл ЮНЕСКО болон Оролцогч улсуудын хооронд хуваалцсан мэдээллийн нууцлалыг хадгалж, Оролцогч улсуудын үндэсний хууль тогтоомжид нийцүүлэн Оролцогч улсуудын эрх бүхий байгууллагад хадгална.
4. Оролцогч улс бүр энэ Конвенцыг зөрчиж эсвэл Олон улсын хууль тогтоомжийг зөрчиж малтсан эсвэл гарган авсан усан доорх соёлын өвийн талаарх мэдээллийг олон улсын зохих мэдээллийн сангаар дамжуулан түгээхэд боломжтой бүх арга хэмжээг авна.

Нийцэж буй эрх зүйн актын холбогдох хэсэг

|    |   |
|----|---|
| 2  | <p><b>Монгол Улсын Үндсэн Хууль</b><br/>Долдугаар зүйл.<br/>1. Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна.<br/>Аравдугаар зүйл.<br/>2. Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.<br/>3. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.</p>  |
| 3. | <p><b>Соёлын тухай хууль</b><br/>21 дүгээр зүйл. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх<br/>21.1. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага соёлын үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:<br/>21.1.7. соёлын гадаад харилцаа, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, соёлын үнэт зүйлийг сурталчлах ажлыг зохион байгуулах;<br/>27 дугаар зүйл. Олон улсын хамтын ажиллагаа<br/>27.1. Олон улсын хамтын ажиллагааг дараах чиглэлээр дэмжиж, хөгжүүлнэ:<br/>27.1.1. монголын түүх, соёлд холбогдох соёлын өвийг сурвалжлан олох, судалж шинжлэх, хадгалж хамгаалах талаар уг өв байгаа улстай хамтран ажиллах;<br/>27.1.2. монголын түүх, соёлд холбогдох соёлын үнэт зүйлийн хуулбарыг авчрах;<br/>27.1.3. хууль бусаар алдагдсан соёлын өвийг эргүүлэн авчрах;<br/>27.1.4. монголын түүх, соёлыг гадаадад сурталчлах;<br/>27.1.5. соёлын биет өвийг сэргээн засварлах;<br/>27.1.6. уран бүтээл хамтран бүтээх, солилцох;<br/>27.1.7. соёлын ажилтныг сургах, мэргэшүүлэх;<br/>27.1.8. соёлын үйл ажиллагаанд шинэ техник технологи, инновац, тоног төхөөрөмж нэвтрүүлэх;<br/>27.1.9. соёлын боловсрол олгох сургалтын арга зүй, сургалтын хөтөлбөрийг харилцан солилцох.<br/>27.2. Төрийн холбогдох байгууллага бүрэн эрхийнхээ хүрээнд энэ хуулийн 27.1-д заасан чиглэлийн дагуу үйл ажиллагаа эрхэлнэ.</p> |
| 4. | <p><b>Соёлын өвийг хамгаалах тухай хууль</b><br/>13 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх<br/>13.1. Засгийн газар соёлын өвийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:<br/>13.1.4. язгуур гарал үүсэл нэг, илэрхийлэгдэх шинжээрээ нийтлэг, монгол угсаатны түүхэнд ач холбогдол бүхий соёлын өвийг хамгаалах талаар уг өв хадгалагдаж буй гадаад улстай хэлэлцээр хийх, хамтын ажиллагааг хөгжүүлэх;<br/>13.1.5. улсын хилээр гарч алдагдсан соёлын биет өвийг эргүүлэн авчрах ажлыг зохион байгуулах, холбогдох байгууллагад чиглэл өгөх, хэрэгжилтэд хяналт тавих;</p>   |

Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийн нэгэн чухал зохицуулалт нь дээрх 19 дүгээр зүйлд заасан хамтын ажиллагаа болон мэдээлэл солилцох тухай юм. Оролцогч улсууд тус Конвенцын дагуу усан доорх соёлын өвийн хамгаалалт, удирдлага ялангуяа хайгуул, малтлага, баримтжуулалт, хадгалалт, судалгаа болон өвийг танилцуулах зэрэг чиглэлээр хамтран ажиллаж, харилцан дэмжлэг үзүүлэх үүргийг хүлээцгээх бөгөөд Усан доорх соёлын өвийг илрүүлсэн тухай, өвийн байршил, Конвенцод үл нийцэх эсвэл Олон улсын хууль тогтоомжийг зөрчиж өвийг малтсан эсвэл усан доороос гарган авсан, холбогдох шинжлэх ухааны арга зүй, технологи, болон тухайн өвтэй холбоотой хууль эрхзүйн хөгжлийн талаарх мэдээллийг конвенцийн зорилгод нийцүүлэн бусад Оролцогч улсуудтай хуваалцах үүргийг Оролцогч улс бүр хүлээдэг. Энэхүү зохицуулалтын манай улсын холбогдох хуулиудын үзэл баримтлалд бүрнээ нийцэж байгаа ч Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хуулиудад олон улсын хамтын ажиллагааны чиглэлийн тухай зохицуулахдаа тус чиглэлийг дурдаагүй байх тул цаашид энэхүү конвенцод нэгдэн орох бол зохих нэмэлт, өөрчлөлтийг хууль оруулах нь зүйтэй.

**1. 20 дугаар зүйл – Олон нийтийн мэдлэг ойлголт**

Оролцогч улс бүр усан доорх соёлын өвийн үнэ цэн, ач холбогдол болон тус Конвенцын дагуу усан доорх соёлын өвийг хамгаалах ач холбогдлын талаар олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх боломжит арга хэмжээг авна.

**Нийцэж буй эрх зүйн актын холбогдох хэсэг**

**2. Монгол Улсын Үндсэн Хууль**

Долдугаар зүйл.

1. Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна.

Аравдугаар зүйл.

2. Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.

3. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.

**3. Соёлын тухай хууль**

4 дүгээр зүйл. Төрөөс соёлын талаар баримтлах бодлого

4.1. Төрөөс соёлын талаар дараах бодлого хэрэгжүүлнэ:

4.1.1. соёлын өвийг төрийн онцгой анхаарал, ивээлд байлгах;

4.1.2. эх хэл, бичиг үсэг, үндэсний түүх, соёл, өв уламжлал, зан заншил зэрэг үндэсний үнэт зүйлийг эрхэмлэн хөгжүүлэх, нандигнан өвлүүлэх замаар үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэх;

4.1.3. соёлын илэрхийллийн олон төрөлд хүндэтгэлтэй хандах, хамгаалах, дэмжих;

4.1.4. соёлын үнэт зүйлийг судлах, өвлөх, уламжлуулах нөхцөл бүрдүүлэх замаар соёлын дархлаа бүхий монгол хүнийг төлөвшүүлэх;

4.1.6. хувь хүний бүтээлч хөгжил, авьяас, ур чадварыг хөгжүүлэхэд соёлын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх, соёлын боловсрол олгох үйл ажиллагааг дэмжих, иргэнийг соён гэгээрүүлэх;

4.1.7. салбар хоорондын хамтын ажиллагаа, түншлэлийг бэхжүүлэх, төр, хуулийн этгээд, иргэний нэгдмэл үйл ажиллагаагаар хэрэгжүүлэх;

4.1.9. соёлын үнэт зүйлийг олон улсад нээлттэй сурталчлан таниулах.

6 дугаар зүйл. Соёлын үйл ажиллагаа

6.1. Соёлын үйл ажиллагаа соёлын үнэт зүйлийг бүтээн туурвих, судлан шинжлэх, хадгалж хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, хөгжүүлэхтэй холбоотой бүхий л үйл ажиллагаанаас бүрдэнэ.

6.2. Соёлын үйл ажиллагаа бүх нийтийн оролцоонд тулгуурлана.

21 дүгээр зүйл. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

21.1. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага соёлын үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

21.1.7. соёлын гадаад харилцаа, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, соёлын үнэт зүйлийг сурталчлах ажлыг зохион байгуулах;

24 дүгээр зүйл. Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

24.1. Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга соёлын үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

24.1.1. орон нутгийн онцлог бүхий соёлын бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, брэнд бий болгох, баяжуулан хөгжүүлэх, сурталчлах ажлыг зохион байгуулах;

25 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн соёлын газар, сум, дүүргийн соёлын төв, соёлын ордны чиг үүрэг

25.2. Сум, дүүргийн соёлын төв, соёлын ордон нь тухайн орон нутгийн иргэний соёлын үйл ажиллагаа эрхлэх, бүтээл туурвих, соёлын ололт, үр шимийг хүртэх нөхцөлийг хангах, орон нутгийн байгаль, түүх, соёлын үнэт зүйлийг сурталчлах, номын сангийн

үйлчилгээ хүргэх чиг үүрэгтэй соёлын боловсрол олгох анхан шатны байгууллага бөгөөд соёл, мэдээллийн төв байна.

#### **4. Соёлын өвийг хамгаалах тухай хууль**

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалах, хамгаалах, сэргээн засварлах, сэргээн уламжлуулах, өвлүүлэх, өмчлөх, эзэмших, ашиглах, сурталчлахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

14 дүгээр зүйл.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

14.1.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага соёлын өвийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

14.1.15.соёлын өвийг хамгаалах, сурталчлах үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

16 дугаар зүйл.Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх

16.1.8.соёлын өвийг сурталчлах;

20 дугаар зүйл.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн тогтолцоо

20.3.Соёлын өвийн үндэсний төв нь соёлын өвийг бүртгэх, судлах, хадгалах, сэргээн засварлах, авран хамгаалах, сурталчлах чиг үүрэг бүхий соёл, эрдэм шинжилгээний байгууллага байна.

36 дугаар зүйл.Соёлын биет өвийг ашиглах

36.1.Соёлын биет өвийг сурталчлах, судалгаа, шинжилгээ, сургалт явуулах зориулалтаар ашиглана.

36.2.Соёлын биет өвийг сурталчлах, судалгаа, шинжилгээ хийх, сургалт явуулах зориулалтаар ашиглахдаа гэмтээх, үрэгдүүлэхийг хориглоно.

39 дүгээр зүйл.Соёлын биет бус өвийг өвлөн уламжлуулах

39.1.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон бүх шатны Засаг дарга соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийг тухайн угсаатан ястны түүх, уламжлал, ёс заншил, ахуй нөхцөлтэй нь уялдаатайгаар судалж, сурталчлах, өвлөн уламжлуулах, хадгалж хамгаалах асуудлыг хариуцна.

49 дүгээр зүйл.Соёлын өвийн боловсрол

49.1.Соёлын өвийн талаарх мэдлэг олгох, түүнийг хамгаалах, сурталчлах арга хэмжээг гэр бүлийн соёл, хүмүүжлийн уламжлал болон боловсролын тогтолцоогоор дамжуулан хэрэгжүүлнэ.

49.2.Соёлын өвийн боловсрол эзэмшүүлэх ажлыг дараах байдлаар зохион байгуулна:

49.2.1.соёлын өв, түүнийг хамгаалах мэдлэгийг сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн боловсролын сургалтын стандартад тусгах;

49.2.2.коллеж, их, дээд сургууль болон мэргэжлийн сургалтын байгууллагын суралцагчид соёлын өвийг хамгаалах, ашиглах талаар шинжлэх ухааны үндэслэлтэй боловсрол эзэмшүүлэх;

49.2.3.олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр соёлын өвийг хамгаалах, өв уламжлал, ёс заншил, хууль тогтоомжийг сурталчлан таниулах.

Оролцогч улс бүр усан доорх соёлын өвийн үнэ цэн, ач холбогдол болон тус Конвенцын дагуу усан доорх соёлын өвийг хамгаалах ач холбогдлын талаар олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх боломжит арга хэмжээг авах үүргийг тус конвенцод нэгдэн орсноор хүлээх бөгөөд энэхүү зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн Хууль, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хуулиудад нийцсэн байх бөгөөд тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох бусад байгууллагын чиг үүрэгт

Тохирч байх тул тус үүргийг хүлээхэд тухайлсан хуульд ямар нэг нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй хэмээн үзэж байна.

**Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийн зүйл, заалт**

- 1.** 21 дүгээр зүйл – Усан доорх археологийн сургалт  
Оролцогч улсууд усан доорх археологийн сургалтыг хүртээмжтэй байлгах, усан доорх соёлын өвийг хадгалж, хамгаалах арга техник болон тохиролцсон нөхцөлд усан доорх соёлын өвтэй холбоотой технологийг дамжуулах чиглэлээр хамтран ажиллана.

**Нийцэж буй эрх зүйн актын холбогдох хэсэг**

**2. Монгол Улсын Үндсэн Хууль**

Долдугаар зүйл.

1. Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна.

Аравдугаар зүйл.

2. Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.

3. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.

**3. Соёлын тухай хууль**

18 дугаар зүйл. Соёлын байгууллагын эрх, үүрэг, удирдлага

18.1. Соёлын байгууллага дараах нийтлэг эрх, үүрэгтэй:

18.1.2. дотоод, гадаадын төсөл, хөтөлбөрт хамрагдах, бусад байгууллагатай мэргэжлийн чиглэлээр хамтран ажиллах;

21 дүгээр зүйл. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

21.1. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага соёлын үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

21.1.1. соёлын хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангуулах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;

21.1.2. хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд соёлын үйл ажиллагааг зохицуулах дүрэм, журмыг баталж, хэрэгжүүлэх;

21.1.3. соёлын үйл ажиллагааны чиглэлээр захиалгат судалгаа, шинжилгээ хийх, инновац нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

21.1.4. соёлын барилга байгууламж, техник, тоног төхөөрөмж, үйлчилгээний орчны шаардлагыг боловсруулж, батлуулах;

21.1.5. соёлын байгууллагыг холбогдох хууль тогтоомжийн дагуу санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлэх;

21.1.6. төрийн болон орон нутгийн өмчийн соёлын байгууллагын оновчтой тогтолцоо, бүтцийг бий болгож ажиллуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээг авах;

21.1.7. соёлын гадаад харилцаа, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, соёлын үнэт зүйлийг сурталчлах ажлыг зохион байгуулах;

21.1.8. соёлын салбарт хүний нөөц бэлтгэх, соёлын байгууллагыг мэргэжлийн ажиллах хүчнээр хангахад дэмжлэг үзүүлэх;

21.1.9. соёлын ажилтны нийгмийн баталгааг хангах асуудлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэх;

21.1.10. соёл судлалын үйл ажиллагааг дэмжих;

21.1.11. соёлын боловсрол олгох арга хэмжээг зохион байгуулах;

27 дугаар зүйл. Олон улсын хамтын ажиллагаа

27.1. Олон улсын хамтын ажиллагааг дараах чиглэлээр дэмжиж, хөгжүүлнэ:

27.1.1. монголын түүх, соёлд холбогдох соёлын өвийг сурвалжлан олох, судалж шинжлэх, хадгалж хамгаалах талаар уг өв байгаа улстай хамтран ажиллах;

27.1.2. монголын түүх, соёлд холбогдох соёлын үнэт зүйлийн хуулбарыг авчрах;

27.1.3. хууль бусаар алдагдсан соёлын өвийг эргүүлэн авчрах;

27.1.4. монголын түүх, соёлыг гадаадад сурталчлах;

27.1.5. соёлын биет өвийг сэргээн засварлах;

27.1.6. уран бүтээл хамтран бүтээх, солилцох;

27.1.7. соёлын ажилтныг сургах, мэргэшүүлэх;

27.1.8.соёлын үйл ажиллагаанд шинэ техник технологи, инновац, тоног төхөөрөмж нэвтрүүлэх;  
 27.1.9.соёлын боловсрол олгох сургалтын арга зүй, сургалтын хөтөлбөрийг харилцан солилцох.  
 27.2.Төрийн холбогдох байгууллага бүрэн эрхийнхээ хүрээнд энэ хуулийн 27.1-д заасан чиглэлийн дагуу үйл ажиллагаа эрхэлнэ.

**4. Соёлын өвийг хамгаалах тухай хууль**

13 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх

13.1.Засгийн газар соёлын өвийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

13.1.4.язгуур гарал үүсэл нэг, илэрхийлэгдэх шинжээрээ нийтлэг, монгол угсаатны түүхэнд ач холбогдол бүхий соёлын өвийг хамгаалах талаар уг өв хадгалагдаж буй гадаад улстай хэлэлцээр хийх, хамтын ажиллагааг хөгжүүлэх;

16 дугаар зүйл.Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх

16.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга соёлын өвийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

16.1.9.дэлхийн болон үндэсний соёлын өвийн дурсгалт газрын хамгаалалтын бүс тогтоох ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран хийж, эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

Оролцогч улсууд усан доорх археологийн сургалтыг хүртээмжтэй байлгах, усан доорх соёлын өвийг хадгалж, хамгаалах арга техник болон тохиролцсон нөхцөлд усан доорх соёлын өвтэй холбоотой технологийг дамжуулах чиглэлээр хамтран ажиллах үүргийг тус конвенцод нэгдэн орсноор хүлээх бөгөөд энэхүү зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн Хууль, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хуулиудад нийцсэн байх бөгөөд тухайн асуудлыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэгт тохирч байх тул тус үүргийг хүлээхэд тухайлсан хуульд ямар нэг нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй хэмээн үзэж байна.

**Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийн зүйл, заалт**

1. 22 дугаар зүйл – Эрх бүхий байгууллага
1. Энэ Конвенцын хэрэгжилтийг хангахын тулд Оролцогч улсууд усан доорх соёлын өвийн бүртгэлийн тогтолцоо, ашиглалт, шинэчлэлт болон усан доорх соёлын өвийн хадгалалт, хамгаалалт, танилцуулга, менежмент, судалгаа болон боловсролын асуудлыг үр дүнтэй байлгах зориулалт бүхий эрх бүхий байгууллагыг байгуулах буюу одоо байгаа байгууллагыг зохистой байдлаар бэхжүүлнэ.
2. Оролцогч улсууд усан доорх соёлын өвтэй холбоотой эрх бүхий байгууллагын нэр, хаягийг Ерөнхий Захиралд мэдэгдэнэ.

**Нийцэж буй эрх зүйн актын холбогдох хэсэг**

2. **Монгол Улсын Үндсэн Хууль**  
 Аравдугаар зүйл.  
 2.Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.
3. **Олон улсын гэрээний тухай хууль**  
 24 дүгээр зүйл. Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, биелэлтэд хяналт тавих
- 24.2.Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийг тухайн олон улсын гэрээгээр зохицуулах асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн олон улсын гэрээгээр салбар хоорондын харилцааг зохицуулсан бол холбогдох байгууллагатай хамтран биелүүлнэ.
- 24.3.Монгол Улсын олон улсын гэрээний үүргийн биелэлтэд гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавьж, гэрээний үүргийн биелэлтийг хангуулах талаар зөвлөмж, чиглэл өгч, шаардлагатай бол энэ тухай санал боловсруулж Улсын Их Хурал, эсхүл Засгийн газарт танилцуулна.
- 24.4.Засгийн газар Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг зохион байгуулна.

|    |  |
|----|--|
|    | 24.5.Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийг гэрээний нөгөө тал, эсхүл бусад тал хэрхэн биелүүлж байгаа, монголын талын эрхийг хэрхэн хангаж байгаад тухайн олон улсын гэрээгээр зохицуулах асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.  |
| 4. | <p><b>Монгол Улсын Засгийн Газрын тухай хууль</b><br/>8 дугаар зүйл.Монгол Улсын яам</p> <p>1.Монгол Улсын яам нь Засгийн газрын үйл ажиллагааны зохих хүрээ, тодорхой чиг үүргийг дагнан эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мөн.</p> <p>3.Засгийн газрын бүтцэд доор дурдсан яам ажиллана:<br/>11/Соёлын яам;<br/>20 дугаар зүйл.Засгийн газрын бүрэлдэхүүн</p> <p>5.Засгийн газрын гишүүн доор дурдсан хүрээний бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг эрхэлнэ:<br/>13/Соёлын сайд:<br/>-соёл, урлагийг хөгжүүлэх асуудал;<br/>-түүх, соёлын өвийг хамгаалах, сэргээх бодлого</p>  |
| 5. | <p><b>Соёлын тухай хууль</b><br/>21 дүгээр зүйл.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх</p> <p>21.1.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага соёлын үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:<br/>21.1.1.соёлын хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангуулах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;<br/>21.1.2.хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд соёлын үйл ажиллагааг зохицуулах дүрэм, журмыг баталж, хэрэгжүүлэх;<br/>21.1.3.соёлын үйл ажиллагааны чиглэлээр захиалгат судалгаа, шинжилгээ хийх, инновац нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;<br/>21.1.4.соёлын барилга байгууламж, техник, тоног төхөөрөмж, үйлчилгээний орчны шаардлагыг боловсруулж, батлуулах;<br/>21.1.5.соёлын байгууллагыг холбогдох хууль тогтоомжийн дагуу санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлэх;<br/>21.1.6.төрийн болон орон нутгийн өмчийн соёлын байгууллагын оновчтой тогтолцоо, бүтцийг бий болгож ажиллуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээг авах;<br/>21.1.7.соёлын гадаад харилцаа, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, соёлын үнэт зүйлийг сурталчлах ажлыг зохион байгуулах;<br/>21.1.8.соёлын салбарт хүний нөөц бэлтгэх, соёлын байгууллагыг мэргэжлийн ажиллах хүчнээр хангахад дэмжлэг үзүүлэх;<br/>21.1.9.соёлын ажилтны нийгмийн баталгааг хангах асуудлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэх;<br/>21.1.10.соёл судлалын үйл ажиллагааг дэмжих;<br/>21.1.11.соёлын боловсрол олгох арга хэмжээг зохион байгуулах;<br/>21.1.12.хуульд заасан бусад бүрэн эрх.</p> |

Энэхүү конвенцийн 22 дугаар зүйлд конвенцын хэрэгжилтийг хангахын тулд Оролцогч улсууд усан доорх соёлын өвийн бүртгэлийн тогтолцоо, ашиглалт, шинэчлэлт болон усан доорх соёлын өвийн хадгалалт, хамгаалалт, танилцуулга, менежмент, судалгаа болон боловсролын асуудлыг үр дүнтэй байлгах зориулалт бүхий эрх бүхий байгууллагыг байгуулах буюу одоо байгаа байгууллагыг зохистой байдлаар бэхжүүлэх үүргийг хүлээлгэхээр зохицуулжээ. Тухайн эрх бүхий байгууллагын чиг үүрэг нь манай улсын соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болох Соёлын яамны чиг үүрэгтэй давхцаж байх тул эрх бүхий байгууллагыг шинээр байгуулах шаардлагагүй бөгөөд зохистой байдлаар бэхжүүлэх үүргийг тус конвенцод нэгдэн орсноор хүлээхээр байна.

**Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийн зүйл, заалт**

|    |  |
|----|--|
| 1. | 26 дугаар зүйл – Соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах эсвэл нэгдэн орох<br>1. Энэ Конвенцыг ЮНЕСКО-ийн гишүүн орнууд соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, |
|----|--|

батлах, нэгдэн орох ёстой.

2. Энэ Конвенцод нэгдэн орох:

(а) ЮНЕСКО -ийн гишүүн биш боловч НҮБ-ын гишүүн, НҮБ-ын систем дэх мэргэшсэн байгууллага эсвэл Олон улсын Атомын энергийн агентлаг, түүнчлэн Олон улсын шүүхийн дүрэмд Оролцогч улс болон ЮНЕСКО -ийн Ерөнхий чуулганаас энэ Конвенцод нэгдэхийг уриалсан бусад улс;

(б) Энэ конвенц нь Нэгдсэн үндэстний байгууллагын Ерөнхий ассамблейн 1514 (XV) тогтоолын дагуу бүрэн тусгаар тогтноогүй боловч Нэгдсэн үндэстний байгууллагын хүлээн зөвшөөрснөөр дотооддоо өөрийгөө бүрэн удирдах эрх бүхий, энэхүү конвенцоор зохицуулах аливаа асуудлыг шийдвэрлэх эрх мэдэлтэй, ялангуяа эдгээр асуудлаар олон улсын гэрээ байгуулах эрх мэдэл бүхий нутаг дэвсгэр нэгдэн ороход мөн нээлттэй байна.

3. Соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, нэгдэх орох тухай баримт бичгийг Ерөнхий Захиралд хадгалуулна

**Нийцэж буй эрх зүйн актын холбогдох хэсэг**

**2. Монгол Улсын Үндсэн Хууль**

Аравдугаар зүйл.

2. Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.

3. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.

**3. Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенц**

б/“соёрхон батлах”, “хүлээн зөвшөөрөх”, “батлах”, “нэгдэн орох” гэж улс гүрэн гэрээг заавал биелүүлэхээ олон улсын хэмжээнд зөвшөөрч байгааг илэрхийлсэн бөгөөд тухайн тохиолдол бүрт өөр өөрөөр нэрлэгдэх олон улсын үйлдлийг хэлнэ;

Арван дөрөвдүгээр зүйл

Соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх буюу баталж гэрээг

Заавал биелүүлэхээ илэрхийлсэн зөвшөөрөл

1. Улс гэрээг заавал биелүүлэхээ зөвшөөрч байгаагаа түүнийг хүлээн зөвшөөрч илэрхийлнэ. Хэрэв:

а/зөвшөөрч байгаагаа соёрхон батлах замаар илэрхийлнэ гэж гэрээнд заасан бол;

б/хэлэлцээнд оролцогч улсууд соёрхон батлах шаардлагатай гэж тохиролцсон нь өөр ямар нэг хэлбэрээр тогтоогдвол;

**4. Олон улсын гэрээний тухай хууль**

3.1.4. "олон улсын гэрээ байгуулах" гэж Монгол Улс, Монгол Улсын Засгийн газраас гадаадын нэг болон хэд хэдэн улс, тэдгээрийн Засгийн газар, эсхүл олон улсын байгууллагатай харилцан тохиролцсон болон тухайн олон улсын гэрээгээр хүлээн зөвшөөрсөн гэрээнд гарын үсэг зурах, гэрээг бүрдүүлэгч баримт бичгийг солилцох, соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, нэгдэн орох, эдгээртэй адилтгах бусад аргаар тухайн олон улсын гэрээг заавал биелүүлэхээ олон улсын хэмжээнд зөвшөөрсөн үйлдлийг;

8 дугаар зүйл. Заавал соёрхон батлах олон улсын гэрээ

8.1. Улсын Их Хурал дараахь олон улсын гэрээг заавал соёрхон батална:

8.1.3. Монгол Улсын хуульд зааснаас өөр журам тогтоож байгаа, эсхүл тухайн гэрээг байгуулснаар, нэгдсэнээр, эсхүл хэрэгжүүлснээр Монгол Улсын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл хууль шинээр батлах шаардлагатай олон улсын гэрээ;

8.2. Заавал соёрхон батлах зохицуулалт бүхий олон талт олон улсын гэрээ болон заавал соёрхон батлуулахаар тохиролцсон хоёр талт олон улсын гэрээг соёрхон батална.

15 дугаар зүйл. Олон улсын гэрээг соёрхон батлах, батлах санал

15.1. Энэ хуулийн 14.1-д заасны дагуу эрх олгогдсон албан тушаалтан олон улсын гэрээнд гарын үсэг зурсны дараа хоёр болон олон талт олон улсын гэрээг соёрхон батлах, эсхүл батлах саналыг тухайн олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийн төсөл, эсхүл батлах тухай Засгийн газрын тогтоолын төслийн хамт энэ хуулийн 9, 10 дугаар зүйлд заасан журмын дагуу Улсын Их Хурал, Засгийн газраар хэлэлцүүлнэ.

15.2. Энэ зүйлийн 15.1-д заасан шаардлага гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох зохицуулалттай олон улсын гэрээнд үйлчлэхгүй.

15.3. Олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын



болно.<sup>58</sup> Иймд Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай ЮНЕСКО-ийн 2001 оны конвенц нь Монгол Улсын заавал соёрхон батлах олон улсын гэрээ мөн юм.

| <b>Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийн зүйл, заалт</b> |  |
|---|--|
| <b>1.</b>   | <b>27 дугаар зүйл – Хүчин төгөлдөр болох</b><br>Энэ конвенц нь 26 дугаар зүйлд дурдсан хорь дахь баримт бичгийг хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно, ингэхдээ баримт бичгээ хадгалуулсан хорин улс эсвэл нутаг дэвсгэрийн хүрээнд хүчин төгөлдөр болно. Харин бусад улсын хувьд тухайн улс баримт бичгийг хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно.   |
| <b>Нийцэж буй эрх зүйн актын холбогдох хэсэг</b>                      |  |
| <b>2.</b>   | <b>Монгол Улсын Үндсэн Хууль</b><br>Аравдугаар зүйл.<br>2. Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.<br>3. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.   |
| <b>3.</b>   | <b>Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенц</b><br>Хорин дөрөвдүгээр зүйл. Хүчин төгөлдөр болох<br>1. Гэрээ нь түүнд заасан буюу хэлэлцээнд оролцогч улсуудын тохиролцсон журам, он, сар, өдөр хүчин төгөлдөр болно.<br>2. Дээрх заалт буюу тохиролцоо байхгүй үед хэлэлцээнд оролцогч бүх улс гэрээг заавал биелүүлэхээ зөвшөөрч байгаагаа илэрхийлмэгц уг гэрээ хүчин төгөлдөр болно.<br>3. Хэрэв улс гэрээ хүчин төгөлдөр болсны дараахь тодорхой он, сар, өдрөөс заавал биелүүлэхээ зөвшөөрч байгаагаа илэрхийлсэн бол тухайн улсын хувьд уг гэрээ дээрх он, сар, өдрөөс эхлэн, хэрэв гэрээнд өөрөөр заагаагүй бол, хүчин төгөлдөр болно.<br>4. Гэрээний эх бичвэрийг адил хүчинтэйг тогтоох, гэрээг заавал биелүүлэхээ зөвшөөрч байгаагаа улс илэрхийлэх, гэрээ хүчин төгөлдөр болох журам, он, сар, өдөр, тайлбар, гэрээний эх хадгалагчийн үүрэг болон гэрээ хүчин төгөлдөр болохоос өмнө зайлшгүй гарч буй бусад асуудлыг зохицуулж байгаа гэрээний заалтуудыг гэрээний эх бичвэрийг хүлээн зөвшөөрсөн үеэс эхлэн хэрэглэнэ.  |
| <b>4.</b>   | <b>Олон улсын гэрээний тухай хууль</b><br>16 дугаар зүйл. Олон улсын гэрээг соёрхон батлах<br>16.1. Засгийн газар гарын үсэг зурсан заавал соёрхон батлах хоёр талт олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлал, тухайн гэрээний эх бичвэрийн хуулбар, шаардлагатай бол тухайн олон улсын гэрээний энэ хуулийн 7.4, 7.5-д заасны дагуу хянан баталгаажуулсан монгол хэл дээрх орчуулга болон холбогдох бусад баримт бичгийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.<br>16.2. Засгийн газар гарын үсэг зурсан заавал соёрхон батлах олон талт олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийн төсөл, шаардлагатай бол холбогдох бусад хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлал, тухайн олон улсын гэрээний эх бичвэрийн хуулбар, боломжтой бол баталгаат хуулбар, тухайн олон улсын гэрээний энэ хуулийн 7.6-д заасны дагуу хянан баталгаажуулсан монгол хэл дээрх орчуулга болон холбогдох бусад баримт бичгийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.<br>16.3. Улсын Их Хурал энэ зүйлийн 16.1, 16.2-т заасны дагуу өргөн мэдүүлсэн олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн дэмжсэн бол тухайн олон улсын гэрээг соёрхон батлах тухай хууль, дэмжээгүй бол хуулийн төслийг Засгийн газарт буцаах тухай тогтоол гаргана.<br>24 дүгээр зүйл. Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, биелэлтэд хяналт тавих<br>24.1. Олон улсын гэрээ Монгол Улсын хувьд хүчин төгөлдөр болсон хугацааг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олон нийтэд албан ёсны цахим хуудсаараа мэдээлэх үүрэгтэй.<br>32 дугаар зүйл. Олон улсын гэрээний бүртгэл хөтлөх<br>32.1. Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |

<sup>58</sup> Ж. Амарсанаа, Б. Чимид, Б. Гүнбилэг, Б. Алтангэрэл, М. Мөнхбат, Ц. Амарсайхан, А. Төмөр, Олон улсын гэрээний тухай Монгол Улсын хуулийн дэлгэрэнгүй тайлбар, 2011 он, 18 дахь тал

Монгол Улсын хоёр талт болон олон талт олон улсын гэрээний бүртгэл хөтөлнө.

32.2. Олон улсын гэрээний бүртгэл дараахь мэдээллийг агуулсан байна:

32.2.5. олон улсын гэрээ талуудын хувьд болон Монгол Улсын хувьд хүчин төгөлдөр болсон өдөр;

32.2.6. олон улсын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан, олон улсын гэрээний үйлчлэлийг дуусгавар болгосон, олон улсын гэрээг цуцалсан, олон улсын гэрээнээс гарсан, олон улсын гэрээний үйлчлэлийг түр зогсоох шийдвэр гарсан өдөр, уг шийдвэр хүчин төгөлдөр болсон өдөр;

32.2.7. олон улсын гэрээнд хийсэн тайлбар, илэрхийлсэн эсэргүүцэл, тайлбарыг эгүүлэн авах шийдвэр гарсан өдөр, тэдгээрийн хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа.

Энэ конвенц нь 26 дугаар зүйлд дурдсан соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, нэгдэх орох тухай баримт бичгийг хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно, ингэхдээ баримт бичгээ хадгалуулсан хорин улс эсвэл нутаг дэвсгэрийн хүрээнд хүчин төгөлдөр болно. Харин бусад улсын хувьд тухайн улс баримт бичгийг хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болохоор зохицуулсан нь Монгол Улсын Үндсэн Хууль, Олон улсын гэрээний эрх зүйн тухай венийн конвенц, Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулиудад тус тус нийцсэн байна.

#### Усанд доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийн зүйл, заалт

1. 28 дугаар зүйл – Дотоодын усны тухай мэдэгдэл  
Энэ Конвенцыг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, нэгдэн орох үед эсвэл түүний дараа аль ч улс эсвэл нутаг дэвсгэр Дүрмийг далайн шинж чанартай биш дотоодын усанд ашиглахыг мэдэгдэж болно.

#### Нийцэж буй эрх зүйн актын холбогдох хэсэг

2. **Монгол Улсын Үндсэн Хууль**  
Долдугаар зүйл.  
1. Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна.

3. **Олон улсын гэрээний тухай хууль**  
3.1.7. "тайлбар" гэж олон улсын гэрээ байгуулахдаа тухайн гэрээний тодорхой заалтыг Монгол Улсын хувьд хэрэгжүүлэхэд хуулийн үйлчлэлийг нь хасах, эсхүл өөрчлөх зорилгоор энэ хуульд заасны дагуу гаргасан мэдэгдлийг;  
16.4. Улсын Их Хурал олон талт олон улсын гэрээг соёрхон батлахдаа тайлбар хийхээр шийдвэрлэсэн бол тухайн олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуульд энэ тухай тусгай заалт оруулна.  
21 дүгээр зүйл. Тайлбар хийх, эсэргүүцэх, эгүүлэн авах  
21.1. Улсын Их Хурал, Засгийн газар олон талт олон улсын гэрээг соёрхон батлах, батлахдаа тайлбар хийсэн бол гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн олон улсын гэрээг соёрхон баталсан Монгол Улсын хууль, баталсан Засгийн газрын тогтоолыг орчуулж тухайн олон улсын гэрээний зохицуулалтын дагуу холбогдох улс, эсхүл олон улсын байгууллагад хүргүүлэх арга хэмжээ авна.  
21.2. Энэ зүйлийн 21.1-д заасны дагуу үйлдсэн тайлбарыг тухайн олон улсын гэрээг соёрхон баталсан тухай Батламж жуух бичиг, эсхүл баталсан тухай баримт бичигтэй хамт хүргүүлнэ.  
21.3. Олон талт олон улсын гэрээнд тайлбар хийх саналыг боловсруулахдаа тухайн олон улсын гэрээгээр тайлбар хийх боломжтой эсэх, тайлбар хийх боломжит хүрээ, тухайн олон улсын гэрээний бусад талын, эсхүл олон улсын байгууллагын зөвшөөрөл шаардлагатай эсэх зэрэг зохицуулалтыг харгалзана.  
21.4. Олон талт олон улсын гэрээнд хийсэн гэрээний бусад талын тайлбарыг зөвшөөрөх эсэх асуудлыг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага судлан, шаардлагатай бол энэ тухай тодорхой санал боловсруулан холбогдох журмын дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.  
21.5. Олон талт олон улсын гэрээнд хийсэн тайлбарыг эгүүлэн авах саналыг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн олон улсын

гэрээгээр зохицуулах асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай тохиролцсоны үндсэн дээр холбогдох журмын дагуу Улсын Их Хурал, эсхүл Засгийн газраар шийдвэрлүүлнэ.

21.6. Соёрхон баталсан олон талт олон улсын гэрээнд хийсэн тайлбарыг эгүүлэн авах шийдвэрийг Улсын Их Хурал, баталсан олон талт олон улсын гэрээнд хийсэн тайлбарыг эгүүлэн авах шийдвэрийг Засгийн газар гаргана.

Энэ Конвенцийг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, нэгдэн орох үед эсвэл түүний дараа аль ч улс эсвэл нутаг дэвсгэр Дүрмийг далайн шинж чанартай биш дотоодын усанд ашиглахыг мэдэгдэж болох тухай дээрх зүйлд заажээ. Энэхүү зохицуулалт нь далайд гарцгүй улсууд тус конвенцод нэгдэн орох, үүгээрээ дотоодын усанд доорх соёлын өвийг хамгаалах боломжтой болж байгаа юм. Манай улс тус мэдэгдлийг гаргахад ямар нэг эрх зүйн ахтанд нийцэхгүй зүйл үгүй байна.

#### Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийн зүйл, заалт

1. 29 дүгээр зүйл – Газарзүйн хамрах хүрээний хязгаарлалт  
Конвенцыг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, нэгдэн орох үед тухайн улс эсвэл нутаг дэвсгэр, нутаг дэвсгэрийн тодорхой хэсэг, дотоодын ус, арал хоорондын ус, харьяа тэнгист энэ Конвенц нь хамаарахгүй болохыг хадгалуулах баримт бичигт мэдэгдэх бөгөөд мөн энэ мэдэгдлийн шалтгааныг тодорхойлно. Мэдэгдэл гаргагч улс нь мэдэгдэлд заасан газар нутагт Конвенцын ашиглах хүрээ, нөхцөлийг аль болох хурдан, боломжтой хэмжээнд тодорхой болгох бөгөөд биелүүлсэн даруйд мэдэгдлийг бүхэлд нь эсвэл буюу хэсэгчлэн эргүүлэн татна.

#### Нийцэж буй эрх зүйн актын холбогдох хэсэг

#### 2. Монгол Улсын Үндсэн Хууль

Дөрөвдүгээр зүйл.

1. Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна.

#### 3. Олон улсын гэрээний тухай хууль

3.1.7. "тайлбар" гэж олон улсын гэрээ байгуулахдаа тухайн гэрээний тодорхой заалтыг Монгол Улсын хувьд хэрэгжүүлэхэд хуулийн үйлчлэлийг нь хасах, эсхүл өөрчлөх зорилгоор энэ хуульд заасны дагуу гаргасан мэдэгдлийг;

16.4. Улсын Их Хурал олон талт олон улсын гэрээг соёрхон батлахдаа тайлбар хийхээр шийдвэрлэсэн бол тухайн олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуульд энэ тухай тусгай заалт оруулна.

21 дүгээр зүйл. Тайлбар хийх, эсэргүүцэх, эгүүлэн авах

21.1. Улсын Их Хурал, Засгийн газар олон талт олон улсын гэрээг соёрхон батлах, батлахдаа тайлбар хийсэн бол гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн олон улсын гэрээг соёрхон баталсан Монгол Улсын хууль, баталсан Засгийн газрын тогтоолыг орчуулж тухайн олон улсын гэрээний зохицуулалтын дагуу холбогдох улс, эсхүл олон улсын байгууллагад хүргүүлэх арга хэмжээ авна.

21.2. Энэ зүйлийн 21.1-д заасны дагуу үйлдсэн тайлбарыг тухайн олон улсын гэрээг соёрхон баталсан тухай Батламж жуух бичиг, эсхүл баталсан тухай баримт бичигтэй хамт хүргүүлнэ.

21.3. Олон талт олон улсын гэрээнд тайлбар хийх саналыг боловсруулахдаа тухайн олон улсын гэрээгээр тайлбар хийх боломжтой эсэх, тайлбар хийх боломжит хүрээ, тухайн олон улсын гэрээний бусад талын, эсхүл олон улсын байгууллагын зөвшөөрөл шаардлагатай эсэх зэрэг зохицуулалтыг харгалзана.

21.4. Олон талт олон улсын гэрээнд хийсэн гэрээний бусад талын тайлбарыг зөвшөөрөх эсэх асуудлыг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага судлан, шаардлагатай бол энэ тухай тодорхой санал боловсруулан холбогдох журмын дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.

21.5. Олон талт олон улсын гэрээнд хийсэн тайлбарыг эгүүлэн авах саналыг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн олон улсын гэрээгээр зохицуулах асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай

тохиролцсоны үндсэн дээр холбогдох журмын дагуу Улсын Их Хурал, эсхүл Засгийн газраар шийдвэрлүүлнэ.

21.6.Соёрхон баталсан олон талт олон улсын гэрээнд хийсэн тайлбарыг эгүүлэн авах шийдвэрийг Улсын Их Хурал, баталсан олон талт олон улсын гэрээнд хийсэн тайлбарыг эгүүлэн авах шийдвэрийг Засгийн газар гаргана.

Конвенцийн дээрх 29 дүгээр зүйл нь юун түрүүнд тусгаар улсын өөрийн нутаг дэвсгэр дээр хэрэгжүүлэх бүрэн эрхийг хүндэтгэсэн буюу хэдийгээр уг конвенцод соёлын өвийг хамгаалахаар нэгдэн орсон ч тодорхой газар нутагт газарзүйн хамрах хүрээний хязгаарлалт тогтоох эрхтэй байхаар зохицуулсан байна. Конвенцыг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, нэгдэн орох үед тухайн улс эсвэл нутаг дэвсгэр, нутаг дэвсгэрийн тодорхой хэсэг, дотоодын ус, арал хоорондын ус, харьяа тэнгист энэ Конвенц нь хамаарахгүй болохыг хадгалуулах баримт бичигт мэдэгдэх бөгөөд ийнхүү мэдэгдэхдээ мэдэгдлийн шалтгааныг тодорхойлсон байх ёстой. Ийнхүү мэдэгдэл гаргахаар конвенцод зохицуулсан нь манай улсын хуульд харшлахгүй бөгөөд нийцэж байгааг дээрх хүснэгтээс харах боломжтой.

#### Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийн зүйл, заалт

1. 30 дугаар зүйл – Тайлбар  
29 -р зүйлээс бусад тохиолдолд энэ Конвенцод ямар нэгэн тайлбар хийх боломжгүй.

#### Нийцэж буй эрх зүйн актын холбогдох хэсэг

#### 2. Олон улсын гэрээний тухай хууль

3.1.7."тайлбар" гэж олон улсын гэрээ байгуулахдаа тухайн гэрээний тодорхой заалтыг Монгол Улсын хувьд хэрэгжүүлэхэд хуулийн үйлчлэлийг нь хасах, эсхүл өөрчлөх зорилгоор энэ хуульд заасны дагуу гаргасан мэдэгдлийг;

16.4.Улсын Их Хурал олон талт олон улсын гэрээг соёрхон батлахдаа тайлбар хийхээр шийдвэрлэсэн бол тухайн олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуульд энэ тухай тусгай заалт оруулна.

21 дүгээр зүйл. Тайлбар хийх, эсэргүүцэх, эгүүлэн авах

21.1.Улсын Их Хурал, Засгийн газар олон талт олон улсын гэрээг соёрхон батлах, батлахдаа тайлбар хийсэн бол гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн олон улсын гэрээг соёрхон баталсан Монгол Улсын хууль, баталсан Засгийн газрын тогтоолыг орчуулж тухайн олон улсын гэрээний зохицуулалтын дагуу холбогдох улс, эсхүл олон улсын байгууллагад хүргүүлэх арга хэмжээ авна.

21.2.Энэ зүйлийн 21.1-д заасны дагуу үйлдсэн тайлбарыг тухайн олон улсын гэрээг соёрхон баталсан тухай Батламж жуух бичиг, эсхүл баталсан тухай баримт бичигтэй хамт хүргүүлнэ.

21.3.Олон талт олон улсын гэрээнд тайлбар хийх саналыг боловсруулахдаа тухайн олон улсын гэрээгээр тайлбар хийх боломжтой эсэх, тайлбар хийх боломжит хүрээ, тухайн олон улсын гэрээний бусад талын, эсхүл олон улсын байгууллагын зөвшөөрөл шаардлагатай эсэх зэрэг зохицуулалтыг харгалзана.

21.4.Олон талт олон улсын гэрээнд хийсэн гэрээний бусад талын тайлбарыг зөвшөөрөх эсэх асуудлыг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага судлан, шаардлагатай бол энэ тухай тодорхой санал боловсруулан холбогдох журмын дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.

21.5.Олон талт олон улсын гэрээнд хийсэн тайлбарыг эгүүлэн авах саналыг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн олон улсын гэрээгээр зохицуулах асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай тохиролцсоны үндсэн дээр холбогдох журмын дагуу Улсын Их Хурал, эсхүл Засгийн газраар шийдвэрлүүлнэ.

21.6.Соёрхон баталсан олон талт олон улсын гэрээнд хийсэн тайлбарыг эгүүлэн авах шийдвэрийг Улсын Их Хурал, баталсан олон талт олон улсын гэрээнд хийсэн тайлбарыг эгүүлэн авах шийдвэрийг Засгийн газар гаргана.

Тус конвенцид ямар нэгэн тайлбар хийхийг хязгаарласан байна. Гэхдээ 29 -р зүйлтэй холбоотойгоор мэдэгдэл хийх боломж нээлттэй. Өөрөөр хэлбэл, Конвенцыг соёрхон батлах, үлээн зөвшөөрөх, батлах, нэгдэн орох үед тухайн улс эсвэл нутаг дэвсгэр, нутаг дэвсгэрийн тодорхой хэсэг, дотоодын ус, арал хоорондын ус, харьяа тэнгист энэ Конвенц нь хамаарахгүй болохыг хадгалуулах баримт бичигт шалтгааныг дурдан мэдэгдэх боломжтой байна.

#### Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийн зүйл, заалт

##### 1. 31 дүгээр зүйл – Нэмэлт өөрчлөлт

1. Оролцогч улс энэ Конвенцод нэмэлт оруулах саналаа Ерөнхий Захиралд хандан бичгээр мэдэгдэнэ. Ерөнхий Захирал ийм мэдэгдлийг бүх Оролцогч улсуудад хүргүүлнэ. Хэрэв уг мэдэгдлийг хүргүүлсэн өдрөөс хойш зургаан сарын дотор Оролцогч улсуудын тавиас доошгүй хувь нь хүсэлтэд эерэгээр хариулбал Ерөнхий Захирал тус саналыг дараагийн Оролцогч улсуудын хуралд хэлэлцүүлж, батлуулахаар танилцуулна.

2. Нэмэлт өөрчлөлтийг санал хураалтад оролцож буй Оролцогч улсуудын гуравны хоёрын саналаар батална.

3. Энэ Конвенцын нэмэлт өөрчлөлтийг баталсны дараа Оролцогч улсууд соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах эсвэл нэгдэн орно.

4. Нэмэлт өөрчлөлт нь энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан баримт бичгийг Оролцогч улсуудын гуравны хоёр нь хадгалуулснаас хойш гурван сарын дараа соёрхон баталж, хүлээн зөвшөөрч, батлаж эсвэл нэгдэн орсон Оролцогч улсуудын хувьд хүчин төгөлдөр болно. Үүний дараа нэмэлт өөрчлөлтийг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах эсвэл нэгдэн орсон улс эсвэл нутаг дэвсгэр бүрийн хувьд энэхүү нэмэлт өөрчлөлт нь тухайн тал соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, нэгдэн орох тухай баримт бичгээ хадгалуулснаас хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно.

5. Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болсны дараа энэ Конвенцод Оролцогч улс эсвэл нутаг дэвсгэрээс өөр санаа зорилго илэрхийлээгүй тохиолдолд дараах байдлаар авч үзнэ.

(a) Нэмэлт өөрчлөлт оруулсан Конвенцын Оролцогч тал; болон

(b) Нэмэлт өөрчлөлтөд хамрагдаагүй аливаа оролцогч улстай холбоотой нэмэлт өөрчлөлт оруулаагүй Конвенцын тал.

#### Нийцэж буй эрх зүйн актын холбогдох хэсэг

##### 2. Олон улсын гэрээний тухай хууль

26 дугаар зүйл. Олон улсын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

26.1. Хоёр талт болон олон талт олон улсын гэрээнд тухайн гэрээний зохицуулалт болон гэрээний нөгөө тал, эсхүл бусад талтай харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт, өөрчлөлт оруулна.

26.2. Олон улсын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах баримт бичгийн төрөл, нэрийг тухайн олон улсын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан гэрээний зохицуулалт болон гэрээний нөгөө тал, эсхүл бусад талтай харилцан тохиролцсоны үндсэн дээр тодорхойлно.

26.3. Соёрхон баталсан олон улсын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийг Улсын Их Хурал, баталсан олон улсын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийг Засгийн газар гаргана.

26.4. Энэ зүйлийн 26.3-т заасан шаардлага Улсын Их Хурал соёрхон баталсан олон улсын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан, эсхүл нэмэлт олон улсын гэрээ нь энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан заавал соёрхон батлах олон улсын гэрээний төрөлд хамаарахгүй, үндсэн олон улсын гэрээний гол нөхцөлийг хөндөөгүй техникийн шинжтэй бол Засгийн газар тухайн олон улсын гэрээг баталж болно.

26.5. Энэ зүйлийн 26.4-т заасан олон улсын гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт, эсхүл нэмэлт олон улсын гэрээ нь үндсэн олон улсын гэрээний гол нөхцөлийг хөндөөгүй техникийн шинжтэй эсэхийг гадаад харилцааны болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран тогтооно.

26.6. Энэ хуулийн 9-20 дугаар зүйлд заасан зохицуулалт нь олон улсын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахад үйлчилнэ.

32 дугаар зүйл. Олон улсын гэрээний бүртгэл хөтлөх

32.1.Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монгол Улсын хоёр талт болон олон талт олон улсын гэрээний бүртгэл хөтөлнө.

32.2.Олон улсын гэрээний бүртгэл дараахь мэдээллийг агуулсан байна:

32.2.6.олон улсын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан, олон улсын гэрээний үйлчлэлийг дуусгавар болгосон, олон улсын гэрээг цуцалсан, олон улсын гэрээнээс гарсан, олон улсын гэрээний үйлчлэлийг түр зогсоох шийдвэр гарсан өдөр, уг шийдвэр хүчин төгөлдөр болсон өдөр;

Тус конвенцод нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Оролцогч улс гаргах бүрэн боломжтой тухай энэхүү 31 дүгээр зүйлд зохицуулжээ. Конвенцод нэмэлт оруулах саналаа Ерөнхий Захиралд хандан бичгээр мэдэгдэх бөгөөд Ерөнхий Захирал ийм мэдэгдлийг бүх Оролцогч улсуудад хүргүүлнэ. Хэрэв уг мэдэгдлийг хүргүүлсэн өдрөөс хойш зургаан сарын дотор Оролцогч улсуудын тавиас доошгүй хувь нь хүсэлтэд эерэгээр хариулбал Ерөнхий Захирал тус саналыг дараагийн Оролцогч улсуудын хуралд хэлэлцүүлж, батлуулахаар танилцуулна. Нэмэлт өөрчлөлтийг санал хураалтад оролцож буй Оролцогч улсуудын гуравны хоёрын саналаар батлах ба ийнхүү Конвенцын нэмэлт өөрчлөлтийг баталсны дараа Оролцогч улсууд соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах эсвэл нэгдэн орохоор зохицуулсан байна. Ийнхүү нэмэлт, өөрчлөлт оруулахыг Монгол Улсын Олон Улсын Гэрээний тухай хуулиар мөн тусгайлан зохицуулсан байгааг дээрх холбогдох зүйл, заалтаас харж болно. Өөрөөр хэлбэл, ийнхүү конвенцод нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зохицуулсан нь манай улсын хуульд харшлахгүй буюу нийцэж байна.

#### Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийн зүйл, заалт

1. 32 дугаар зүйл– Цуцлах
1. Оролцогч улс энэ Конвенцыг цуцалсан тухайгаа бичгээр үйлдэж Ерөнхий Захиралд хадгалуулна.
  2. Цуцлах өдрийг мэдэгдэлд өөрөөр заагаагүй тохиолдолд цуцалсан тухай мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш арван хоёр сарын дараа цуцлалт хүчин төгөлдөр болно.
  3. Конвенцыг цуцлах нь аливаа Оролцогч улсад уг Конвенцод тусгагдсан олон улсын эрх зүйн хүрээнд хамаарах аливаа үүргээ биелүүлэхэд нөлөөлөхгүй.

#### Нийцэж буй эрх зүйн актын холбогдох хэсэг

2. Олон улсын гэрээний тухай хуулийн 24 дүгээр зүйл. /Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, биелэлтэд хяналт тавих/  
24.6. Олон улсын гэрээний үүргээ биелүүлэхгүй байгаа бол олон улсын гэрээний үүргээ биелүүлэх шаардлагыг олон улсын гэрээний нөгөө тал, эсхүл бусад талд тавих, шаардлагатай бол тухайн олон улсын гэрээний үйлчлэлийг дуусгавар болгох, цуцлах, гарах, эсхүл үйлчлэлийг түр зогсоох саналыг Улсын Их Хурал, эсхүл Засгийн газраар хэлэлцүүлнэ.
3. Олон улсын гэрээний тухай хуулийн 29 дүгээр зүйл. /Олон улсын гэрээг цуцлах, олон улсын гэрээнээс гарах, гэрээний үйлчлэлийг түр зогсоох/  
29.1.Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ олон улсын гэрээний нөгөө тал, эсхүл бусад тал үл биелүүлсэн, эсхүл удаа дараа зөрчсөн тохиолдолд болон тухайн олон улсын гэрээний зохицуулалтын дагуу олон улсын гэрээг цуцлах, олон талт олон улсын гэрээнээс гарах, түүний үйлчлэлийг түр зогсоох саналыг тухайн олон улсын гэрээгээр зохицуулах асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай тохиролцсоны үндсэн дээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж болно.  
29.2.Соёрхон баталсан олон улсын гэрээг цуцлах, олон талт олон улсын гэрээнээс гарах, олон улсын гэрээний үйлчлэлийг түр зогсоох эсэх асуудлыг Засгийн газрын саналыг үндэслэн Улсын Их Хурал, бусад олон улсын гэрээний хувьд Засгийн газар энэ зүйлийн 29.1-д заасан саналыг үндэслэн шийдвэрлэнэ.

29.3. Олон улсын гэрээний үйлчлэлийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, олон улсын гэрээг цуцлах, олон талт олон улсын гэрээнээс гарах, олон улсын гэрээний үйлчлэлийг түр зогсоох шийдвэр гаргасан бол Улсын Их Хурал хууль, Засгийн газар тогтоол батална.

Тус конвенцийн 32 дугаар зүйлд хүчин төгөлдөр болсон конвенцийг цуцлах талаар тусгасан байна. Гэхдээ үндэслэлийг тодорхой заагаагүй, процедурыг тусгажээ. Энэ нь (1) Орлоцогч улс конвенцыг цуцалсан тухайгаа бичгээр үйлдэж Ерөнхий Захиралд хадгалуулах замаар хэзээ ч цуцлаж болно. (2) Цуцлах өдрийг мэдэгдэлд өөрөөр заагаагүй тохиолдолд цуцалсан тухай мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш арван хоёр сарын дараа цуцлалт хүчин төгөлдөр болно. Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуульд олон улсын гэрээний бусад тал олон улсын гэрээний үүргээ биелүүлэхгүй бол шаардлага тавих, эсхүл гэрээг цуцлах саналыг УИХ, ЗГ хэлэлцэж, тогтоол батлахаар заажээ. Олон улсын гэрээнээс гарах буюу денонсаци хийх тохиолдол манай улсын хувьд тийм ч түгээмэл тохиолддоггүй ба энэхүү гэрээ, дотоодын хуулийн дагуу гэрээг цуцлах боломжтой байна.

“Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 5.5. Асуудалд дүн шинжилгээ хийж, зохицуулалтын хувилбаруудыг сонгож тандан судлах явцад тухайн асуудлыг зөвхөн хууль гаргах замаар шийдвэрлэнэ гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд хууль тогтоомжийн төслийн бүтэц, агуулга, нэмэлт, өөрчлөлт оруулах, шинээр боловсруулах шаардлагатай хууль тогтоомжийг ерөнхий байдлаар томъёолж бичнэ,<sup>59</sup> Олон улсын гэрээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4. Улсын Их Хурал олон талт олон улсын гэрээг соёрхон батлахдаа тайлбар хийхээр шийдвэрлэсэн бол тухайн олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуульд энэ тухай тусгай заалт оруулна<sup>60</sup> гэснийг тус тус үндэслэн хуулийн төслийг дараах байдлаар томъёолов.

<sup>59</sup> Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

<sup>60</sup> Олон улсын гэрээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017, №02

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ..... сарын ..... өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

КОНВЕНЦ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай” 2001 оны ЮНЕСКО-гийн конвенцыг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

## АВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Судалгааны энэхүү үе шатанд зохицуулалтын хувилбаруудын эерэг болон сөрөг үр нөлөөг хооронд нь харьцуулах ажиллагаа хийгддэг бөгөөд аль хувилбар нь зорилгод хүрэх хамгийн боломжтой талаар дүгнэлтийг хийдэг. Өөрөөр хэлбэл, үр нөлөөг тооцох ажиллагааны үр дүнд ганц хувилбар зорилгод хүрэх хамгийн боломжтой гэсэн дүгнэлтэд хүрч болно. Харин асуудлыг шийдвэрлэх хэд хэдэн боломжит хувилбарыг гаргаж ирж тэдгээр хувилбарууд бүгд хэрэгтэй гэж үзвэл тэдгээрийг хооронд нь харьцуулах шаардлагагүй болдог. Мөн зохицуулалтын хувилбаруудаас шууд аль нэгийг сонгох ёстой тухай тухайлан аргачлалд заасан бол харьцуулах боломжгүй юм.

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт болох Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын 5 дугаар зүйлийн 5.4-т хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг шууд сонгох дөрвөн тохиолдлыг заасан байх бөгөөд тус зүйлийн 5.4.2 дахь хэсэгт “тухайн асуудлыг гагцхүү хуулиар зохицуулах шаардлагатай болохыг Үндсэн хуульд онцлон заасан бол” хэмээн заасанд манай тохиолдол нийцэж байгаа тухай дээр өгүүлсэн. Иймд бид өмнөх хоёр үе шатанд “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай ЮНЕСКО-ийн 2001 оны конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл боловсруулж батлах” хэмээх зохицуулалтын ганц хувилбарыг л шалгасан билээ. Ийнхүү ганц хувилбарыг өмнөх үе шатад сонгосон тул энэ үе шатанд харьцуулалт хийх боломжгүй болж байна. Тиймээс судалгааны энэхүү үе шатанд “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай ЮНЕСКО-ийн 2001 оны конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл боловсруулж батлах” хэмээх зохицуулалтын хувилбараас гарч болох эерэг болон сөрөг үр дагаварыг доорх шалгуур үзүүлэлтээр урьдчилан тооцоолсны үр дүнд тодорхойллоо.

|                  | <b>Зохицуулалтын хувилбарууд</b>                                | <b>Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай ЮНЕСКО-ийн 2001 оны конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл боловсруулж батлах</b>   |
|------------------|---|--|
| Шалгуур үзүүлэлт | Зорилгод хүрэх байдал   | Тус хувилбарын хувьд:<br>-Хууль нь батлагдах шаардлага болон агуулгын чанар сайтай;<br>-Манай улсад тодорхой нэг конвенцод нэгдсэнээр соёлын өвийг амжилттай хамгаалсан сайн туршлага бий<br>-Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд болон салбарын мэргэжилтнүүд тус конвенцод нэгдэхийг санал нэгтгэйгээр дэмжиж байгаа бөгөөд соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бодлого ч мөн нийцэж байгаа тул тус хувилбар нь иймд зорилгод нийцсэн байна. |
|                  | Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө | Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд эерэг нөлөө үзүүлж байгааг өмнөх үе шатанд шалгалтын үндсэн дээр тогтоосон болно.   |
|                  | Зардал, үр өгөөжийн харьцаа                                     | Төрөөс хууль батлахтай холбоотой зардал тодорхой хэмжээгээр гарах хэдий ч тус хувилбар нь зорилгод хүрэхэд илүү тохиромжтой, үр өгөөжтэй байна. Иймд зардал, үр өгөөжийн харьцааны хувьд үр өгөөж нь илүү хэмээн дүгнэж болохоор байна.  |
|                  | Хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх                            | Хууль тогтоомжтой нийцэж байгааг өмнөх үе шатанд дэлгэрэнгүй шалгасан болно. Тухайлбал, “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 12 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 1.13 дахь хэсэгт заасны дагуу   |

|  |  |
|--|--|
|  | “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийг соёрхон батлах тухай” хуулийн төслийг боловсруулж, 2023 онд Улсын Их Хуралд өргөн барихаар төлөвлөсөн байна.   |
| Тухайн зохицуулалтаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх этгээдийг тогтоох | Хүн ам, соёлын салбарт ажиллагсад болон соёлын өвийн эсрэг гэмт хэргийн улмаас эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчид нь энэхүү зохицуулалтаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх этгээдүүд болно. Харин конвенцийн дагаа тодорхой эрх агуулагч этгээдүүд нь Усан доорх соёлын өвийг хамгаалах конвенцийн Оролцогч улсууд, эрх бүхий байгууллага, соёл, түүх эсвэл археологийн холбоо хамааралтай улс, Зохицуулагч улс, Зөвлөлдөж буй улсууд, Оролцогч улсын харьяаллын иргэн, Конвенцын Нарийн бичгийн дарга нарын газар, ЮНЕСКО-ийн Ерөнхий Захирал болно. |

Дээрх урьдчилсан тооцоололд үндэслэн тухайн хувилбарын эерэг болон сөрөг талыг дүгнэлээ.

#### **Гарч болох эерэг үр дүн**

Бидний сонгосон “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай ЮНЕСКО-ийн 2001 оны конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл боловсруулж батлах” хэмээх зохицуулалтын хувилбар нь зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлт, зардал, үр өгөөжийн харьцаа шалгуур үзүүлэлт, хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх шалгуур үзүүлэлт, хүний эрхэд үзүүлэх үр нөлөө гэх шалгуур үзүүлэлтийн хувьд эерэг үр дүнг үзүүлж байгаа нь нотлогдож байх бөгөөд энэхүү судалгаагаар шийдвэрлэх зорилго гэж тодорхойлсон “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай ЮНЕСКО-ийн 2001 оны конвенцод нэгдэн орох” хэмээх зорилгыг хангаж байна.

#### **Гарч болох сөрөг үр дагавар**

Зохицуулалтын хувилбарын хувьд гарч болох сөрөг үр дагаварын хувьд тухайн конвенцийн зохицуулалттай холбоотой өмчлөх эрхийн хязгаарлалт, Оролцогч улсуудын зүгээс авагдах хориг арга хэмжээ байж болох хэдий ч эдгээр нь гагцхүү эрх зүйн бус үйлдлийн үр дүнд үүсэх үр дагавар юм. Иймд аргачлалын дагуу дэвшүүлсэн шалгуур үзүүлэлтийг тус зохицуулалтын хувилбар эерэг үзүүлэлттэйгээр давсан болно.

## ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

### Усан доорх соёлын өвийг хамгаалах олон улсын эрх зүйн зохицуулалт

Дэлхийн өнцөг булан бүрт далайн ёроолд гурван сая хөлөг онгоцны сүйрэл, живсэн хөтүүд болон балар эртний дурсгалт газрууд байдаг гэсэн тооцоо бий.<sup>61</sup> Гэсэн хэдий ч усан доорх соёлын өвийг зөвхөн эдийн засгийн ач холбогдолтой бараа хэмээн ойлгодог байсан үе бий. Тухайлбал, 1999 онд Хятадын 350,000 шаазан эдлэлийг далайгаас гаргаж, Германд дуудлага худалдаанд оруулж, эдгээр эд өлгийн түүх, археологийн үнэ цэнийг үл тоомсорлосон түүхтэй.<sup>62</sup>

Усан доорх соёлын өвийн байршлыг тогтоох, сэргээх, малтлага явуулахад далайн гүндэх үйл ажиллагаанд зориулагдсан тусгай технологи маш чухал юм. Тасралтгүй эрчимжиж буй технологийн хөгжил нь эртний хөлөг онгоцны үлдэгдлийг малтах ажлыг хөнгөвчилсөөр байгаа бөгөөд одоогоор 300 гаруй метрийн гүнд хүрэх боломжтой<sup>63</sup> байна. Түүнчлэн усан доорх соёлын өв нь аль нэг улсын шууд харьяалалгүй усан доор байх нь бий учир олон янзын ашиг сонирхол бүхий этгээдүүдийн анхааралд үргэлж байсаар иржээ. Энэ ч утгаараа ЮНЕСКО усан доорх соёлын өвд хулгай, шинжлэх ухааны үндэслэлгүй, хууль бус малтлага зэрэг заналхийлж байна хэмээн үздэг.

Өмнө хэсгүүдэд бид дотоодын соёлын өвийг хамгаалдаг хууль эрх зүйн дэглэмтэй харьцуулахад усан доорх соёлын өвийг хамгаалах эрх зүйн зохицуулалт хангалтгүй байдаг тухай дурдсан билээ. Үүнийг харгалзан усан доорх соёлын өвийг хамгаалж чадах олон улсын эрх зүйн тогтолцоог бий болгож, хөгжүүлэх шаардлагатай гэдэг дээр судлаачид, болоод олон улсын байгууллагууд санал нэгдсэний үр дүнд харьцангуй иж бүрэн эрх зүйн орчныг бүхий, амин чухал олон улсын гэрээ болох Усан доорхи соёлын өвийг хамгаалах тухай 2001 оны конвенцийг баталсан юм.<sup>64</sup>

Энэхүү конвенц нэг чухал зарчим бол усан доорх соёлын өвийг газар дээр нь хадгалж, хамгаалахыг нэн тэргүүнд эрмэлзэх тухай юм. Энэ тухай конвенцийн 2 дугаар зүйлийн 5-дахь хэсэгт “Усан доорх соёлын өвд чиглэсэн аливаа үйл ажиллагааг зөвшөөрөх эсвэл хийхээс өмнө усан доорх соёлын өвийг оршин байгаа газарт одоогийн байдлаар нь хадгалах нь хамгаалалтын эхний сонголт гэж үзэх ёстой.” хэмээн заасан байдаг.<sup>65</sup> Үүнийг олон судлаачид усан доорх соёлын өвийг хамгаалах хамгийн сайн арга гэж хүлээн зөвшөөрдөг.<sup>66</sup> Учир нь усан доорх нөхцөл байдалд л тухайн соёлын өв нь тогтвортой буюу бүрэн бүтэн байдлаа хадгалан оршиж байдаг бөгөөд уснаас гаргах нь маш өндөр эрсдэлтэй гэж үздэг.

<sup>61</sup> Events at UNESCO Headquarters to Improve the Protection of Underwater Cultural Heritage, холбоос: <http://www.unesco.org/new/en/unesco/resources/heritage-under-the-waves/>.

<sup>62</sup> Lin Wenrong, The Shipwreck Keeps Germans Busy, холбоос: <http://www.people.com.cn/GB/paper40/2027/324471.html>

<sup>63</sup> A Journey to 308 Meters: The Deepest Open Circuit Scuba Dive Ever, Холбоос: <http://www.tech-dive-academy.com/journey.html>

<sup>64</sup> NIE Bomin, On the International Legal Protection of Underwater Cultural Heritage, China Oceans Law Review/China Oceans Law Review (Vol. 2015 No. 2) холбоос: [https://core.ac.uk/download/pdf/41460226.pdf?fbclid=IwAR36f76yi-G7Qw0eBJLF47A9tj4WvkAlcmA5bs8\\_9dStGRFAW-luTp-3Bkl](https://core.ac.uk/download/pdf/41460226.pdf?fbclid=IwAR36f76yi-G7Qw0eBJLF47A9tj4WvkAlcmA5bs8_9dStGRFAW-luTp-3Bkl)

<sup>65</sup> The UNESCO Convention on the Protection of the Underwater Cultural Heritage, adopted in November 2001

<sup>66</sup> Patrick J. O’Keefe, Shipwrecked Heritage: A Commentary on the UNESCO Convention on Underwater Cultural Heritage, Leicester: Institute of Art and Law, 2002, p. 49

Тус конвенц нь дээр дурдсан зохицуулалтаас гадна усан доорх соёлын өвийг хамгаалахад чиглэсэн олон улсын эрх зүйн хийдлийг нөхөх чухал алхам болсон бөгөөд усан доорх соёлын өвийг дээрэм, хууль бус малтлагаас хамгаалахад чиглэсэн гол зохицуулалт бүхий өргөн хэмжээний зохицуулалт, нарийн зохицуулсан дүрэм бүхий гэдгээрээ чухал олон улсын эрх зүйн баримт бичиг юм. Үүгээр зогсохгүй усан доорх соёлын өвийг хамгаалахад улс орнуудад олон нийтийн мэдлэг, мэдээлэл зохих ёсоор шаардлагатайг харгалзан үзэхийн тула тус салбарын хөгжлийг дэмжихэд анхаардагаараа нэн эерэг нөлөөлөл, үр дүнг үзүүлдэг хэмээн судлаачид санал нэгтгэйгээр хүлээн зөвшөөрдөг билээ.

### Усан доорх соёлын өвийг хамгуулах тухай ЮНЕСКО-ийн 2001 оны конвенцод нэгдэн орсон улсуудын талаарх мэдээлэл

Өнөөдрийг хүртэл тус конвенцод 71 орон нэгдэн ороод байна. Энэ нь ЮНЕСКО-гийн гишүүн орнуудын бараг гуравны нэг нь нэгдэн орсон гэсэн үг юм. Энэхүү конвенц нь конвенцийн 27 дугаар зүйлд заасны дагуу соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах тухай нэгдэн орох тухай баримт бичгээ хадгалуулснаар хүчин төгөлдөр болдог. Конвенцод нэгдэн орсон улсуудыг доорх хүснэгтэд энэхүү судалгаанд ач холбогдолтой мэдээллийн хамтаар, ЮНЕСКО-ийн соёлын өвийн газар зүйн ангиллын дагуу ангилж, жагсаан харуулав.

| №  | Оролцогч улс             | Нэгдэн орсон огноо | Нэгдэн орсон хэлбэр     | Далайд гарцгүй орон эсэх |
|--|--------------------------|--------------------|-------------------------|--------------------------|
| <b>Европ/баруун болон хойд/ ба Хойд Америкийн улсууд</b> |                          |                    |                         |                          |
| 1.   | Бельги                   | 08/05/2013         | Соёрхон баталсан        | Үгүй                     |
| 2.   | Франц                    | 02/07/2013         | Соёрхон баталсан        | Үгүй                     |
| 3.   | Итали                    | 01/08/2010         | Соёрхон баталсан        | Үгүй                     |
| 4.   | Литва                    | 06/12/2006         | Соёрхон баталсан        | Үгүй                     |
| 5.   | Мальта                   | 04/07/2021         | Соёрхон баталсан        | Үгүй                     |
| 6.   | Микронезийн Холбоот Улс  | 04/19/2018         | Соёрхон баталсан        | Үгүй                     |
| 7.   | Монтенегро               | 07/18/2008         | Соёрхон баталсан        | Үгүй                     |
| 8.   | Португал                 | 09/21/2006         | Соёрхон баталсан        | Үгүй                     |
| 9.   | Испани                   | 06/06/2005         | Соёрхон баталсан        | Үгүй                     |
| 10.  | <b>Швейцар</b>           | <b>10/25/2019</b>  | <b>Соёрхон баталсан</b> | <b>Тийм</b>              |
| <b>Зүүн Европын улсууд</b>                               |                          |                    |                         |                          |
| 11.  | Албани                   | 03/19/2009         | Соёрхон баталсан        | Үгүй                     |
| 12.  | Болгар                   | 10/06/2003         | Соёрхон баталсан        | Үгүй                     |
| 13.  | Босни Херцеговина        | 04/22/2009         | Соёрхон баталсан        | Үгүй                     |
| 14.  | Хорват                   | 12/01/2004         | Соёрхон баталсан        | Үгүй                     |
| 15.  | Эстони                   | 11/02/2020         | Баталсан                | Үгүй                     |
| 16.  | <b>Унгар</b>             | <b>03/19/2014</b>  | <b>Соёрхон баталсан</b> | <b>Тийм</b>              |
| 17.  | Румин                    | 07/31/2007         | Хүлээн зөвшөөрсөн       | Үгүй                     |
| 18.  | Польш                    | 05/18/2021         | Соёрхон баталсан        | Үгүй                     |
| 19.  | <b>Словак</b>            | <b>03/11/2009</b>  | <b>Соёрхон баталсан</b> | <b>Тийм</b>              |
| 20.  | Словен                   | 09/18/2008         | Соёрхон баталсан        | Үгүй                     |
| 21.  | Украйн                   | 12/27/2006         | Соёрхон баталсан        | Үгүй                     |
| <b>Латин Америк ба Карибийн тэнгисийн улсууд</b>         |                          |                    |                         |                          |
| 22.  | Антигуа Барбуда          | 04/25/2013         | Соёрхон баталсан        | Үгүй                     |
| 23.  | Аргентин                 | 07/19/2010         | Соёрхон баталсан        | Үгүй                     |
| 24.  | Барбадос                 | 10/02/2008         | Хүлээн зөвшөөрсөн       | Үгүй                     |
| 25.  | <b>Болив</b>             | <b>02/24/2017</b>  | <b>Соёрхон баталсан</b> | <b>Тийм</b>              |
| 26.  | Коста Рика               | 04/27/2018         | Соёрхон баталсан        | Үгүй                     |
| 27.  | Куба                     | 05/26/2008         | Соёрхон баталсан        | Үгүй                     |
| 28.  | Бүгд Найрамдах Доминикан | 23/09/2021         | Соёрхон баталсан        | Үгүй                     |

|                                  |                                |                   |                         |             |
|----------------------------------|--------------------------------|-------------------|-------------------------|-------------|
| 29.                              | Эквадорь                       | 12/01/2006        | Соёрхон баталсан        | Үгүй        |
| 30.                              | Гренада                        | 01/15/2009        | Соёрхон баталсан        | Үгүй        |
| 31.                              | Гуатемал                       | 11/03/2015        | Соёрхон баталсан        | Үгүй        |
| 32.                              | Гуяана                         | 04/28/2014        | Соёрхон баталсан        | Үгүй        |
| 33.                              | Гайти                          | 11/09/2009        | Соёрхон баталсан        | Үгүй        |
| 34.                              | Гондурас                       | 07/23/2010        | Соёрхон баталсан        | Үгүй        |
| 35.                              | Ямаик                          | 08/09/2011        | Соёрхон баталсан        | Үгүй        |
| 36.                              | Мексик                         | 07/05/2006        | Соёрхон баталсан        | Үгүй        |
| 37.                              | Панам                          | 05/20/2003        | Соёрхон баталсан        | Үгүй        |
| 38.                              | <b>Парагвей</b>                | <b>09/07/2006</b> | <b>Соёрхон баталсан</b> | <b>Тийм</b> |
| 39.                              | Сэйнт Киттс ба Невис           | 12/03/2009        | Соёрхон баталсан        | Үгүй        |
| 40.                              | Сэйнт Люс                      | 02/01/2007        | Соёрхон баталсан        | Үгүй        |
| 41.                              | Сэйнт Винсент ба Гренадин      | 11/08/2010        | Соёрхон баталсан        | Үгүй        |
| <b>Африкийн улсууд</b>           |                                |                   |                         |             |
| 42.                              | Бенин                          | 08/04/2011        | Соёрхон баталсан        | Үгүй        |
| 43.                              | Кабо Верде                     | 03/26/2019        | Соёрхон баталсан        | Үгүй        |
| 44.                              | Ардчилсан Бүгд Найрамдах Конго | 09/28/2010        | Соёрхон баталсан        | Үгүй        |
| 45.                              | Габон                          | 02/01/2010        | Хүлээн зөвшөөрсөн       | Үгүй        |
| 46.                              | Гана                           | 01/20/2016        | Соёрхон баталсан        | Үгүй        |
| 47.                              | Гвиней                         | 07/13/2021        | Соёрхон баталсан        | Үгүй        |
| 48.                              | Гвиней-Бисау                   | 03/07/2016        | Хүлээн зөвшөөрсөн       | Үгүй        |
| 49.                              | Мадагаскар                     | 01/19/2015        | Соёрхон баталсан        | Үгүй        |
| 50.                              | <b>Мали</b>                    | <b>03/02/2021</b> | <b>Соёрхон баталсан</b> | <b>Тийм</b> |
| 51.                              | Намиб                          | 03/09/2011        | Соёрхон баталсан        | Үгүй        |
| 52.                              | Нигир                          | 10/21/2005        | Соёрхон баталсан        | Үгүй        |
| 53.                              | Сенегал                        | 09/15/2020        | Соёрхон баталсан        | Үгүй        |
| 54.                              | Өмнөд Африк                    | 05/12/2015        | Хүлээн зөвшөөрсөн       | Үгүй        |
| 55.                              | Того                           | 06/07/2013        | Соёрхон баталсан        | Үгүй        |
| 56.                              | Тринидад Тобаго                | 07/27/2010        | Соёрхон баталсан        | Үгүй        |
| <b>Арабын улсууд</b>             |                                |                   |                         |             |
| 57.                              | Алжир                          | 02/26/2015        | Соёрхон баталсан        | Үгүй        |
| 58.                              | Бахрайн                        | 03/07/2014        | Соёрхон баталсан        | Үгүй        |
| 59.                              | Египт                          | 08/30/2017        | Соёрхон баталсан        | Үгүй        |
| 60.                              | Иордан                         | 12/02/2009        | Соёрхон баталсан        | Үгүй        |
| 61.                              | Кувейт                         | 05/30/2017        | Соёрхон баталсан        | Үгүй        |
| 62.                              | Исламын Бүгд Найрамдах Иран    | 06/16/2009        | Соёрхон баталсан        | Үгүй        |
| 63.                              | Ливан                          | 01/08/2007        | Хүлээн зөвшөөрсөн       | Үгүй        |
| 64.                              | Лив                            | 06/23/2005        | Соёрхон баталсан        | Үгүй        |
| 65.                              | Морокко                        | 06/20/2011        | Соёрхон баталсан        | Үгүй        |
| 66.                              | Оман                           | 06/10/2020        | Соёрхон баталсан        | Үгүй        |
| 67.                              | Палестин                       | 12/08/2011        | Соёрхон баталсан        | Үгүй        |
| 68.                              | Саудын Араб                    | 11/13/2015        | Соёрхон баталсан        | Үгүй        |
| 69.                              | Тунис                          | 01/15/2009        | Соёрхон баталсан        | Үгүй        |
| <b>Ази, Номхон далайн улсууд</b> |                                |                   |                         |             |
| 70.                              | Камбож                         | 11/24/2007        | Соёрхон баталсан        | Үгүй        |
| 71.                              | Ньюэ                           | 11/15/2019        | Хүлээн зөвшөөрсөн       | Үгүй        |

Дээрхээс харвал, тус конвенцод Европ/баруун болон хойд/ ба Хойд Америкийн бүс нутгийн 10 улс, Зүүн Европын 11 улс, Латин Америк ба Карибийн тэнгисийн 20 улс, Африкийн 15 улс, Арабын 13 улс, Ази, Номхон далайн 2 улс тус тус нэгдэн орсон байна. Ийнхүү нэгдэн орохдоо 63 улс соёрхон баталж, 7 улс хүлээн зөвшөөрч, 1 улс баталж тус тус нэгдэн оржээ. Конвенцод нэгдэн орсон улсуудаас Швейцар, Унгар, Словак, Болив, Парагвей, Мали гэсэн 6

Улс далайд гарцгүй байна. Манай улстай адил далайд гарцгүй ч уг конвенцод нэгдэн орсон Эдгээр улсуудад анхаарах нь зүйтэй хэмээн үзэж Швейцар болон Унгар улсын тухай цааш Тухайлан авч үзье.

## Швейцарын Холбооны Улс

2019 оны 10-р сарын 25-ны өдөр Швейцарын Холбооны Улсын Дотоод хэргийн яам хариуцсан Холбооны Зөвлөлийн гишүүн Ален Берсет ЮНЕСКО-гийн Ерөнхий захирал Одри Азулэйд "Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай" ЮНЕСКО-гийн конвенцийг соёрхон баталсан тухай баримт бичгийг гардуулан өгснөөр Швейцарын Холбооны Улс тус конвенцод нэгдэн орсон юм.

Швейцар улс далайд гарцгүй хэдий ч нуур, гол мөрний усан доорх соёлын өв ихтэй гэгддэг. Тус улс нь усан доорх археологийн чиглэлээр удаан хугацааны турш тууштай ажиллаж ирсэн бөгөөд судалгааныхаа чанар, шинжлэх ухааны арга зүйн нарийн арга барилаараа дэлхийд алдартай.<sup>67</sup> Швейцар улс нь археологийн өвөөр маш баялаг. Өнөөдрийн байдлаар хүн төрөлхтний түүхийн бүх цаг үед холбогдох 40,000 орчим археологийн дурсгалууд мэдэгдэж байгаа бөгөөд үүнээс ч олон нь хараахан олдоогүй байгаа гэж үздэг.<sup>68</sup>

Швейцарын нуур, гол мөрөн, намгархаг газар нь хүн төрөлхтний түүхийн бүх цаг үеийн соёлын баялаг өвийг агуулж байдаг онцлогтой. Хамгийн алдартай нь 2011 онд ЮНЕСКО-гийн Дэлхийн өвд бүртгэгдсэн "Альпийн нурууны эргэн тойрон дахь балар эртний үеийн байшингууд" хэмээх овоолгын суурингууд юм. Энэхүү соёлын өв нь нийт 111 объектоос бүрдэх бөгөөд 6 өөр улсын нутаг дэвсгэрт байрладаг.<sup>69</sup> "Альпийн нурууны эргэн тойрон дахь балар эртний үеийн байшингууд" нь Альпийн нуруу болон түүний эргэн тойронд МЭӨ 5000-аас 500-аад оны үед нуур, гол мөрөн эсвэл намгархаг газарт баригдсан балар эртний овоолго бүхий суурингуудын үлдэгдэл юм. Зарим газарт хийсэн малтлагуудаас Альпийн Европ дахь неолит болон хүрэл зэвсгийн үеийн амьдрал, нийгэм, хүмүүс хүрээлэн буй орчинтойгоо хэрхэн харьцаж байсан талаар чухал ойлголт өгөх баримтуудыг олсон байдаг. Эдгээр газруудын 56 нь Швейцарт байрладаг. Тус суурингууд нь бидний үед онцгой сайн хадгалагдан үлдэж чадсан баялаг соёлын ул мөр, түүх, археологийн дурсгалт газруудын өвөрмөц цогц юм. Иймд энэ бүс нутгийн эрт үеийн газар тариалангийн нийгэм, аж ахуй, соёлыг судлах хамгийн чухал эх сурвалжуудын нэг хэмээн тооцогддог.<sup>70</sup>

Швейцарь улс нь Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийг соёрхон баталснаар энэхүү соёлын өвд илүү хариуцлагатай хандаж, устгах, тоногдох тохиолдолд шийтгэл ногдуулах, энэ мэтчилэн соёлын эсрэг чиглэсэн үйлдлүүдтэй тэмцэх үүргийг хүлээж буй бөгөөд усан доорх соёлын өвийн эд зүйлсийг хууль бусаар худалдаалахтай тэмцэхэд уг конвенцод нэгдэн орох явдал нь чухал дэмжлэг болно хэмээн үзэж тийнхүү нэгдэн оржээ.<sup>71</sup>

## Унгар Улс

<sup>67</sup> Switzerland ratifies UNESCO Convention on the Protection of the Underwater Cultural Heritage, Холбоос: <https://www.unesco.org/en/articles/switzerland-ratifies-unesco-convention-protection-underwater-cultural-heritage>

<sup>68</sup> Archaeological heritage, <https://archaeologie-schweiz.ch/en/archaeological-heritage/>

<sup>69</sup> Switzerland ratifies UNESCO convention on underwater cultural heritage. холбоос: <https://heritagetribune.eu/switzerland/switzerland-ratifies-unesco-convention-on-underwater-cultural-heritage/>

<sup>70</sup> Switzerland commits to the protection of underwater cultural heritage, холбоос: <https://www.unesco.org/en/articles/switzerland-commits-protection-underwater-cultural-heritage>

<sup>71</sup> Convention on the Protection of the Underwater Cultural Heritage, Холбоос: <https://www.bak.admin.ch/bak/en/home/baukultur/archaeologie-und-denkmalspflege/unterwasser-kulturerbe.html>

Унгар Улс бол Төв Европын далайд гарцгүй орон юм. Тус улсын томоохон голууд нь Дунай, Тиса ажээ. Дунай нь Унгарын нутаг дэвсгэрт 418 км, Тиса гол нь тус улсад 444 км урттай урсдаг. Бусад томоохон голуудад Хорватын хил дагуух Драва, Раба, Сзамос, Сие, Словакийн хил дагуух Иполи зэрэг голууд ордог. Унгар Улс нь гурван том нууртай. Хамгийн том нь болох Балатон нуур нь 78 км урт, 3-14 км өргөн, 600 хавтгай дөрвөлжин км талбайтай. Унгарчууд тус нуурыг “Унгарын тэнгис” гэж нэрлэдэг. Энэ бол Төв Европын хамгийн том цэнгэг устай нуур бөгөөд амралт зугаалгын чухал бүс юм. Гүехэн ус нь зуны улиралд сэлэх боломжийг олгодог бол, өвлийн улиралд хөлдсөн гадаргуу нь өвлийн спортоор хичээллэх сайхан боломжийг олгодог байна. Бусад томоохон нуур нь Фежер муж дахь Веленс нуур (26 хавтгай дөрвөлжин км) ба Ферто нуур (Нейзидлер Си - Унгарын нутаг дэвсгэрт 82 хавтгай дөрвөлжин км), хиймэл Тиса нуур юм.<sup>72</sup>

Унгар нь гол мөрөн, нуурын усан доорхи соёлын өв арвинтай, усан доорх археологийн салбар хөгжих өргөн боломжтой улс хэмээгддэг. Тиймдээ ч гол мөрний археологи эрчимтэй хөгжиж байна. Тус улсад усан доорх соёлын өв бүхий 55,000 орчим газар мэдэгдэж байгаа бөгөөд өдгөө 15,000-20,000 газрыг илрүүлээд байгаа ажээ.<sup>73</sup> Усан доорх газрууд болон голын эрэг дээрх бусад газруудын хувьд (өтгөн ой, бутаар бүрхэгдсэн) соёлын өв бий эсэх нь нэн тодорхойгүй байдаг онцлогтой агаад ийм учир судлаачид тус улсын усан доорх соёлын өвийн 90-95% нь хараахан олдоогүй байгаа хэмээн үздэг.

2008 онд Дэлхийн нэгдүгээр дайны үед сүйрсэн Австри-Унгарын Тэнгисийн цэргийн хүчинд зориулан бүтээсэн Тегеттофф зэрэглэлийн дөрвөн байлдааны хөлөг онгоцны сүүлчийнх нь болох MS Szent István буюу Эрхэм дээдсийн хөлөг Гэгээн Стефан хөлөг онгоцны сүйрлийг судалсан олон улсын шумбагчдын баг нь хуучин Австри-Унгарын эзэнт гүрний олон үндэстний төлөөллөөс бүрдэж, энэхүү түүхэн соёлын өвийн талаар хамтран ажилласан нь Унгар улсын хувьд бэлгэдлийн хувьд ч өндөр ач холбогдолтой байгаад зогсохгүй усан доорх соёлын өвийг хамгаалах асуудалд олон нийтийн болоод бодлого тодорхойлогчдын анхаарлыг хандуулж чадсан ажээ.

Унгар улс Усан доорх соёлын өвийг хамгаалах конвенцийг 2014 онд соёрхон баталсан байдаг. Тухайн үед Унгар улсаас Парис хотноо ЮНЕСКО-д суугаа Байнгын төлөөлөгч байсан Каталин Богяй энэхүү конвенцод нэгдэн орсон явдлыг “Унгар улс усан доорхи соёлын өвийг газар дээрх болон доорх өвийг хамгаалж байгаатай ижил төрлийн хамгаалалтаар хангахын ач холбогдлыг ойлгосны үр дүн юм.”<sup>74</sup> хэмээгээд тус конвенцод нэгдэн орсон зорилгыг далайд гарцгүй улс орнуудын усан доорх соёлын өвийг дээрэмдэх, арилжааны зорилгоор ашиглахаас хамгаалах хамтын ажиллагааг нэмэгдүүлэх явдал гэж тодорхойлсон байдаг.

## **Бүгд Найрамдах Солонгос Улсын тус конвенц дох оролцоо**

Одоогийн байдлаар Ази, Номхон далайн бүс нутгаас Камбож, Ниуэ гэсэн 2 улс л Усан доорх соёлын өвийг хамгаалах конвенцод нэгдэн орсон нь бусад бүс нутагтай харьцуулахад хамгийн бага үзүүлэлт юм. Харин сүүлийн жилүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улс /цаашид БНСУ гэх/ усан доорх соёлын өвийн тухай үндэсний тайланг гаргаж эхлээд байна. Үндэсний тайлан гэдэг нь усан доорх соёлын өвийн байдал, түүнийг хамгаалах, түүнтэй холбоотой

<sup>72</sup> A Balaton áttekintő térképe és települései, холбоос: <http://www.kdtvizi.hu/hu/53ab9177-7e15-44eb-a7f3-c004010c2277>

<sup>73</sup> Attila J. Tóth, River archaeology – a new tool for historical hydrology, холбоос: <http://real.mtak.hu/5117/1/1135834.pdf>

<sup>74</sup> Statement by H.E. Ambassador Katalin Bogay at the side event organized by UNESCO and Honduras entitled An Ocean without history? - The importance of underwater cultural heritage, холбоос: <https://ensz.newyork.mfa.gov.hu/enq/news/statement-by-he-ambassador-katalin-bogay-at-the-side-event-organized-by-unesco-and-honduras-entitled-an-ocean-without-history-the-importance-of-underwater-cultural-heritage>

Усад үйл ажиллагааны тухай, улс орнуудын усан доорх археологийн хөгжлийн талаарх Үндэсний тайлан мэдээ юм. Энэхүү тайланг конвенцод оролцогч улсууд болон ЮНЕСКО-ийн гишүүн орнууд зөвшилцөх зорилгоор сайн дурын үндсэн дээр гаргадаг бөгөөд албан ёсны татусгүй байдаг.<sup>75</sup>

БНСУ-д соёлын өвийг хамгаалах ажил 1962 оны 1-р сард "Соёлын өвийг хамгаалах тухай хууль"-ийг баталсанаар эхэлсэн хэдий ч усан доорх соёлын өвийн асуудлыг тусгайлан зохицуулаагүй байдаг. Гэсэн хэдий ч усан доорх археологийн малталга ихээхэн хөгжсөн. 2010 онд "Соёлын өвийг хамгаалах тухай хууль"-ийн хийдэлтэй зохицуулалтыг нөхөх зорилгоор "Оршуулсан соёлын өвийг хамгаалах, судлах тухай хууль"-ийг баталсан. Энэхүү хууль нь усан доорх соёлын өв, ил задгай соёлын өвийн бүс нутгийг тодорхойлох тодорхой заалтуудыг агуулснаараа онцлогтой. Үүгээр усан доорх соёлын өвийн эрх зүйн зохицуулалтыг цаашид илүү дэвшилтэт тогтолцоонд шилжүүлэхэд бэлтгэсэн гэж хэлж болно. БНСУ-ын Далайн соёлын өвийн үндэсний судалгааны хүрээлэнгийн Усан доорх малтлага, хамгаалалтын албаны дарга, Ван Сук Мүүн Үндэсний тайландаа "Солонгосын Соёлын өвийн хэрэг эрхлэх газар, Гадаад хэргийн яам, Газар тээвэр, далайн харилцааны яамтай хамтран Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийг соёрхон батлах асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна."<sup>76</sup> хэмээсэн нь тус улс энэхүү конвенцийг усан доорх соёлын өвийн эрх зүйн зохицуулалтыг хөгжүүлэх гол түлхэц хэмээн харж байгааг илтгэж буй хэрэг юм.

БНСУ-ын усан доорх соёлын өвийн талаарх судалгааг гадаргын судалгаа, малтлага гэсэн хоёр хэсэгт ангилан авч үздэг. Энэхүү ажлын хүрээнд мэргэшсэн байгууллагууд нь Соёлын өвийн газарт бүлтгүүлэн зохих зөвшөөрөл авснаар судалгаа хийх боломжтой болдог бөгөөд одоогийн байдлаар зургаан байгууллага газрын гадаргын судалгаа хийхээр бүртгүүлээд байна.<sup>77</sup> Харин Далайн соёлын өвийн үндэсний судалгааны хүрээлэн нь БНСУ дахь усан доорх малтлага хийх эрх бүхий цорын ганц институт бөгөөд усан доорх соёлын өвийн малтлагыг дагнан хариуцдаг байгууллага юм. БНСУ-д 1971 оноос өнөөдрийг хүртэл усан доорхи соёлын өвийн нээлт, холбогдох тайлангийн тоо ойролцоогоор 250-д хүрээд байна. Усан доорх малтлагын эхлэл нь 1976 онд Шинань хөлөг онгоцны сүйрлээс эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар 11 живсэн хөлөг онгоц, 95,000 шаазан, модон эдлэлийн олдворуудыг 18 газраас малтаж гаргаж ирээд байна. Ийнхүү малтлага, судалгаа хийхэд байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйлс хүндрэл учруулсаар байна. Тухайлбал, усны хурдан түрлэг, шаварлаг гадаргуу болон өвлийн улиралд усны температур бага байдаг гэх мэт.

Дээр дурдсан Далайн соёлын өвийн үндэсний судалгааны хүрээлэн нь 2011 онд Тэан тэнгисийн бүс нутагт соёлын өвийн аюулгүй байдлыг хангах зорилгоор "Тэан хамгаалах төв"-ийг байгуулсан. Түүнчлэн усан доорх малталт хийх зориулалт бүхий (290 тонн) тусгай аврах хөлөг онгоц бүтээн байгуулалтын шатандаа явж байгаа бөгөөд энэ нь Зүүн Азид анхдагч юм. Цаашилбал, Тэанд усан доорх соёлын өвийн цогц судалгаа, үзэсгэлэнгийн талбай байгуулж, Солонгосын усан доорх археологийн дэвшилтэт бааз болгон хөгжүүлэхээр төлөвлөж байна.

<sup>75</sup> National Reports, холбоос:

[https://en.unesco.org/underwater-heritage/2001?fbclid=IwAR2zWphYRHWYRM\\_iKh3r3HU1iR-Qf0IeQ6dnSeG4RqDinSdxflQAY6VWYpC](https://en.unesco.org/underwater-heritage/2001?fbclid=IwAR2zWphYRHWYRM_iKh3r3HU1iR-Qf0IeQ6dnSeG4RqDinSdxflQAY6VWYpC)

<sup>76</sup> Korean statutes of Underwater Cultural Heritage protection, a product of underwater excavation and the stance of the 2001 Underwater Heritage Convention, холбоос:

[https://en.unesco.org/sites/default/files/korea\\_world\\_reports\\_on\\_underwater\\_cultural\\_heritage.pdf](https://en.unesco.org/sites/default/files/korea_world_reports_on_underwater_cultural_heritage.pdf)

<sup>77</sup> Мөн тэнд.

## ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

Энэ хэсэгт Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай ЮНЕСКО-ийн 2001 оны Конвенцыг соёрхон батлах тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан Судлах судалгааны өмнөх үе шатуудыг нэгтгэн дүгнэж, энэхүү дүгнэлтэд үндэслэн Тодорхой зөвлөмжийг гаргах болно.

Асуудлыг тодорхойлж шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоож, нөхцөл байдлыг дүгнэж үзвэл дараах асуудлуудыг судалгааны Шийдвэрлэх асуудал хэмээн үзсэн болно. Үүнд:

Нэгдүгээрт, “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцыг соёрхон батлах тухай” хуулийг батлах шаардлага нь юун түрүүнд Монгол Улсын олон улсын гэрээтэй холбоотой байна.

Хоёрдугаарт, “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцыг соёрхон батлах тухай” хуулийг батлах хэрэгцээ, шаардлага нь Монгол Улсад усан доорх соёлын өвийг хамгаалах эрх зүйн тодорхой, нарийвчилсан зохицуулалтыг бий болгох, энэ чиглэлээр бусад улсуудтай хамтын ажиллагаа хөгжүүлэх замаар өөрийн улсын түүх, археологийн холбогдол бүхий соёлын өвийг үндэсний эрх зүйн үйлчлэлээс өргөн хүрээнд хамгаалах боломжтой болох зэрэг бодит нөхцөл байдлуудаас үүсэж байна.

Асуудлын хүрээнд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд нь Монгол Улсын нийт хүн ам, соёлын салбарт ажиллагсад, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчид болно.

“Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийг соёрхон батлах тухай” хуулийг батлах шаардлагыг үүсгэж буй асуудлын шалтгаан нөхцлийг дараах нөхцөл байдлууд хэмээн үзсэн. Эдгээр нь:

1. Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай ЮНЕСКО-ийн 2001 оны конвенц нь Монгол Улсын заавал соёрхон батлах олон улсын гэрээ мөн.
2. “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцийг соёрхон батлах тухай” хуулийг батлах нь өөрийн улсын түүх, археологийн холбогдол бүхий соёлын өвийг үндэсний эрх зүйн үйлчлэлээс өргөн хүрээнд хамгаалах боломжтой. Тус конвенцод нэгдсэнээр манай улсын археологийн салбар усан доор малтлага, судалгаа хийх чиглэлээр хөгжих боломж бүрдээд зогсохгүй үүгээр дамжуулан бидний нэгэн гол зорилго болсон өөрийн улсын түүхэн холбогдол бүхий гадаад улс дахь дурсгалт газруудад тухайн улстай хамтран ажиллах боломж ч бий болох өндөр ач холбогдолтой.
3. Манай улс далайн эрх зүйн чиглэлд олон улсад санаачилгатай, идэвхтэй үйл ажиллагаа явуулсаар өдийг хүрсэн нь нээлттэй далайд ч, дотоодын усанд ч хамааралтай олон улсын гэрээ, конвенцуудад нэгдэн орсон байдал, хил орчмын усны тухайд хөрш орнуудтайгаа олон талаар идэвхтэй хамтран ажиллаж байгаа зэргээс харагдаж байна. Энэ нь манай улс усан доорх соёлын өвийг хамгаалах чиглэлд ч идэвхтэй үйл ажиллагаа явуулах үүргийг албан бусаар хүлээлгэж байна. Мөн түүнчлэн, Монгол Улсын гадаргын усны нөхцөл байдал, цаашид ирээдүйд эрчим хүчний чиглэлээрх төрийн бодлого

усан цахилгаан станц байгуулахад чиглэж байгаагаас манай улсад усан доорх археологийн малтлага, судалгаа явуулах бүрэн боломжтой болох нь батлагдаад зогсохгүй Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцын үйлчлэл дотоодын усанд ч үйлчлэх боломжтой учир үүгээр дамжуулан тус чиглэлийг хөгжүүлэх ч боломж нээлттэй байгааг дурдах нь зүйтэй.

4. Усан доорх малтлага, судалгааны ажлыг хөгжүүлэх нь хүрээлэн буй орчныг хамгаалахад чухал шаардлагатай.
5. Усан доорх соёлын өвийг хамгаалах эрх зүйн орчны дутмаг байдал.

Дээр дурдсан асуудлыг шийдвэрлэх зорилгыг “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай ЮНЕСКО-ийн 2001 оны конвенцод нэгдэн орох” хэмээн тодорхойлсон.

Асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтооход, олон улсын гэрээнд нэгдэн орохын тулд зайлшгүй соёрхон батлах тухай хуулийг батлах замаар л нэгдэн орох боломжтой хэмээн Үндсэн хуульд заасан тул хууль тогтоомжийн төсөл боловсруулах зохицуулалтын хувилбарыг шууд сонгох ёстой болсон. Ингэснээр зохицуулалтын хувилбар “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай ЮНЕСКО-ийн 2001 оны конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл боловсруулж батлах” хэмээн тодорхойлогдсон. Ийнхүү дэвшүүлсэн асуудлыг шийдвэрлэх боломжит 7 хувилбарыг ерөнхий байдлаар нягтлан шалгахад 1-ээс 6 дугаар хувилбарыг цааш шалгах боломжгүй болох нь батлагдсан тул тэдгээрийн үр нөлөөг тооцох шаардлагагүй гэж үзсэн.

Зохицуулалтуудын хувилбаруудын эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах хэсэгт дээрх зохицуулалтын хувилбарыг зорилгод хүрэх байдал болон зардал, үр өгөөжийн харьцаа гэсэн шалгуур үзүүлэлтийг харгалзан харьцуулан судалсан. Тус зохицуулалтын хувилбарын зорилгод хүрэх байдлыг авч үзэхэд, адилтгах туршлага буюу “Соёлын биет бус өвийг хамгаалан дэмжих тухай” ЮНЕСКО-ийн 2003 оны Конвенцод нэгдэн орсон соёлын өвийг амжилттай хамгаалж буй сайн туршлага бий. Түүнчлэн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд болон салбарын мэргэжилтнүүд зохицуулалтын хувилбарыг батлах ёстой гэдэгт санал нэгдсэн байдаг. Зардал, үр өгөөжийн харьцааны хувьд, тус зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлэхэд Олон улсын гэрээний тухай хуульд заасан олон улсын гэрээ байгуулах асуудлаар хэлэлцээ хийх, томилолтоор ажиллах, төлөөлөгчид хүлээн авах, хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулах, олон улсын гэрээ байгуулах, олон улсын гэрээнд нэгдэн орохтой холбоотой судалгаа хийх, олон улсын гэрээг орчуулах, орчуулгыг хянан баталгаажуулах, олон улсын гэрээний тусгай хэвлэмэл хуудас, хавтас, үдээс, лац захиалах зардал улсын төсвөөс гарах бөгөөд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд захиргааны ачаалал, нэмэлт зардал үүсгэхгүй. Харин нийгэмд үзүүлэх үр өгөөж нь конвенцыг ашиглан усан доорх соёлын өвийг хамгаалах эрх зүйн зохицуулалт сайжирч, усан доорх археологийн салбар тус чиглэлээр хөгжиж, цаашид өөрийн улсын түүх, археологийн холбогдол бүхий соёлын өвийг бусад улстай хамтран судлах, малтах боломжтой болох явдал бөгөөд гарах зардлаас ямагт өндөр байна.

Судалгааны дөрөв болон тавдугаар бүлгийг нэгтгэн дүгнэвэл, “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай ЮНЕСКО-ийн 2001 оны конвенцыг соёрхон батлах

“Ухай хуулийн төсөл боловсруулж батлах” хэмээх зохицуулалтын хувилбар нь Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлт, зардал, үр өгөөжийн харьцаа шалгуур үзүүлэлт, хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх шалгуур үзүүлэлт, хүний эрхэд үзүүлэх үр нөлөө гэх шалгуур үзүүлэлтийн хувьд эерэг үр дүнг үзүүлж байгаа нь нотлогдож байх бөгөөд энэхүү судалгаагаар шийдвэрлэх зорилго гэж тодорхойлсон “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай ЮНЕСКО-ийн 2001 оны конвенцод нэгдэн орох” хэмээх зорилгыг хангаж байгаа нь тогтоогдсон.

Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай ЮНЕСКО-ийн 2001 оны конвенцод одоогийн байдлаар ЮНЕСКО-гийн гишүүн орнуудын бараг гуравны нэг нь 71 орон нэгдэн ороод байгаа ба эдгээр улсуудыг ангилан авч үзвэл, Европ/баруун болон хойд/ба Хойд Америкийн бүс нутгийн 10 улс, Зүүн Европын 11 улс, Латин Америк ба Карибийн тэнгисийн 20 улс, Африкийн 15 улс, Арабын 13 улс, Ази, Номхон далайн 2 улс тус тус нэгдэн орсон байна. Ийнхүү нэгдэн орохдоо 63 улс соёрхон баталж, 7 улс хүлээн зөвшөөрч, 1 улс баталж тус тус нэгдэн орсоноос үзвэл дийлэнх улсууд тус конвенцыг соёрхон батлах замаар нэгдэн орох хандлагатай байдаг ажээ. Конвенцод нэгдэн орсон улсуудаас Швейцар, Унгар, Словак, Болив, Парагвей, Мали гэсэн 6 улс далайд гарцгүй байна. Манай улстай адил далайд гарцгүй ч уг конвенцод нэгдэн орсон эдгээр улсуудад анхаарах нь зүйтэй хэмээн үзэж Швейцар болон Унгар улсын тухай нарийвчлан судалсан.

Тус хоёр улсын хувьд нийтлэг байдлаар далайд гарцгүй хэдий ч нуур, гол мөрний усан доорх соёлын өв ихтэй, усан доорх археологийн чиглэлээр удаан хугацааны турш тууштай ажиллаж ирсэн арвин туршлагатай улсууд байна. Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцод нэгдэн орсон зорилгын хувьд тус улсууд нь усан доорх соёлын өвд илүү хариуцлагатай хандаж, устгах, тоногдох тохиолдолд шийтгэл ногдуулах, энэ мэтчилэн соёлын эсрэг чиглэсэн үйлдлүүдтэй тэмцэх үүргийг хүлээж усан доорх соёлын өвийн эд зүйлсийг хууль бусаар худалдаалахтай тэмцэхэд дэмжлэг болно хэмээн үзэж далайд гарцгүй улс орнуудын усан доорх соёлын өвийг дээрэмдэх, арилжааны зорилгоор ашиглахаас хамгаалах хамтын ажиллагааг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулах зорилготой байна.

Манай улсын харьяалагддаг Ази, Номхон далайн бүс нутгаас одоогийн байдлаар Камбож, Никуэ гэсэн 2 улс л Усан доорх соёлын өвийг хамгаалах конвенцод нэгдэн орсон нь бусад бүс нутагтай харьцуулахад хамгийн бага үзүүлэлт юм. Харин сүүлийн жилүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улс усан доорх соёлын өвийн тухай үндэсний тайланг гаргаж эхлэн энэ чиглэлээрх үйл ажиллагаагаа эрчимжүүлж тус конвенцод нэгдэн орох зорилгыг дэвшүүлэн ажиллаж байгаа нь манай улстай түүхийн хувьд холбогдол бүхий тус улстай конвенцын дагуу хамтран ажиллах боломж бүрдэхээр байна.

Ийнхүү Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай ЮНЕСКО-ийн 2001 оны конвенцыг соёрхон батлах тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны өмнөх үе шатуудыг нэгтгэн дүгнэсний үндсэн дээр дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

1. Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай ЮНЕСКО-ийн 2001 оны конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийг “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ын 3 дугаар бүлгийн 4 дүгээр зүйл (олон улсын гэрээ соёрхон батлах тухай хуулийн төсөл боловсруулах)-д зааснаар боловсруулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу УИХ-ын чуулганаар хэлэлцүүлж батлах.
2. Тус конвенцод нэгдэн орохдоо конвенцын 28 дугаар зүйлд заасан дотоодын усны тухай мэдэгдлийг гаргах замаар конвенцын Дүрмийг далайн шинж чанартай биш дотоодын усанд ашиглахаа мэдэгдэх.
3. Тус конвенцод нэгдэн орсон тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн жагсаалтад “живсэн хөлөг онгоц, агаарын хөлөг” гэж нэмэх, “Усан доорх соёлын өвд чиглэсэн үйл ажиллагаа”, “Усан доорх соёлын өвд санамсаргүй нөлөөлж буй үйл ажиллагаа” гэх ойлголтуудыг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хуульчлах.
4. Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хуулиудад усан доорх соёлын өвийг хадгалах зорилгоор хоёр талт, бүс нутгийн болон бусад олон талт хэлэлцээр байгуулах, олон улсын хамтын ажиллагааны тухай дэлгэрэнгүй зохицуулалтыг нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хуульчлах.
5. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 38 дугаар зүйлд тодорхойлсон соёлын өвийг хамгаалахтай холбоотой хориглох үйл ажиллагаанууд нь газар, газрын доорх соёлын өвд шууд хамаарах агуулгатай байгааг бусад төрлийн соёлын өвд ч хамаарах агуулгатайгаар өөрчлөх.
6. Далай ашиглах тухай хуульд Монгол Улсын төрийн далбаа мандуулсан хөлөг онгоц усан доорх соёлын өвтэй холбоотой ямар нэг харилцаанд орох бол хэрхэх тухай зохицуулалтыг тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хуульчлах.

**АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ**

**Хууль тогтоомж**

Монгол хэлээр:

Гадаад хэлээр:

**Ном, сурах бичиг, судалгааны тайлан, эмхэтгэл**

Монгол хэлээр:

Гадаад хэлээр

**Цахим эх сурвалж**

Монгол хэлээр:

Гадаад хэлээр:



**СОЁЛ, СПОРТ,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,  
ЗАЛУУЧУУДЫН ЯАМ**

**“УСАН ДООРХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ  
ТУХАЙ” ЮНЕСКО-ИЙН КОНВЕНЦЫГ СОЁРХОН  
БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ  
ҮНЭЛГЭЭ**

Улаанбаатар хот  
2026 он

“УСАН ДООРХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ” ЮНЕСКО-ИЙН  
КОНВЕНЦЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР  
НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээний ажлын гол зорилго нь “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай” ЮНЕСКО-ийн конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийн зүйл, заалтад тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцох, давхардал, хийдэл, зөрчил байгаа эсэхийг тогтоох, арилгах, хуулийн зүйл, заалтын ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад хуулийн төсөл боловсруулагчдад дэмжлэг үзүүлэх, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад оршино.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хууль нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь хэсэгт заасны дагуу анхдагч хуулийн төсөл хэлбэрээр боловсруулагдсан байна.

Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай” ЮНЕСКО-ийн конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийн /цаашид “хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”<sup>1</sup> /цаашид “аргачлал” гэх/-д заасны дагуу дараах үе шаттайгаар гүйцэтгэлээ. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгийг сонгох;
3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг хийхдээ уг хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл, хуулийн төсөл боловсруулах хүрээнд хийсэн урьдчилсан тандан судалгааны тайлан, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага болон нийтээр даган мөрдөхөөр гаргасан олон улсын конвенц гэрээ, хэлэлцээр, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан гүйцэтгэсэн үр нөлөөний болон санхүүгийн судалгааны тайлан, бусад холбогдох хууль тогтоомжийн зохицуулалтыг сонгон авч ашиглалаа.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР  
ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

---

Үнэлгээний ажлыг гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалын 6 шалгуур үзүүлэлтээс 5 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

- зорилгод хүрэх байдал;
- практикт хэрэгжих боломж;
- ойлгомжтой байдал;
- хүлээн зөвшөөрөгдөх байдал;
- харилцан уялдаа... зэрэг болно.

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг дараах байдлаар тогтоолоо.

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зорилго нь үзэл баримтлалд тусгасан хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл шаардлагад нийцсэн эсэх, хуулийн төслийн үндсэн зорилго нь усан доорх соёлын өвийг хамгаалах асуудлыг шийдвэрлэхэд хэрхэн нөлөөлөхийг дүгнэн, усан доорх соёлын өвийг хамгаалах үйл ажиллагааг хуульчлах хэрэгцээ шаардлагыг бүрэн илэрхийлэх боломж бүрдсэн эсэхэд голлон анхаарч үнэлгээг гүйцэтгэв. Түүнчлэн, хуулийн төсөлд тусгасан заалт нь хуулийн зорилгыг хангах боломжтой байна уу гэдгийг үнэллээ. Эдгээр үнэлгээг хийхдээ холбогдох судалгааны баримт бичиг болон үзэл баримтлалтай танилцаж, хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлага, хуулийн төслийн зорилго болон зорилгод хүрэхэд чиглэгдсэн, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ, зохицуулалтыг сонгож авсан.

“Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөр зохицуулсан харилцаанд оролцогч талууд хуулийн төсөлд заасан нэр томъёог ижил утгаар хэрэглэх боломжтой эсэхийг нягтлах, хуулийн төсөл логик дарааллын дагуу боловсруулагдсан эсэхийг тандах, Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг тодорхойлох байдлаар үнэлгээг хийхээр сонголоо.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн хүрээнд хамрагдах төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллөөс хуулийн төсөлд туссан зохицуулалтыг хүлээн зөвшөөрөх эсэхийг дүгнэх зорилгоор сонгож авсан.

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн заалт Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний тухай хууль, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон Монгол улсын Олон улсын гэрээ, холбогдох бусад хууль тогтоомжтой нийцсэн эсэхийг Аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээг хийхээр тооцон сонголоо.

Хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлын тооцоог тусгайлан хийсэн тул цаг хугацаа, нөөцийн хэмнэлт хийх үүднээс “зардал тооцох” шалгуур үзүүлэлтийг сонгоогүй болно.

### ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар авч үзэв.

| № | Шалгуур үзүүлэлт           | Үр нөлөөг үнэлэх хэсэг  | Тохирох шалгах хэрэгсэл   |
|---|----------------------------|---|---|
| 1 | Зорилгод хүрэх байдал      | Хуулийн төслийн холбогдох зохицуулалт   | Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангасан эсэхэд дүн шинжилгээ хийх.   |
| 2 | Практикт хэрэгжих боломж   | Хуулийн төслийн холбогдох зохицуулалт   | Одоо байгаа нөөц боломжийн хүрээнд хуулийг хэрэгжүүлэх боломжтой эсэхийг тогтоох. Улмаар уг зохицуулалтын талаарх бусад орны эрх зүйн зохицуулалт, туршлагыг судлах, Үүнд: Усан доорх соёлын өвийг хамгаалж буй сайн туршлага, хадгалж хамгаалахад үүсдэг нийтлэг бэрхшээл, түүнээс урьдчилан сэргийлэх, арга механизм зэргийг харьцуулж, цаашид Монгол Улсад хэрэгжүүлэх боломжийг судлах, холбогдох байгууллагуудын статистик мэдээ, хуулийн төсөлд ирүүлсэн саналуудад дүн шинжилгээ хийх. |
| 3 | Ойлгомжтой байдал          | Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах                             | Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйл, Хуульд тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.  |
| 4 | Хүлээн зөвшөөрөгдөх байдал | Хуулийн төслөөр дэмжлэг авах этгээд болон дэмжлэг үзүүлэх этгээдийг хамруулах | Практик нөхцөл байдалд эрх ашиг нь хөндөгдөх этгээдийг тодорхойлж, аль эрх ашгийг хэрхэн хөндөх асуудлыг тодорхойлох.   |
| 5 | Харилцан уялдаа            | Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах                             | Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10-т болон Аргачлалын 4.10-т заасан  |

|  |  |  |
|--|--|--|
|  |  | шаардлага, шаардлагыг хангасан эсэхийг шалгах. |
|--|--|--|

| № | Шалгуур үзүүлэлт      | Үр нөлөөг үнэлэх хэсэг  | Тохирох шалгах хэрэгсэл   |
|---|-----------------------|---|---|
| 1 | Зорилгод хүрэх байдал | <p>Монгол Улсын Үндсэн хуулийн Долоодугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна.” гэж</p>  | <p>Монголын ард түмний түүх, соёлд хамаарах усан доорх соёлын өв, үнэт зүйлийг хамгаалах, үүсэж болох аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх эрх зүйн зохицуулалт хангагдана.</p>   |
|   |                       | <p>Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 1.1.6-д “Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх нь монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа мөн.” гэж, мөн</p>   | <p>Монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа болсон соёлын өв – усан доорх соёлын өвийг хадгалж, хамгаалах, бүртгэн баримтжуулах, судлах эрх зүйн зохицуулалтыг хангах</p>   |
|   |                       | <p>2011 оны 10 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал”-ын 25.1-д “Боловсрол, соёл, урлаг, спорт, олон нийт, мэдээллийн олон улсын байгууллагатай идэвхтэй харилцах, шаардлагатай гэрээнд нэгдэн орох, ижил төрлийн байгууллагуудын хооронд шууд харилцаа, солилцоо хөгжүүлэх, соёл, урлаг, спортын олон улсын арга хэмжээнд оролцох, ийм төрлийн арга хэмжээг эх</p> | <p>“Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай” ЮНЕСКО-ийн конвенцод нэгдэн орсноор олон улсын байгууллагатай идэвхтэй харилцах, шаардлагатай гэрээнд нэгдэн орох, ижил төрлийн байгууллагуудын хооронд шууд харилцаа, солилцоо хөгжүүлэх боломжтой болно.</p> |

|   |                          |   |   |
|---|--------------------------|---|---|
|   |                          | орондоо зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх," гэж,   |   |
|   |                          | 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 1.1.9-д "Монгол Улсад түүх, соёлын өвийг сүйтгэгчидтэй хийх тэмцлийг орон даяар өрнүүлж, хууль сахиулах тусгай чиг үүрэгтэй байгууллагуудын хариуцлагыг нэмэгдүүлнэ" гэж заасан. | "Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай" ЮНЕСКО-ийн конвенцод нэгдэн орсноор дотоодын ус болон гадаад далай, тэнгис дэх Монголын түүхэнд хамаарах соёлын өвийг сурвалжлан олох, бүртгэх, судлах, хадгалж хамгаалах, сурталчлан таниулах чиглэлээр бусад улс оронтой идэвхтэй хамтран ажиллах, туршлага судлах, усан доорх соёлын өвийг хамгаалах чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх боломж бүрдэнэ.  |
| 2 | Практикт хэрэгжих боломж | Хуулийн төслийн холбогдох зохицуулалт   | Одоо байгаа нөөц боломжийн хүрээнд хуулийг хэрэгжүүлэх боломжтой эсэхийг тогтоох. Улмаар уг зохицуулалтын талаарх бусад орны эрх зүйн зохицуулалт, туршлагыг судлах, Үүнд: Усан доорх соёлын өвийг хамгаалж буй сайн туршлага, хадгалж хамгаалахад үүсдэг нийтлэг бэрхшээл, түүнээс урьдчилан сэргийлэх, арга механизм зэргийг харьцуулж, цаашид Монгол Улсад хэрэгжүүлэх боломжийг судлах, холбогдох байгууллагуудын статистик мэдээ, хуулийн төсөлд ирүүлсэн саналуудад дүн шинжилгээ хийх. |
| 3 | Ойлгомжтой байдал        | Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах   | Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйл, Хуульд тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд   |

|   |                            |   |   |
|---|----------------------------|---|---|
|   |                            |   | заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.  |
| 4 | Хүлээн зөвшөөрөгдөх байдал | Хуулийн төслөөр дэмжлэг авах этгээд болон дэмжлэг үзүүлэх этгээдийг хамруулах | Практик нөхцөл байдалд эрх ашиг нь хөндөгдөх этгээдийг тодорхойлж, аль эрх ашгийг хэрхэн хөндөх асуудлыг тодорхойлох.                                     |
| 5 | Харилцан уялдаа            | Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах                             | Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10-т болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шаардлагыг хангасан эсэхийг шалгах. |

Аргачлалд заасны дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлт, үр нөлөөг үнэлэх хэсгийг тус тус тогтоож, тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар тодорхойллоо:

| №   | Шалгуур үзүүлэлт           | Үр нөлөөг үнэлэх хэсэг | Тохирох шалгах хэрэгсэл   |
|-----|----------------------------|------------------------|---|
| 4.1 | Зорилгод хүрэх байдал      | Хуулийн төсөл бүхэлдээ | <b>Зорилгод дүн шинжилгээ хийх:</b><br>Хуулийн төслийн зохицуулалт нь төслийн үзэл баримтлалд дурдсан зорилгод нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийнэ.  |
| 4.2 | Ойлгомжтой байдал          | Хуулийн төсөл бүхэлдээ | <b>Ойлгомжтой байдлыг шалгах:</b><br>Хуулийн төслийн зохицуулалт ойлгомжтой, логик дараалалтай, хэл зүйн талаасаа зөв томъёологдсон эсэхийг Аргачлалын асуултад хариулах хэлбэрээр судална. |
| 4.3 | Хүлээн зөвшөөрөгдөх байдал | Хуулийн төсөл бүхэлдээ | <b>Хүлээн зөвшөөрөгдөх байдлыг шалгах:</b><br>Хуулийн төсөлд туссан зохицуулалт үйлчлэх хүрээний оролцогсдын хүсэлтэд нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийнэ.                                   |
| 4.4 | Харилцан уялдаа            | Хуулийн төсөл бүхэлдээ | <b>Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах:</b><br>Хуулийн төслийн уялдааг хууль тогтоомжийн төсөл боловсруулах   |

|  |  |  |  |
|--|--|--|--|
|  |  |  | аргачлалын хүрээнд судалж, хоорондын уялдаа холбоог аргачлалд заасан асуултад хариулах байдлаар шалгана. |
|--|--|--|--|

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

## ДӨРӨВ. УРЬДЧИЛСАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

### 4.1.Шалгуур үзүүлэлт: Зорилгод хүрэх байдал:

Шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь төслийн үзэл баримтлалд дурдсан зорилгод нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийнэ.

Хуулийн төсөл нь 1 зүйлтэй байх бөгөөд тус зүйлд “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай” ЮНЕСКО-ийн конвенцыг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлах тухай заасан байна.

Хуулийн үзэл баримтлалд “Монгол Улсын Үндсэн хуулийн Долдугаар зүйлийн долоогийн нэг дэх хэсэгт “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэж, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 1.1.6-д “Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж, хөгжүүлэх нь Монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа мөн” гэж, мөн 2011 оны 10 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал”-ын 25.1-д “Боловсрол, соёл, урлаг, спорт, олон нийт мэдээллийн олон улсын байгууллагатай идэвхтэй харилцах, шаардлагатай гэрээнд нэгдэн орох, ижил төрлийн байгууллагуудын хооронд шууд харилцаа, солилцоо хөгжүүлэх, соёл, урлаг, спортын олон улсын арга хэмжээнд оролцох, ийм төрлийн арга хэмжээг эх орондоо зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх” гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 1.1.9-д “Монгол Улсад түүх, соёлын өвийг сүйтгэгчидтэй хийх тэмцлийг орон даяар өрнүүлж, хууль сахиулах болон тусгай чиг үүрэгтэй байгууллагуудын хариуцлагыг нэмэгдүүлнэ” гэж... тус тус заасан”,

“Нэгдсэн Үндэстний байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО) -ийн “Усан доорх соёлын өвийг хамгаалах” конвенцын механизмын хүрээнд усан доорх соёлын өвийг хамгаалах, оролцогч талуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, усан доорх соёлын өвийг судлах, малтах, хамгаалахад шинжлэх ухааны тусгай арга зүй, техник технологийг ашиглах, хөгжүүлэх”,

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 1.13.117-д “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцыг соёрхон батлах”-аар заасан.

“Хуулийн төсөл нь 1 зүйлтэй байх бөгөөд тус зүйлд “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай” ЮНЕСКО-гийн конвенцыг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлах тухай заана”.

“Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай” ЮНЕСКО-ийн конвенцыг соёрхон баталснаар дотоодын ус болон гадаад, далай тэнгисийн усан доор хадгалагдаж буй Монголын түүхэнд хамаарах соёлын өвийг олж тогтоох, бүртгэх, судлах, хадгалж, хамгаалах, сэргээн засварлах, сурталчлан таниулах болон олон улсын эрх зүйн хүрээнд усан доорх соёлын өвийг хамгаалах эрх зүйн орчин бүрдэх юм”,

“Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай” ЮНЕСКО-ийн конвенцыг соёрхон батлах тухай хуулийг баталснаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн хүрээнд сөрөг үр дагавар гарахгүй” гэжээ.

Хуулийн төслийн зохицуулалтыг нэгтгэн дүгнэвэл, хуулийн төслийн хэрэгцээ шаардлагад үндэслэн зорилгод хүрэх боломжтой байна.

#### 4.2.Шалгуур үзүүлэлт: Ойлгомжтой байдал

Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавигдах нийтлэг шаардлага, хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавигдах нийтлэг шаардлагыг хангасан эсэхийг аргачлалд заасан асуултад хариулах байдлаар шалгалаа.

“Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай” ЮНЕСКО-ийн конвенцыг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлах тухай заасан 1 зүйлтэй хуулийн төсөл нь улдаа холбоотой ойлгомжтой болсон байна.

|  |  |
|--|--|
| Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан<br>Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага                          |  |
| Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт  | Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал  |
| 29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх; | Үндсэн хуульд заасан суурь зарчмуудтай зөрчилдөхгүй ба хуулийн 7 дугаар зүйлийн 1-т заасныг хангахад чухал үүрэг гүйцэтгэхэд чиглэсэн байна. |

|   |                            |
|---|----------------------------|
| 29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;   | Шаардлагыг хангасан байна. |
| 29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;   | Шаардлагыг хангасан байна. |
| 29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;   | Шаардлагыг хангасан байна. |
| 29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;  | Шаардлагыг хангасан байна. |
| 29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;   | Шаардлагыг хангасан байна. |
| 29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;   | Шаардлагыг хангасан байна. |
| 29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;        | Шаардлагыг хангасан байна. |
| 29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт; | Байхгүй                    |
| 29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;  | Шаардлагагүй               |
| 29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний  | Шаардлагыг хангасан байна. |

|  |                            |
|--|----------------------------|
| үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.  |                            |
| 30 дугаар зүйл.Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага   |                            |
| 30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;                                    | Шаардлагыг хангасан байна. |
| 30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;  | Шаардлагыг хангасан байна. |
| 30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих; | Шаардлагыг хангасан байна. |
| 30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;   | Шаардлагыг хангасан байна. |
| 30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.   | Шаардлагыг хангасан байна. |

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан зарчимтай зөрчилдөөгүй, түүнийг хангахад чиглэсэн байх бөгөөд бусад хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа хууль тогтоомжтой зөрчилдөөгүй, хуульд заасан шаардлагыг бүрэн хангасан байх ба Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын дагуу хуулийн төслийг боловсруулсан байна.

#### 4.3.Шалгуур үзүүлэлт: Хүлээн зөвшөөрөгдөх байдал

Хуулийн төсөлд туссан зохицуулалт үйлчлэх хүрээний оролцогсдын хүсэлтэд нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийнэ.

Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Гадаад харилцааны яам, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны газар хамтран 2019 онд зохион байгуулсан “Соёлын үнэт зүйлсийн хууль бус экспорт, импорт, өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх тухай бүс нутгийн сургалт”-ын сургагч багш нар (Итали Улсын Ром хот дахь Бритинаийн их сургуулийн профессор Петер Кэмпбэлл, Грек Улсын усан доорх соёлын өвийн археологич Орфиас Сотиреоу) Монгол Улсыг “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай” ЮНЕСКО-ийн конвенцод богино хугацаанд цаг алдалгүй нэгдэн орохыг зөвлөжээ.

Мөн НҮБ-аас 2014 онд баталсан соёлын үнэт зүйлийн худалдаа болон бусад холбогдох гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх олон улсын удирдамжид гишүүн орнуудыг 1970 оны ЮНЕСКО-гийн болон 1995 оны ЮНИДРУА-гийн конвенц, Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай ЮНЕСКО-ийн 2001 оны конвенц болон бусад холбогдох олон улсын олон талт гэрээг соёрхон баталж, хэрэгжүүлэх шаардлагатайг дурджээ.

Монгол Улсын нутаг дэвсгэр дээрх эртний тахилгатай томоохон нуур, гол мөрний ёроолд уламжлалт зан үйлийн дагуу өргөсөн алт, мөнгөн аяга, тагш, мөнгөн ембүү,

мөнгөн аягыг төлөөлүүлж өргөсөн бүслүүр, амсар, ёроол зэрэг зүйлс хадгалагдан үлдсэн тохиолдолд элбэг бий. Тухайлбал, Орхон голд “Түшээ гүн” цол олгож, жил бүр 25 лангийн мөнгөн ембүү өргөн тахидаг уламжлал байсан бол, Отгонтэнгэр хайрханы Бадархундага нуурт мөнгөн аягаар өргөл өргөдөг уламжлал өнөө ч хадгалагдсаар байна. Эдгээр нь түүхэн тодорхой цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж, түүх, соёл, шинжлэх ухаан, танин мэдэхүйн үнэ цэнэ, ач холбогдолтой байдаг нь зарим талаар соёлын өвийн хэв шинжийг агуулдаг бөгөөд цаг улирах тусам үнэ цэнэ нь улам бүр өсөн нэмэгдэж, угсаатны бүлэг, хамт олны зан үйлийн уламжлалыг биетээр гэрчлэн үлддэг байна.

Монгол Улс усан доор хадгалагдан үлдсэн дээрх үнэт зүйлсийг эрх зүйн хүрээнд томьёолж, хадгалж хамгаалах харилцааг нарийвчлан зохицуулж байсан туршлага байхгүй, бүртгэл судалгаагүй, усан доор ажиллах хүний нөөц бэлтгэгдээгүй дэд бүтэц, техник технологийн орчин, нөхцөл дутмаг зэрэг олон шалтгааны улмаас усан доорх соёлын өв, үнэт зүйл эрсдэлд орох тохиолдол гарсаар байна. Энэ нөхцөл байдал Монголчуудын бүтээн туурвисан соёлын биет болон биет бус өвийн харилцан шүтэлцээтэй үнэт зүйлийн илэрхийллийг цогцоор нь хамгаалах боломж хомс байгааг илтгэдэг.

2018 онд Завхан аймгийн Отгон сумын нутаг, Отгонтэнгэр хайрхны бэлд орших Бадархундага нуурт хэсэг этгээд шумбалт хийж, иргэдийн өргөсөн том жижиг мөнгөн аяга, мөнгөн аяганы бүрдэл хэсэг болох бүслүүр, ёроол зэрэг нийт 366 ширхэг эд зүйлийг хулгайлсныг цагдаагийн байгууллага илрүүлэн, эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан. Уг хэргийг шүүхийн шатанд шийдвэрлэхдээ 366 ширхэг эд зүйлийг Завхан аймгийн Улиастай сумын Засаг даргын Тамгын газарт шилжүүлжээ. Тус сумын Тамгын газар аяганы мөнгийг тагшнаас салган авч, нийт 6,825 гр болгоод нэг ланг 35,000 төгрөгөөр тооцон худалдаж 6,370,000.0 төгрөг болсныг автомашины сэлбэг зэрэг зүйлд зарцуулсан байна. Хэргийн үйл явцад эрх зүйн зохицуулалт байхгүйн улмаас соёлын өвийн мэргэжилтнийг аль ч шатанд оролцуулаагүй байна.

Монгол орны томоохон нуур, гол мөрний усан доор өмнө дурдсан уламжлалын дагуу өргөсөн мөнгөн аяга, живсэн усан завь зэрэг үнэт зүйлс цөөнгүй хадгалагдаж байдаг. Эдгээр нь бүгд эзгүй эзлүүд газар, эсхүл хүний хараа хяналтаас хол далд газарт, гүехэн усанд оршин байдаг нь хялбар аргаар ашиг хонжоо хайгчдад далим болж, шунахайн сэдлээр тонон дээрэмдэх нөхцөлийг бүрдүүлж байна. Энэ нь Монголын ард түмний оюун санааны болон эдийн соёлын үнэт зүйлийн өвөрмөц өвийн нэг болох нуур, усаа эрхэмлэн шүтэх уламжлалт зан үйл оршин тогтнох чадвараа алдаж мартагдах, цаашлаад устаж болзошгүй байна. Дээрх жишээ баримт нь усан доорх соёлын өвийг хамгаалах эрх зүйн тогтолцоог нэн даруй бүрдүүлж, олон улсын жишгийн дагуу үнэт зүйлсийг бүртгэн баримтжуулах, судлан шинжлэх, хадгалж хамгаалах, сурталчлан таниулах, зохистой хэлбэрээр ашиглах асуудлыг хуулийн хүрээнд журамлах шаардлагатай байгааг харуулж байна.

Монгол Улсын дотоодын усанд байх соёлын өвд тулгарсан бодит нөхцөл байдал болон салбарын мэргэжилтэн, байгууллагын дунд явуулсан сургалт хэлэлцүүлгийн зөвлөмж, шийдвэрийг нэгтгэн дүгнэвэл конвенцын соёрхон батлах хэрэгцээ шаардлага тулгараад байгаа нь харагдаж байна.

#### 4.4.Шалгуур үзүүлэлт: Хуулийн төслийн уялдаа холбоо

Хуулийн төслийн уялдааг хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын хүрээнд судалж, хоорондын уялдаа холбоог аргачлалд заасан асуултад хариулах байдлаар шалгана.

| № | Асуулт  | Хариулт буюу дүн шинжилгээ   |
|---|---|--|
| 1 | Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;  | Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн зорилтод нийцэж байна.  |
| 2 | Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;       |  |
| 3 | Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх; | Хуулийн төсөлд заасан нэр томъёо тухай хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа болно.  |
| 4 | Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;                   | Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байна.  |
| 5 | Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;                    | Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардаагүй.  |
| 6 | Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;   | Хуулийн төслийн Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай ЮНЕСКО-гийн конвенц Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлахаар тодорхой тусгасан. |
| 7 | Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;  | Орхигдуулсан агуулга байхгүй   |
| 8 | Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;                                | Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан зохицуулалт байхгүй байна.  |

|    |  |   |
|----|--|---|
| 9  | Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;   | Конвенцын хэрэгжилтийг хангах ажлыг хэрэгжилтийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоотой хамтран гүйцэтгүүлэх боломжтой байна. |
| 10 | Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;  | Албан татвар, төлбөр, хураамж тогтоосон зохицуулалт тусгагдаагүй байна.   |
| 11 | Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх; | Хуулийн төсөлд тусгай зөвшөөрлийн асуудал тусгагдаагүй байна.   |
| 12 | Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;                        | Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгагдаагүй байна.    |
| 13 | Хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;  | Хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдалд нөлөөлөх, холбогдох зохицуулалт агуулаагүй байна.                            |
| 14 | Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;   | Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй байна.   |
| 15 | Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;   | Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй байна.   |
| 16 | Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.                               | Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгагдаагүй болно.           |

Хуулийн төслийн зохицуулалт нь бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа ба Монгол Улсын Үндсэн хуультай зөрчилдөөгүй байна.

## ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

### 5.1.Баримтжуулалт

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхэд ашигласан дараах баримт бичиг, мэдээлэл, тоо баримтыг цуглуулан үр нөлөөг тооцох ажиллагааны тайланд баримтжуулж хавсаргалаа.

1.Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 1.13.117 дахь хэсэг,

2.“Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай” ЮНЕСКО-ийн конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийн үзэл баримтлал,

3. “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай” ЮНЕСКО-ийн конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл.

## 5.2.Үнэлэлт дүгнэлт

“Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай” ЮНЕСКО-ийн конвенцыг соёрхон баталснаар дотоодын ус болон гадаад далай тэнгис дэх Монголын түүхэнд холбогдох усан доорх соёлын өвийг хамгаалах чиглэлээр бусад улстай хамтран ажиллах, туршлага судлах, олон улсын эрх зүйн хүрээнд усан доорх соёлын өвийг хамгаалах эрх зүйн орчин бүрдэх юм.

Энэхүү үнэлгээний ажлын явцад улс орнуудын сайн туршлага бүхий хуультай харьцуулах, давхардал хийдлийг илрүүлэхээр хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид дүн шинжилгээ хийх зэрэг аргыг хэрэглэснээс гадна энэ асуудлын хүрээнд хамаарах төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөлттэй уулзалт зохион байгуулах, төрийн захиргааны төв байгууллагаас хийгдсэн судалгааг ашигласан болно.

----oOo----



**СОЁЛ, СПОРТ,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,  
ЗАЛУУЧУУДЫН ЯАМ**

**ЮНЕСКО-ИЙН 2001 ОНЫ “УСАН ДООРХ СОЁЛЫН ӨВИЙГ  
ХАМГААЛАХ ТУХАЙ КОНВЕНЦ”-ЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот  
2026 он

## ЮНЕСКО-ИЙН 2001 ОНЫ “УСАН ДООРХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ КОНВЕНЦ”-ЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

ЮНЕСКО-ийн 2001 оны Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцыг соёрхон батлах тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тооцож, тоймлон гаргалаа.

Уг аргачлалын 1.5 дахь хэсэгт заасан журмын дагуу төрийн байгууллагын зардал, хуулийн этгээд, иргэнд үүсэх зардал гэсэн гурван төрлөөр тооцов.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход доор дурдсан дараах нийтлэг зарчмыг баримталсан болно:

- гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;
- үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;
- бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;
- аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.

### НЭГ.КОНВЕНЦЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХАД ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮССЭН ЗАРДАЛ

Конвенцын хэрэгжилтийг үндэсний хэмжээнд хангахад төрийн байгууллагын хувьд дараах зардлыг тооцох шаардлагатай. Үүнд:

- 1.конвенцын хэрэгжилтийг хангах чиг үүрэгтэй албан хаагчийн орон тоог бий болгох;
- 2.усан доорх соёлын өвийг хамгаалахад хүний нөөцийг бэлтгэх;
- 3.монгол Улсын түүх, соёлд хамаарах усан доорх соёлын өв бүхий газар, усан доорх соёлын өвийн судалгаа мэдээллийн сан бүрдүүлэх.

**1.1.Конвенцын хэрэгжилтийг хангах чиг үүрэгтэй албан хаагчийн орон тоог бий болгох.** Монгол Улсын Үндсэн хуулийн Долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна.” гэж, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 1.1.6-д “Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж, хөгжүүлэх нь Монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа мөн” гэж, мөн 2011 оны 10 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал”-ын 25.4-д “Боловсрол, соёл, урлаг, спорт, олон нийт мэдээллийн олон улсын байгууллагатай

идэвхтэй харилцах, шаардлагатай гэрээнд нэгдэн орох, ижил төрлийн байгууллагуудын хооронд шууд харилцаа, солилцоо хөгжүүлэх, соёл, урлаг, спортын олон улсын арга хэмжээнд оролцох, ийм төрлийн арга хэмжээг эх орондоо зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх” гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 1.1.9-д “Монгол Улсад түүх, соёлын өвийг сүйтгэгчидтэй хийх тэмцлийг орон даяар өрнүүлж, хууль сахиулах болон тусгай чиг үүрэгтэй байгууллагуудын хариуцлагыг нэмэгдүүлнэ” гэж тус тус заасан.

Олон улсад соёлын өвийг оршин тогтнох хэлбэрээр нь соёлын биет болон биет бус өв гэж ангилдаг, биет өв нь дотроо үл хөдлөх болон хөдлөх гэж ангилагддаг. Энэ ангилал нь олон улсын гэрээ хэлэлцээрт заасан, томъёоллын дагуу ангилж авч үзсэн нийтийн ойлголт юм. Монгол Улс дээрх ангиллын дагуу Соёлын өвийг хамгаалах тухай хуулийг баталсан байдаг. Усан доорх соёлын өв нь дээрх ангиллын биет өвийн хэв шинжийг агуулдаг, дэлхийн ихэнх улс орнууд энэ ангиллын дагуу хадгалж хамгаалах үйл ажиллагааг зохион явуулдаг.

Манай улсын хувьд усан доорх соёлын өв нь биет болон биет бус хэв шинжийг давхар агуулдаг өвөрмөц онцлог ажиглагддаг. Тухайлбал, нуур ус шүтэх зан үйлтэй холбогдсон соёлын биет бус өвийн илэрхийлэл манай улсын аль ч хэсэгт уламжлагдан үлдсэн байдаг.

Усан доорх соёлын өвийг хамгаалах конвенцын хэрэгжилтийг үндэсний хэмжээнд хангахад дараах төрийн болон орон нутгийн байгууллагын чиг үүрэгт нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага үүсэхээр байна. Үүнд:

1. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан Засгийн газрын бүтцэд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам ажиллахаар хуульчилсан. Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 07 дугаар тогтоолоор баталсан Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны бүтцэд Соёл, урлагийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт Соёлын өвийн хэлтэстэй байхаар шийдвэрлэсэн. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 121 дүгээр тушаалаар баталсан “Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны албан тушаалын нэршил”-д Соёлын өвийн нэгж нь дарга, шинжээч, 3 ахлах мэргэжилтэн, 2 мэргэжилтэнтэй байхаар тогтоосон. Цаашид конвенцын хэрэгжилтийг үндэсний хэмжээнд хангахтай холбоотой бодлого, зохицуулалтын чиг үүргийг Соёлын өвийн хэлтэс хариуцаж ажиллах бөгөөд конвенцод нэгдэн орсноор тус нэгжид нэмэлт орон тоо, цалингийн сан шаардахгүй, 3 ахлах мэргэжилтний ажлын чиг үүрэгт нэмэлт оруулах замаар зохицуулалт хийх боломжтой

байна. Харин усан доорх соёлын өвийг хамгаалахтай холбоотой чиг үүргийг гүйцэтгэж байгаа албан хаагчийн чадавхыг бэхжүүлэх, туршлага судлах, конвенцын хүрээний хурал, чуулганд оролцох чиглэлээр жилд 1 удаа гадаад томилолтын зардал гарах шаардлага үүсэхээр байна.

2.Монгол Улсын Их Хурлын 2024 оны 13 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-д Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар ажиллахаар шийдвэрлэсэн. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны А/412 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц”-д Соёлын өвийн бодлогын хэргэжилтийг зохицуулах хэлтэстэй байхаар шийдвэрлэсэн. Тус нэгж нь дарга, шинжээч, 2 мэргэжилтэнтэй ажиллахаар орон тоог тогтоосон бөгөөд конвенцод нэгдэн орсноор тус нэгжид нэмэлт орон тоо, цалингийн сан шаардахгүй, соёлын биет болон биет бус өвийн асуудал хариуцсан 2 мэргэжилтний чиг үүрэгт нэмэлт өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх боломжтой байна. Харин усан доорх соёлын өвийг хамгаалахтай холбоотой чиг үүргийг гүйцэтгэж байгаа албан хаагчийн чадавхыг бэхжүүлэх, туршлага судлах, конвенцын хүрээний бүсчилсэн техникийн уулзалт, зөвлөгөөнд оролцох чиглэлээр жилд 1 удаа гадаад томилолтын зардал гарах шаардлага үүсэхээр байна.

3.Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 239 дүгээр тогтоолоор Соёлын өвийн төвийн барилга байгууламж, эд хөрөнгө, тоног төхөөрөмжид түшиглэн соёлын өвийг бүртгэн мэдээлэх, авран хамгаалах чиг үүрэг бүхий Соёлын өвийн үндэсний төв болгон өргөжүүлж байгуулсан. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/2 дугаар тушаалаар тус төвийн бүтэц, дүрмийг шинэчлэн баталсан. Энэ шийдвэрийн дагуу Соёлын өвийн үндэсний төвийн захирлын 2026 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн А/5 дугаар тушаалаар байгууллагын бүтцийн нэгжийн орон тоо, албан тушаалыг шинэчлэн баталсан. Соёлын өвийн үндэсний төв усан доорх соёлын өвийг хамгаалах үйл ажиллагааны гол чиглэл болох бүртгэн баримтжуулах, судлан шинжлэх, хадгалах үйл ажиллагааг үндэсний хэмжээнд хариуцан гүйцэтгэх ба цаашид энэ чиглэлээр олон улсын байгууллагатай хамтран ажиллах түшиц байгууллага юм. Тус төвийн бүртгэл, мэдээлэл, авран хамгаалах, сэргээн засварлах технологи судалгааны газрын чиг үүрэгт усан доорх соёлын өвийг хамгаалах чиг үүргийг тусгаж хэрэгжүүлнэ. Тус төвийн хадгалалт хамгаалалт, технологи судалгааны газар болон авран хамгаалах, эрсдэлийн судалгааны газарт усан доорх соёлын өвийн чиглэлээр 2 шинжээч, мэргэжилтний орон тоог нэмэх шаардлага үүснэ. Тус 2 шинжээч, мэргэжилтэн нь усан доорх соёлын өвийг эрэн сурвалжлах, тодорхойлох, хадгалж хамгаалах арга зүй боловсруулах, авран хамгаалах, эвдрэл гэмтлийн судалгаа хийх, эрдэм шинжилгээний болон сурталчилгааны ном бүтээл бичиж нийтлүүлэх, гэмт хэрэг, зөрчилд шинжээчийн

түвшинд ажиллах зэрэг чиг үүргийг гүйцэтгэнэ. Шинээр нэмэх шаардлагатай 2 шинжээч, мэргэжилтэн нь жилд 1 удаа гадаад улсад туршлага судлах, конвенцын хүрээний бүсчилсэн техникийн уулзалт, зөвлөгөөнд оролцох чиглэлээр томилолтоор ажиллах шаардлага үүсэхээр байна.

Соёлын өвийн үндэсний төвийн хадгалалт хамгаалалт, технологи судалгааны газар болон авран хамгаалах, эрсдэлийн судалгааны газарт усан доорх соёлын өвийг хамгаалах чиг үүргийг гүйцэтгэх 2 шинжээч, мэргэжилтэн Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралтаар баталсан “Соёл, урлаг, биеийн тамир, спортын салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээ”-ний ТҮСБ-6 шатлалд хамаарах бөгөөд 1 сард ногдох цалин, хөлс, урамшуулалд зарцуулах зардлын хэмжээг дараах хүснэгтэд үзүүлэв:

| Д/д  | Албан тушаал   | Гүйцэтгэх чиг үүрэг   | Цалин хөлс, урамшуулал<br>(1 сараар)  |
|--|--|---|---|
| 1  | Усан доорх соёлын өвийн хадгалалт хамгаалалт, технологи судалгаа хариуцсан шинжээч/мэргэжилтэн | <ul style="list-style-type: none"> <li>- усан доорх соёлын өвийг бүртгэх, тодорхойлох;</li> <li>- хадгалалт хамгаалалтын арга зүй боловсруулах, турших;</li> <li>- хадгалалт хамгаалалтын байдалд хяналт тавих;</li> <li>- хамтарсан судалгаанд оролцох.</li> </ul> | Үндсэн цалин:<br>ТҮСБ-6 <b>1,718,000.00</b><br><br>Нэмэгдэл цалин:<br>Ур чадвар <b>343,600.00</b><br><i>/үндсэн цалингийн 20 %-иар тооцов/</i><br><br>Ажилласан жил <b>171,800.00</b><br><i>/10 жилийн туршлагатай байхаар тооцов/</i><br><br><b>Бүгд 2,233,400.00</b><br><b>1 жилд 26,800,800.00</b> |
| 2  | Усан доорх соёлын өвийг авран хамгаалах, эрсдэлийн судалгаа хариуцсан шинжээч/мэргэжилтэн      | <ul style="list-style-type: none"> <li>- усан доорх соёлын өвийн төлөв байдалд үнэлгээ хийх, зөвлөмж боловсруулах;</li> <li>- эрсдэл учирсан усан доорх соёлын өвийг авран хамгаалах;</li> <li>- шинжээчийн дүгнэлт гаргах;</li> <li>- судалгаа хийх.</li> </ul>    | Үндсэн цалин:<br>ТҮСБ-6 <b>1,718,000.00</b><br><br>Нэмэгдэл цалин:<br>Ур чадвар <b>343,600.00</b><br><i>/үндсэн цалингийн 20 %-иар тооцов/</i><br><br>Ажилласан жил <b>171,800.00</b><br><i>/10 жилийн туршлагатай байхаар тооцов/</i><br><br><b>Бүгд 2,233,400.00</b><br><b>1 жилд 26,800,800.00</b> |
| <b>Нийт /1 жилд/</b>   |  |   | <b>53,601,000.00</b>  |
| Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.4-д заасны дагуу докторын, мэргэжлийн зэрэг, цолны нэмэгдэл журам ёсоор нэмэгдэх боломжтой байна. |  |   |   |

4.Соёлын тухай хуулийн 25 дугаар зүйлд аймаг, нийслэлд соёлын газар ажиллахаар туссан. Засгийн газрын 2025 оны 37 дугаар тогтоолоор “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаар”-т Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар ажиллахаар

баталсан. Энэ газар нь соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын салбарын хууль тогтоомж, бодлого, стратегийг хэрэгжүүлэх, орон нутгийн засаг захиргааны бодлогыг хэрэгжүүлэх үүрэг хариуцлагыг хүлээж, хариуцсан чиг үүргийн дагуу иргэд, олон нийтэд шуурхай, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх үндсэн үүрэгтэй.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/435 дугаар тушаалаар “Аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц”-ийг баталсан. Энэ шийдвэр ёсоор аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газарт Түүх, соёлын өвийн асуудал хариуцсан мэргэжилтэн ажиллахаар заасан. Конвенцод нэгдэн орсноор тус газарт орон тоо, цалингийн сан нэмэхгүй соёлын өвийн асуудал хариуцсан мэргэжилтний чиг үүрэгт нэмэлт өөрчлөлт оруулах замаар усан доорх соёлын өвийн хадгалалт хамгаалалтын байдалд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэх боломжтой байна. Харин усан доорх соёлын өвийг хамгаалахтай холбоотой чиг үүргийг гүйцэтгэж байгаа албан хаагчийн мэдлэг, ур чадварыг бэхжүүлэх чиглэлээр жилд 1 удаа үндэсний хэмжээнд сургалтад хамрагдахад дотоод томилолтын зардал гарах шаардлага үүсэхээр байна.

**1.2.Усан доорх соёлын өвийг хамгаалахад хүний нөөцийг бэлтгэх.** Усан доорх соёлын өвийг хамгаалах үндэсний чадавхыг оролцогч талуудын дунд үндэсний болон олон улсын хэмжээнд 2 хэлбэрээр сургалт зохион байгуулах замаар бэхжүүлэх боломжтой гэж тооцов. Үндэсний хэмжээний сургалтыг конвенцын Нарийн бичгийн дарга нарын газар болон бусад туршлагатай байгууллагын оролцоо дэмжлэгтэйгээр зохион байгуулах бөгөөд конвенцыг соёрхон баталсан эхний 2 жилд хийхээр тооцлоо. Сургалтад дараах зардал шаардлагатай.

| Д/д | Зардлын утга                            | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ     | Тайлбар   |
|-----|---|------------|----------------|--------------|---|
| 1   | Сургалтын гарын авлага                  | 40 ш       | 5,000.00       | 200,000.00   | Конвенцын Нарийн бичгийн дарга нарын газраас бэлтгэсэн гарын авлагыг орчуулж, хэвлэхээр тооцсон.                                |
| 2   | Сургалтын заал танхимын түрээс          | 12 цаг     | 200,000.00     | 2,400,000.00 | Гадаад багш нар цахим хэлбэрээр сургалтад оролцох тул орчуулгын болон бусад тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг харгалзаж тооцсон. |
| 3   | Орчуулагчийн хөлс                       | 12 цаг     | 340,000.00     | 4,080,000.00 | Синхрон орчуулгын цагийн дундаж үнэлгээгээр тооцов.   |
| 4   | Синхрон орчуулгын төхөөрөмжийн түрээс   | 40 ш       | 50,000.00      | 2,000,000.00 | Синхрон орчуулгын микрофон, дамжуулагч, хүлээн авагч төхөөрөмжийн дундаж ханшаар тооцов.  |
| 5   | Сургалтад оролцогчдын томилолтын зардал | 21*2       | 200,000.00     | 8,400,000.00 | Сургалтыг Улаанбаатар хотод 2 өдөр зохион байгуулахаар төлөвлөж,  |

|   |                                    |          |             |                      |  |
|---|------------------------------------|----------|-------------|----------------------|--|
|   |                                    |          |             |                      | байр, хоолны зардлыг Сангийн сайдын 2024 оны А/50 дугаар тушаалыг баримтлан тооцов.                                  |
| 6   | Сургалтад оролцогчдын замын зардал | 21*2     | 67,000.00   | 2,814,000.00         | Аймгийн төвөөс Улаанбаатар хүртэлх нийтийн тээврийн зардлын дунджаар 2 талд тооцов.                                  |
| 7   | Цай, кофены зардал                 | 40 ш * 3 | 25,000.00   | 3,000,000.00         | Зардлын энэ төрлийн үйлчилгээний дундаж ханшаар тооцов.  |
| 8   | Сургагч багшийн хөлс               | 3        | 3,400,00.00 | 10,200,000.00        | Конвенцын Нарийн бичгийн дарга нарын газар болон туршлагатай байгууллагын гадаад шинжээч нарыг оролцуулахаар тооцов. |
| <b>Нийт зардал</b>  |                                    |          |             | <b>33,094,000.00</b> |  |
| ЖИЧ: Сургалтыг зохион байгуулах зардлыг Усан доорх соёлын өвийг хамгаалах конвенцын сан болон ЮНЕСКО-ийн бусад санд хандаж, санхүүжүүгийн дэмжлэг авах чиглэлээр идэвхтэй ажиллаж, бүрдүүлэх боломжтой. 3563.74 |                                    |          |             |                      |  |

Усан доорх соёлын өвийг хамгаалах Конвенцын нарийн бичгийн дарга нарын газраас оролцогч талуудын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр бүсчилсэн болон төвлөрсөн сургалтын төлөвлөгөөг гаргаж, улс орнуудын мэргэжилтнүүдийг хамруулдаг. Зардлын тооцооны тайланд манай улсын харьяалдаг Ази-Номхон далайн бүсийн сургалтын төв /Тайландын Хаант Улсын Чантабүри хотод байрладаг/-д зохион байгуулагддаг сургалтад албан хаагчдыг оролцуулахад гарах зардлыг дараах байдлаар тооцов:

| Д/д   | Зардлын утга      |        | Тоо хэмжээ       | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ             | Тайлбар   |
|---|-------------------|--------|------------------|----------------|----------------------|---|
| 1   | Томилолтын зардал | Хоол   | 10 хоног * 5 хүн | 142,560.00     | 7,128,000.00         | Усан доорх соёлын өвийн Ази-Номхон далайн бүсийн сургалтын төв Тайландын Хаант Улсын Чантабүри хотод байрладаг. Уг төвийн төлөвлөгөөт сургалтад яам, агентлаг, СӨҮТ-ийн 5 албан хаагчийг хамруулахаар тооцов. Зардлыг Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаалыг баримтлан тооцов. |
| 2   |                   | Буудал | 10 хоног * 5 хүн | 3,564,000.00   | 17,820,000.00        |   |
| 3   | Хот доторх зардал | унааны | 10 хоног * 5 хүн | 356,400.00     | 1,782,000.00         |   |
| 3   | Онгоцны тасалбар  |        | 5 хүн            | 3,000,000.00   | 15,000,000.00        |   |
| <b>Нийт зардал</b>  |                   |        |                  |                | <b>41,730,000.00</b> | Зардлыг тооцоог 2026 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн Монголбанкны ханшаар тооцов.   |
| ЖИЧ: Сургалтын зардлыг Усан доорх соёлын өвийг хамгаалах конвенцын сан болон ЮНЕСКО-ийн бусад санд хандаж, санхүүжүүгийн дэмжлэг авах чиглэлээр идэвхтэй ажиллаж, бүрдүүлэх боломжтой байдаг. |                   |        |                  |                |                      |   |

Соёлын өвийн үндэсний төвийн мэргэжилтнүүд 2023 оноос Япон Улсын Мацуура хотын Такашима арал дээрх “Усан доорх археологийн судалгааны төв”-тэй хамтын ажиллагаа өрнүүлэх замаар далайн ёроол дахь Хубилай хааны цэргийн флотын судалгааны үр дүнтэй богино хугацаагаар танилцаж, туршлага судлад байна. Энэ төв цаашид манай улсын мэргэжилтнүүдийг сургаж, усан доорх соёлын өвийн чиглэлээр өөрийн материаллаг баазыг түшиглэн мэргэшүүлэх боломжтой талаар мэдэгдээд байна. Харин замын зардал гэх мэт зарим зардлыг манай улс хариуцах ёстойг сануулсан. Энэхүү боломжийг ашиглан бага зардал гаргаж, дотоодын мэргэжилтнүүдээ мэргэшүүлэх боломжтойг анхаарах нь зүйтэй.

### **1.3.Монгол Улсын түүх, соёлд хамаарах усан доорх соёлын өв бүхий газар, усан доорх соёлын өвийн судалгаа мэдээллийн сан бүрдүүлэх.**

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт “улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг Соёлын өвийн үндэсний төвд тус тус бүрдүүлж, хадгална” гэж, мөн зүйлийн 20.3-т “Соёлын өвийн үндэсний төв нь соёлын өвийг бүртгэх, судлах, хадгалах, сэргээн засварлах, авран хамгаалах, сурталчлах чиг үүрэг бүхий соёл, эрдэм шинжилгээний байгууллага байна” гэж заасан. Энэ хуулийн дагуу Соёлын өвийн үндэсний төв нь Монгол нутаг дахь соёлын биет болон биет бус өвийн бүртгэлийг бүрдүүлэх, хадгалах, мэдээлэх чиг үүргийг хариуцан гүйцэтгэдэг.

Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн системийн хөгжүүлэлтийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023-2024 онд шинэчилж, соёлын өвийн оршин тогтнох хэлбэрээр тус тусдаа программ хангамж ашиглаж байсныг нэгтгэн харилцан уялдаатай бүртгэл үйлдэх боломжийг бүрдүүлсэн. Усан доорх соёлын өвийн хамгаалах конвенцыг соёрхон батлах тохиолдолд Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн системд өргөтгөл хийж, усан доорх соёлын өвийг хадгалж байгаа газар болон түүнээс олж илрүүлсэн хөдлөх дурсгалт зүйлийг бүртгэх шаардлага үүснэ.

Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн системд усан доорх соёлын өв бүхий дурсгалт газрыг бүртгэх, олж илрүүлсэн хөдлөх дурсгалт зүйлийг бүртгэх бэлэн байдлыг хангаж, хөгжүүлэлт хийхэд 1 удаа 100,000,000.00 төгрөг шаардагдах тооцоог хийв. Зардлын задаргааг дараах хүснэгтээр харуулав.

| Д/д | Зардлын утга | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ | Тайлбар |
|-----|--------------|------------|----------------|----------|---------|
| 1   |              |            |                |          |         |
| 2   |              |            |                |          |         |
| 3   |              |            |                |          |         |
| 4   |              |            |                |          |         |

Конвенцыг соёрхон баталсны дараах 2-3 жилд үндэсний мэргэжилтнүүдийн чадавх сул, материаллаг бааз шаардлагын түвшинд хүрч бэхжээгүй байх тул Конвенцын нарийн бичгийн дарга нарын газрын санхүүгийн тусламжтайгаар усан

доорх соёлын өвийг эрэн сурвалжлах, олж тогтоох, тодорхойлох төсөл, арга хэмжээг практик-дадлага хэлбэрээр гүйцэтгэнэ. Цаашид /2029 оноос/ Соёлын өвийн үндэсний төвийн төсөвт усан доорх соёлын өвийг хамгаалах зардлыг тухайлан нэмж, зориулалтын дагуу зарцуулах шаардлага үүснэ. Зардлын задаргааг дараах байдлаар урьдчилан тооцов.

| Д/д                | Зардлын утга                                | Тоо хэмжээ            | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ             | Тайлбар  |  |
|--------------------|---|-----------------------|----------------|----------------------|--|--|
| 1                  | Автомашин түрээс                            | 15 хоног              | 200,000.00     | 3,000,000.00         | Орон нутагт дунджаар 15 хоног ажиллахаар тооцов.   |  |
| 2                  | Шатахуун тослох материал                    | 1500 км               | 2,590.00       | 854,000.00           | Туулах чадвар сайтай автомашинаар 100 км-т 22 л шатахуун зарцуулахаар тооцов.                    |  |
| 3                  | Ажилтны томилолтын зардал                   | 3 хүн * 15 хоног      | 90,000.00      | 4,050,000.00         | Сангийн сайдын 2024 оны А/52 дугаар тушаалаар баталсан зардлын хүрээнд суманд ажиллахаар тооцов. |  |
| 4                  | Усан доор ажиллах иж бүрэн хувцас, хэрэгсэл | 2 багц                | 12,000,000.00  | 24,000,000.00        | Хувцас, малгай, маск, гутал, цаг гэх мэт иж бүрдэлтэй байхаар тооцов.                            |  |
| 5                  | Баримтжуулалтын техник, тоног төхөөрөмж     | Гэрэл зургийн аппарат | 1              | 16,000,000.00        | 16,000,000.00  | Ус, чийгний хамгаалалттай их бие, дуран /линз/-ийн хамт тооцов.    |
| 6                  |   | Дрон                  | 1              | 10,000,000.00        | 10,000,000.00  | Усны мандаар хайгуул хийхэд ашиглах, чанартай дрон байхаар тооцов. |
| 7                  |   | Усны гэрэл            | 1              | 3,500,000.00         | 3,500,000.00   | Гүний усанд гэрэлтүүлгийн нэвчилт сайтай гэрэл байхаар тооцов.     |
| 8                  | Усан доор ажиллах хэмжилт, хэрэгсэл бичгийн | 1 багц                | 2,000,000.00   | 2,000,000.00         | Усанд ашиглах боломжтой харандаа, цаас, шугам, томруулдаг шил гэх мэт зүйлс байхаар тооцов.      |  |
| 9                  | Хийлдэг завь                                | 1                     | 18,000,000.00  | 18,000,000.00        | 3-4 хүн ажил гүйцэтгэх боломжтой, мотор бүхий завь байхаар тооцов.                               |  |
| <b>Нийт зардал</b> |   |                       |                | <b>81,404,000.00</b> |  |  |

## ХОЁР.КОНВЕНЦЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХАД ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮССЭН ЗАРДАЛ

Хуулийн төсөлтэй холбоотой иргэн хуулийн этгээдээс зардал гарахгүй.

**ГУРАВ.ХУУЛИЙГ СУРТАЛЧЛАХ, КОНВЕНЦЫН ТАЛААРХ МЭДЛЭГ ОЙЛГОЛТЫГ ДЭЭШЛЭХЭД ЧИГЛЭГДСЭН СУРТАЛЧИЛГААНЫ АЖИЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ**

Усан доорх соёлын өвийг хамгаалах конвенцыг олон нийтэд сурталчилж, ач холбогдлыг танин мэдүүлэх чиглэлээр эхний 2-3 жилд үе шаттайгаар дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр тооцсоныг хүснэгтээр харуулав.

| Д/д                | Зардлын утга   | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ              | Тайлбар   |
|--------------------|--|------------|----------------|-----------------------|---|
| 1                  | Контент бэлтгэж, түгээх  | 2 ш        | 15,000,000.00  | 30,000,000.00         | Гадаадын чанар сайтай бэлэн контент орчуулж түгээх, шинээр контент бүтээж түгээхээр тооцов.                                 |
| 2                  | Баримтат кино бүтээж, түгээх                                   | 1 км       | 80,000,000.00  | 80,000,000.00         | Монгол орны аль нэг гол нууранд хийх судалгааны ажлын талаар баримтат кино хийж түгээхээр тооцов.                           |
| 3                  | Усан доороос олж илрүүлсэн эд зүйлсээр тусгай үзэсгэлэн гаргах | 1          | 40,000,000.00  | 40,000,000.00         | Японы Такашима орчмын далайн ёроолоос гарсан эд зүйлсээр үзэсгэлэн гаргахаар тооцов.  |
| 4                  | Музейн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх                        | 1          | 8,000,000.00   | 8,000,000.00          | Музейн боловсролын хөтөлбөрөөр дамжуулан конвенцын үзэл санаа болон Монголчуудын уламжлалт зан үйлийг сурталчлахаар тооцов. |
| 5                  | Мэргэжлийн ангийн оюутнуудад лекц зохион байгуулах             | 1          | 3,000,000.00   | 3,000,000.00          | Түүх, археологи, соёл судлал, соёлын өвийн чиглэлээр суралцаж байгаа оюутнуудыг хамруулахаар тооцов.                        |
| 6                  | Постер аннонс хэвлүүлж сурталчлах                              | 2          | 5,000,000.00   | 5,000,000.00          | Цахим сүлжээнд сонирхолтой постер аннонс гаргаж, сурталчлахаар тооцов.  |
| <b>Нийт зардал</b> |  |            |                | <b>166,000,000.00</b> |   |

ЮНЕСКО-ийн 2001 оны Усан доорх соёлын өвийг хамгаалах конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийн үр дагаварт бий болох зардлыг тооцоход манай улсын энэ төрлийн соёлын өвийг хамгаалах туршлагагүй, хүний нөөц сул, материаллаг бааз

байхгүй зэрэг шалтгааны улмаас эхний жилүүдэд конвенцын хэрэгжилтийг хангахад бэрхшээл учрах төлөвтэй байна. Зардлын тооцоонд тусгасан санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулах нь манай улсын усан доорх соёлын өвийг хамгаалах үндэсний чадавхыг бэхжүүлэх, бие даан судалгаа хийх, соёлын өвийг эх төрхөөр нь хадгалах, тусгай зориулалтын аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгож ашиглах зэрэг нийгмийн зэрэг үр нөлөөтэй байна. Зардлын тооцоонд ойрын 3 жилд дараах утгатай зардал гарахаар байна.

| Д/д | Зардлын утга               | Зардлын дүн    | Тайлбар   |
|-----|----------------------------|----------------|---|
| 1   | Тогтмол зардал             | 61,505,000.00  | Гадаадын чанар сайтай бэлэн контентыг орчуулж түгээх, шинээр контент бүтээж түгээхээр тооцов.   |
| 2   | Урсгал зардал /1 удаагийн/ | 240,824,000.00 | Үүнд албан хаагчдын дотоод гадаадад сургалтад хамруулах, конвенцыг сурталчлах, судалгааны ажил хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээнд шаардлагатай зардлыг тусгав. |
| 3   | Хөрөнгө оруулалтын зардал  | 153,500,000.00 | Усны иж бүрэн хувцас, гэрэл зургийн аппарат, дрон, хийлдэг завь болон бүртгэл, мэдээллийн нэгдсэн системд хөгжүүлэлт хийх зардлыг тусгав.                   |
|     | Бүгд                       | 455,829,000.00 |   |

Дээрх хүснэгтэд тусгасан 61,5 сая төгрөгийн тогтмол зардал нь 2027 оноос хойш Соёлын өвийн үндэсний төвийн, 240,8 сая төгрөгийн урсгал зардал нь Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар, Соёлын өвийн үндэсний төвийн 2027-2029 онд тохирох хэмжээгээр, 153,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын зардал нь Соёлын өвийн үндэсний төвийн төсөвт 2027, 2028 онд тохирох ангилалд тусгаж, санхүүжүүлэх шаардлагатай.

Цаашид ЮНЕСКО, Конвенцын нарийн бичгийн дарга нарын газар болон бусад сан, санхүүжүүлэгч байгууллагаас дэмжлэг авах боломж өргөн байгаа тул оролцогч талууд эдгээр эх үүсвэрийг ашиглах замаар санаачлагатай ажиллах нь усан доорх соёлын өвийг хамгаалах үндэсний сүлжээг чадавхжуулж бэхжүүлэх, конвенцын хэрэгжилтийг хангахад чухал нөлөөтэйг анхаарах нь зүйтэй.

---oOo---

# СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМ

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-ийн 1.13.117-д усан дээрх соёлын өвийг хадгалан хамгаалах, түгээн дэлгэрүүлэх сурталчлах хууль бус худалдаа, маллагаас сэргийлэх нөхцөлийг бий болгох үүднээс "Усан дээрх соёлын өвийг хамгаалах тухай конвенцыг соёрхон батлах"-аар заасны дагуу "Усан дээрх соёлын өвийг хамгаалах тухай конвенц"-ыг соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсруулаад байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь хэсэгт "эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтээр хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлж, санал авах"-аар заасны дагуу хуулийн төсөлд 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хүртэлх хугацаанд нээлттэй санал авч байна. Та бүхэн саналаа [isoltmol@tocs.gov.mn](mailto:isoltmol@tocs.gov.mn) хаягаар ирүүлнэ үү.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Төрөл  
Төрөл ордон,  
Уламбалуур хот

2025 оны ... дугаар сарын ... өдөр

КСНВЕНЦ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий бага хурлын 2001 оны 31 дугаар чуулганаар баталсан "Усан дээрх соёлын өвийг хамгаалах тухай конвенц"-ыг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлгээр соёрхон баталсугай.

Гэрэн үсэг

**“УСАН ДООРХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ” ЮНЕСКО- ИЙН  
КОНВЕНЦЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН  
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

| № | Нэрс           | Албан тушаал   | Холбогдох утасны дугаар |
|---|----------------|--|-------------------------|
| 1 | Ж.АЛДАРЖАВХЛАН | Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд                              | 80108003                |
| 2 | Б.Бат-Эрдэнэ   | Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга | 99107220                |
| 3 | Б.Даваацэрэн   | Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Соёлын өвийн хэлтсийн дарга | 99775694                |